

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-14
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	15-134
1.“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/	17-18
2.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/	18
3.“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/	18-19
4.“Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүнээс 2024.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	19-25
5.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлт /Татварын ерөнхий хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/	25-32
6.“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	32-75
7.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	75-86
8.“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	86-114
9.“Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	114-133

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 26-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 71 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Х.Баасанжаргал, М.Бадамсүрэн, Б.Бат-Эрдэнэ, Ш.Бямбасүрэн, Д.Ганмаа;

Чөлөөтэй: Ч.Номин, О.Номинчимэг, Б.Тулга;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Анар, Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, С.Лүндэг, Э.Одбаяр, Д.Пүрэвдаваа, Д.Рэгдэл;

Тасалсан: Н.Алтанхуяг, О.Амгаланбаатар, Х.Баттулга, Да.Цогтбаатар;

Хоцорсон: Т.Аубакир -1 цаг 03 минут, Ц.Баатархүү -28 минут, Э.Бат-Амгалан -1 цаг 07 минут, Д.Батбаяр -17 минут, Д.Батлут -11 минут, Б.Батцэцэг -17 минут, Э.Батшугар -01 минут, Б.Бейсен -01 минут, Х.Болормаа -02 минут, С.Бямбацогт -35 минут, Ж.Галбадрах -02 минут, Д.Ганбат -13 минут, Л.Гантөмөр -05 минут, Ц.Даваасүрэн -02 минут, Г.Дамдинням -1 цаг 03 минут, Т.Доржханд -55 минут, Б.Жавхлан -2 цаг 03 минут, Б.Жаргалан -03 минут, Д.Жаргалсайхан -32 минут, Б.Заяабал -05 минут, Ц.Мөнхбат -06 минут, П.Мөнхтулга -05 минут, С.Одонтуяа -05 минут, Б.Пунсалмаа -1 цаг 57 минут, Б.Түвшин -10 минут, А.Ундраа -03 минут, Н.Учрал -07 минут, Д.Цогтбаатар -04 минут, Ж.Чинбүрэн -02 минут, Б.Чойжилсүрэн -59 минут, Ж.Энхбаяр -1 цаг 09 минут, Д.Энхтуяа -05 минут, Д.Энхтүвшин -6 цаг 17 минут, Р.Эрдэнэбүрэн -35 минут.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүнээс 2024.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2024.12.23-ны өдөр өргөн мэдүүлсэн Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугараас 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав.

Нэг. “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

Д.Амарбаясгалан: “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуульъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 14
Бүгд: 87
83.9 хувийн саналаар дэмжигдлээ.

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг гишүүдийн олонхын саналаар яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тул Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

Д.Амарбаясгалан: Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 11
Бүгд: 87
87.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр, Д.Энхтуяа, Т.Мөнхсайхан, П.Сайнзориг, Б.Хэрлэн, С.Одонтуяа нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг гишүүдийн олонхын саналаар яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тул Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

Д.Амарбаясгалан: “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	74
Татгалзсан:	15
Бүгд:	89

83.1 хувийн саналаар дэмжигдлээ.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг гишүүдийн олонхын саналаар яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тул Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүнээс 2024.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын

байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Батбаатар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Батбаатар нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 39
Бүгд: 95
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

“Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлт
/Татварын ерөнхий хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 04 дүгээр дүгнэлтийг Цэцийн гишүүн Д.Гангабаатар, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 04 дүгээр дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут нар тус тус танилцуулав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 04 дүгээр дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.4-т заасны дагуу Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан ... татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ... Иргэний хувийн ... халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэж санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 47
Бүгд: 97
51.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:04/

Уг асуудлыг 11 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Эдийн засгийн байнгын хороо хуралдах тул хуралдаан 11 цаг 04 минутад завсарлав.

Хуралдаан 14 цаг 27 минутаас үргэлжлэв.

Зургаа. “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд

Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Артуур, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын дэд захирал Б.Батмагнай, мөн яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Д.Бат-Өлзий, Хилийн хэлтсийн дарга Т.Баяржаргал, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Уул уурхай, технологийн газрын дарга Ч.Алтанбагана, Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Э.Түвшинжаргал, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Уянга, Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга О.Цэрэндондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Ц.Сандаг-Очир, Ж.Баясгалан, Ө.Шижир, О.Цогтгэрэл, С.Ганбаатар, О.Батнайрамдал, П.Батчимэг, Г.Ганбаатар, Х.Тэмүүжин, Б.Уянга, Ж.Алдаржавхлан, Н.Алтаншагай, Б.Батбаатар, Ж.Золжаргал, Н.Номтойбаяр, Н.Наранбаатар, Б.Жаргалан, Л.Мөнхбаатар, Ц.Мөнхбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 16 цаг 40 минутаас 17 цаг 12 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, С.Ганбаатар, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их

Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 86
Татгалзсан: 19
Бүгд: 105
81.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, П.Батчимэг, Б.Бейсен, О.Алтангэрэл, Р.Батболд, Б.Пунсалмаа, Д.Бум-Очир, Ж.Батжаргал, П.Сайнзориг, Ж.Чинбүрэн, Н.Номтойбаяр, Д.Ганбат нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Б.Уянга, С.Эрдэнэбат, Д.Үүрийнтуяа, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх санал хураалтыг хэлэлцэх асуудлын дарааллын 7, 8, 9 дэх асуудлыг хэлэлцэж дууссаны дараа хамтатган явуулахаар түр хойшлуулав./17:43/

Найм. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, мөн газрын Үндэсний хороо, төсөл, хөтөлбөр хариуцсан хэлтсийн дарга П.Баттөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ц.Өнөрнасан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга Л.Баттөр, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Усны газрын дарга З.Батбаяр, Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул, ашиглалтын газрын дарга С.Ган-Очир, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын захирал Б.Болдбаатар, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, мөн албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан, А.Мандуул, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян, Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, Хамтын ажиллагааны хэлтсийн менежер Т.Төрбадрах, “Мон-Атом” ХХК-ийн захирал Д.Далайжаргал, мөн компанийн Захиргааны албаны дарга Д.Сугарсүрэн, ахлах геологич А.Алтанхундага, Олон улсын харилцааны судлаач, профессор Д.Баярхүү, Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, академич, профессор Я.Ганболд, физикийн ухааны доктор Н.Тэгшбаяр, дотоодын хуулийн зөвлөх С.Батхүлэг, З.Шагдарсүрэн, Г.Мөнхболд, Б.Баярмандах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа, О.Цогтгэрэл, С.Ганбаатар, О.Батнайрамдал, Д.Үүрийнтуяа, Б.Батбаатар, Н.Номтойбаяр нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 18 цаг 49 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Батбаатар, Н.Номтойбаяр, Г.Дамдинням нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх санал хураалтыг хэлэлцэх асуудлын дарааллын 7, 8, 9 дэх асуудлыг хэлэлцэж дууссаны дараа хамтатган явуулахаар түр хойшлуулав./19:36/

Ес. “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Пунцагбалжир, Гэрээ, эрх зүйн газрын дарга Г.Эрхэмбаяр, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Нямсүрэн, “Дулааны цахилгаан станц-3” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар, мөн компанийн Техникийн бодлогын хэлтсийн дарга Г.Амартүвшин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад

бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 19 цаг 41 минутаас 19 цаг 43 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 19 цаг 43 минутаас хуралдааныг даргалав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, О.Цогтгэрэл, Ч.Лодойсамбуу, Ж.Баярмаа, С.Цэнгүүн, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Х.Булгантуяа, Х.Тэмүүжин, З.Мэндсайхан, С.Бямбацогт нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 33
Бүгд: 105

68.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Б.Жавхлан, Ж.Батжаргал нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Уг асуудлыг 20 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 86

Татгалзсан: 19
Бүгд: 105
81.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Ж.Батжаргал нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

2.Байнгын хорооны саналаар Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 83
Татгалзсан: 22
Бүгд: 105
79.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн, Аюулгүй байдал, гадаад бодлогын, Төсвийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 82
Татгалзсан: 23
Бүгд: 105
78.1 хувийн саналаар дэмжигдлээ.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн, Аюулгүй байдал, гадаад бодлогын, Төсвийн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 9 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хуралдаан зохион

байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 20 минут үргэлжилж, 126 гишүүнээс 106 гишүүн хүрэлцэн ирж, 84.1 хувийн ирцтэйгээр 20 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 05 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. 71 гишүүн ирцэд бүртгэгдэж, ирц 56,3 хүрсэн байна. 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр нийт 9 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт, “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

2 дугаарт, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

3 дугаарт, “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

4 дүгээрт, Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

5 дугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ.

6 дугаарт, “Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

7 дугаарт, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

8 дугаарт, “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

9 дүгээрт, Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хурлын өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороо, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан байгаа. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1 дүгээрт, Хархорум хотын бүтээн байгуулалт хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлснийг ТББХ-нд.

2 дугаарт, “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлснийг ТББХ-нд.

3 дугаарт, Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд.

4 дүгээрт, Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах тухай хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд.

5 дугаарт, “Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд.

6.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд.

7.“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд.

8.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд.

9“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлснийг ТББХ-нд тус тус хуваарилсан. Ингээд хэлэлцэх асуудалдаа орёё.

Нэг.“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн.

Төслийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа. Одоо төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна. Санал хураалт 1.Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт 83,9 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

10.13 цаг

Хоёр. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Дараагийн асуудалд оръё. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн. Төслүүдийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа.

Одоо төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна. Санал хураалт.

1. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 80,5 хувь буюу 70 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ. Протоколд Лувсаннъямын Гантөмөр, Доржзодовын Энхтуяа, Тогтмолын Мөнхсайхан, Пүрэвжавын Сайнзориг, Хэрлэн гишүүн нар протоколд дэмжсэнээр, Салдангийн Одонтуяа гишүүн протоколд дэмжсэнээр тэмдэглүүлье гэж хүсэлт гаргаж байна.

Ингээд хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

10.15 цаг

Гурав. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Дараагийн асуудалд орёе. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн.

Төслийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа. Одоо төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна. Санал хураалт. 1. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалт. 83,1 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

10.17 цаг

Яаралтай хэлэлцэх 3 асуудал Улсын Их Хурлын чуулганы хуралдааны оролцож байгаа гишүүдийн олонхоор дэмжигдсэн тул Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэгдсэн байгаа. Эдийн засгийн байнгын хороо одоо шууд хуралдаж, тухайн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулахаар байгаа Улсын Их Хурлын чуулган үргэлжилж дараагийн асуудлаа хэлэлцэж явна энэ хооронд. Сэддорж дарга, 10 цаг 20 минутаас Эдийн засгийн байнгын хороо Байнгын хорооны аль танхимд хуралдах вэ? Чингис хаан танхимд Эдийн засгийн байнгын хорооны хурлыг одоо эхлүүлье.

Дөрөв. “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүнээс 2024.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд орёе Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд танилцуулна. Индэрт урьж байна.

С.Эрдэнэболд: Монгол Улсын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаарх авах зарим арга хэмжээний тухай

Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэр бүхий 101 гишүүний дэмжлэгтэйгээр санаачлан өргөн мэдүүлж байгаа юм.

Монгол төрийн зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаарх тогтоолын төсөл нь Жамсрангийн Самбуу Түшээт хан аймгийн Зоригт вангийн хошуу одоогийн Төв аймгийн Бүрэн сумын нутагт 1895 оны 6 дугаар сарын 27-нд мэндэлсэн. Тэрээр 1903 онд нутгийн сайн бичээч Дугарсүрэн гэдэг хүнд шавь орж гэрээр бичиг үсэг сурч, Хошуу тамгын газраас бичээч болж, 1950 онд Намын шинэ хүчний сургуульд суралцаж төгсжээ.

Жамсрангийн Самбуу 1912 оноос Нийслэл хүрээний түмтийн өртөөнд улаач, 1921 оноос Түшээт вангийн хошууны Тамгын газар хавсраа бичээч, 1923 оноос Ардын Засгийн газрын Сангийн яаманд гутгаар зэргийн нягтлан бодогч, 1926 оноос тэргүүн зэргийн нягтлан бодогч түшмэл, 1928 онд эрхэлсэн түшмэл, 1930 оноос Богд Хан уулын одоогийн Төв аймгийн дарга, 1931 оноос Өмнөговь аймгийн дарга, 1932 оноос тус аймгийн шүүхийн даргаар ажиллаж байсан. 1934-өөс 37 онд Мал тариалангийн яаманд хэлтсийн дарга, 1937-гоос 41 онд БНМАУ-аас Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс хуучин нэрээр ЗХУ суух бүрэн эрхт төлөөлөгч, 1941-ээс 46 онд Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, 1946-аас 50 онд Гадаад явдлын яамны Ази Дорнодын хэлтсийн дарга, 1950-аас 52 онд Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, 1952-оос 53 онд Гадаад яамны орлогч сайд, 1953-аас 54 онд Монгол Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгийн орлогч даргаар ажиллажээ.

Тэрбээр 1954-өөс 1960 онд БНМАУ-ын Улсын Их Хурлын дарга, 1960-аас 72 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн даргаар удаа дараа сонгогдон ажиллахдаа түүний санаачилгаар улсын хөгжил дэвшилтэй холбоотой олон чухал шийдвэр гарсан байна. Үүнээс үзэхэд Жамсрангийн Самбуу нь Монгол Улсын төрийн анхан, дунд, дээд шатны албыг 60 жилийн турш ээлж дараатай хашсан, эх орныхоо хөгжил дэвшил, гадаад харилцаанд бодитой хувь нэмэр оруулсан төрийн зүтгэлтэн, дипломатч хүн юм. Жамсрангийн Самбуу 1935, 37, 43, 45, 58, 61, 65, 71 онуудад онуудад Мал аж ахуй дээр ажиллах тухай Ардад өгөх сануулга сургаал, Малчдад өгөх зөвлөгөө, Малчин ардын амьдрал ахуй, хэв заншил зэрэг 12 бүтээл туурвисан нь манай эдийн засгийн уламжлалт салбар мал аж ахуй эрхлэгчдэд өдгөө ч үнэ цэнтэй гарын авлага хэвээр байна.

Монгол Улсын төрийн тэргүүн байсан Жамсрангийн Самбуугийн хөдөлмөр зүтгэлийг үнэлж БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одонгоор 4 удаа, мөн зарим гадаад орны төрийн дээд шагналуудаар шагнасан бол түүний мэргэн ухаан, төрийн ажлын арга туршлага, ур чадварыг нь ард түмэн үнэлж, Монгол төрийн мэргэн өвөө хэмээн хүндэтгэн нэрлэдэг билээ. Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан манай орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх үйлсэд түүний оруулсан үнэтэй хувь нэмэр, амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах зорилгоор Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Та бүхнийг дэмжиж хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар танилцуулна. Индэрт урьж байна.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүнээс 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг ТББХ 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах үйлсэд оруулсан үнэтэй хувь нэмрийг олон нийтэд сурталчлах, төрийн ажлын өвөрмөц арга барил болон уламжлалт мал аж ахуйг зөв зохистой эрхлэх талаарх түүний үнэ цэнтэй бүтээл, сургаалыг ирээдүй хойч үедээ таниулах, эзэмшүүлэх чухал ач холбогдолтой хэмээн үзэж, Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг d.parliament.mn цахим хаягт байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно. Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд олонх буюу 53,3 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. ТББХ-ны хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир.

Д.Амарбаясгалан: Баярлалаа Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. 2 гишүүн нэр ирүүлсэн байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Энэ шийдвэрийг дэмжиж байгаа. Уг нь хуулиараа Засгийн газар санаачилж орж ирэх ёстой, учиртай. Харин ч энэ Эрдэнэболд гишүүн болон энэ бусад гишүүдийн санаачилгад их талархаж байна. Самбуу гуайн энэ ойг тэмдэглэх үйл ажиллагаа дээр 3 том заалт орсон байна. Түүн дээр 1 дүгээрт асуулт 150 сая төгрөгийн зардал гарах юм байна. Энэ ямар, хаанаас, аль санхүүжилтээс, аль зардлаас гаргаж байгаа вэ гэдгийг тодруулж асууя.

2 дугаарт Самбуу гуайн амьдрал түүх намтрыг уншихад үнэхээр гайхалтай, бахархмаар. Тэр социализмын бүтээн байгуулалт эд хийрхэл явж байх үед материал техникийн бааз гэж байх үед мал аж ахуй, бэлчээрийн мал аж ахуй дээрээ гол төвлөрч суурилна. Бидний тусгаар тогтнол баталгаа бо мал аж ахуй юм шүү гэдгийг бүүр онцгойлж тэр үед хатуу байр суурьтай байсан. Өнөөдөр ч гэсэн энэ үнэ цэн хэвээрээ байгаа. Тэгээд түүний гол арга барил бол тэргүүн туршлагыг нь л нэвтрүүлэх, бусдад нь нэвтрүүлэх гэдэг ийм л гол арга байсан. Олон сурах бичиг бичсэн, олон зохиол ном бичсэн. Энэ болгоныг Монголчуудын хүртээл дахин болгоно гэж би итгэж, их баяртайгаар хүлээж авч байна.

Тэгэхээр 2 дахь миний асуулт энэ тэргүүн туршлага болгож байгаа 5 ном байгаа миний мэдсэн. Яг энэ мал аж ахуй дээр яаж ажиллах тухай ардад өгөх сануулга сургаал гэж байгаа. Малчдад өгөх зөвлөгөө, малчин ардын амьдрал ахуй, хэв заншлаас зэрэг олон бүтээлүүд байгаа. Энийг Монголчуудад, малчдад эргэн сануулахад мөн орчин цагт Хөдөө аж ахуйн яамнаас би бараг бүтэн 6 сар гуйж байна л даа, удахгүй өгөх байх. Мал аж ахуйн салбар хөдөө аж ахуйн салбарт байгаа хамгийн тэргүүн туршлагууд юу вэ гэдэг асуултад одоо хүртэл хариулахгүй байгаа. Хамгийн тэргүүн зэргийн эгнээнд явж байгаа аж ахуйн нэгж эрхлэгч, хоршоодод бусдад нь нялзаая гэдэг асуудал дээр. Тэгэхээр энэ сургаал бүтээлүүд дээр ард иргэдэд хүргэхэд ямар арга хэмжээ авах вэ, юу төлөвлөж байгаа вэ гэдгийг тодруулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Төсөл санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд хариулт өгье.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр Жамсрангийн Самбуу гуайг мэдээж олон талт ажил хийж байсан хүн учраас маш их хүмүүс мэддэг. Энэ хүний тухай маш их ном байгаа. Тэгэхдээ энэ хүнийг оновчтойгоор тодорхойлох үг байдаг. Багабанди гуайн хэлсэн үг “бодол боширгон, хэл чивчиргэн” гэж. Монгол төрийн хар хүний жудаг, эрхэм чанар, дээрээс нь энэ төрийн үйл хэрэгт ямар ёс зүйн хэм хэмжээтэйгээр энэ албыг хаших вэ гэдэг дээр маш том үлгэрлэлийг бий болгосон гэж үздэг.

Тэгээд энэ дэлхийн 2 дугаар дайны дараа манай улсын дарга нар нэлээн хөлжөөд, гадна, дотноос их хэмжээний хувийн эд хогшил авч ирсэн. Тэр тохиолдолд тухайн үед маршал Чойбалсан гуай хэлж байсан. Дарга нар эдийн шуналын асуудал дээр элчин Самбуугаас суралц гэж. Москвад 6 жил Элчин сайд суугаад ирэхдээ хоёрхон чемодантай галт тэрэгний буудал дээр бууж байсан гэж. Эндээс юу гэж хэлдэг вэ гэхээр ерөөсөө энэ төрийн хүн шуналгүй байх ёстой. Хувийн шуналаа давсан хүн Монголын төрийн тэр босгоор алхах ёстой гэдэг энэ зарчмыг тухайн үедээ маш хүчтэй үлгэрлэж байсан. Өнөөдөр ч гэсэн энэ авлига хээл хахуулийн асуудал, орчин цагт нөгөө шунал гэдэг зүйл хэвээрээ байгаад байгаа. Тэгэхээр хуучны юм бүхэн ул болсон гэсэн үг биш. Өөрөөр хэлбэл бид их түүхээ хүндэтгэж, түүхэн дэх үнэ хүндтэй, сайн мөртэй хүмүүсийнхээ тэр залгамж халааг Монголын төрдөө зарчим болгон авч явах ёстой гэсэн санаа.

Тэгээд энэ Ганбаатар гишүүн 150 сая төгрөг гэж хэлж байгаа. Энэ дээр ном буюу энэ хүний гар бичмэл болон энэ холбогдох зүйлүүдийг ном болгож гаргах, дээрээс нь баримтат нэвтрүүлэг кино, дээрээс нь энэ гадаад харилцаатай холбоотой, мал аж ахуй, газар тариалантай холбоотой энэ хүний энэ төрийн хүний

ёс суртахуунтай холбоотой ийм эрдэм шинжилгээний цогц хурлуудыг хийхээр заагдсан байгаа. Тэгээд энэ өнөөдрийн энэ тогтоолоос бол, хэлэлцэж байгаа тогтоол маань Засгийн газарт чиглэл өгөхөөр. Зарим зардлууд нь эндээс гарах байх, ихэнх зардлууд нь энэ хувь хүмүүсийн хандив, энэ хүний нэрэмжит сан, нутгийн зөвлөл гээд энэ хувилбарууд олон тал талбараас гарна гэсэн үг. Өөрөөр хэлбэл 100 хувь төсвөөс мөнгө зарцуулагдахгүй гэж ойлгож болно. 100 хувь биш, тодорхой хэсэг нь төсвөөс зарцуулагдахгүй гэж ойлгож болно.

Тэгээд саяын сүүлийн 2 дахь асуултад байгаа тэр номуудыг нь хэвлэх ёстой байгаа. Тэгэхдээ энийг илүү орчин үеийн аргаар дижитал байдлаар янз бүрийн аргаар хэвлэж мэдээллүүдийг нь шинэчилж, шинэчлэхээр байгаа. Энэ дээр академич Бакей тэргүүтэй эрдэмтдийн баг ажиллаж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Бид ойн арга хэмжээ, түүхэн хүмүүсийн Монгол Улсад хийж бүтээх цагтаа хийж бүтээж, энэ улс орныг өнөөдөр ирэхэд хүргэж ирсэн түүхэн хүмүүсийг анхаарах нь зүйтэй. Төсөл санаачлагчийг 100 гаруй гишүүн дэмжсэнээр энэ тогтоолын төсөл өргөн баригдаж байгаа. Түүн дотор миний бие байгаа. Тийм болохоор дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ Байнгын хороо, Засгийн газар ер нь ийм зүйлүүдийг цаашид яах юм бэ? Ингээд нэг нэгээрээ тогтоолын төсөл санаачлаад оруулж ирдэг байх юм уу? Энэ чиглэлүүд дээр ямар зүйл дээр, яаж анхаарч байх ёстой юм энийгээ нэг жоохон бодож, гаргаж байхгүй бол. Яаж шийддэг байх юм бэ гэдгийг л Байнгын хорооноос асуух гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн хариулт өгье.

С.Эрдэнэболд: Гишүүнд баярлалаа. Ер нь бид олон улсын туршлагыг энэ дээр судалсан байгаа. Ард талд нь хавсаргасан байгаа. Зарим улсууд энэ төр, нийгмийн зүтгэлтэн буюу statesman гэж хэлдэг. Олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эдгээр хүмүүсийнхээ ойг нь мөнхжүүлэх ийм үйлдлүүдийг дэлхийн ямар ч улс орнууд хийдэг. Самбуу гуайн хувьд яагаад ийм онцгой Улсын Их Хурлын тогтоолын түвшинд яригдсан бэ гэхээр энэ хүн өөрөө 1972 оныг хүртэл 18 жилийн турш Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн даргаар ажилласан буюу одоогийн энэ Ардын Их Хурлын спикерийн Их Хурлын, Монгол Улсын Их Хурлын даргатай дүйцэхүйц энэ ажлыг 18 жил хийсэн учраас Монголын парламент хүндэтгэл үзүүлж, энэ тогтоол Засгийн газарт чиглэл өгсөн тогтоолыг гаргах талаар бид судалгаа хийсэн. Ингээд боломжтой гэж үзсэн учраас энэ орж ирж байгаа юм.

Өөрөөр хэлбэл нөгөө тохиолдлын юм уу, байнга л ийм хэн нэгэн хүнийг мөнхжүүлэх зорилгоор орж ирж байгаа асуудлаас яагаад ялгаатай вэ гэхээр энэ Их Хурлын даргаар 18 жил ажиллаж байсан гэдэг онцлог байгаа. Бусад улсуудын Английн ч гэдэг юм уу, Америкийн дээд, доод танхим ч гэдэг юм уу, ингээд Шинэ Зеланд ч гэдэг юм уу, бусад иймэрхүү ижилхэн парламентын засаглалтай болон зарим Ерөнхийлөгчийн засаглалтай улсууд ч гэсэн энэ statesman түвшинд үнэлэгдсэн, хүндлэгдсэн хүмүүстэй ингэж ач холбогдол өгдөг байгаа. Тэгээд энэ зарчмыг Монголд ч гэсэн авч явна.

Ер нь бид 1990 оноос хойших түүх эсхүл 1921, 1911 оноос хойших түүх гэж Монголын түүхийг олон хуваахаасаа илүүтэйгээр энэ түүхийн ээдрээтэй нугачаанд Монголын төлөө зүрх сэтгэлээ зориулж байсан эдгээр хүмүүсийгээ санан дурсаж,

хүндэтгэж байх, тэд нарын сайн талуудыг нь хойч үедээ өвлүүлэх нь том ач холбогдолтой байгаа. Зарим үг байдаг шүү дээ. Монголын төр зүтгэсэн хүндээ халтай эд нар гээд хэлмэгдүүлэлтийн жилүүдийн үг байдаг. Бид тийм учраас өнгөрсөн үеэ ямар нэгэн үзэл бодол, тухайн үед социализм нь байсан уу, коммунизм нь байсан уу, ардчилал нь байсан уу үл хамаарч Монгол төрийн алтан аргамж бол Монгол төрдөө үнэлэгдэх ёстой хүмүүстээ хүндэтгэл үзүүлж байх ёстой гэсэн зарчим явж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаг гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлье.

С.Ганбаатар: Энэ дэмжиж байгаа. Хамгийн гол нь утга учиртай зүгээр нэг баяр ёслолын байдалтай тэмдэглээд өнгөрөх биш өнөөгийн улс төрчид яг юу сурах вэ, өнөөгийн мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбарт тэргүүн туршлагыг урдаа барьж, энэ хоршоо гээд л Шинэ хоршоо гээд тэгэхэд чинь таарууг нь л яриад байдаг, маш олон ололт амжилттай талууд байгаа. Маш олон сайн, сайн туршлагууд байгаа. Энийгээ дэлгэрүүлэх тал дээр өнцгөө өөрчилж, ажиллахад өвгөдийн Самбуу даргын туршлагууд бидэнд их чухал байгаа. Өнөөдөр ч гэсэн энэ хуучраагүй байгаа гэдгийг анхаарч, энэхүү ойг тэмдэглэх явцдаа энийг онцгой анхаарна гэж би итгэж байна.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн үг хэлье.

Б.Батбаатар: Мөн энэхүү төслийг тогтоолын төслийг дэмжиж байна. Гэхдээ цааш цаашдаа бид анхаарах ёстой зүйл юу вэ гэхээр бидэнд үлдээсэн өв, бидний хадгалж тээж явж байх ёстой үнэт зүйл, зарчим энэ хүмүүсээс үлдсэн зүйлийг илүү тод томруун болгож өгдөг энэ агуулгын чиглэлд нь илүү их анхаарч байхгүй бол болохгүй байгаад байгаа юм.

Иргэний Зориг ногоон намын хувьд Санжаасүрэнгийн Зоригийн үзэл санаа, үнэт зүйлийг тээж явдаг нам гэдгээ байнга илэрхийлж байгаа. Өнөөдөр хүртэл тэр хүний харамсалтайгаар амь насаа алдсан хэрэг илрээгүй байгаа. Тэгэхээр энэ тодорхой түүхэн хүмүүсийг бүдгэрүүлэх, мартагдуулах нь тухайн цаг үед бий болж байсан үзэл санаа, үнэт зүйлийг илэрхийлэгч, манлайлагч, тээж явж байсан тэр ноён нуруу болж байсан хүмүүсийг мартагдуулах нь өөрөө тэр үзэл санаанаас зугтах урвах, өөр үйлдэл хийх ийм нөхцөл байдлыг бий болгодог. Тийм учраас миний хувьд энэхүү тогтоолын төслийг дэмжиж байгаа утгаа ингэж илэрхийлж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна. Ирц бүртгэлийн нэг санал хураалт явуулах уу, болохоор байгаа юм байна.

Санал хураалт. 1.Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд

хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт 57,9 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ. Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцүүлэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр ТББХ-нд шилжүүллээ. Далайн Батбаяр гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

10.41 цаг

***Тав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлт
/Татварын ерөнхий хуулийн зарим хэсэг, заалт Монгол Улсын Үндсэн хуулийг
зөрчсөн эсэх/***

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Дашбалбарын Гангабаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Гангабаатар: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг танилцуулж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Эрдэнэбулган, Гангабаатар, Мөнхсайхан, Энхтуяа нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлтээ хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Эрхэмбаяр, мэдээлэл гаргагчийн өмгөөлөгч Болд-Эрдэнэ, Түмэнбаяр болон мэргэжилтнээр Татварын ерөнхий газрын дарга Чимидсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн нар оролцлоо. Мэдээлэл гаргагч иргэн Лодойсамбуу, Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Жавхлан нар хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй болсон тул эзгүйд нь маргааныг хянан шийдвэрлэхийг зөвшөөрсөн хүсэлтийг ирүүлсэн болно.

Энэхүү хуралдаанаар Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцвэй.

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлт нийт 37 нүүр, түүний үндэслэл хэсэг нь дангаараа 16 нүүр болсон учраас та бүхэнд дүгнэлтийн үндэслэл хэсгийг товчилж, тогтоох хэсгийг бүхэлд нь уншиж сонсгоё.

Үндэслэл. Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно гэж заасан. Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад заасан халдашгүй чөлөөтэй байх эрхэд хамаарах хувийн мэдээлэл болон алдар хүнд халдашгүй байх эрхийг хязгаарлах үр дагавартай байна.

Татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр түүний талаар нийтэд мэдээлж болохоор заахдаа нийтэд мэдээлэх мэдээллийн агуулга, хүрээ, мэдээлэх арга, хугацаа, мэдээллийн хэрэгсэл, зөрчлөө арилгасан бол мэдээллийг устгах эсэх, ийнхүү устгах нөхцөл, журмыг тодорхой тусгаагүй байх бөгөөд мэдээллийг дэлгэх эрх бүхий этгээдийг татварын алба гэж ерөнхий хуульчилсан байна. Мөн 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан болохыг хэн, хэрхэн тогтоох нь тодорхойгүй буюу хуулиар зохицуулаагүй байна. Тодруулбал ямар зөрчлийг хууль тогтоомжид заасан хугацаанд арилгаагүй гэж үзээд, татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх болон ямар зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан тохиолдолд татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх вэ гэдэг нь ойлгомжгүй байх бөгөөд энэ 2 нөхцөл давхацсан эсэх нь ч хуулийн зохицуулалтаас нэг мөр ойлгогдохгүй байна.

Маргаан бүхий хуулийн заалтад нийтэд мэдээлж болно гэж заасан нь дээр дурдсан урьдач нөхцөлийг бүгдийг хангаж, татварын хууль тогтоомж зөрчсөн, улмаар оргон зайлж, эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийг нийтэд мэдээлэх эсэхийг татварын албаны холбогдох албан тушаалтан өөрийн үзэмжээр шийдвэрлэх эрсдэлийг бүрдүүлжээ. Ийнхүү уг асуудлыг шийдвэрлэх эрхийг түүний үзэмжид үлдээсэн нь хуулийн дээрх зохицуулалтыг дур мэдэж эсхүл ялгамжтай байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, урвуулан ашиглах боломжийг үүсгэсэн гэж үзэхээр байна.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг нь эрх зүйн үр дагаврын хувьд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, түүний дотроо хувийн мэдээлэл болон алдар хүнд халдашгүй байх эрхийг тус тус хязгаарлаж байгаа тул татвар төлөгчийн хувийн мэдээллийг түүний зөвшөөрөлгүй нийтэд дэлгэх үндэслэл, журам нь тодорхой хуульчлагдсан байх, тохирсон байх, шүүхийн хяналтад байх шалгуурт нийцсэн байх ёстой боловч эдгээрийг бүрэн хангаагүй байна.

Тодруулбал уг зохицуулалтын зарим хэсгийг төрийн эрх бүхий албан тушаалтан дур зоргоор хэрэгжүүлэх, эсвэл үл хэрэгжүүлэх, огт хэрэгжүүлэхгүй байх боломжтой. Түүнчлэн уг заалтыг хэрхэн ойлгон хэрэглэх нь тодорхой бус мөн хууль ёсны зорилготой нь холбогдуулан авч үзэхэд зайлшгүй тэнцвэртэй байх шалгуурыг хангаагүй байна. Иймд Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.4 дэх хэсэг татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан татвар төлөгчийн талаар Татварын алба татвар төлөгчийн үндэслэлгүйгээр нийтэд мэдээлж болно гэж заасан нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Иргэний хувийн халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг зөрчсөн байна.

Татвар төлөгчийн дансны мэдээлэл уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээлэл, дансны гүйлгээний мэдээллийг банк санхүүгийн байгууллагаас гаргуулж авснаар хангагдах нийтийн ашиг сонирхол нь энэ тохиолдолд хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийн хамгаалалтаас илүү ач холбогдолтой байх тул Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалт нь тэнцвэрийн зарчмыг хангаж байна. Тодруулбал маргаан бүхий хуулийн зохицуулалт нь хуулиар ногдуулсан албан татвар төлөх Үндсэн хуулиар тогтоосон иргэний үндсэн үүргийг хэрэгжүүлэх, татварын хяналт шалгалт хийх, эрсдэлийг үнэлэх, шинжлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд улсын төсөвт төвлөрөх татварын орлогыг нэмэгдүүлэхэд бодитой үр нөлөөтэй байна. Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалт нь Үндсэн хууль, хууль дээдлэх ёсны хүрээнд тогтоосон шалгуурт нийцсэн байх бөгөөд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, 66 дугаар зүйлийн хоёр дахь хэсгийн нэг дэх заалт Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон Үндсэн хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1.Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан, татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Иргэний хувийн халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг зөрчсөн байна.

2.Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1 дэх заалтад татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр, 34.4.3 дахь заалтад татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг татвар, татварын албанаас бичгээр, эсхүл цахимаар гаргасан хүсэлтийг үндэслэнэ гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг зөрчөөгүй байна.

3.Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай. Даргалагч Баясгалан, Эрдэнэбулган, Гангабаатар, Мөнхсайхан, Энхтуяа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Алдаржавхлан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн зарим хэсгийг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг ХЗБХ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу 2024 оны 12 сарын 24 өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд ХЗБХ Дамдины Цогтбаатар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлт дээр агуулгыг танилцуулсан болно. ХЗБХ-ны хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин хуралдаанд оролцсон Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудаас санхүүгийн тайлангаа хугацаанд нь гаргаж өгөөгүй хуулийн этгээдэд хариуцлага тооцох, олон нийтэд мэдээлэх, татан буулгах зэрэг үр дагаврын талаар, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүрэг байдаг эсэх талаар, зөрчил гаргасан хуулийн этгээдийг захиргааны аргаар улсын бүртгэлээс хасаж байгаа зохицуулалт нь хүн өмчтэй байх, хувийн хэвшлийн эрхлэх зэрэг Үндсэн хуулиар олгосон хүний эрхийг зөрчиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар эзэн нь мэдээгүй байхад санхүүгийн тайлангаа удаа дараа гаргаагүй гэсэн үндэслэлээр хуулийн этгээдийг захиргааны журмаар улсын бүртгэлээс татан буулгаж хассан тохиолдол байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтэц, хүний нөөцийн талаар, нийт татварын улсын байцаагч нарын аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг цахимаар нэвтэрч үзэх боломж байдаг эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг татварын байгууллагын эзэнд мэдэгдэхгүйгээр хуулийн этгээдийн банкны данснаас татварын өр авлагыг төлүүлэх талаар тухайн банканд албан тоот явуулж, өр авлагыг төлүүлдэг эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Монгол Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлт бол Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд жишиг болох дүгнэлт гарсан гэдгийг цохон тэмдэглээд, уг дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуулийн холбогдох заалтыг тайлбарлах замаар гаргасан байх бөгөөд Монгол Улсын хууль тогтоох байгууллага, Монгол Улсын Ерөнхийлөгч, бүх шатны шүүх, Монгол Улсын Засгийн газар, хууль төсөл боловсруулдаг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнууд, гүйцэтгэх чиг үүргийн хууль хяналтын байгууллагууд уг дүгнэлтээр хуульд заасан үндэслэл, журмаар эсхүл дур зоргоор хүний халдашгүй эрхэд халдах гэдэг цаашид ямар хүрээ хязгаар ойлгож явах талаар хэрхэн тодорхойлсныг асуух нь, анхаарах нь зүйтэй талаар үг хэллээ.

Мөн Монгол Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин иргэн, бизнес эрхлэх хувийн хэвшилтэй байх асуудал нь Монгол Улсад Үндсэн хуульд байгаа гол зарчмуудын нэг бөгөөд түүнийг хангах нь төрийн чиг үүрэг болох талаар, төр хуулиар иргэд засаглахаас илүү хувийн эрх, эрх чөлөөг хуулиар хамгаалах гэж оршин байдаг

зарчмыг тодотгож, мөн төрийн байгууллагууд өөрсдийн чиг үүрэг, үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор хууль тогтоох үйл ажиллагаанд тодорхой нөлөөллөө оруулж, хууль тогтоомжид тусгуулах замаар иргэн, аж ахуйн нэгжид үүрэг хариуцлага оногдуулж байгаа талаар үг хэллээ.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг үйл ажиллагаа нь зогсоод удсан, татвар төлдөггүй, тайлан гаргадаггүй боловч улсын бүртгэлд бүртгэлтэй хэвээр байдаг хуулийн этгээдүүдийн тооноос хамаарч холбогдох статистик, тоо баримт, шалгуур үзүүлэлт буруу гардаг тул шаардлагатай хуулийн этгээд хуульд заасан үндэслэлээр улсын бүртгэлээс хасах, ингэхдээ тухайн хуулийн этгээд эзэмшигчид урьдчилан мэдэгддэг байх ёстой гэж гэдэг талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат олон улсын татварын бодлого, хууль, эрх зүйн орчны талаар, Улсын Их Хурлын гишүүн Заяабал Үндсэн хуулийн цэцийн 04 дүгээр дүгнэлтэд Татварын ерөнхий хуулийн зарим хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзсэн боловч Цэцийн дүгнэлтэд тусгасан уг асуудал нь Үндсэн хууль зөрчсөн гэхээс илүүтэй холбогдох хууль тогтоомжийг илүү нарийвчлан боловсруулах шаардлагатай талаар дурдсан үг хэллээ.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ганбат татварын алба болон улсын бүртгэлийн газрын хооронд мэдээлэл, үйл ажиллагааг нэгтгэж, уялдаа холбоо дээр анхаарах шаардлагатай талаар, мөн Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар Үндсэн хуулийн цэцийн 04 дүгээр дүгнэлтийн нэг онцлог нь Татварын албанд зөрчилтэй хуулийн этгээдийн талаар олон нийтэд мэдээлэх эрх байхгүй гэж дурдаагүй, гагцхүү олон нийтэд мэдээлэх арга, хэлбэр, тогтолцоог тэнцвэртэй байдал хангаж чадахгүй байгаа талаар тус үг хэлсэн болно.

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татвар төлөгч нь татварын хууль тогтоомж зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан зөрчлөө арилгаагүй, 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан бол татвар төлөгчийн талаар татварын алба албан татвар төлөгчдийг зөвшөөрөлгүй нийтэд мэдээлж болно гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтын халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг хязгаарлахыг хориглоно, иргэний хувийн халдашгүй байдлыг хуулиар хангана гэсэн заалтуудыг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Улсын Их Хурлын ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Цэцийн дүгнэлтийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут танилцуулна.

Д.Батлут: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг

хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 4 дүгээр сарын, 04 дүгээр дүгнэлтийг 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Их Хуралд ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганзориг улсын төсвийн орлогыг бүрдүүлдэг татварын орлогуудыг төвлөрүүлэхтэй холбоотой татварын хуулиудын зохицуулалтуудыг цэгцлэх шаардлагатай бөгөөд орлого бүрдүүлэхийн тулд ихэвчлэн захиргааны арга хэмжээ авч байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Түвшин Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн авч, цаашид татвар, төлбөр хураах үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх нь зүйтэй талаар үг хэлж, байр сууриа илэрхийлсэн.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, 1 зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан, татвар төлөгчийн татвар, татварын талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн, 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно, иргэний хувийн халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг зөрчсөн байна гэж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх төсвийн Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 1 гишүүнээр тасаллаа. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ч.Лодойсамбуу: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Яг 2 жилийн өмнө Үндсэн хуулийн цэцэд яг би 3 асуудлаар хандсан юм. 1 дүгээрт хүүхдийн мөнгийг ялгавартайгаар олгож байна, 2 дугаарт хувийн дансны мэдээллийг татварын албаныхан дансыг чөлөөтэй нэгжиж байна, 3 дугаарт энэ татварын байцаагч хэрвээ шаардлага биелүүлээгүй гэж үзвэл олон нийтэд шууд мэдээлдэг энэ байдал нь Үндсэн хууль зөрчиж байна гээд 3 асуудлаар Цэцэд хандсан.

Эхнийх нь Засгийн газар маргаан үүсэнгүүт шийдвэрээ өөрчлөөд, эцэг, эхийнх нь орлогоос үл хамаараад, хүүхдийн мөнгө гэж нэрлэсэн учраас хүүхэд бүрд олгох нь зөв юм байна гээд шийдвэрээ зассанаар биеллээ олсон. Ингээд 2 дахь нь өнөөдөр Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гараад, өнөөдөр Их Хурал дээр орж ирж байна. Энэ нь нөгөө Үндсэн хуулийн 16.17 дээр хувь хүний нууцыг хуулиар тогтоон

хамгаална. Хувь хүний халдашгүй байдалд халдаж байна, энэ нь Үндсэн хууль зөрчиж байна гэдэг дүгнэлт гараад, өнөөдөр Их Хурал дээр орж ирж байгаа.

Өчигдөр Байнгын хорооны Төсвийн байнгын хорооны хурлыг харсан. Төсвийн байнгын хороо дээр энэ асуудлыг дэмжихгүй гэж шийдвэр гарч байх шиг байна лээ. Тэгээд гишүүддээ би өнөөдөр энэ асуудлыг хэлэлцээд, дэмжиж өгөөч гэж хүсэж байгаа юм. Тэгээд маш олон хуульчид, Үндсэн хуулийн цэц өөрөө энэ асуудлыг хэлэлцээд, Үндсэн хууль зөрчсөн байна гээд үзээд дүгнэлтээ гаргачихсан байгаа учраас дэмжиж өгөөсэй гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байгаа. Санал хураалт руу оръё. Ирц ямар байна вэ, нэг ирц бүртгэлийн санал хураалт явуулаадахъя. Байнгын хороо давхар хуралдаж байгаа учраас зарим гишүүд Байнгын хорооны хуралдаанд орсон байна. Танхимд байгаа гишүүдийн ирцийн бүртгэлийг явуулъя. Бүртгэлийн санал хураалт. 49, 50 гишүүн буюу 51 хувиар бүртгэл хийгдэж байна. Тест.

Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 1.Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан ... татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ... Иргэний хувийн ... халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Хууль зүйн байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх буюу 51,5 хувиар Хууль зүйн байнгын хорооны санал дэмжигдлээ.

Байнгын хорооны саналаар санал хурааж дууссан байна. Хууль зүйн байнгын хорооны саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсанд тооцлоо.

Тогтоол уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаандаа зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон түүнээс дээш удаа давтан гаргасан татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт халдашгүй чөлөөтэй байх эрхтэй, хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно, иргэний хувийн халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг

зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.04 цаг

Эдийн засгийн байнгын хороо хуралдаж хараахан дуусаагүй байна. Эхний асуудал дээрээ явж байгаа юм байна. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хорооны хурлыг дуустал чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлууллаа. Гишүүд богино хугацаанд асуудал шийдэгдэж дуусах байх. Гишүүдэд ойрын хугацаанд мэдэгдэнэ. Тэгэхээр хол явахгүй байхыг хүсье.

2024 оны 12 дугаар сарын 26, Пүрэв гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 27 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Гишүүдэд өдрийн амар амгаланг айлтгая. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдааныг эхлүүлье.

Зургаа. “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Сая Эдийн засгийн байнгын хороо хуралдаж, хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлгүүдийг явуулсан байгаа. Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан. Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын, Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ уншиж танилцуулна. Индэрт урьж байна. Ерөнхий сайдыг индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Эрхэм Монголчууд аа, Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Өнгөрснийг дүгнэж, эдийн засгийн тусгаар тогтнол, их бүтээн байгуулалтыг өрнүүлэх зорилго бүхий Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогыг улс төрийн намууд зөвшилцөж, эрдэмтэн судлаачидтайгаа хамтран боловсруулж, Монгол Улсын Их Хурал баталсан билээ. Бодлого, засаглал тогтворгүй, эрх зүйн орчин ойлгомжгүй, хөрөнгө оруулагчдад хэлсэндээ хүрдэггүй, том төслүүдээ улс төржин гацаадаг гэсэн нэршил Монголын зан хэмээн ирсэн та бидний язгуурын философиос нэлээдгүй зөрж ирсэн нь нууц биш юм.

Сайтар судалсны үндсэн дээр улс төрийн намууд зөвшилцөж, 2023 онд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурал баталж, 126 гишүүнтэй шинэ парламент холимог тогтолцоогоор бүрдэж хамтарсан Засгийн газар Хурдтай хөгжлийн төлөөх зориг үйл ажиллагааны хөтөлбөрийг батлуулж, 14 мега төсөлд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж эхлээд 100 хонож байна. Олон жил гацсан мега төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлж, гацсан шалтгаануудад дүн шинжилгээ хийж, гадаад талдаа улс орнуудын тогтолцоо эрх зүйн ялгаатай байдал, дотоод талдаа намууд хоорондын үзэл бодол болон мэдээллийн ялгаатай байдлыг цэгцэлж, нэгдсэн ойлголтод хүрэхэд Засгийн газар өнгөрсөн хугацаанд бүхий л боломжоо дайчлан ажиллаж, эхнээсээ үр дүнд хүрч эхэлж байна.

Хөгжлийн мега төслүүд гацсан суурь шалтгааныг 1 дүгээрт, олон улсын геополитикийн нөхцөл байдал болон тусгай албадын шууд болон шууд бус нөлөөлөл байна гэж үзсэн. 2 дугаарт, мега төслүүд гацсан шалтгаанд эдийн засгийн төслүүдэд эрх ашгаа шингээхийг хүссэн улс төр болон эрх ашгийн хил дамнасан бүлэглэл, хувь улс төрчид байна гэж үзсэн. 3 дугаарт, дээрх нөлөөллөөс үүдэлтэй их хэмжээний санхүүжилттэй улс төрийн зорилтот акц. Эдгээр 3 нөлөөллийг Улсын Их Хурал, Засгийн газар даахгүй явсаар ирсэн нь гашуун үнэн байжээ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, ажлын хэсэгт орсон төрийн албан хаагчдын аюулгүй байдалд заналхийлэл учруулсан олон баримтууд ч мөн бийг дурдах нь зүйтэй. Сонгуулийн холимог тогтолцоо, түүнээс бүрдсэн хамтарсан Засгийн газар ийм л нөхцөл байдлыг даван гарч, улс орныхоо хөгжлийн түүхийг эхлүүлж чадсаныг дэлхийн улс орнуудын түүх нотолдог. Олон нийт ч биднээс ийм хүлээлттэй байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газар 100 хоногтоо багтааж, өнгөрсөн 11 дүгээр сарын 5-ны өдөр Шанхай хотод 14 мега төслийн 1 болох 1964 оноос хойш яригдсан Эрдэнэбүрэнгийн УЦС-ын тусгайлсан зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурж, 253 сая ам.долларын санхүүжилтийн асуудал эцэслэн шийдвэрлэгдэж, ирэх хавар бүтээн байгуулалтын ажил эхлэхэд бэлэн болсныг дуулгахад таатай байна. Энэ асуудалд улс төрийн манлайлал үзүүлж ирсэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, холбогдох ажлын хэсгийн гишүүд, үе үеийн Засгийн газрын сайд нарт талархал илэрхийлэх нь зүйтэй. 34 жил шийдвэрлэж чадаагүй эрчим хүчний үнэ чөлөөлөх асуудлыг зориг гарган шийдвэрлэснээр эдийн засгийн хувьд алдагдалтай байсан эрчим хүчний төслүүд гацаанаас гарч эхэллээ. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Бөөрөлжүүтийн цахилгаан станц мөн ашиглалтад орж эхнийхээ галыг асааж чадлаа. Гал аван шийдвэрлэсэн энэхүү шийдвэр өнөөдөр магадгүй хүнд ч, ирээдүйд эрчээ алдсан эрчим хүчний салбарыг эргэн сэргээх түүхэн шийдвэрүүдийн нэг болж үлдэнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Энэхүү шийдвэрийг дэмжсэн парламентын гишүүдэд мөн талархаж байгаагаа илэрхийлье.

Ийм шийдвэрүүдийг гагцхүү холимог тогтолцоогоор бүрдсэн парламенттай үед, хамтарсан Засгийн газар л шийдвэрлэж чадна гэдгийг мөн дурдах нь зүйтэй. Энэ сард Ерөнхий сайд Булангийн орнуудад хийсэн айлчлалаар үнэ чөлөөлсөн энэхүү шийдвэр болон сэргээгдэх эрчим хүчний экспортын хэлцлийг улс орнуудтай хийж чадвал эрчим хүчний томоохон мега төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтыг Монгол Улсад хийхэд бэлэн байна гэдгээ Булангийн орнуудын Засгийн газар болон баялгийн сангууд албан ёсоор илэрхийлсэн гэдгийг мөн дуулгахад таатай байна.

Тийм учраас шинэ тогтолцоонд шилжсэн эхний үр дүнгүүд гарч, эдийн засагт эерэг нөлөө үзүүлж эхэлж байна гэж Ерөнхий сайдын хувьд эергээр дүгнэж байна.

Он солигдох дөхөж буй энэ үед 2024 оны эдийн засгийн макро үзүүлэлтүүдийг Засгийн газар өнгөрсөн хуралдаанаар хэлэлцэн дүгнэсэн. Урьдчилсан байдлаар эдийн засгийн өсөлт оны төгсгөлд 5 хувьтай, валютын нөөц 5,1 тэрбум ам.доллар, экспортын орлого 16,1 тэрбум ам.долларт хүрч, нүүрсний экспортын хэмжээ 84 сая тонн буюу одоо байгаа олборлолт, дэд бүтцийн хүчин чадлын хувьд түүхэн хамгийн оргил үед хүрсэн байна гэж дүгнэсэн. Гадаад өрнүүдийн дарамт буурч, зээлжих зэрэглэл олон улсад сайжирлаа. Харин импорт даган нэмэгдэж, 11,2 тэрбум ам.долларын бараа, бүтээгдэхүүн худалдан авсны 42,5 хувийг автомашин бүрдүүлж байгаад бид цаашид дүгнэлт хийх учиртай. Энэ ч агуулгаар Засгийн газар 2025 оныг бүхэлд нь Нийслэлийн дэд бүтцийг дэмжих жил болгон зарласан нь үүнтэй холбоотой.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш шударга хүртээхэд чиглэнэ гэж заасны дагуу Засгийн газраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр хэлэлцэн баталж байсан. 2024 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар нэгтгэн дүгнэж үзэхэд Ирээдүйн өв сан 4 их наяд төгрөг, Хуримтлалын сан буюу иргэдийн хадгаламж анх удаа 495 тэрбум буюу иргэн бүрд 135 мянган төгрөгийн хадгаламж үүсэж, Хөгжлийн санд 240 тэрбум төвлөрсөн байгаа нь хууль хэрэгжиж эхэлсэн өнгөрсөн 8 сарын хугацаа гэхэд чамлахааргүй үзүүлэлт гэдгийг мөн дурдах нь зүйтэй.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар стратегийн ордуудын 34 хувь, түүнтэй дүйцүүлэх өгөөжийг иргэд боловсрол, эрүүл мэнд, орон сууцдаа бэлэн бусаар захиран зарцуулах, ноогдол ашгийг ашгийн хувийг бэлэн мөнгөөр авах, эсвэл хуримтлалын сангийн хадгаламждаа хийх, мөн хөгжлийн санд хандивлах зэрэг зохицуулалтууд нээгдэж байгаа бөгөөд баялгийн өгөөжийг төсөл тус бүрээр ИМонголаар дамжуулан иргэд өөрсдөө хянах боломж мөн бүрдэж байгаа юм. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан 14 мега төсөл хэрэгжсэнээр Үндэсний баялгийн сангийн хуримтлалын сан 2030 он гэхэд 18-аас 20 их наяд төгрөгт хүрэх тооцоололтой байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эдгээр тоог тогтвортой өсгөхөд гацсан мега төслүүдээ хөдөлгөхөөс өөр сонголт Монгол Улсад байхгүй. Шинэ төсөл ярих ёс зүйн эрх авахын тулд бид өнгөрсөн алдаагаа засахаас өөр сонголт бидэнд байхгүй. Өнөөдөр Засгийн газраас 14 мега төслийн 1 дүгээрт эрэмбэлэгдсэн Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын Гашуунсухайт-Ганцмод хил холболтын төмөр замыг холбох бүтээн байгуулалтын гэрээ байгуулахад баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монгол Улс, Франц Улстай хамтран Зөөвч-Овоо төслийг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний төсөлтэй Улсын Их Хурлын тогтоолын төслийг хамтад нь ийнхүү өргөн барьж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгч Бүгд найрамдах Франц Улсад 2023 оны 10 дугаар сард хийсэн төрийн айлчлал, Монгол Улсын Засгийн газар болон Орано майнинг

компани хооронд олон жил яригдсан энэхүү төслийг урагшлахад томоохон улс төрийн түлхэц болсон. Энэхүү Хөрөнгө оруулалтын гэрээ батлагдвал Оюу толгой төслөөс хойш 3 дахь хөрш оронтой хамтран хэрэгжүүлэх Монгол Улсын 2 дахь хөрөнгө оруулалтын гэрээ болох бөгөөд Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчинд эерэг нөлөө үзүүлнэ гэж тооцож байна. Оюу толгой төсөлтэй харьцуулахад 34 хувийн энгийн хувьцааг 10 хувийн давуу эрхийн хувьцаа болгож байгаа бөгөөд үлдсэн 24 хувийг Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр буюу Амнат-р орлуулан тооцож байгаа нь ноогдол ашиг хүлээх, нэмэлт өр үүсэх, төсөл эхэлсэн цагаас эхлэн үр өгөөжийг иргэд хуримтлалын сангаар дамжуулан шууд хүртэж эхлэх зэрэг боломжийг бүрдүүлснээрээ онцлогтой юм.

Цөмийн энергийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх үеэр энэхүү төслийн талаар Улсын Их Хурал дэлгэрэнгүй ярьсан тул өнөөдөр Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замыг холбох бүтээн байгуулалтын 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн талаар илүү төвлөрч мэдээлэл өгье. Гашуунсухайт-Ганцмод хил холболтын төмөр зам ашиглалтад орсноор боомтын хүчин чадал 2 дахин нэмэгдэж, одоо байгаа жилийн 85 сая тонн нүүрсний экспорт дунджаар 165 сая тоннд хүрэх тооцоололтой байгаа. Бид 16 жилийн өмнө энэхүү төмөр замын төслийг хэрэгжүүлж чадсан бол өнөөдөр нийслэлийн утаа, түгжрэлээс огт өөр сэдвийг ярьж байх боломж бидэнд байлаа.

Ирээдүйд дахиж ийм цаг хугацаа, боломжийг алдахгүйн тулд хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашгийг давж, нийтийн эрх ашгийн төлөө энэ төслийг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд Улсын Их Хурал Засгийн газар хоорондын гэрээг соёрхон баталсан тохиолдолд Засгийн газар ирэх хавар энэхүү бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд бэлэн байгаа гэдгээ мөн илэрхийлье. Энэ төсөл хэрэгжсэнээр Замын-Үүд, Эрээн хилийн боомт төмөр замаар холбогдсоноос хойш 70 орчим жилийн дараа өмнөд хөрштэйгөө төмөр замаар холбогдох хилийн 2 дахь боомт ашиглалтад орох бөгөөд энэ боомт ашиглалтад орсноор Шивээхүрэн, Сэхээ, Бичигт, Зүүн хатавч, Хангимандалын боомтууд мөн холбогдох боломж эрх зүйн орчин бүрдэх юм.

Мөн эрчим хүчний нүүрс экспорт, нүүрсийг гүн боловсруулах аж үйлдвэрийн эхлэл эхлэх зэрэг олон давуу талууд мөн энэ төсөл хөдөлснөөр гарна. Ингэснээр дотоодын нийт бүтээгдэхүүн 2028 он гэхэд 132,3 их наяд төгрөгт хүрч, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 10 мянган ам.долларт хүргэх Засгийн газрын зорилтыг хэрэгжүүлэхэд энэ төсөл үндсэн шийдэл болох юм. Цаг хугацааны цаглаврын хувьд энэхүү төслийг авч үзвэл 2003 оноос эхлэн харилцан санал солилцож эхэлсэн. 2008 оноос албан ёсоор яригдаж, өнгөрсөн 16-аас 20 жилийн хугацаанд нийт 60 гаруй удаагийн яриа хэлэлцээр 2 талд хийгдсэн байна. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөл 2 зөвлөмж, Улсын Их Хурал 5 удаагийн тогтоол, Засгийн газар 45 удаагийн тогтоол гарч, төмөр зам барих тусгай зөвшөөрлийг 5 удаа олгож, мөн 4 удаа цуцалж байсан байна.

Товчоор дүгнэж хэлэхэд эдгээр хэлэлцээр 2 улсын Засгийн газар хооронд хийгдэх хэлэлцээрт гуравдагч этгээдийг оруулах, Эрдэнэс Тавантолгой тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, хувь эзэмших, Тавантолгойн орд болон төмөр замын эзэмшил 49, 17, 17, 17 байх зэрэг асуудлыг оруулснаас болж, улс төрийн гацалт үүсэх үндсэн шалтгаан үүссэн байна гэж дүгнэж болно. Мөн төмөр зам тавигдах нь жижиглэнгээр нүүрсний худалдаа хийдэг зарим компаниуд Тавантолгойн өрсөлдөгч

ААН-үүдийн эрх ашигт нөлөөлнө гэж үзсэнээр улс төрд томоохон хэмжээний эсрэг блок үүсгэж, улс төрчид болон олон нийтийн нөлөөлөгчдөд эдийн засгийн хувьд нөлөөлснөөр ирсэн нь нууц биш юм. Хэлэлцээр явж байх үед ч энэ асуудал Оюу толгойн 2,3 тэрбум ам.долларын өр тэглэгдэх, Эрдэнэтийн 49 хувийн санхүүгийн схемийг Их Хуралд оруулж, ил тод болгох, Хөгжлийн банкны чанаргүй зээлийг зарлах сонсгол хийгдэж байх хугацаатай харьцуулж үзэхэд адилхан үйл явдал давтагдаж байгаа гэдгийг мөн дурдах нь зүйтэй.

2014 оны 8 дугаар сарын 21-нд 2 улсын төрийн тэргүүнийг байлцуулан зурагдсан Гашуунсухайт-Ганцмод хил холболтын төмөр замын санхүүжилтийн гэрээнд үндэслэн Хятадын тал Ганцмод хилийн боомтын бүтээн байгуулалтыг 2015 оны 1 дүгээр сард ашиглалтад оруулж, харин манай улсын Гашуунсухайт талын бүтээн байгуулалт гацсанаас шалтгаалж эдийн засгийн алдагдал, алдагдсан боломжийн өртөг, мөн бусад хил холбох боомтын асуудлууд мөн нийгмийн томоохон төслүүд гацаж, харилцааны хувьд 2 улсын дунд асуудал үүссэн нь түүхэн үнэн юм.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар өнгөрсөн хугацаанд үүссэн эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд энэхүү тогтоолын төслийг өргөн барьж байна. Энэхүү тогтоолд 1 дүгээрт Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг Монгол Улс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд төрийн өндөр дээд түвшинд тохирсон иж бүрэн хамтын ажиллагааны хүрээнд аливаа гуравдагч талын оролцоогүйгээр хэрэгжүүлэх. 2.Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын эдийн засгийн үр ашгийг хангах зорилгоор төмөр замын бүтээн байгуулалт, нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ байгуулах, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх 3 асуудлыг харилцан уялдаатай цогц байдлаар шийдвэрлэх. 3.Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажиллагаандаа Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцаа, эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг аливаа бусад этгээдэд шилжүүлэхгүй байх.

4.Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн багтаамж, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний үнийг тогтоохдоо Эрдэнэс Тавантолгой ХК-ийн урт хугацаатай байгуулсан гэрээний нөхцөл, үнийн аргачлалаар жишиг болгож, гэрээ үйлчлэх хугацааг 16 жилээр тогтоох. 5. Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу нийлүүлэх нүүрсний хэмжээг 2025-аас 2029 онд 27 сая тонн, 2030 оноос эхлэн 20 сая тонноос бууруулахгүйгээр нэмэлтээр тооцох. 6.Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг байгуулахад өргөн, нарийн царигийн аливаа маргаан дахин үүсгэхгүйг бататгах буюу Монголын тал өргөн, Хятадын тал нарийн царигаар баригдаж, зөвхөн хил холболтын зорилгоор цариг хоорондоо зөрөх.

7.Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтад нэг зураг төсөлтэй, нэг гүйцэтгэгч бүтээн байгуулалтыг зэрэг эхлүүлж, зэрэг дуусгах нийтлэг зарчмыг баримтлах. 8.Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих, түүнийг холбох бүтээн байгуулалтын төслийн ажлыг

Хятадын талын сонгон шалгаруулсан аж ахуйн нэгжээр төмөр зам, түүнийг холбох барилга, байгууламжийг гүйцэтгүүлэн хамтран ажиллах бүтээн байгуулалтад үндэсний компаниудаа оролцох боломжоор хангах. 9.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх Ганцмод боомт хүртэл баригдсан төмөр замын бүтээн байгуулалттай холбогдуулж өнгөрсөн хугацаанд Хятадын талд гарсан аливаа зардал, алдагдал, хохирол болон төмөр замын хил холболтод шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг ирээдүйд нэхэмжлэхгүй байх.

10.Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлснээр Монгол Хятадын хилийн Шивээхүрэн, Сэхээ, Хангимандал, Бичигт, Зүүнхатавч зэрэг боомтуудыг төмөр замаар холбох ажлыг үе шаттайгаар эхлүүлэх. 11.Сэргээгдэх эрчим хүчний экспорт эрчим хүчний нүүрс экспортлох, нүүрсийг гүн боловсруулах аж үйлдвэржилт, говийг усжуулах, шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх, хил холболт болон дэд бүтцийн бүтээн байгуулалт, орон сууцжуулалтын асуудал зэрэг нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг харилцан ашигтай хувилбар шийдэл бүхий асуудлыг энэхүү гэрээ үргэлжлэх 16 жилийн хугацаанд байгуулж, хамтран ажиллахыг судлах зэрэг асуудлуудыг оруулж ирж байна.

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцууллаа. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

П.Батчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын 2004 оны Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хэлэлцээрийн дагуу Монгол Хятадын хилийн хэсэгт Шивээхүрэн-Сэхээ, Гашуунсухайт-Ганцмод, Замын-Үүд-Эрээн, Бичигт-Зүүнхатавч хилийн боомтуудад төмөр замын хилийн боомт ажиллахаар тогтсон. Дээрх хэлэлцээрийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас Ганц мод, Сэхээ, Зүүнхатавч боомтууд хүртэлх төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хийж дуусгасан бөгөөд Монгол Улсын төмөр замтай холбогдоход бэлэн болсон. Харин Монгол Улсын талаас хэлэлцээр байгуулагдсанаас хойш төмөр замын хилийн холболт, боомтын бүтээн байгуулалтын ажлууд хэрэгжээгүй байгаа тул Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг Алсын хараа 2050-ийн хэрэгжилтийг

хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг байгуулахад баримтлах чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулжээ.

Төсөлд боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг Монгол Улс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд төрийн дээд өндөр түвшинд тохирсон иж бүрэн хамтын ажиллагааны хүрээнд аливаа гуравдагч талын оролцоогүйгээр хэрэгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг хангах зорилгоор төмөр замын бүтээн байгуулалт, нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг байгуулах, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх 3 асуудлыг харилцан уялдаатай цогц байдлаар хамтад нь шийдвэрлэх, сэргээгдэх эрчим хүчний экспорт, эрчим хүчний нүүрс экспортлох, нүүрсийг гүн боловсруулах аж үйлдвэржилт, говийг усжуулах, шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх, хил холболт болон дэд бүтцийн бүтээн байгуулалт, орон сууц сууцжуулалтын асуудалд харилцан ашигтай хамтран ажиллах гэх зэрэг асуудлуудыг тусгасан байна.

Тогтоолын төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна. Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Батсүмбэрэл, Ганбаатар, Батчимэг, Жаргалан, Алдаржавхлан, Мөнхсоёл, Найдалаа, Золжаргал нар төсөл санаачлагчаас асуулт асууж, хариулт авлаа. Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Өнөөдөр гишүүддээ хандаж товч зүйлийг хэлье гэж бодож байна. 2023 онд орсон Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтийн үр дүнгээр 126 гишүүнтэй парламент бүрдсэн. 5 нам, эвслийн оролцоотой энэ парламент 1992 оны ардчилсан Үндсэн хуулийн үзэл санааг бүрэн хэрэгжүүлэхээр байгуулагдсан нь онцгой чухал ач холбогдолтой ийм цаг үе тохиож байна. Манай парламентын хувьд эдгээр өдрүүд Монгол Улсын түүхэнд тодоор бичигдэх өдрүүд болж байгаа нь маш чухал юм гэж үзэж байгаа. Учир нь гэвэл өнөөдөр та бид хамтдаа 10-аас 30 орчим жилийн хугацаанд гацсан БНХАУ, ОХУ, Францын Орано групптэй Засгийн газар хоорондын хэлэлцээр хийх энэ төслүүдийг хэлэлцэж байгаа нь түүхэн чухал ач холбогдол. 126 гишүүнтэй, 5 нам эвслийн оролцоотой парламентын үүрэг бол улс орны эдийн засгийг боомилсон, олон төсөл, хөтөлбөрүүд гацсан, эдгээр төслүүдийг хөдөлгөх, улс орныхоо эдийн засагт илүү өндөр ашигтай байх чиглэлийг баримталж ажиллах энэ чиглэл дээр зорилго, бодлогоо дэвшүүлэн ажиллаж байгаа.

Өнөөдөр хэлэлцэж байгаа энэ 3 Засгийн газар хоорондын хэлэлцээр нь өөрөө Монгол Улсын өнөөгийн ДНБ-ээс 1-ээс 1,5 дахин илүү хэмжээний дүнтэй томоохон төсөл, хөтөлбөр хөтөлбөрүүд юм гэдгийг та бүхэндээ тодотгож хэлэхийг хүсэж байна. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд эдгээр 3 чухал асуудал дээр онцгой ач холбогдол өгч, ирц бүрэн оролцохыг хүсэж байна.

Ажлын хэсгийн гишүүдийг та бүхэндээ танилцуулъя. Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээвэр хөгжлийн сайд, Сэрээтэрийн Жавхлантаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Туулхангайн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Баярын Хулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга, Бямбааюугийн Артур Зам, тээвэр хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Хүчитбаатарын Итгэлт Зам, тээвэр хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Батзаяагийн Батмагнай Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын дэд захирал, Даваадоржийн Бат-Өлзий ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал, Түргэнбаярын Баяржаргал ГХЯ-ны Хилийн хэлтсийн дарга, Хүүгийн Мөнхжаргал Эрдэнэс Тавантолгой ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эрдэнийн Түвшинжаргал Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Осоржамаагийн Цэрэндондог Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Асуулт асууж, хариулт авна. Нийт 24 гишүүний нэр ирсэн байгаа. Баярмагнайн Баярбаатар гишүүн асуулт асууна.

Б.Баярбаатар: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Асуулт юу байх вэ, санал хэлчихье. Бидэнд нэг улс төржих сэдэв байна, улс төржиж болохгүй сэдэв гэж байна. Өнөөдөр энэ 126 гишүүнтэй парламентын ирэх холын зорилтыг дэвшүүлсэн ийм түүхэн шийдвэрүүдийг гарах мөч гэж харж байгаа. Тэгэхээр энэ Засгийн газраас яаралтай хэлэлцүүлэх горимоор оруулж ирсэн энэ 3 том төсөл бол бид нарын мөрийн хөтөлбөртөө тусгасан 14 мега төслийн гол эхлэл. Хэрвээ бид энэ 3 төслөө дэмжих боломжгүй байдлаар үзэх юм бол дараа дараагийн асуудлууд явахааргүй харагдаж байгаа. Тэгэхээр би энэ дээр хамгийн түрүүнд энэ улс төржилт гэдэг зүйлийг битгий ороосой гэж хүсмээр байна. Саяын тэр ажиллах хүчний хуулийг татаж авдагтай холбоотойгоор санаатай болон янз бүрийн зорилго, ашиг сонирхлын үүднээс асуудлыг гацаадаг нөхдүүд өнөөдөр өөрсдөө ирээгүй байна л даа. Тэгэхээр энэ парламент бол хариуцлагатай энэ зүйл дээр хандах нь зөв.

Дараагийн асуудал энэ геополитикийн хувьд Монгол хувьд улсын хувьд чухал ач холбогдолтой зүйл. Өнөөдөр бид 2 хөршийнхөө болон гуравдагч хөршийн харилцаатай холбоотой асуудлыг шийдвэрлэнэ. Аль нэг нь дэмжигдэж, аль нэг нь унах боломж бол угаасаа байхгүй. Мэдээж олон ургалч үзэл, санал бодлоо илэрхийлэх нь зөв. Тэгэхдээ бид алсдаа ер нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, энэ хөгжилд хэр үр дүн гарах вэ гэдэг асуудлыг энэ парламентад сууж байгаа гишүүд маань томоор харах нь зөв болов уу гэж харж байна.

Тэгээд яг өнөөдрийн энэ эхний хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуудал дээр Монгол Улс өнгөрсөн хугацаанд бараг 2008 оноос, 9 оноос хойш бол 14, 5 жилийн хугацаанд маш хариуцлагагүй хандаж ирсэн юм байна лээ. Улсын нууцад хамааруулж байгаад янз бүрийн асуудлыг нь гацаасан юм байна лээ. Янз бүрийн танк орж ирнэ гэж цариг ярьж байгаад тодорхой хугацаанд гацаасан. Тэгээд бид энэ хугацаанд алдагдсан эдийн засгийн боломж маш том боломжийг алдсан. Ганцхан Монгол Улсдаа алдах төдийгүй урд хөршдөө бид энэ боломжийг энэ алдагдлыг давхар үүрүүлсэн. Тэгэхээр цаашид ийм алдаа дутагдлыг дахиж гаргахгүйгээр асуудалдаа хандаад явах нь зөв болов уу гэж бодож байна. Мэдээж 100 хувь төгс явна гэж юу байх вэ, янз бүрийн дайралт, янз бүрийн шүүмжлэл, гомдол саналууд олноор орж ирнэ. Тэгэхдээ бидний зорилго бол энэ улсын ирээдүйн хөгжил, эдийн засгийн нөхцөл байдлыг илүү сайжруулах, ойрын зайны эрсдэлээс айж, холын зайны зорилгоо бид үгүйсгэж болохгүй гэсэн ийм саналтай байна. Тэгээд гишүүд ч гэсэн энэ дээр дэмжиж, мэргэжлийн Байнгын хороодоос оруулж ирсэн саналыг дэмжиж, саналаа өгөхийг хамгийн эхний үг хэлсэн гишүүнийхээ хувьд уриалж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууж, хариулт авна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Зарчмын хувьд тогтоолын төслийг дэмжиж байгаа. Энд ч дэмжихгүй гээд байх үзэл бодолтой хүн ч бараг байхгүй байлгүй дээ. Ийм боломжийн чиглэл агуулсан ийм төсөл, хөтөлбөрийг ингэж оруулж ирж байхад 16 жилийн дараа оруулж ирж байхад энэний эсрэг байр суурьтай байна гэдэг бол үнэхээр улс орны хөгжлийн төлөө байна уу, үгүй юү гэдэг асуудал үүсэх хэмжээнд яригдах байх.

Тэгээд өнөөдөр энэ төслийг явуулах 1 яригдахгүй байгаа асуудал хариуцлагын асуудал байна, хариуцлага. Өнөөдөр бид бүхэн, манай улс эдийн засаг, хөгжлийн хувьд ийм байдалтай байгаа нь энэнээс ч дээр байх боломжтой байсан. Гагцхүү ийм сая Ерөнхий сайдын үгэнд нөлөөлөл нь улс төр, эдийн засгийн ашиг сонирхолтой бүлэг зөрчил улс төрчдийн оролцоо байсан гэж хэлж байна. Тэгээд энэ улс орны эдийн засагтай холбоотой, эрх ашигтай холбоотой ийм том төслүүдийг ингэж гацааж, хойш татсан энэ чухам хэн юм бэ? Ийм улсуудыг өнөөдөр ингээд намжаагаад хариуцлагын асуудал ярихгүйгээр ингээд өнгөрөөд өнгөрнө гэж үү?

Урд тал чинь мөнгөн дүнгээрээ 13,9 тэрбумын юанийн хохирол амсчихсан гэдгээ мөнгөн дүнгээр гаргаад ирчихсэн байна. Манай улс эндээс ямар хэмжээний хохирол үзсэн, хүлээсэн бэ? Энэ алдагдсан боломжийг хэн хариуцах вэ? 16 жилийн өмнө төмөр замтай болсон бол бид ямар эдийн засгийн ашиг хувь хүртэх байсан бэ? Энэ хууль хүчний байгууллагууд 16 жилийн хугацаанд хаана нь ажиллаж байсан юм бэ? Тэгээд хариуцлагын асуудлыг өнөөдөр яримаар байна.

Энэ танхим дотор энэ төслийг гацаасан улсууд байгаа бол ийм улсуудтай мөр зэрэгцээд сууж байна гэдэг үнэхээр харамсалтай, гутамшигтай байна. Тэгээд энэ асуудлыг ярихгүйгээр өнгөрч болохгүй байх. Ингээд намжаагаад өнгөрч болохгүй. Харин ч энэ төслийн үзэл баримтлал чинь нөгөө тал чинь алдагдсан боломжоо эдийн засгийн хувьд нэхэмжлэхгүй гэдэг ийм боломжийн саналыг оруулж ирсэн байна шүү дээ. Тэгвэл бид бүхэн дотроо хариуцлагын асуудлаа ярьж, энэ алдагдсан боломжийг ингээд дуугай өнгөрч, толгойг нь илээд өнгөрч болохгүй гэж бодож

байна. Энэ дээр дуугай өнгөрвөл дараа дараагийн олон төслүүдийг ингэж гацаасан асуудлууд гарч ирнэ. Тэгээд ийм байсан учраас өнгөрсөн хугацаанд ийм арчаагүй, дотоодын улс төрөө дийлэхгүй ийм байдалтай явсаар өнөөдрийг тулчихсан юм шиг л ингэж харагдаж байна. Тийм учраас улс орны эрх ашгаас давсан хэсэг бүлэг нөхдүүдтэй улс төрийн хариуцлагыг ярих цаг болсон гэж би хувьдаа харж байгаа юм. Тэгээд энэ дээр хэн хариуцлага хүлээх вэ гэдгийг л би дахин, дахин асуумаар байна гэдгээ хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Туваан сайд алдагдалтай холбоотой асуудлаар асуулт тодруулж байна.

Ц.Туваан: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ маш удаан хугацаанд гацсан ийм төсөл. Тэгээд 2015 онд энэ төсөл хэрэгжээд төмөр зам холболт явчихсан байсан бол, алдагдсан энэ гацсанаас болж алдагдсан боломжууд их байгаа. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын тал энд оруулсан хөрөнгө оруулалт, алдагдсан боломжуудаа тооцоолж явуулсан. Манай хувьд манай талаас энэ төмөр замаа холбоод нүүрс экспортолсон бол 18,5 их наяд төгрөгийн ийм боломж алдагдсан гэсэн ийм тооцооллыг манай яамны газрынхан хийсэн байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Би хэн гээд асуугаад байгаа шүү дээ, хариуцлага асуугаад байгаа шүү дээ. Тэгээд яг ингээд л нэг улс төрчтэй холбоотой, нөлөө бүхий нөхдүүдтэй холбоотой асуудал болохоор, ард түмэн юунд бухимдаад уурлаад байгаа гэхээр яг ийм улс төрчдийн орооцолдсон ийм хэргүүд илэрдэггүй, нуугддаг, дарагддаг учраас ард түмэн шударга ёсыг нэхээд байгаа шүү дээ энд. Тийм учраас энэ хариуцлагыг хэн хүлээх вэ гэдгийг би хэлээд байна. Яах вэ 18 их наяд төгрөгийн хохирол амссан юм байна эдийн засгийн хувьд. Энийг тэгвэл хэн учруулсан юм бэ? Эзэн бие олддоггүй шүү дээ ингээд улс төрчтэй холбоотой хэрэг ярихаар. Энэ чинь өөрөө улс төрийн сэдэв байхгүй юу. Ярьж байгаа асуудлаа л хэлж байна би. Ганцмодны энэ холболтын асуудлаа ярьж байна. Тэгээд бүгдээрээ сайхан найзан дундаа ороод асуудал ярихаар ингээд дундаа ингээд толгойг нь илээд өнгөрдөг бол цаана чинь энэ илүү олон асуудлууд үүснэ шүү дээ.

Д.Амарбаясгалан: Улс төржилт энэ Монгол Улсын эдийн засгийг 10-аас 30 жилийн хугацаанд боомилсон гээд бид дотроо бүгд ярьж байгаа шүү дээ. Тэгээд энэ удаагийн парламентын онцлог 126 гишүүнтэй болсон. Энэ олон нам улс төрийн зөвшилцлийг хоорондоо маш сайн хийж, энэ олон жилийн туршид хөдөлж чадахгүй байсан төслүүдийг хөдөлгөө гэж ингэж зорьж байгаа учраас айхтар улс төржилтийн асуудлыг энэ дотор яриад яах вэ. Мэдээж тэр гацаасан эсхүл эрсдэл учруулсан нөхдүүд байдаг бол тэр хууль хяналтын байгууллагууд асуудлаа яриад, шийдээд явах нь зүй ёсны хэрэг. Парламентын танхимд бид хэн нэгнийг зөв, буруугаар шүүх нь зохисгүй зүйл юм гэж үзэж байна. Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Баясгалан: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ удаагийн 126 гишүүнтэй парламент, дээр нь нэмэгдээд энэ хамтарсан засаг байгуулж байж энэ засагт Ардчилсан нам, ХҮН нам орж ирж байж энэ төслүүд явах гэж байна. Энэ бол яг л бодитой байдал энэ байна шүү дээ. Дангаараа аль нь ч авч явсангүй, хамтарч байж энэ асуудал шийдэгдэж байна. Тэгэхээр Ганцмод-Гашуунсухайт руу очиж

үзсэн, танилцсан. Тэгээд үнэхээр Монголын тал Хятадын тал 2 яг л өдөр, шөнө шиг зөрөөтэй байгаа шүү дээ. Хийсэн ажил нь, хийчихсэн, бүтээчихсэн юмнууд нь. Тэгээд энэ Ганцмод-Гашуунсухайтын төсөл явснаараа үнэхээр 2 дахин энэ Монгол Улсын нүүрсний борлуулалт нэмэгдэхээр байна лээ. Тэрийг газар дээр нь очоод харсан.

2 дугаарт гэвэл энэ нэмэгдсэнээрээ дахиад нөгөө талдаа ажиллах хүчин, дахиад дараа дараагийн төслүүд гацахгүй явах энэ боломж бүрдэх юм байна. Ажлын хэсэг нийт 59 удаа хуралдсан гэсэн шүү дээ. 59 удаа гараанаасаа гардаг. Тэгээд л яг эхлэлээсээ бүх юмаа яриад л, эцсийн цэгтээ хүрэхийн өмнө засаг солигдоод ч юм уу, сайд солигдоод ч юм уу ямар нэгэн шалтгаанаар буцаад резин нь харвачихдаг. Ингээд 60 дахь удаагаа болж байна. Монголынхон ч залхаж байна, Хятадын тал ч залхаж байна. Тийм болохоор энэ ажлаа яг нэгэнт л энэ чинь бид тангараг өргөхдөө хэлсэн шүү дээ. Улсын эрх ашиг 1 дүгээрт байна, хувь хүний эрх ашиг хамаагүй. Тэгэхээр улсынхаа эрх ашгийг бодоод энэ удаа бүгдээрээ энийг дэмжээсэй гэж хүсэж байна.

Судалгаагүй эсвэл хүний үгээр хэлж байгаа юм биш, өөрөө очиж үзсэний хувьд. Тэгээд энэ ажил явснаараа дараа дараагийн төслүүд явна. Энэ дээр улс төржилтөөс айгаад, эсвэл хэвлэл мэдээлэл, гаднын ямар нэг тийм юмнаас айж ингэж хойшоо суух ерөөсөө хэрэггүй гэж бодож байна. Бүгдээрээ тангаргаа өргөсөн, бүгдээрээ энийг хийх гэж орж ирсэн. Энэ 126 энэ олон төслүүдийг явуулах хэрэгтэй шүү дээ. Явуулж байж улс орон маань өөрөө, газар доор байгаа баялаг бол баялаг биш, энэ бол нөөц. Газар доор байгаа тэр баялгийг чинь гаргаад, экспортод гаргаж байж, эцсийн бүтээгдэхүүн болгож байж, тэр нь баялаг болдог. Тийм болохоор би яг энэ өнөөдрийн орж ирж байгаа асуудал дээр ерөөсөө маш их бусад гишүүддээ ч хэлмээр байна. Улс төржилтөө нэг удаа хаяад, яг энэ урдах бүтээн байгуулалтаа бодоод энэ асуудлыг дэмжээд өгөөрэй гэж хэлж байна.

Тэгээд яах вэ ажлын хэсгээс асуухад зарим хүмүүсийн хувьд мэдэхгүй байгаа нэг асуудал байгаа. Тэр нь үнийг яах юм бэ? Үнийг 16 жилийн турш нэг үнэ дээр барих юм уу эсвэл энэ нь зах зээлийнхээ зарчмаар өсөж, уруудаад ингэж явах юм уу гэдэг дээр зарим гишүүд, зарим ард түмэн ч гэсэн ойлголтгүй байгаа. Түүн дээр яг хариулаад өгөөч, үнийн хувьд яаж явах юм бэ? Энэ 16 жилийн турш нэг үнээрээ явах юм уу эсвэл хэлбэлзээд явах юм уу гэдгийг хариулаад өгөөрэй. Тэгээд сүүлд нь хэлэхэд зарчмын хувьд 100 хувь дэмжиж байгаа.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Үнэтэй холбоотой асуудал энэ 60 удаагийн уулзалтын нэлээн төвөгтэй, шийдэхэд төвөгтэй байсан ийм асуудлуудын нэг яах аргагүй мөн. Энэ 16 жилийн хугацаанд нэг үнээр байхгүй, үнийг Эрдэнэс Тавантолгой компанийн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн өмчит болон компаниудад борлуулж байгаа одоогийн борлуулж байгаа үнийг жишиг болгож барьж явъя гэдэг ийм зүйл дээр 2 талын ажлын хэсэг тохирч байгаа. Тэгээд үнэ бол улирал тутамд солигдоод явах ийм үнэ гэдгийг хэлье. Дээрээс нь энэ бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 5 боомтын нүүрсний борлуулалтын үнийн индексүүдийг тодорхой хувиар аваад суурь үнэдээ нэмж оруулаад ингээд тогтдог үнэ байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Баясгалан гишүүнээ болчхов уу? Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Гашуунсухайт-Ганцмодны хил холболтын төмөр зам, мөн уран Засгийн газраас өргөн барьсан нийтдээ 14 мега төслийг бүгдийг нь зарчмын хувьд 100 хувь дэмжиж байгаа. Бид нүүрс үнс болоогүй, цаашид үнс болохгүй гэдгийг ч бас өнөөдөр харлаа. 10 гаруй жил гацаж байгаад нь энэ хэрэгжсэн төмөр зам үндсэндээ яагаад гацсан бэ гэхээр Тавантолгой бүлэг ордыг нэг компани авах уу, Монгол Улс өөрөө эзэмших үү гэдэг гацалт шүү дээ. Өргөн, нарийндаа ч биш, үндсэндээ нэг компанийн эрх ашиг улсын эрх ашгаас өндөр байсан гэсэн үг. Тийм учраас энэ төслүүд гацсан юм. Бүхэл бүтэн 14 жилийн хугацаанд эхлээд Тавантолгойн бүлэг ордыг нь авах гэж үзээд чадаагүй, дараа нь экспортын төмөр замыг нь авах гэж үзээд чадаагүй байхгүй юу. Тэгээд улс авч үлдсэн учраас өнөөдөр бид энэ гэрээ яригдаж байна. Цаашдаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтууд ярьж байна.

Ирэх жилүүдэд Хятадын үл хөдлөх хөрөнгийн сэргэлт, мөн эрчим хүчний эрэлт, хэрэгцээ нэмэгдэж байгаатай холбогдуулан нүүрсний салбар байнгын өсөлттэй байна. Тэгэхээр бид энэ эрин үеийг заавал ашиглах ёстой. Нэн даруй энийг хэрэгжүүлэх ёстой. 2000 хэрвээ энэ Гашуунсухайт-Ганцмодны боомтод холбогдох юм бол 2030 он гэхэд манай улс зөвхөн төмөр замаараа 80 сая тонн экспортлох ийм боломж бүрдэж байгаа шүү дээ. Одоогоос яг 10 жилийн өмнө Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд үгэн дундаа дурдаж байна лээ. Дундын зуучлагчаар энэ ордыг чинь авах гэж үзсэн шүү дээ. Дараа нь төмөр замыг нь бас авах гэж үзсэн. Энэ бол бодитой.

Өнөөдөр улсад үлдсэн учраас бид маш олон асуудлыг шийдэж байгаа. Энэ Тавантолгой бүлэг орд Эрдэнэс Тавантолгой дээр байгаа учраас өнөөдөр улсын төсвийн 30 хувийг бүрдүүлж байгаа юм. Зөвхөн нүүрсний экспортоор. Иргэн бүрд 1072 хувьцаа эзэмших ноогдол ашгийг өгч байгаа юм. Баялгийг иргэн бүрд хүртээх Баялгийн санг бий болгох нөхцөл байдал бүрдэж байгаа юм. Өнгөрсөн хугацаанд 18 их наяд төгрөг улсын төсөвт ямар нэгэн байдлаар зөвхөн энэ ордоос үүссэн. Хэрвээ экспортын төмөр зам, энэ бүлэг орд хувийн компанид байсан бол бид нарт ийм боломж байхгүй.

Ковидын үеийн нөхцөл байдлыг ямар компанийн орлого, ямар компанийн үйл ажиллагаагаар бид эрсдэл багатай даван туулсныг санах хэрэгтэй. Хэрвээ энийг хувийн компани авчихсан байсан бол ийм боломж бид нарт байхгүй байх байсан. Үр дүнд нь юу болсон бэ гэхээр 2020-оос 2023 онд нийтдээ гуравхан жилийн хугацаанд Монголчууд 800км орчим төмөр зам үндэсний сүлжээ бий болгочихсон байхгүй юу. Энэ компанийн чинь орлогоор. Тийм учраас хил холболтын төмөр замыг ярьж байгаа юм. Хэрвээ 2020-оос 2023 оны хугацаанд энэ 800км орчим үндэсний төмөр замын сүлжээгээ хийж чадаагүй байсан бол бид хил холболтын төмөр замыг дахиад 5 жилийн дараа ярих байсан юм. Тийм болохоор ер нь ахиж Улсын Их Хуралд Монголын иргэдийн нийт, Монгол Улсад байгаа иргэдийн нийтийн өмч хөрөнгийг аль нэг компани авах гэсэн ийм санаархал, ийм улс төрийн явуулга ахиж битгий орж ирээсэй.

Тэгээд үүнийгээ булзааруулахын тулд зөвхөн царигийн маргаан болгодог. Яг бодитоор энэ чинь Тавантолгойн ордыг авах уу, төрд үлдээх үү гэдэг л маргаан байсан шүү дээ. Тэгээд тэрэнд нь ингээд манай Их Хурлын гишүүд хүртэл

итгэчихсэн. Үр дүнд нь юу болсон бэ гэхээр одоо бид үндэсний төмөр замын сүлжээтэй болсон, гуравхан жилийн дотор өөрсдөө 800км орчим төмөр зам барьж чаддаг болсон. Одоо ганцхан хил холболтын л төмөр зам байгаа. Тэгэхээр энэ төсөл заавал явах хэрэгтэй. Тэгээд цааш цаашдаа ингээд улс төржсөн байдлаар асуулт асуух эсвэл улс төржсөн байдлаар энэ том төслүүдийг ярьдаг байх үнэхээр зохимжгүй шүү. Тийм учраас энийг хэлье гэж бодсон юм.

Тэгээд эцэст нь надад ганц асуулт байна. Энэ хэрвээ төсөл хэрэгжээд ингээд явахад мэдээж гэрээний дагуу хоорондоо таарч тохирохгүй юмнууд байна. Ингээд ямар нэгэн байдлаар тодорхой хэмжээнд маргаан үүсвэл аль улсын арбитраар шийдэх вэ? Энэ талаар надад хариулт өгөөч Туваан сайдаа.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Маргааныг арбитрын зарчмаар шийднэ. Манай хэлэлцээр дээр бол Сингапурын Арбитрын шүүх гэсэн ийм төсөлтэй явж байгаа.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Тавантолгойн хил холболтын цэг гээд олон жил гацсан. Манай худалдаа, эдийн засгийн хамгийн том хөрштэйгөө хийх гэж байгаа ахиц дэвшил гарах гэж байгаа ийм утга учиртай Улсын Их Хурлын тогтоол орж ирж байна гэж үзэж байгаа. Ийм ч учраас Ардчилсан намын бүлгийн хувьд зарчмын хувьд үзэл баримтлалынх нь түвшинд дэмжих нь зүйтэй гэдэг шийдвэр гаргаад явж байгааг хэлье. Мэдээж үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа ч гэсэн цааш цаашид нь дотоодод нь үр ашгийн талаасаа олон, олон зүйлийг бид хэлэлцэх, ярилцах шаардлагатай болж таарна мэдээж. Тэгээд энэ дээр 2, 3 асуулт байгаад байгаа юм. Мэдээж энэ дээр алдагдсан боломжийн тухай яриа энэ дээр өнгөрсөн 10 гаруй жилийн асуудал юм чинь алдагдсан боломж, бас айлын талд хохирол гарсан олон, олон зүйлүүд яригддаг, мөнгөн дүн нь бүхий. Тэгэхээр энэ дээр нэг тооцооллыг нэг урьдчилсан байдлаар, хэдийгээр энэ чиглэл өгч байгаа тогтоол явж байгаа ч гэсэн энэ дээр тооцооллыг эдийн засгийн тооцооллын хэлж өгөөч.

Миний ойлгож байгаагаар 2,1 тэрбум юанийн алдагдал гэж хэлж болох мөнгөн дүн Хятадын талаас яригддаг. Нэмэлт 4 тэрбум юанийн дахиад шинээр зардал гарах тухай яригддаг. Энэ ингээд энэ дүнтэй нэг ийм тэрбум гаруй доллар орчимд яригдах алдагдсан боломж болоод нэмэлт зардал байх юм байна. Нөгөө талд нь 250, 260-аад тонн нүүрсийг олон жилийн хугацаанд тодорхой хэмжээний хөнгөлөлттэй үнээр өгөх энэ дүн чинь өөрөө бага биш дүн болж хувирдаг. Мэдээж цаг хугацааны үнэ цэн гэж мөнгөнд бий. Энийг өнөөгийн үнэ цэнээр магадгүй тооцоод ингээд харьцуулбал энэ маань өөрөө ямар хэмжээний эдийн засгийн тэр баланс тэнцвэр нь маань юу болж байна вэ? 250 сая тонныг Чалкогийн үнээр гэхээр тодорхой хэмжээний бараг 30-аад долларын магадгүй хямдралын асуудал урт хугацаандаа яригдах юм байна лээ. Энэ дээр төлбөрийн нөхцөл, төлбөрийг урьдчилж авах энэ тэрүүд дээр тодорхой хэмжээний ямар тодорхой тийм шийдлүүд энэ дээр яригдаж байгаа вэ? Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хэмжээний тийм эдийн засгийн тооцоолол талаасаа нэг мэдээлэл өгөөч.

2 дугаарт нь ер нь манай Тавантолгойн ордын 1 тонн нүүрснийх нь өөрийнх нь өртөг ямар байдаг юм бэ? Урт хугацаанд бид 10, 20 жилээр ингээд хатуу гэрээ биржийн үнээр гээд гэрээ хийчихдэг. Манай өртөг зардлаас магадгүй урт хугацаанд

тодорхой хэмжээгээр үнэ өртөг доошоо ороод ирж байсан тохиолдол ч 10 жилийн өмнө байгаа шүү дээ. Чалкотой хийсэн гэрээнд тухайн үед чинь 30 долларын өртөгтэй 27-гоор ч билүү зарж байсан гээд л гардаг. Манайх энэ гэрээг яг энэ чигээрээ явсан чинь магадгүй маргааш зах зээл ер нь, нөгөөдөр зах зээл юу болохыг бид тааварлашгүй. Тэгэхээр энэ дээр тэр гэрээ дээр тодорхой хэмжээний Улсын Их Хурлын тогтоол дээр ч юм уу шал үнийг, доод үнийг тогтоож өгөх тийм хэрэгцээ шаардлага ер нь байгаа юу? Энэ дээр яг цаашид гэрээ хэлэлцээр хийх хүмүүс энэ дээр нэг тодорхой байр сууриуд, анхны мэдээллүүдээсээ өгөөч?

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье. Нэмж Эрдэнэс Тавантолгойгоос өөрийн өртөгтэй холбоотой асуудлаар нэмэлт хариулт өгнө.

Ц.Туваан: Цогтгэрэл даргын асуултад хариулъя. Мэдээж энэ төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын эдийн засагт томоохон өөрчлөлт орж ирнэ. Бид ДНБ-ээ 2 дахин нэмэх, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнээ 10 мянган ам.доллар-оос давуулах гэсэн энэ зорилтод хүрэхэд энэ Гашуунсухайт-Ганцмодны төмөр замын хил холболт хамгийн чухал нөлөө үзүүлнэ. Мөн энэ дээр шууд энэ төмөр зам явсны дараа дараагийн төмөр замын хил холболтуудыг үе шаттайгаар холбоно. Мөн урд хөрштэйгөө хийх хамтран хэрэгжүүлэх маш том төслүүд дээр ахиц гарснаар үр ашгийн хувьд маш том ашигтай гэдгийг хэлье.

2-т гэрээ хэлэлцээр учраас 2 талаас саналуудаа тавиад, тэгээд харилцан тохиролцсон зүйлүүд дээрээ ингээд нэгтгээд хэлэлцээр гэрээ болгоод явж байгаа гэдгийг хэлье. Хятадын талаас энэ Эрдэнэс Тавантолгой компанийн ямар нэгэн хувь, Эрдэнэс Тавантолгой эзэмшиж байгаа лицензийг эзэмших гэдэг энэ саналыг дахиж тавихгүй. Мөн алдагдсан боломжийн өртгийг дахиж нэхэх асуудлыг гаргахгүй. Мөн энэ дээрээс өргөн, нарийн царигийн асуудал дахиж яригдахгүй гэсэн ийм буултуудыг хийж байгаа.

Үнийн хувьд мэдээж Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн өмчит компаниудтай одоо Тавантолгойн нүүрсээ зарж байгаа үнэ байгаа. Тэгээд энэ үнийн аргачлалыг жишиг болгож өгөөч гэдэг асуудлыг тавьж байгаа. Тэгэхээр энэ үнэ дээр бол хүмүүс нэг буруу зүйл ойлгоод байгаа нь энэ үнэ бол амны үнэ, биржийн үнэ 2-ыг их хол зөрөөтэй байна гэж хараад байгаа юм. Яг яс юман дээр биржийн үнэ манай Уул уурхайн биржийн тухай хуулиар борлуулагдаад хил хүртэл хүргэх энэ тээврийн зардал орсон үнэ байдаг. Тэр Чалко компанийн үнэ гэдэг үнэ бол амны үнэ байгаа. Тэгэхээр энэ дээр хол зөрөөтэй ингэж харагдаж байгаа байдал нь бол ийм байгаа юм. Дээрээс нь энэ манай өнөөдрийн нүүрсний өртөг бол Эрдэнэс Тавантолгой компанийн нэг метр³ нүүрс олборлолтын өртөг нь 14 мянган төгрөг байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Тэгэхээр саяын хариултаас тэр улс төрийн ач холбогдлыг угаасаа ойлгож байна л даа. Ойлгож байгаа учраас нэлээн олон гишүүд дэмжиж байгаа байх гэж бодож байна. Улс төрийн талаасаа, дараа дараагийн төслүүд, ирээдүйн боломж дээр давуу талууд гарч байгааг бүгдээрээ ойлгож байгаа. Яг энэ төсөл дээр жишээ нь тэр нэг алдагдсан боломжийг нэхэхгүй энэ тэр гэдэг бол жаахан хийсвэр заалт харагдаж байна лээ. Хийсвэр гэдэг нь ирээдүйд 10 хэдэн жил 20 сая тонноор нүүрс хөнгөлөлттэй үнээр авна гэдэг чинь энэ алдагдсан боломжийн төлбөр л энд явж байгаа шүү дээ. Энэний цаана ямар эдийн засгийн тооцоо байгаа

вэ гэдэг асуултыг би уг нь асуугаад байна л даа. Тоотойгоор, өнөөгийн үнэ цэн дээр, ирээдүйн үнэ цэн дээр нь авчирч байгаад тэр discount... гэдэг зүйлийг нь тооцож байгаад яг ийм учраас энэ бол тийм харилцан ашигтай юм, боломжийн юм, яагаад гэвэл гэдэг тоо энд уг нь хэрэгтэй байгаад байгаа байхгүй юу. Түүнээс улс төрийн ач холбогдол, олон улсын харилцааны ач холбогдлыг бүгдээрээ ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд гүйцээж хариулъя.

Ц.Туваан: Энэ дээр 2025-аас 29 оны хооронд 5 жилийн хугацаанд 27 сая тонн нүүрсийг худалдахаар явж байгаа. 30 оноос эхлээд жил болгон 20 сая тонн нүүрс худалдах асуудал яригдаж байгаа. Тэгээд экспортын орлого энэ эхний 5 жилдээ бол жил болгон ойролцоогоор 2,5 тэрбум доллароор нэмэгдэнэ. 2030 оноос эхлээд 11 тэрбум доллароос дээш хэмжээгээр нэмэгдээд явна. Эдийн засагт үзүүлэх нөлөө бол энэ эхний 5 жилд 1,1-ээс 1,2 нэгж хувиар өсөхөөр, 2030 оноос хойш бол мөн үүнийг даблдсан байдлаар өсөх ийм тооцоолол байгаа.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Бид өнөөдөр төр гэж ард түмний сонгуулиар гарч ирчхээд, ард түмний баялгийн талаар бид шийдвэр гаргах гээд байж байна. Тэгээд мэдээллийг ард иргэдэд давхар өгөх ёстой. Тэгээд түрүүнээс хойш миний эхний, би 3 асуулттай. Эхний асуулт Ардын намын зарим нөхдүүд маань гаслаад л байна. Нарийн цариг, бүдүүн цариг, өргөн цариг гэсээр байгаад л хайран алдагдсан боломж гээд гаслаад байна. Энэ дээр дахиж ийм царигийн тухай яриа хийхгүйн тулд би энэ асуултад хариулж байгаа Туваан сайдаа, Баасандорж даргаа 12-оос 16 онд би Улсын Их Хурлын гишүүн байсан, бие даагч байсан. Гашуунсухайт, Хангийн замыг нарийнаар баталсан. Ардчилсан нам олонх байсан, үндсэн зам болохыг өргөнөөр байсан ийм тогтоол шийдвэр гарсан.

Дараа нь 16-аас 20 онд Ардын нам үнэмлэхүй олонх байхад Цэцээр энэ нарийныг өргөн болгоё гэж Гашуунсухайт, Ханги шүү. Одоо би бүр хоёуланг нь хэлж байна. Өргөн болгоё гэж Цэцээр дүгнэлт гаргаад, Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлаар орж ирэхэд үг дуугүй бүгдийг нь хүлээж авсан. Өнөөдөр цаас харж бид асуудлыг ярих ёстой. Өнөөдөр яг энэ цаасыг 126 гишүүдэд бүгдэд нь өгөх ёстой. Би өнөөдөр яагаад та нар бүдүүнийг хүлээгээд авчихсан юм бэ гэж асуухаасаа илүү зүгээр л баримттай байя, мэдээлэлтэй байя, дахиж ийм тулга тойрсон юмаа ярихаа больё гэдгийг 1 дүгээрт хэлж байна. Миний асуулт энэ шийдвэрүүдийг тодорхой болгож, гишүүдэд материал тараах ёстой боломж байна уу?

2 дугаар зүйл одоо бол Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдыг бид ойлгох ёстой. Ёстой нөгөө ухна ишигний зовлон мэдэхгүй гэдэг шиг бид чинь ачаагаа үүрүүлчхээд л, нүүрс зараарай, цалин, тэтгэврээ нэммээр байна шүү, ажлын байртай болгомоор байна, гал алдуулав гээд л шахаад байдаг. Очоод л Засгийн газар очоод л янз бүрийн хэлэлцээрт ордог, шахалтад ордог, зовлон зүдгүүр байгаа. Бид энийг ойлгож, мэдэрч авахаас өөр аргагүй. Тэгэхээр энэ асуудал дээр миний 2 дугаар асуулт бол Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн 4 дүгээр зүйл, энэ тогтоолын энэ баримтлах үндсэн чиглэл батлах тухай энэ тогтоолын 4 дүгээр зүйл дээр Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн багтаамж, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний үнийг тогтоохдоо Эрдэнэс Тавантолгой компанийн урт хугацаатай байгуулсан гэрээний нөхцөл үнийн аргачлалыг жишиг болгож, гэрээний хугацааг 16

жилээр тогтоно гэж байгаа. Үүнийг ард түмэнд ил тодоор яг ямар нөхцөлтэй юм бэ, ямар аргачлалтай юм бэ гэдгийг энийг дэлгэрэнгүй Туваан сайд хэлж өгнө үү. Бөөрөнхийлөхгүйгээр яг ийм аргачлалтай, ийм үнэтэй. Энийг тодорхой байхгүйгээр зүгээр бөөрөнхийлөөд яриад байвал энэний цаана хардлага байдаг. Энэний цаана гацаа тээг үүсдэг.

3 дугаар асуулт. Хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг байгуулахад өргөн, нарийн царигийн тухай дахиж ярихгүй гэж хэлж байна. Яг яаж ярихгүй гэж байгаа юм бэ, миний түрүүний арга зөв үү? Тэр талаар яригдсан, үл ойлголцсон юмнуудаа бүгдийг нь тараагаад, тэр нь буруутай, энэ нь зөвтэй гэдгээ нэг тогтоод, тэгээд мартъя. Энэ тулга тойрсон би зөв, тэр буруу гэдэг юмаа одоо больё. Констрактив байх ёстой шүү дээ бид. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх би 9 дүгээр зүйлийг асууж байна шүү. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх Ганцмод боомт хүртэл баригдсан төмөр замын бүтээн байгуулалттай холбогдуулан өнгөрсөн хугацаанд Хятадын талд гарсан аливаа алдагдал, хохирол болон төмөр замын хил холболтод шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг ирээдүйд нэхэмжлүүлэхгүй байх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

С.Ганбаатар: Энэ дээр Монголын талаас маш их олон буулт хийж, энэ асуудлаа явуулъя, энэ нүүрсээ гаргая, энэ олон жил гацсан зүйлүүдээ явуулъя гэдэг дээр буулт хийж, одоо энэ fixation гэж ярьж байгаа шүү дээ. Үнийн энэ хөлдөөлтийг, энэ үнийг тогтворжуулж байгаа явдал бол зах зээлээс гадуур бид маш их олон алдагдалд орох магадлалтай. Энэ зүйлүүд дээр бид өнөөдөр эрсдэлээ өөрсдөө даагаад энэ асуудлуудаа бид ингэж хариуцлагатай байгаа гэдгээ бичих ёстой гэсэн ийм боломж байгаа юу? 3 дахь асуулт.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Ганбаатар гишүүний 2, 3 дугаар асуудал дээр хариулт өгье. Төмөр замтай холбоотой асуудал дээр Дэлгэрсайхан сайд хариулт өгчих байх. Үнийн аргачлалд бол энэ өнөөдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Чалко, Норинко зэрэг компаниудад 4 компанид Эрдэнэс Тавантолгой компани нүүрсээ борлуулж байгаа. Тэгээд энэ Чайна Энержи компанийнхан энэ үнийн аргачлалыг баримталж, бусад компаниудад борлуулж байгаа үнээр манайд борлуулаач гэдэг шаардлага, санал тавьж байгаа. Тэгэхээр энэ үнийн аргачлал гэдэг нь өөрөө суурь үнэ дээр нэмэх нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 5 хилийн боомтын нүүрсний борлуулалтын үнүүдийг тодорхой процентуудаар 30 хувь, 20 хувь, 10 хувь, 10 хувь гээд ингээд процентолж оруулаад, тэгээд дундаж дундчилж гаргадаг ийм үнэ байгаа. Тэгээд энэ үнэ өөрөө тогтмол үнэ биш, 3 сар тутамд хөдөлдөг ийм үнэ байгаа гэдгийг хэлье.

Дээрээс нь түрүүн би хэлсэн. Тэр хүмүүсийн буруу ойлгоод байгаа үнэ дээр амны үнэ хил үнэ 2-ын хоорондын тээврийн зардалтай, зардалгүй үнийн хооронд маш их зөрөөтэй байгаа юм шиг ийм буруу, ташаа ойлголт байгаад байдаг юм. Тэгэхээр манай Уул уурхайн биржийн тухай хуулийн дагуу зарж байгаа нүүрсийг, борлуулж байгаа нүүрсийг бид хил хүртэл хүргэж өгдөг энэ үнэ бол тэр зарлагдаж байгаа үнэ дотор байгаа үнэ юм гэдгийг хэлье.

Царигийн асуудлыг бид оруулж ирсэн энэ дээр заалт. Тэгээд энэ бол дахиж энэ талын асуудлыг шийдэхгүй ярихгүйгээр ингээд цэглэнэ гэсэн таны энэ ойлголттой нэг байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд төмөр замтай холбоотой асуудлаар хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Ганбаатар гишүүнийхээ асуултад хариулъя. Бид бол урд хөрштэй төмөр замын нарийн, өргөн цариг гэж таны хэлдгээр олон жил маргасан. Тэгэхдээ энэ асуудал дээр удаан хугацаанд ярилцсаны эцэст харилцан тохиролцож чадсан. Олон улсын төмөр замын баримталдаг жишгээр манай өргөн цариг Ганцмодны боомт руу орж ачаагаа буулгана. Бид өөрөөр хэлбэл уурхайгаас шууд задгай вагоноор ачаад, Ганцмодны боомт руу оруулаад, тэнд тэдний өнөөдөр барьчихсан байгаа терминал дээр шууд задгай вагоноо хөмрөх маягаар ингэж буулгалт хийнэ.

Нарийн царигаар наашаа орж ирж байгаа урд хөршийн зам дээрээс бол чингэлгээр нүүрсээ ачна. Ийм маягаар ачихад бид өргөн царигаар гаргаж байгаа, задгай вагоноор гаргаж байгаа ачааны хэмжээ 10 сая тонн, нарийн царигаар чингэлэгтэй гаргаж байгаа ачааны хэмжээ 20 сая тонн байхаар тооцож ингээд 2 талын төмөр замаа харилцан тохиролцож, ямар нэгэн маргаангүй 2 талын төмөр замынхаа царигийг хүндэтгэлтэйгээр хандана гэдэгтэй санал нийлсэн учраас энэ дээр дахиж энэ оруулж ирж байгаа энэ зүйл, заалтын нэгд 8 дугаарх байхдаа ямар нэгэн царигийн маргаан дахиж гарахгүй гэдэг зүйл байгаа гэдгийг давтан хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууна.

О.Батнайрамдал: Баярлалаа. Тэгэхээр маш удаан хүлээсэн нэг түүхэн тогтоол орж ирж байна гэж харж байгаа юм. Надад маш ойлгомжтой 3 асуулт байгаа юм. Эхний 2 асуултыг би Ерөнхий сайдаас асуумаар байна. Ер нь Монгол Улсын эдийн засгийн сүүлийн 30 жилийн эдийн засаг, улс төрийг аваад үзвэл тогтворгүй байсан, эдийн засгийн маш том алдагдсан боломж ирж байна. Дандаа хэдэн мега төслөө л тойрч ирсэн. Өнөөдөр бид төмөр зам ирж байна. Ганцхан төмөр зам байгаагүй. 40 жил Монгол Улсыг тэжээж ирсэн Эрдэнэтээс эхэлж байсан. Эрдэнэтийн 49-өөс эхэлнэ. Оюу толгойн маргаан байна. Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэс Тавантолгойг дагаж ирсэн далд эдийн засаг. Гэхдээ маш том тайлбарууд байсан. Хятад, Орос, геополитик. Яг бодит амьдрал дээрээ дандаа хөндлөнгийн оролцоо мөнгөний сонирхол байсан. Ерөөсөө мөнгөний сонирхол шүү.

Тэгэхээр энэ Улсын Их Хурлын тогтоол дээр 1 дүгээрт дөрөвхөн үгээр тодорхойлсон боловч магадгүй хамгийн чухал нэг зүйл байгаа юм. Энэхүү гэрээг хийхэд гуравдагч талын оролцоогүйгээр хэрэгжүүлнэ. Магадгүй гацаж ирсэн хамгийн том шалтгаан нь энэ. Дөрөвхөн үгээр тодорхойлсон боловч энийг Ерөнхий сайд маш тодорхой хэлж өгмөөр байна. Гуравдагч талын оролцоогүй гэж бид яг юу гэж ойлгох юм бэ? Энийг маш олон хүмүүс үзэж байгаа. Гацааж ирсэн гол шалтгаан.

2 дугаарт төмөр зам ашиглалтад орсноороо мэдээж уул уурхайн салбар дээр энэ дараагийн түвшинд гаргах маш том тээвэрлэлтийн асуудал. Өнөөдөр бид төмөр замгүйгээр яг 19-ний, 12 сарын 19-ний байдлаар 81,7 сая тонн нүүрс гаргачихсан байгаа юм. Энэ төмөр замгүйгээр. Энэнээс цаашаага бид дахиад 10, 20-оор нэмье

гэвэл ерөөсөө л төмөр замгүй бол бараг бид хоолойндоо хүрчихсэн гэсэн үг. Энэний эдийн засаг нь ерөөсөө маш ойлгомжтой энгийн. Өнөөдөр тээвэрлэлтдээ бид нэг машинд 30 доллар, тэгээд 1 тонн нүүрс тээвэрлэхэд 30 доллар байна. Оргил үедээ 100 доллар хүрч байсан шүү. Энийг төмөр зам ашиглалтад орвол бид 8 доллар болгож буулгана. Энэний эдийн засгийн үр өгөөж нь хэнд ч гэсэн ойлгомжтой.

Энэ тогтоолыг ганцхан Гашуунсухайт гэж харахгүй байгаа юм л даа. Энэ тогтоолын 10 дээр нь цаашдаа Шивээхүрэн-Сэхээ, Хангимандал-Бичигт, Зүүнхатавч зэрэг боомтууд холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх тохиролцоонд хүрнэ гээд. Нэг ёсондоо ерөөсөө ганцхан Гашуунсухайт биш Монгол Улс Хятадтай төмөр замаар холбогдох уу, үгүй юү гэдгийг шийдэх тогтоол гарах гээд байна л даа. Тэгэхээр энэ дээр маш ойлгомжтой гэрээ дээрээ тусгах уу? Бид Шивээхүрэн, Хангимандал, Бичигтийг яг хэдэн сарын хэдэнд холбохоор Хятадтай тохирох вэ? Магадгүй Хятадтай бид энэ анх, энэ том хэлэлцээр хийхэд түүн дээрээ маш ойлгомжтой цаг хугацаа зоож өгөх үү гэж асуумаар байгаа юм. Яагаад гэхээр энэ Гашуунсухайт-Ганцмодны боомтын хил холболт явснаараа бусад төмөр замын хил холболтууд явна. Гэхдээ энэ нь өдөр тутам бид алдах тусам алдагдсан боломжийн өртөг бид зөндөө олон ярилаа. Дахиад л эд нар алдагдсан боломжийн өртөг бусад хилийн боомт дээр яригдана гэсэн үг юм.

3 дахь асуултыг би магадгүй Жавхлан сайд хариулах байх. Энэ дээр бид ам үнэ гээд л олон юм ярьж байна л даа. Ам үнэ гэрээгээрээ тохирох байх. Гэхдээ төсөвт бид ам үнээс эсвэл тэр үнээс Амнат тооцогдох юм. Тэгэхээр бид тэгвэл төсөв дээр ирэх тэр Амнатыг тэгвэл ямар үнээс тооцно гэж харж байгаа юм бэ? Яг төсөв дээр буцаад Амнат л яригдана шүү дээ. Тэгэхээр ийм 3 асуултыг асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Борхүүгийн Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Тэгээд сая өөрөө ярилаа. Ер нь төмөр зам ингээд 2 талдаа холбогдсоноороо энэ тээврийн зардлын үнэ үнэхээр өөрийн чинь хэлж байгаагаар бууна. Ингэснээрээ нөгөө тээврийн зардал энэ өнгөрсөн цаг хугацаанд машинаар тээвэрлэж байсан. Өөрөөр хэлбэл ихэнх нүүрсний үнэ нь өөрөө машиныхаа тээврийн өртөг зардал шингээд ингээд тээврийн бизнес болж байсан тэр цаг үе бол тодорхой хэмжээгээр ард үлдэж, үнэндээ өөрийн чинь хэлдгээр энэ үр ашиг бол Монголдоо үлдэнэ. Тийм учраас, тэгэхдээ бид ганц энэ юугаар галт тэргээр нүүрсээ вагоноор зөөгөөд байх биш, хажуугаар нь энэ машинаар тээвэрлэх аль болохоор нүүрсээ түлхүү гаргах дээр хамт ингэж явна гэдгийг энэ ташрамд хэлье.

Тэгээд нийлээд энэ төмөр зам ашиглалтад орсноороо өнөөдрийн машинаар гарч байгаа нүүрсний хэмжээ дээр төмөр замаар гарах нүүрсний хэмжээ дахиж нэмэгдэх юм 1 дүгээрт. 2 дугаарт энэ төмөр зам бол ганцхан Чайна Энержи компани ашиглахгүй, тэгш эрхтэйгээр адил тэнцүү ашиглана гэдгээ бол бид энэ 3 гэрээгээ хийхдээ эндээ бол нарийн зааж өгнө гэдгийг харилцан тохирсон байгаа гэдгийг энэ ташрамд хэлье.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулт өгье.

Ц.Туваан: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Энэ бид Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах чиглэлийнхээ хүрээ хязгаарыг үндсэн чиглэлээ авах ийм Улсын Их Хурлын тогтоол. Энэ тогтоолын 1 дүгээрт нь энэ таны

асуусан гуравдагч талын оролцоогүйгээр гэж энэ бол шууд 2 улсын Засгийн газар хоорондоо шууд хийх гэдэг утга агуулга. Ямар нэгэн дундын зуучлагч этгээд юм уу, ямар нэгэн компани энэ тэр орохгүйгээр хийнэ гэсэн санааг л энд оруулж өгсөн.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ гэрээ дээр Амнаттай холбоотой ямар нэг зөрөө ерөөсөө огт гарахгүй. Хэдийгээр амны үнээр зарагдаж байгаа боловч Амнатыг бид жишиг үнээр тооцож авна. Хэрвээ биржээр явбал биржийн үнээр авдаг, биржийн үнэ жишиг үнэ 2-ын хувьд зөрөөтэй, биржийн үнэ арай бага байдаг. Өөрөөр хэлбэл аль болох биржээр арилжаалсны урамшуулал нь тэр зөрөөнөөс явдаг гэсэн үг. Харин энэ гэрээ дээр бол бид арай өндөр жишиг үнээс авна. Жишиг үнийг сар болгон Засгийн газраас байгуулсан ажлын хэсэг Уул уурхайн сайд, Сангийн сайдын хамтарсан 2 яамны хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг сар бүр зарлаад явдаг байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

О.Батнайрамдал: Тэгэхээр гуравдагч талын оролцоо энийг мэдээж тогтоол дээр ингээд гарах байх. Гэхдээ гэрээ дээрээ маш ойлгомжтой тусгаж өгмөөр байна л даа. Дараа нь тэр гэрээнээс гадна дэд гэрээнүүд байгуулагдахад ямар нэгэн ашиг сонирхол дундуур нь орж ирж асуудал үүсэхгүй, энийг л хамгийн гол нь ойлгомжтой байгаад байгаа юм. Тэгэхээр ер нь 16 жил гацаж ирсэн гол шалтгаан нь өөрөө энэ учраас тэр гэрээ бүх юм жин тан ногоон гэрлээр явчихна гэж бол итгэхгүй л байгаад байна л даа. 16 жил, намайг бага байхад л энэ гэрээ яригдаж байсан, одоо хүртэл ингээд л яригдаж байгаа юм.

2 дугаарт энэ гэрээгээр ашиглаад бусад төмөр замууд ашиглалтад орох хугацаагаа Хятадын талтай маш ойлгомжтой цаг хугацаагаар тохирчихмоор байна. Тэгж чадвал магадгүй бид нарт энэ бусад төмөр замууд орох тэр давуу тал үүснэ гэж хараад байна л даа. Зөвхөн Гашуунсухайт гэж битгий хараасай. Энийг Хятадтай бүх холбох төмөр замын цогц гэрээ хэлэлцээр хийгдэнэ гэж нөгөө талаас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах уу? Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулт өгье. Учрал.

Ц.Туваан: Энэ Улсын Их Хурлаар бид үндсэн чиглэлээ батлуулж аваад, энэ чиглэлийнхээ хүрээнд үүний дараа энэ чиглэл батлагдсаны дараа 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр хоорондоо Засгийн газар 2 талаасаа хийгээд, тэгээд энэ хэлэлцээрээ Улсын Их Хурлаар эцэслэн, соёрхон батлуулаад, тэгээд нөгөө компани аж ахуйн нэгж хоорондын гэрээнүүд дараалалтай ийм 3 дарааллаар орж ирнэ. Бид үндсэн чиглэлээ бариад өөр ямар нэгэн гуравдагч этгээдийг оруулахгүйгээр гэрээгээ хийгээд явна.

Төмөр зам дээр бид болж өгвөл шууд ингээд зэрэгцүүлээд юм уу, ингээд нээчихмээр байгаа. Маш хурдан хугацаанд. Ингэж байж нөгөө тээврийн болон эдийн засгийн ашиг Монголын талд орж ирнэ. Тэгэхдээ өмнөд хөршийн талаас баримталж байгаа бодлого дээр бол эхлээд Гашуунсухайт-Ганцмодны боомтоо ашиглалтад оруулах, энэ соёрхон батлах энэ хэлэлцээрээ хийчхээд, дараагийн

асуудлууд руу оръё гэсэн ийм саналыг тавьж байгаа. Тэгэхээр бид бүхэн энийгээ хурдан хийж эхлүүлээд л дараагийн асуудлууд руугаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Пүрэвийн Батчимэг асуулт асууна.

П.Батчимэг: Хамтарсан Засгийн газар өнөөдөр цаг үеэ олсон энэ түүхэн шийдвэр гаргах асуудлыг Их Хурлаар оруулж хэлэлцэж байгаад талархалтай байна. Тэгээд Гашуунсухайт-Ганцмод энэ хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын асуудал олон жил гацсан, гацаасан. Үе үеийн Засгийн газрын тэргүүн, тэгээд улс төрчид, аж ахуйн нэгжийн тийм хувиа бодсон, ийм унхиагүй байдлаас болж энэ 2003 онд анх яригдаж эхэлснээс хойш 10 гаруй жил энэ ажил бол үнэхээр урагшилсангүй л дээ. Тэгээд аливаа улс орны хөгжил бол тухайн орны дэд бүтэц, тэр дотроо авто зам, төмөр зам, эрчим хүч гээд эдгээр салбаруудын хөгжлөөр тодорхойлогддог. Үнэхээр хилийн цаана, наана 2 байгаа 2 тосгоны тэр байгаа байдал, хотын байгаа байдал үнэхээр өдөр, шөнө шиг тийм ялгаатай харагдаж байгаа.

Манай улсын хувьд эдийн засгийг урагшлуулах, эдийн засгийн өсөлт, багтаамж, эдийн засгийг нэмэгдүүлэх, иргэдийнхээ аж амьдралыг дээшлүүлэх энэ гол уул уурхайгаас хамааралтай эдийн засагтай улс орны хувьд өнөөдөр энэхүү бүтээн байгуулалтыг яалт ч үгүй хийх ийм гарцаагүй шаардлага үүссэн гэж би харж байгаа юм.

Гишүүд их оновчтой саналууд хэлж байгаа. Нэгэнт Хятад улс өнөөдөр түүхий нүүрс хэрэглэх эрэлт хэрэгцээ нь цагаас цагт, жилээс жилд буурч байгаа хандлага үнэхээр эх сурвалжаас харагдаж байгаа юм. Хэрвээ 2060, 2070 он үнэхээр энэ түүхий нүүрс энэ нийлүүлэлтийг ингээд багасгачих юм бол бид өнөөдөр ямар, бидэнд ямар гарц цаашид байх юм бэ? Өнөөдрийн энэ Гашуунсухайт-Ганцмод төмөр замын бүтээн байгуулалт, гүүрэн байгууламжаар дамжигдаж, хажуугаар нь авто зам, авто замын бүтээн байгуулалт, ачаа тээврийн эргэлтийн тэр терминал ингэж тэнд цогцоороо босож байгаа байдал бол үнэхээрийн манай улсын эдийн засагт том боломж, араас нь олон, олон боомтуудыг барьж байгуулах асуудал үе шаттайгаар явагдаж байгаа нь том хаалгыг нээлээ гэж би үзэж байна.

Тэгээд гацсан энэ төмөр зам Ганцмод, Гашуунсухайт-Ганцмодын төмөр замын энэ Засгийн газрын 2 улсын Засгийн газрын хэлэлцээр өнөөдөр үр дүнгээ өгч, Монгол Улсын эдийн засаг тодорхой хэмжээнд дээшилж, уул уурхайгаас орж ирэх ашиг орлого нэмэгдэж, иргэдийн амьдралд энэ манай улсын хөгжилд тодорхой ахиц дэвшил гарна. Харин нэг жилийн дараа, хагас жилийн дараа нэг ийм сул, унхиагүй, дахиад л нэг урагшлаагүй нэг иймэрхүү мэдээ тайлантай бид сонсож суумааргүй байна л даа. Тэгээд гишүүдийг энэ өнөөдрийн гарах шийдвэрийг дэмжих байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн алга байна. Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууна.

Г.Ганбаатар: Өнөөдөр манай энэ шинэ парламент, хамтарсан Засгийн газар 2 Монгол Улсын эдийн засагт их чухал нөлөөтэй шийдвэр гаргах гэж байна. Манай Улсын Их Хурал гэдэг байгууллага бол улс орны ирээдүйг зурж байдаг байгууллага. Тийм учраас аливаа ийм томоохон шийдвэр гаргахдаа бодитой мэдээлэл дээр тулгуурлаж гаргаж байвал шийдвэр зөв гарна. Улсын Их Хурлаас 20-иод гишүүн өнгөрсөн долоо хоногт яг энэ Ганцмод-Гашуунсухайтын боомт дээр ажилласан.

Тэгээд энэ боомт дээр ажиллаж байхад үнэхээрийн бид өнгөрсөн 16 жил маш их цаг хугацааг алдаж дээ гэсэн халаглал. Нөгөө талдаа хэн Цэцэд хандаад, Цэц яагаад тийм шийдвэр гаргаад, Цэцийн шийдвэрийг Улсын Их Хурал яагаад хүлээж авчихсан юм бол доо гэсэн ийм бодол төрж байсныг энд хэлэхийг хүсэж байна.

3 асуулт байна. Яах вэ ер нь тэгээд цаашдаа энэ хэн нь, хаанаа, юу болсныг цаг хугацаа харуулна биз дээ. Гашуунсухайт-Ганцмод дээр 3 гол асуудал байгаа юм билээ түрүүнд Ерөнхий сайдын мэдээлэлд гарсан. 1 дүгээрт төмөр замын бүтээн байгуулалт, 2-т нүүрс худалдах, худалдан авах гэрээ, 3-д уул уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудал. Энэ уул уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэдэг дээр яг ямар, ямар ажлууд хийгдэх вэ Туваан сайдаа? Хоёрдугаарх асуудал нь бид их ярьдаг л даа Чалкогийн гэрээ гээд, 11 онд байгуулагдсан гэрээ. 22 оны 3 дугаар сарын 16, 3 дугаар сарын 23, 3 дугаар сарын 30-ны өдрүүдэд Засгийн газрын хуралдаанд танилцуулагдсан энэ Чалкогийн гэрээг 11 жилийн дараа өчнөөн жил ярьсан сайжруулах болов уу гэж бодсон, тухайн үед сайжруулаагүй шүү дээ. Тухайн үеийн Уул уурхайн яам, Эрдэнэс Тавантолгой тэр улсууд энэ дээр хариуцлага хүлээгээгүй.

Яг энэ Чалкогийн гэрээтэй адилхан өнөөдөр ингээд чуулган дээр сонсоод сууж байхад Чайна Энержид нүүрсний үнийн энэ нөхцөл иймэрхүү маягаар л явах юм шиг байна. 22 оноос хойш тэр гэрээ шинэчлэгдсэнээс хойш Чалкод хэдэн сая тонн нүүрсийг, ямар үнээр нийлүүлсэн бэ? Өнөөдрийн Чалкогийн үнэ, нээлттэй бирж 2-ын үнийн зөрөө яг хэдэн доллар байгаа вэ гэдэг асуултад холбогдох хүмүүс нь хариулаарай гэж хүсэж байна.

3 дахь асуудалд нь тогтоолын төслийн үзэл баримтлал болоод төслийн зорилго, зохицуулах харилцаа, хамрах хүрээний хэсгийн 11-д говийг усжуулах, шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх гэх зэргээр харилцан ашигтай хамтран ажиллах болно гэж. Энэ заалтад нөгөө бид нарын яриад байгаа говийн бүсийн боловсруулах үйлдвэрийг мөн усны дутагдалтай бүс нутгийг усаар хангах Хэрлэн говь, Орхон говь төслүүдийн хамрагдаж байгаа гэж ойлгох уу? Эдгээр 3 асуултад хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 3 цогц гэрээ байгаа. Нэгдүгээрх нь төмөр замын хил холболтын гэрээ, хоёрдугаарх нь урт хугацаанд нүүрс худалдах, худалдан авах гэрээ, 3 дугаарт нь уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэсэн ийм 3 асуудал байгаа. 3 дахь асуудлын хүрээнд өнөөдөр манай Эрдэнэс Тавантолгой компани 30 гаруй сая тонн нүүрсийг яг өнөөгийн хамгийн дээд максимум хүчин чадлаараа олборлож, экспортод гаргаж байгаа. Энэ гэрээ хэлцэл яваад нэмэгдэж гарах нүүрс ялангуяа тэр 30 оноос хойш явах 20 сая тонноор нэмэгдүүлэхийн тулд бид энэ уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлж, өөр амыг нээж байж нийлүүлэх ийм боломж бүрдэх юм байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид өмнө нь геологийн урьдчилсан судалгаа хийсэн. Онч хараат, Бор толгой гэсэн ийм 2 цэг талбай дотроо ийм 2 амыг нээх ажил энэ дотор явагдана. Тэгээд энэ компанийн операторын асуудал бол нээлттэй тендер зарлаж байж оператор нь шалгараад явах ийм асуудал байгаа.

11 дүгээр асуудал дотор энэ Хятадын төрийн өмчит компаниудтай бид ингээд ярьж байгаа. Мөн ингээд Хөгжил шинэтгэлийн хороотой ч гэсэн асуудлууд яриад явна. Тэгэхээр энэ асуудлыг шийдсэний араас бид Хятадын талаас маш олон

салбарууд дээр ялангуяа энд дурдсан салбарууд дээр хамтын ажиллагаагаа эхлүүлэх ийм боломжууд нээгдэнэ гэдгийг ярьж байгаа. Тэгэхээр энэ дээр таны та нэмж хэлэлцэх эсэх нь шийдэгдээд, Байнгын хороон дээр санал гаргаад саяын асуудлыг нэмж болно гэж бодож байна.

2 дахь асуудлын хүрээнд тэр үнэ дээр бид өнөөдөр Хятадын 4 компанид урт хугацаанд нүүрс борлуулж байгаа, олборлоод нийлүүлж байгаа. Тэгээд үүний нэгд нь энэ Чалко компанийн үнэ байгаа. Чалко компанийн үнэ түрүүний миний хэлсэн суурь үнэ дээр нэмэх нь 5 биржийн үнийг нэмээд дундчилж гаргасан ийм үнэ байгаа. Тэгээд яг өнөөдрийн байдлаар хил холболтынхоо юу хил хүрэх логистикийн үнэтэйгээ 110 орчим долларын үнэ гарахаар байгаа. Энэ Чайна Энержи компанитай бид ярьж байгаа энэ нүүрс дотор бол бүх нүүрс коксжих буюу 160 орчим доллароор зарагддаггүй. Энэ 160 доллар хил хүртэлх тээврийн үнэ нь орчихсон үнэ байгаа. Тэгэхээр хүмүүс амны үнэ энэ 2-ыг хооронд нь холиод зөрөө их байна гэж ингэж яриад байдаг юм. Манайхан тэр нүүрсний хэмжээг нь Эрдэнэс Тавантолгой компанийнхан нэмээд хариулчихъя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон Эрдэнэс Тавантолгой ХК-ийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Мөнхжаргал хариулт өгье.

Х.Мөнхжаргал: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Гишүүний асуултад хариулъя. Эрдэнэс Тавантолгой компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхжаргал байна. Чалко компани нь анх 2011 оноос хойш гэрээ эхлээд, хамгийн сүүлийн өөрчлөлт түрүүн хэлсэн 2022 оны 3 сард хийгдээд, 2028 онд хугацаа нь дуусахаар явж байгаа. Анх гэрээ хийгдсэнээс хойш нийтдээ Чалко компани 32 сая тонн 2 тэрбум орчим долларын үнэтэй 32 сая тонн нүүрсний гүйцэтгэлтэй. Хамгийн сүүлийн гэрээний өөрчлөлт буюу 22 оноос хойш нийтдээ 8 аравны сая 2 сая тонн буюу 750 сая долларын нүүрсний ачилт хийсэн гүйцэтгэлтэй байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууя.

Х.Тэмүүжин: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад жоохон том зургаараа бид нар тодорхой сэдвийг хөндөж ярилцах ёстой гэж би хувьдаа бодож байгаа юм. Энэ төмөр замын холболттой холбоотой, нүүрс тээвэрлэлттэй холбоотой бид нүүрсээ том зах зээл дээр гаргаж зарахтай холбоотой асуудал үндсэндээ том өрсөлдөөн байсан. Аль улс нь хамгийн бага өртөг зардлаар олборлолт тээвэрлэлттэй хийж зах зээл дээр илүү ашигтай, үр ашигтай борлуулалт хийж чадах вэ гэдэг том өрсөлдөөн байсан. Энэ 16 жилийн хугацаанд. Нөгөө гөлөг төөрүүлнэ гэдэг шиг уурхай авч үлдэх гэж байсан, дотроо нэг том хувийн хэвшилд юмаа алдах гэж байсан гэдэг тайлбарууд зүгээр популист тайлбар. Энэ бол жижиг тайлбар.

Хамгийн гол тайлбар бол Хятадын зах зээл дээр Монгол Улсын нүүрс өрсөлдөх чадвартай байх уу, зарж байгаа нүүрсээсээ Монгол Улс илүү өндөр ашиг авч чадах уу гэдэг тийм өрсөлдөөн байсан. Энэ өрсөлдөөнд бид 16 жил ялагдсан. Тэрийг бол бодитойгоор хүлээн зөвшөөрөх ёстой. Энэ өрсөлдөөний гайгаар бидэнд алдагдсан боломж юу байгаа вэ гэдгээ бид харах ёстой. Зүгээр бизнесийн төслийнхөө зарчмаар Монгол Улс санхүүгийн ачаа үүрэхгүйгээр эдийн засгийн үр ашгаа олж авч байгаа бол болох дэд бүтэц байгуулж болох, түүн дээрээ суурилад дараа дараагийнхаа асуудлыг шийдэж болох байсан тэр боломжуудаа бид үнэхээр алдсан.

Өнөөдөр энэ эрчим хүчний хомсдолтой байгаа, энэ утаатай байгаа, эмнэлэг хүрэлцэхгүй байгаа, боловсролын чанарын доогуур байгаа гэх мэтчилэн. Тэгээд бүр томоороо бид эдийн засгийн тусгаар тогтнолоо хангаж чадахгүй байгаа байдал чинь зүгээр л гаднын гар, хөлүүдийн тоглолт дотор орсон шүү дээ. Ерөнхий сайд сая 1 том дүгнэлт хэлчих шиг боллоо. Тусгай албадын оролцоо байсан гээд. Үнэхээр тийм байсан гэдгийг бид хүлээн хүлээн зөвшөөрөх ёстой 1.

2-т нь дахиад яг үүнийг дагаад бид ямар алдагдалд хүрсэн бэ гэдгээ зүгээр би эдийн засгийн тооцоог нь ярихгүй. Монгол Улсад 3 зүйлийг галзууруулсан. Популизмыг галзууруулсан, бид эрүүл ухаанаар асуудлаа шийдэж чадахаа ерөөсөө байсан. Зүгээр л хэн илүү сайн популизм хийж, хэн илүү сайн хүмүүсийг хуурмаглаж чадна тэр нь улс төрийн оноо авдаг болтлоо яг галзуурсан. 2-т нь төрийн данхайлт. Энэний үр дүнд сүүлийн 10 жил төрийн эрх мэдэл, оролцоо, өөртөө зарж байгаа мөнгө зүгээр л галзууртлаа данхайсан. 3-д нь хуулийн байгууллагууд дээр сорилт бий болсон. Тогтолцооны авлига чинь зүгээр бүхэлдээ зүгээр гаарчихсан шүү дээ. Түрүүний 2, 3 гишүүний үгэнд гарлаа. Үндсэн хуулийн цэц оролцож ирээд Үндсэн хуулийг хулгайлаад яг ийм дүгнэлт хийгдэж байгаа чинь энэ чинь тогтолцооны авлигын хамгийн тод сонгодог жишээ шүү дээ. Үндсэн хуулийн цэц энэ шийдвэрээ гаргачхаад, гаргасан Цэцийн гишүүд нь ямар хуулийн төсөл боловсруулж байсныг санаж байна уу? Яг жил хагасын өмнө. Цэцийн гишүүн бүрэн эрхээ өгсөн ч гэсэн үхэн үхтэл нь хуулийн байгууллага шалгаж болохгүй гэдэг хуулийн төсөл боловсруулаад Улсын Их Хурал руу оруулж ирсэн шүү дээ.

Хамгийн том Үндсэн хуулийг сахигч нь хүртэл хулгайгаа хамгаалахын тулд, арьсаа хамгаалж ийм хууль хийх хүртлээ галзуурсан байхгүй юу. Бид үнэхээр эдийн засгийнхаа хөшүүрэг болсон энэ алхмаа шийдэж байгаа бол ард нь энэнээс бий болсон үр дагавруудаа арилгах талаар бодох ёстой. Хулгай хийдэг ийм.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Х.Тэмүүжин: Хулгай хийдэг ийм өндөр түвшний албан тушаалтнуудад хууль очиж чадах эсэхээ хүртэл бид ярилцах ёстой нэг. 2-т нь энэ сүүлийн 10 жилийн төрийн данхайлтаа буулгах юм уу гэдгээ ярилцах ёстой. 3-д нь үнэхээр популизмгүйгээр Монгол Улсын амин хэрэгцээ болсон ийм шийдвэрүүд дээр хэдүүлээ зоригтой, ухаалаг шийдвэр гаргаж чадах эсэхээ одоо бол ярилцах ёстой. Тэгэхгүй бол дараа дараагийн шийдлүүд дээр чинь дахиад л нөгөө тусгай албад чинь нөгөө өөр хоорондоо үл ойлголцдог олигархууд чинь дахиад энэ эрх мэдлээрээ дамжуулаад мөнгөний эрх мэдлээрээ дамжуулаад улс төрийг худалдаад авчихдаг энэ систем чинь өөрөө амьд байгаа. Энэ системээ янзлахгүй бол бид энэ 16 жилээ дахиад л.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Тогтоолын төслийн 2-т дурдсан нөгөө уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэдэг дээр тодруулж асуулт асууя. Туваан сайдын хариултад энэ Онч хараат, Бор толгой гэсэн хэсэгт шинээр ам нээж энэ гэрээнд туссан байгаа нүүрсний тоо хэмжээг экспортолно гэж дурдагдлаа. Тэгэхээр Эрдэнэс Тавантолгой компанийн эзэмшилд байгаа Тавантолгойн бүлэг ордод Цанхи, Бортолгой, Бортээг, Оорцог, Онч хараат гээд хэсгүүд байгаагаас мэдэж байгаагаар бол Онч хараат, Бортолгойн

хэсэгт эрэл үнэлгээний л ажил хийгдсэн байдаг. Тэгэхээр үүн дээр нэмээд хайгуулын ажил хийгдэх ёстой. Яг хэчнээн хэмжээний нүүрс ямар, ямар шинж чанартайгаар ямар, ямар үеүд нь байдгийгаа бид мэдэх ёстой. Дараа нь олборлолтын ажлыг гүйцэтгэх ёстой. Тэгэхээр энэ дээр санхүүжилтийг нь хаанаас гаргахаар төлөвлөж байгаа вэ? Менежментийг нь хэн явуулахаар төлөвлөгдөж байгаа вэ? Хэлэлцээрт дурдагдаж байгаа байх.

Тэгэхээр гэрээгээр хүлээсэн үүргээ гэрээ байгуулагдлаа, Улсын Их Хурлын тогтоол гарлаа, Засгийн газар хоорондын хэлэлцээр хийгдлээ. Ингээд яг энэ Онч хараат, Бор толгой хэсгүүдээс хэрвээ ам нээнэ гэх юм бол хайгуул, олборлолтын ажил, бэлтгэл ажил гээд хугацаа орох байх гэж бодоод байх юм. Тэгэхээр энэ дээр яг санхүүжилт нь хаанаас гарах юм бэ, менежментийг нь хэн явуулах вэ гэдэг дээр дэлгэрүүлээд хариулаад өгөөрэй.

2 дугаарт болохоороо манайх оффтейк гэрээгээр нүүрсийг экспортолж байгаа. Монгол Улсын зах зээлээс гарч байгаа, бид бүгдээрээ мэддэг, ярьдаг. Энэ 24 оны сая Батнайрамдал гишүүний дурдсанаар 81 сая тонн нүүрс Монгол Улсаас гарлаа гэж байна, экспортлогдлоо. Яг үүний хэдэн сая тонн нь, хэчнээн хувь нь энэ оффтейк гэрээгээр хүлээсэн үүргийн нүүрс байгаа юм бэ? Энэ бид гэрээгээ хийчихээр 30 оноос 16 жилийн турш бас оффтейк гэрээ гарах тоо нь ингээд нэмэгдээд явна.

Тэгэхээр бид уг нь Биржийн тухай хуулийг хэрэгжүүлж эхлээд нүүрснийхээ үнийг өсгөөд эдийн засагтаа нэлээн их нэмэр болсон. Тэгээд 2023 оны 1 дүгээр улирлаас авхуулаад биржээр зарагдаж байгаа нүүрснийхээ жигнэсэн дундаж үнийг харахаар ер нь бол бууж яваа. Гэхдээ энэ оффтейк гэрээ бол биржийн бус арилжаа болно. Тэгэхээр энэ дээр манай биржийн арилжаа дээр сөрөг нөлөө үүсэх үү? Энэ дээр ямар зүйлийг хариулж болохоор байна вэ? Ийм 2 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Уянга гишүүний асуултад хариулъя. Энэ заалт дээр 3 дахь хэсэг дээр буюу энэ уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх дээр Тавантолгойн бүлэг ордын хэмжээнд байгаа 8 лиценз байгаа. Тэгээд энэ дотор орж байгаа Бор толгой, Онч хараат дээр өмнө нь урьдчилсан байдлаар баримжаа судалгаа л хийгдсэн байдаг өмнө нь. Энэ дээр мэдээж дахиж нэмж өрөмдөж нөөцөө тогтоох асуудал байгаа. Тэгээд эндээс гарах санхүүжилтийг бол Эрдэнэс Тавантолгой компани өөрөө гаргаад явна. Оператор дээр бол Эрдэнэс Тавантолгой компани нээлттэй тендер зарлачихсан байгаа. Яг одоогийн түвшинд бол. Тэгэхдээ энийгээ шалгаруулаагүй түр хаасан. Энэ төслийн асуудлыг хүлээгээд түр хаасан байгаа. Тэгэхээр энэ дээр операторыг сонгон шалгаруулалтад шалгарсан компаниар явуулна гэдгийг хэлье.

Энэ түрүүн хэлсэн эхний 5 жилийн хугацаанд 27 сая тонн нүүрсийг 5, 5, 5, 6, 6 гээд ийм сая тоннуудаар 5 жилийн хугацаанд 29 он хүртэл гаргана. Энийг өнөөдрийн Эрдэнэс Тавантолгой компанийн олборлож байгаа энэ амнаас нэмж хүчин чадлыг нэмэгдүүлж эндээсээ нэмж борлуулах ийм боломжтой гэж харж байгаа. Тэгээд энэ 5 жилийн хугацаа өнгөрсний дараа 30 оноос шинэ амуудаа нээж, тэндээс нэмж нүүрс олборлож энэ нэмэгдэх хэмжээг хангана гэдгийг танд хэлье. Юуны энэ юуны хувийг манайхнаас нэмээд хариулчихъя. Эрдэнэс Тавантолгой хариулчихъя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон өгье нэмж хариулъя.

Х.Мөнхжаргал: Уянга гишүүний асуултад хариулъя. Эрдэнэс Тавантолгой 2024 оны борлуулалтын хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийтдээ 30 сая тонны борлуулалт хийхээр байгаа. Үүн дээр бол тус компанийн борлуулалт нь 2 янзаар явагдаж байгаа. Амны болон түрүүн саяын хэлдэг 4 компани, мөн биржийн борлуулалт. 2023 онд Биржийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш Эрдэнэс Тавантолгой компани 23 онд болохоор нийтдээ 10 сая тонн нүүрсийг биржээр арилжаалж байсан бол энэ нь өөрөө тухайн жилийнхээ 17 хувь бирж биржийн арилжаа, 24 онд болохоор нийтдээ 30 сая тонн нүүрс борлуулсны 15 сая нь биржийн арилжаагаар борлуулагдсан байгаа. Тэгэхээр нийтдээ бараг энэ 48 орчим хувь болж байгаа байх.

Тэгэхээр цаашид компанийн борлуулалтын арга зарчим яаж явах вэ гэхээр биржийн үйл ажиллагаа хэвийн явагдана. Биржийнхээ тухай хуулийн дагуу арилжаагаа хийгээд энэ одоо байгаа компанийн хүчин чадал дээр нэмэх нь Чайна Энержи буюу энэ хил холболтын төмөр замтай холбоотой жилд 5 сая, эхний 5 жил 27 сая, төмөр зам ашиглалтад орсноос 20 сая гэдэг юу нэмэгдээд явах юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Манай Монголчууд ер нь нүүрс олборлоод, тээвэрлээд, экспортлоод өөрсдөө нэлээн чадавхажсан, Эрдэнэс Тавантолгой ч гэсэндээ өөрсдөө тоног төхөөрөмжөө аваад, зарим үйл ажиллагаанууд өөрсдөө хийдэг болж байгаа. Тэгээд хэрвээ Онч хараат, Бор толгой дээр 2030 оноос хойш олборлолт хийж эхэлнэ гэвэл дотоодын менежменттэй байгаасай. Дотоод компаниуд Монголчууд өөрсдөө ажиллаасай ийм саналтай байна. Тэгээд албан ёсоороо саналаа хүргүүлье.

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан: Би иргэд үзэж байгаа учраас энгийн хоёрхон асуулт асуучихъя. Энэ Гашуунсухайт-Ганцмод боомтыг холбох төмөр замын асуудал ярьж байна гэж иргэд ойлгож байгаа тийм ээ. Тэгэхээр иргэдэд ойлголт өгөх үүднээс энэ боомт өнөөдөр яг хэдэн тонн нүүрс гаргадаг юм бэ? Энийг холбовол хэд болох вэ гэдэг нэгд ийм асуултыг асууж өгөөд, энэ төслийнхөө ач холбогдлыг иргэдэд ойлгуулмаар байна.

2-т нь энэ тогтоолын төслийн 5 дугаар зүйл дээр 25-аас 27 он хүртэл жилд 27 сая тонн нүүрс гаргана гээд хатуу заачихсан байгаа. Энийг өөрчлөх арга байна уу? 27-гоос илүү гарчихвал яах вэ? Улсын Их Хурал тогтоолын төсөл зөрчсөн болох гээд байдаг, дутуу болчихвол зөрчсөн болох гээд байгаа учраас энэ тоогоо хэдүүлээ эргэж харвал яасан юм бэ гэсэн ийм саналыг Туваан сайдад тавьж байна.

3 дугаарт нь нөгөө алдагдсан боломж гээд ярихаар улс төржсөн болчих гээд аягүй хэцүү юм байна. Нэг хүний асуудал яригдчих гээд байгаа ч юм шиг. Гэхдээ гарцаа байхгүй үнэн 10 гаруй жил энэ боломжийг гацаасан асуудал байгаа. Тэгээд сая манай зарим нэг гишүүдийн яриагаар бол компани руу чиглээд явж байх шиг байна энэ чинь сүүлдээ. Бид нарын ойлгож байгаагаар улс төрчийн асуудал яригдаж байгаа. Тэгээд манай Сандаг-Очир гишүүн ярьсан хариуцлагын асуудлыг хэдүүлээ ярихгүй юм уу гэж. Энэ хариуцлагын асуудлыг сөхөж байхгүй бол ингээд

цаашдаа ингээд алга болчихдог, бүх салбар луу ордог, бүх жагсаал руу оролцдог тийм болох вий дээ. Энэ дээр хариуцлагын асуудлыг манай төрийн удирдлагууд, Улсын Их Хурлын гишүүд маань хаана хаанаа ярьж явахгүй бол болохгүй нь гэж би үзэж байгаа. Энийг зүгээр саналын хувьд хэлчихье. Ийм 2 санал байна.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Цэвэгдоржийн Туваан сайд.

Ц.Туваан: Өнөөдөр Монгол Улс одоогийн байдлаар 81,8 сая тонн нүүрс экспортод гаргаад явж байгаа. Үүнийг 4 боомтоор, мөн 5 боомтуудаар гаргаж байгаа. Гашуунсухайт өнөөдрийн байдлаар жилдээ 40 сая тонн нүүрс гаргаж байгаа. Шивээхүрэн 15 сая, Ханги 8, Бичигт 5 сая бусад боомтуудаар 17 сая тонн нүүрс гарч байгаа. Энэ төмөр замын холболт хийгдсэнээр Гашуунсухайт боомтоор нэмж 30 сая тонн нүүрс гарах ийм боломж гарна гэдгийг хэлье. 27 сая гэдэг бол 5 жилийн хугацаанд 5, 5, 5, 6, 6 сая тонн гээд хэмжээ дээд хэмжээг нь тавьж өгч байгаа ийм 5 жилийн нийт нийлбэр дүн байгаа. 30 оноос хойш бол бид 20 сая тонныг жил болгон гэж ингэж ойлгож болно.

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн алга байна. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуулт асууя.

Н.Алтаншагай: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. 2 асуулт байна. Бид өнгөрсөн 10 жилийн хугацаа, 10 гаруй жил ч өнгөрчихлөө дөө. Өмнө нь байгуулагдах байсан энэ бүтээн байгуулалтын ажил, том төсөл хүлээгдсээр байгаад өнөөдөртэй учран золгож байгаа юм. Энэ төсөл өөрөө их амаргүй цаг үеийг туулж, бидэнд ирж байгаа юм. Улс төрийн түнэр харанхуй шоу дундуур явсаар байгаад маш их хүлээлт үүсгээд, айдаст автуулаад, тэгээд өнөөдөртэй золгож байгаа юм. Энэ сүүлийн 8 жилийн улс төрийн тогтвортой байдлын үр дүнд энэ төсөл маань өнөөдөр ингээд бид бүхэн яг ширээний ард суугаад, хэлэлцээд, сайн, муугаа ярилцаад сууж байгаа юм.

Тэгээд 2 үндсэн асуулт байгаа юм. Энэ 2 талаасаа Засгийн газрын хооронд хэлэлцээр байгуулаад, төмөр замаа холбох ажил ингээд яригдаад эхэлж байна. Энэ төмөр зам маань хэрвээ батлагдах юм бол яг хэзээ дуусаад, хэзээ эхлэх юм бэ? Энэ цаг хугацааг нь иргэддээ маш тодорхой хэлж өгөөч? Маш их хүлээлт үүсчихсэн энэ тэнгэр дээр л нэг том юм байгаад байна гэсэн ийм ойлголтыг иргэддээ өгчихсөн. Тэгээд түүн дээр нь дандаа улс төрийн шоу хийсээр байгаад ингээд ийм улс төрчдөдөө иргэд нь итгэхээ байчихсан, төрдөө итгэхээ байчихсан ийм маш хүндрэлтэй асуудал үүссэн. Тухайн үед энэ төсөл яригдаж байх үед Монгол Улсын эдийн засаг 17 хувийн өсөлттэй дэлхийд өндрөөр үнэлэгдэж байсан. Яг энэ алтан боломжтой энэ цаг үедээ бид бүхэн энэ төсөл хэрэгжээд явсан бол өнөөдрийн яригдаад байгаа энэ 17 мега төсөл маань ажил хэрэг болчихсон, иргэд маань үр өгөөжөө хүртээд байж байх байсан.

Дээр нь 2 дахь асуултын маань дараачийн зүйл бол энэ иргэдийн дунд нэг том төөрөгдөл байгаа юм. 2 зам нь зөрчихсөн юм, өндөржилтийн зөрөөтэй гээд. Энийгээ маш товч бөгөөд тодорхой яг иргэддээ ойлголтыг нь өгөөч. 18км зөрчихсөн юм гээд л, 20км зөрчихсөн юм гээд л. Тэгээд энэ чинь энэ Монголоос явж байгаа төмөр зам тэр хилийн бүс рүүгээ орно, цаанаас явж байгаа зам орж ирээд хилийн бүс дотроо нүүрсээ буулгах ийм л зам гэж би ойлгоод байгаа юм. Гэтэл энэ нарийн зам, өргөн замыг нийлүүлэх гэж байгаа юм шиг яг ийм ойлголт өгөөд, тэгээд танк

орж ирэх гэж байна гээд ингээд явчихсан. Тэгээд энд яг хэн хариуцлага хүлээх юм бэ? Энэ ингээд эзэн биегүй үлдэх юм уу? Энэ дээр хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайд орж ирсэн тогтоолын төсөл дээрээсээ маш тодорхой он, сар, цаг хугацаатай заалтууд байгаа. Тэрийгээ маш тодорхой хариулах нь зүйтэй байх гэж бодож байна. Орж ирсэн төслөөр бол энэ асуудал Улсын Их Хурлаар дэмжигдсэн тохиолдолд ирэх хавар бүтээн байгуулалтын ажил эхэлнэ. 2, 3 жилийн дотор хийж гүйцэтгэж дуусгана энэ тэр гэсэн заалтууд байлаа шүү дээ. Тэрийгээ маш тодорхой хариулт өгөх нь зүйтэй. Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн хэлэлцэж байгаа бид энэ Улсын Их Хуралд өргөн барьсан тогтоолын төслөө ингээд энэ намрын чуулганаараа баталж амжвал бид ингээд он гараад хэлэлцээгээ хийж эхэлнэ. Тэгээд энэ хэлцлээ хийгээд, үндсэндээ намрын чуулганаа завсарлахаас өмнө тогтоолын төслөө соёрхон батлах байх гэж ойлгож байгаа. Хэрэв энэ намрын чуулганаараа тогтоолын төслөө соёрхон баталж дуусвал компаниуд хооронд 3 төрлийн гэрээ хийгдэнэ. Энэний хамгийн гол гэрээний нэг нь Төмөр замын гэрээ байгаа. Төмөр замын гэрээг сая Улсын Их Хурлын даргын хэлсэнчлэн яг энэ заалтад, энэ 11 заалт бүхий тогтоол дээр байгаагаар 25-аас 27-ны хооронд буюу 3 жилийн хугацаанд хийх ийм гүүрэн байгууламжийн нэлээн төвөгшилтэй, төвөгшил ихтэй ийм байгууламж байгаа юм.

Ингээд энэ ажил маань бид энэ 25 оны хавар эхэлж чадвал 27 ондоо дуусгана. 3 жилийн хугацаатай гэж үзэж байгаа. Ер нь гэрээ дээр урьдчилсан гэрээний draft дээр ийм хугацаа байгаа. 2 талаасаа шахаж ажиллаж чадвал бид 2,6 жилд энийгээ хийнэ гэж байгаа юм. Яг байдал газар дээрээ 30 метрийн зөрөөтэй, өндөршлийн зөрөөг хэлж байгаа юм. Тэгэхээр 30 метрийн зөрөөг гаргахын тулд гүүрэн байгууламж хийж явна. Гүүрэн байгууламжийг хийхдээ тойрог хэлбэрээр хийж байгаа. Энийг тойрог хэлбэрээр хийж байгаа гол шалтгаан бол манайд байгаа зам руу оруулж ирэхэд байгууламжийг нь өөрөөр хэлбэл тааруулж, нөгөө өндөршилтийг нь тааруулж оруулж ирэхийн тулд тойрог хэлбэрээр хийгдэж байгаа гэдгийг энэ ташрамд хэлье.

2 дугаарт манайд хийгдэх байгууламж нь 11, 18,3км-ийн байгууламж байгаа юм. Өргөн царигийн байгууламж нь 10км, нарийн цэргийн байгууламж нь 8км орчим байгаа. Тэгээд манайд орж ирж байгаа нарийн цариг нь мөн ялгаагүй гүүрэн байгууламжаар орж ирнэ. Тэгэхээр 30 метрээр биш энэ байгууламж бол өргөн төмөр зам явж байгаа байгууламжийнхаа доогуур зөрж орж ирэх ийм байгууламж учраас 10 гаруй метрээр зөрж орж ирэх ийм байгууламжууд байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ бол манай сая газар дээр нь очиж үзсэн гишүүдийн хувьд маш тодорхой байгаа. Урд талдаа бол манай урд хөршийн барьж орж ирсэн төмөр зам хилээс 300 метрийн зайд бий. Тэгэхээр зэрэг ихэнх энэ хийгдэх ажиллагаа бол Монгол Улсын газар нутаг дээр хийгдэнэ. Ийм асуудал байгаа. Тэгээд бид хугацааны хувьд аль болохоор гэрээ маань ингээд богино хугацаанд батлагдаад, соёрхон батлагдаад, компани хооронд гэрээгээ зурчихвал энэ хавартаа багтаагаад 3 сараас ажил эхэлнэ гэж тооцож байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайдаа орж ирсэн тогтоолын төсөл дээр бусад хилийн боомтуудын холболтын асуудал хөндөгдсөн байсан. Тэр заалтын талаар та тайлбар өгөх нь зүйтэй байх. Нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас эхлээд Ганцмод-Гашуунсухайтын төмөр замыг холбох асуудлыг ярьж байгаа. Тэгээд өнөөдөр бид яг энэ асуудлыг ярьж байна. Тэгээд энэ бусад төмөр замуудыг энэ гэрээ хийгдвэл бусад боомтын төмөр замуудын дэс дараатайгаар холбоно гэдэг ийм асуудлыг тавьж байгаа учраас энэ гэрээ хийгдэнгүүт бусад төмөр замуудаа холбох асуудлаа үргэлжлүүлээд яриад, гэрээгээ хийгээд, ингээд үргэлжлүүлж бүтээн байгуулалтаа хийх ийм боломж бололцоотой гэдгийг энэ ташрамд хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энэ их тийм чухал заалт шүү. Энэ дээрээ Зам, тээврийн сайд онцгой анхаарч ажиллах хэрэгтэй. Бусад бэлэн болчихсон байгаа Шивээхүрэн, Хангимандал, Бичигт, Зүүн хатавч чиглэлийн төмөр замын холболтын ажлыг нэн даруй эхлүүлэх дээр анхаарах хэрэгтэй, тогтоолоор орж ирсэн байгаа. Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: 1 зүйл гараанаас гаргаж байна. Тэгээд гараанаас гаргана, гацаанаас гаргана гэдэг их хүнд хэцүү шийдэл. Тодорхой эсэргүүцэлтэй тулж байж л ард нь гардаг. Тэгэхээр энэ гэрээний төсөл Их Хурлын тогтоолын төсөл дотор байгаа зүйлүүдийг чадах чинээгээрээ судалсан учраас эндээс асуухааргүй өөр зүйлийг Ерөнхий сайдаас асуумаар байгаа юм. Бид ингээд цаг хугацаа алдаад, цагийн шүүлтэд ороод өнөөдөр аргагүйн эрхэнд юу болоод өнгөрсөн бэ гэдгээ шүүгээд ярьж байна. Хэн хохирсон юм бэ? Энэ тухай Ерөнхий сайдыг хариулж өгөөсэй гэж хүсэж байна.

Дээрээс нь энэ гэрээ байгуулагдсанаар Монголын ард түмэн, иргэд, сонгогчид юуг хожих юм бэ? Тэд нарын амьдралд, тэд нарын хөргөгчид, хадгаламжид, боловсрол мэдлэг, эрүүл мэндэд, хүрээлэн байгаа орчинд юу өөрчлөгдөх юм бэ? Энэ тухай Монгол Улсын Ерөнхий сайдыг үг хэлбэл, хариулт өгвөл туйлаас баярлахаар байна. Бид нэн тэргүүнд бид нарын хийж байгаа, гаргаж байгаа тогтоол шийдвэр, үг, үйлдэл болгон Монголын 3 сая 500 мянган ард иргэдийг хамгийн сайн сайхан аж амьдрал руу хөтлөхөд л зориулагдах ёстой. Ойр зуур жижиг сажиг илүү, дутуу хоорондын асуудал руу чиглэгдэх ёсгүй. Эрх ашгийн эрэмбээ тэгж барих ёстой. Тийм болохоор энэ гэрээний зүйл, заалтуудыг ярихаасаа илүү, энэ гэрээ байгуулагдсанаар ямар хохирол арилах юм бэ, ямар хожил ирэх юм бэ, Монголын ард түмэнд юу очих юм бэ л гэдгийг асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ гэрээ 1 дүгээрт Засгийн газар хооронд хийгдэж байгаа. Засгийн газар хооронд хийгдээд, Их Хурлаар соёрхон батлуулж байгаа учраас аливаа 3 дахь тал оролцуулахгүй гэдэг ийм үндсэн тохиролцоо хийгдэж байгаа. Тийм учраас хамгийн ил тод, хамгийн нээлттэй ярилцах боломж бол 2 улсын Засгийн газар ингээд Их Хуралтайгаа хамтраад ингээд хийгдэнэ гэдэг байдлаар өнөөдөр оруулж ирж байгаа. Өмнө болсон маргааны гол сэдэв болсон Эрдэнэс Тавантолгой компанийн лицензийг аль нэг газарт шилжүүлэхгүй, царигтай холбоотой асуудал Монголын тал өргөн царигаараа, Хятадын тал нарийн царигаараа холбогдоно. Цариг солилцох ийм гүүрэн байгууламж хийгдэнэ. Энэ төсөл хөдөлснөөр одоо бол бид 85 сая тонн нүүрсийг экспортолж байгаа. Энэ бол 165 сая тоннд хүрнэ.

Энэ гэрээ соёрхон батлагдсанаар бусад боомтууд нээгдэнэ. Бусад боомтууд нээгдэх дараалал эхлээд Шивээхүрэн боомт байна. 2 дахь нь Бичигт боомт байна. Ингээд бусад боомтууд нээгдэнэ гэдэг нь баруун, зүүн 2 босоо тэнхлэгийн зам хийгдэх ийм боломжийг Хөгжлийн шинэтгэлийн хороотой тохиролцох ийм боломж гарна гэсэн үг. Яагаад энэ хийгдээгүй вэ гэхээр 2014 онд зурагдаад, 10 жилийн хугацаанд Монголын тал Гашуунсухайт талдаа бүтээн байгуулалтыг хийж чадаагүй учраас энэ төмөр зам холбогдтол бусад төмөр замуудыг холбохгүй байх ийм шийдвэр гараад ингээд явж байгаа гэж ойлгож болно. 165 сая тонн нүүрсний дэд бүтэц, бусад боомтуудын төмөр зам ашиглалтад орсноор санхүүгийн хувьд одоо байгаа ДНБ 2 дахин тэлнэ. Тийм учраас энэ нь өөрөө эрүүл мэнд, боловсрол, бусад салбар Үндэсний баялгийн санд орох орлого бол одоо байгаагаас 2 дахин нэмэгдэх ийм өгөөжтэй гэж ойлгож болно.

Мөн эрчим хүчийг бид экспортлох ийм хэлэлцээр хийгдэж байгаа. Хэрвээ энэ гэрээ соёрхон батлагдвал эрчим хүч болон эрчим хүчний нүүрсний экспортыг нэмэгдүүлэх ийм боломжтой гэдэг байдлаар Засгийн газартай нь тохиролцож байгаа гэдгийг хэлье.

Мөн дээрээс нь энэ 16 жилийн хугацаанд сэргээгдэх эрчим хүч, говийг усжуулах, нийслэлийн дэд бүтэц гээд, орон сууцжуулалт гээд бусад ийм нийгмийн асуудлуудыг бид шийдвэрлэхэд хамтарч ажиллаж бол болно гэдгээ илэрхийлж байгаа. Энэ ямар арга хэлбэрээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Батбаатар: Хариултын хугацаанд нь арай багтсангүй байна. Тэгээд Монголын ард түмэнд юу очих вэ гэдгийг иргэд, сонгогчдод юу очих вэ гэдгийг хэлээд өгөөсэй гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: ДНБ 10 мянган ам.долларт хүргэж байж нийгмийн бусад асуудлууд шийдэгдэнэ л гэдэг ийм асуудлыг бид ярьж байгаа. Энэ маань л өөрөө боловсрол, эрүүл мэндэд шууд орох ийм хөрөнгө оруулалт болно гэсэн үг. Тийм учраас бид одоо байгаа эдийн засгийн хүчин чадлыг 2 дахин тэлэх ийм боломжтой төслийг өнөөдөр ярьж байна гэсэн үг.

Гүйцээгээд хариулахад саяын дурдсан нийгмийн тулгамдсан асуудлуудыг энэ гэрээ хийгдсэнээр шууд энэ асуудлууд руу орох ийм томоохон төслүүд дээр хамтын ажиллагааг энэ 16 жилийн хугацаанд нээлттэй өрнүүлэхэд бэлэн байгаа гэдгээ илэрхийлж байгаа. Ийм төслүүд хэрвээ явах бол Засгийн газар Улсын Их Хуралд ороод ямар, ямар төсөл дээр энэ компанитай, Засгийн газартай нь яаж хамтарч ажиллах вэ гэдгээ нээлттэй ярилцаад явах ийм боломж байгаа.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Монгол Улс Бүгд Найрамдах Хятад Ард Улстай 20 дугаар зууны дунд үеэс энэ төмөр замаар холбогдсоноос өөр Замын-Үүдээс өөр тийм том байгууламж байхгүй. Тэгэхээр энэ ач холбогдлын талаар ахин дахин давтаад яах вэ. Хэрвээ үнэхээр ингээд холбогдоод яах юм бол маш чухал бөгөөд бүгд л хүлээж байгаа гэдэгт итгэлтэй байна. Тэгэхдээ анхаарууштай юмнууд байгаа юм.

Хятадын талаас ирүүлсэн хүсэлт нь энэ төмөр замын байгууламж, нүүрсний худалдаа гэдэг бол 2 тусдаа зүйл. Тэгэхдээ худалдан авагч талаасаа дээрээс нь уурхайн хүчин чадлыг нэмээд, энэ 3 асуудлыг нэг болгож цогцоор нь тавих. Энэ бол ингээд тэдний хүсэлт, нөхцөл. Тэгэхээр үүнийг ойлголцоод Засгийн газар ажлын хэсэг ер нь бол ойлгоод хүлээж авчихлаа гэж тийм дүгнэлт гарчихлаа гэж ойлгож байгаа. Энэ хүрээндээ, окэй хүлээгээд авчихсан байна. Энэ хүрээндээ дотор нь дахиад нарийн зүйлс байгаа. Түүн дээр ямар нэгэн байдлаар өөрчлөлт байх юм уу, байхгүй юм уу? Өөр арга байхгүй ингэж хэлсэн гээд ингээд байх юм бол Улсын Их Хурал дээр хэлэлцүүлэх ямар хэрэг байх вэ? Хятад улсыг бол тэр маш их ийм нөгөө хэлэлцээр хийх чадалтай, Монгол Улсыг их л тэгж хүндэтгэж үздэг, хүлээцтэй ханддаг, маш их тэвчээртэй ийм хүмүүс шүү дээ. Тэгэхээр их, бага хэмжээгээр бид яаж сайжруулах вэ гэдгийг анхаарах нь зүйтэй байх.

Тэгээд хэдэн санал хэлье, санал бөгөөд асуулт. 1 дүгээрт нь урд талаас ирсэн албан бичиг дээр коксжих нүүрс гэсэн үг байсан нийтлэгдсэн, тэр нь өөр бол байхгүй. Тэгэхээр энэ Тавантолгойн нүүрс чинь 3 төрлийн нүүрстэй учраас зөвхөн коксжих нүүрсийг нь их хэмжээгээр нийлүүлээд байх юм бол нөгөөдүүлээ борлуулах боломжгүй болоод технологийн хувьд ордоо, баялгаа хаяхад хүрдэг. Тийм болохоор энэ зарчим дээрээ 3 төрлийн нүүрсээ ийм харьцаатай, тодорхой харьцаатайгаар оруулна гэдэг байх хэрэгтэй санагдаж байгаа. Тэгээд тэгж тусгаж болох уу гээд.

2 дугаарт нь Монголын нутаг дээрх тээврийн хөлс төмөр зам орсноор ингээд маш их ашигтай болно гээд түрүүн Батнайрамдал гишүүн ярьсан. Дэлгэрсайхан сайд ярьсан. Энэ зөрөө нь хэрвээ Монголын тал тээврээ хийгээд, хил хүргэж өгөх юм бол манай талд орж ирнэ. Тэгэхээр хил хүргэх гэдэг нь тээвэр чинь өөрөө уур амьсгал, салхи шуурга, тэгээд нөгөө зам боодог үзэгдэл, техникийн зам арчилгааны эрсдэлүүдтэй. Энэ эрсдэлийг худалдан авагч тал хариуцах нь манайд гарч байгаа нутаг дээр гарч байгаа эрсдэлийг хариуцах угаасаа хүнд. Тэгэхээр энийг Монголын тал хариуцаад хил хүргэж өгөх энийгээ ярьж болохгүй юм уу? Тэртээ тэргүй л хөнгөлөлттэй үнээр нийлүүлнэ. Гэхдээ тээврийнх нь эрсдэлийг нь хаая, 2 дугаарт нь тээврийнх нь үр ашгийг манай тал авъя л даа ийм асуулт.

3 дугаарт нь үнийн индекс ингээд одоо болтол хэрэгжүүлсэн энэ хуучин юун дээрээ тулгуурлана гэж байгаа. Тэгэхдээ тэр дотор нэг жоохон, жоохон юмнууд байна л даа. Нөгөө суурь үнэ дээр хувь нэмдэг. Тэгэхээр суурь үнээ мэдээж хуучнаараа нэмэхгүй байх суурь үнэ. Дээрээс нь хувь нэмдэг индексийг Хятадын дотоодын индексээс гадна Монгол чинь энэ хөрөнгийн, нүүрсний биржийн худалдаа нэлээн явчихлаа шүү дээ. Тэгэхээр тэр чинь манай индекс байхгүй юу. Тэгээд энийгээ ингээд аль алийг нь оруулаад, аль болохоор бодитой, тэрнээс биш алдагдалтай нөгөө талдаа алдагдалтай гэсэн зүйл байхгүй. Энийг нэг update хийх ийм хэрэгцээ байна гэж. Яагаад гэвэл энэ үнийн зөрөөний асуудал бол тийм бага мөнгө биш. Ер нь их наядаар тоологдохоор л юм гарч ирнэ төгрөгөөр хэмжээ нь их учраас. Тэгэхээр энэ тэртээ тэргүй хөнгөлөлт байх нь ойлгомжтой. Урт хугацаанд, тогтвортой манай тал давуу байна. Гэхдээ индекс дээрээ дахиад нэг анхаарах хэрэг байна шүү гэж. Тэгээд хамгийн гол нэг юм нь, 1 минут нэмж авах байх.

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Ж.Золжаргал: 20 сая тонн гэдэг их хэмжээ. Их хэмжээгээр зарах юм бол Монголд хэрэгтэй. 20 байтугай бүр их бол бүр л сайн. Гэхдээ нийт гаргаж байгаа нүүрсний хэмжээ нь эдийн засгийн янз бүрийн олон улсын байдлаас болоод огцом уначих юм бол 20 сая тонн гэдэг чинь Эрдэнэс Тавантолгойн үйлдвэрлэлийн 50-иас дээш хувь байхгүй юу. Тэгэхээр тэрийг дагаад зөвхөн Тавантолгойгоос гадна Монголын нүүрсний нийт үнэ унах эрсдэл байгаа. Тийм болохоор нэгэнт 2 Засгийн газрын хоорондын хэлэлцээр ярьж байгаа учраас энэ дотроо нөгөө 120 сая тонн хүрнэ гээд байгаа шүү дээ. Энэ тоог оруулаад, тэрийгээ ингээд зураад. 120 байж байх юм бол тэр Чайна Энержид хэдийг л бол хэдийг гаргаж болж байгаа байхгүй юу. Тэгэхээр Чайна Энержид өгөх хэмжээ нь нийт Монголоос Хятад руу нийлүүлсэн нүүрсний 20 хувь байна ч гэдэг юм уу. Тэгээд тэр 100 гаруй сая тонныг ингээд fix болгочих боломж байна уу гэж. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайд хариулт өгье. Яг энэ дээр нэг зүйлийг маш сайн тодруулаад хэлээд өгөх нь зүйтэй байх гэж бодож байна. Хил хүртэл Монгол Улсын эзэмшлийн төмөр зам байгаа. Түрүүн Туваан сайдын тайлбарлаж байгаагаар хил хүртэлх үнийн асуудал хөндөгдөж яригдаж байгаа гэдгийг тодруулж тайлбарлаж хэлэх нь зүйтэй байх. Тэр төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой асуудлыг Эрдэнэс Тавантолгой ХК чинь өөрөө захиалга өгч, төлбөрөө төлж хийлгэх тийм гэрээ хэлцэл явж байгаа гэдэг энэ 2 дээр сайн тодруулж хэлж өгье. Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Ж.Золжаргал: Энэ 3-ыг хамтад нь шийдье гэдэг бол зөвхөн нэг талын санаачилга биш. 2 талын санал байгаа гэдгийг энэ ташрамд тодруулж хэлэх нь зөв. Яагаад вэ гэхээр бид энэ төмөр замыг холбочоод өнөөдөр нүүрс зөөхгүй зүгээр л нэг төмөр зам холбох төдий гэрээ хийвэл нүүрс авахгүй болчихвол яах вэ гэдэг юмыг давхар тооцож, бид төмөр замыг холбоно, холбохдоо нүүрсээ гаргана, нүүрсээ гаргахдаа их хэмжээгээр гаргана гэдэг ийм логикоор бодож 3-ыг хамтад нь шийдье гэдэг ийм асуудлыг хамтдаа тавьсан юм шүү. Энэ бол ганц урд хөршийн юу биш, санаачилга биш гэдгийг 1 дүгээрт хэлье.

2 дугаарт 25-аас 29 оны хооронд гаргах 5, 5 сая, 6 сая гэдэг энэ нүүрс бол төмөр зам баригдаж дуустал Монголын тээвэрчид Монголын тээврийн машинаар тээвэр хийж байгаа компаниуд энэ тээврийг хийнэ. Тийм учраас тээврийн зардлын үр өгөөж Монгол талдаа үлдэнэ гэдгийг хэлье.

3 дугаарт төмөр зам холбогдсоны дараа хил хүртэлх төмөр замын байгууламж өөрөө Монголын төрийн өмч учраас энэ төмөр замаар тээгдэж байгаа ачаа, энэ гарч байгаа төмөр замд ачигдах энэ зардал бүгд Монголын талд үлдэж байгаа үр өгөөж гэдгийг энэ ташрамд хэлье. Тэгээд өөрийн чинь хэлж байгаатай адилхан бид тухайн үедээ гэрээгээ хийх явцдаа энэ индексжүүлэх, жишээлбэл энэ Гашуунсухайтаар хэдэн тонн нь гарах юм, үлдсэн боомтуудаар хэд нь гарах юм гэдэг юмнуудаа энэ 3 гэрээгээ хийх явцдаа нэлээн нарийн зааж өгөх байх гэж бодож байна. Энэ дээр бол тээвэрлэлтийн хувьд Зам, тээврийн яам хариуцаж байгаагийн хувьд бид аль болохоор тээвэрлэлтийг Монголын тал өөрөө хийж, энэ тээврийн үр өгөөжийг өнөөдөр тээвэр хийж байгаа жолооч болоод тээврийн компаниуддаа үлдээх ийм асуудлаа ярьж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нямтайширын Номтойбаяр гишүүн асуулт асууя. Золжаргал гишүүний асуултад гүйцээж хариулт өгье. Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Энэ дээр дан ганц коксжих нүүрсний асуудал яригдаагүй. Манай бирж дээр нийтдээ коксжих 1/3 нь коксжих, эрчим хүчний ийм 3 нүүрс зарагдаж байгаа, борлуулагдаж байгаа. Тэгэхээр энэ гэрээ дээр бид энэ Хятадын талтай энэ 3 төрлийн нүүрсээ ярьж байгаа. Мөн энэ зүйлийн, чиглэлийн 11 дүгээр зүйл дотор бид энэ эрчим хүчний нүүрс экспортлох гээд энэ асуудлаа оруулж өгсөн байгаа гэдгийг хэлье.

Суурь үнэ дээр би түрүүн хэлсэн, үгүй ээ нүүрсний үнэ дээр. Суурь үнэ дээр нэмэх нь 5 биржийн борлуулалтын индексийг 5 цэгийн боомтын үнийг оруулж ингээд явж байгаа. Тэгээд энэ үнийн талаар боомтын талаар би танд мэдээллийг тусад нь өгье. Нүүрсний үнэ дээр ер нь цаашдаа бид яаман дээр олон улсын нүүрсний төлөв байдлыг харж үзэж байгаа. Мэдээж дэлхий нийтээрээ энэ ногоон эрчим хүч, ногоон шилжилт яригдаж байгаа энэ үе дээр эрчим хүчний нүүрсний хэрэглээнээс татгалзах ийм байдал аажмаар бага хэмжээгээр энэ чиглэл рүү явах ийм байдал ажиглагдаж, төлөвтэй байгаа. Харин энэ коксжих буюу энэ гангийн үйлдвэрлэлд хэрэглэх нүүрсний хэрэглээ бол хэвээрээ байна гэсэн ийм хандлага байгаа.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Золжаргал: Дэлгэрсайхан сайдаас тодруулж асуух гэсэн юм. Нөгөө 30 сая тонн хүчин чадалтай шүү дээ манай төмөр зам чинь. Энэ юу маань болохоор 20 сая тонн байна. Тэгээд 10 сая тонн дээр нь бусад худалдаж авсан нүүрсийг зөвхөн хил хүргээд зогсохгүй цааш нь Шинхуа компанийн эзэмшлийн төмөр замаар Хятадын дотоод сүлжээ рүү оруулах талаар ер нь яригдаж байгаа гэж дээр сонсож байсан. Тэгэхээр энэ зүйл энэ хэлэлцээр дээр маань яг цаасан дээр буух уу?

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Баярлалаа. Бид энэ төмөр замын гэрээг хийхдээ энэ тээвэрлэлтийн асуудлаа энэ дээр хамт оруулна. Төмөр замыг адил тэнцүү, тэгш эрхтэй ашиглана гэдгийгээ нэн тэргүүнд тохирсон байгаа гэдгийг хэлье энэ ташрамд. Ер нь 30 сая тонн нүүрс ачих зөөх ийм боломж бололцоо нь байгаа. Бид аль болохоор нэмэгдүүлэх, хэрвээ 2 талдаа энэ ачилтаа 2 талаасаа менежментээ сайн хийж чадвал 50 сая хүртэл ачих ийм боломжтой гэдгийг аль, аль талын төмөр замчид энийг илэрхийлдэг. Тэгэхдээ өнөөдөр ямар ч байсан холбогдоогүй байгаа төмөр зам дээр ийм амлалт өгөх нь буруу байх. Ямар ч гэсэн өргөн царигийн төмөр замаараа 10 сая тонныг гаргахад цаанаа нөгөө өөрөөр хэлбэл бид задгай вагоноор.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье Дэлгэрсайхан сайдад.

Б.Дэлгэрсайхан: Цаад талдаа Ганцмодны төмөр замын ачиж буулгах терминал нь өөрөө вагоноо хөмөрч буулгах ийм байгууламжтай. Энэ нь 10 сая тонныг буулгаад, цаашаа дамжуулаад ачих ийм боломжтой юм билээ. Бид нүдээрээ очиж харсан. 20 сая тонн нь чингэлэг тээврээр гаргах учраас энэ бол нарийн царигаар ингээд гарчихна. Тэгээд цаашдаа Хятадын тал юу гэж байгаа вэ гэхээр бид энэ хөмөрч ачиж буулгах байгууламжаа ингээд менежментийг нь сайн хийгээд,

дамжуулан ачилтаа нэмэгдүүлж чадвал ахиад 10 сая, 20 саяыг нэмэх ийм бололцоотой гэж илэрхийлсэн учраас 50 сая тоннд хүрэх боломжтой гэдгийг энэ ташрамд хэлж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нямтайширын Номтойбаяр гишүүн асуулт асууя.

Н.Номтойбаяр: Энэ хэлэлцэж байгаа соёрхон батлах гээд байгаа хуулийн үндсэн нэг задаргаа нь 1 дүгээрт нүүрсний гэрээ байгаа юм, 2 дугаарт төмөр замын холболт байгаа юм, 3 дугаарт цаашдын стратеги хамтын ажиллагаа ялангуяа энэ нүүрсэнд гүн боловсруулалт хийх, сэргээгдэх эрчим хүч гээд ийм ач холбогдолтой. Уг нь нүүрсний гэрээг Чайна Энержи нь Эрдэнэс Тавантолгойтой байгуулчих, төмөр замын холболтын асуудлыг Засгийн газар л хийчих ийм бид эрх зүйн зохицуулалттай. Гэтэл өнөөдөр яагаад бид Улсын Их Хурлаар энэ асуудлыг соёрхон батлах болов, юу болж өнгөрөөд өнөөдөр хүртэл бид ийм байдалд хүрээд байна вэ гэдгээ бодчихмоор асуудал байгаад байгаа юм л даа.

Яах аргагүй өнгөрсөн 10 жилийн хугацаанд тэгээд л нарийн цариг, нарийн царигаар төмөр зам барих юм бол танк ороод ирнэ, тэгээд л гаднынханд 100 жилээр газар нутгаа алдана, энэ Эрдэнэс Тавантолгой нь ингэх гэж байна, тэгэх гэж байна гээд л үндсэндээ ингээд нэг улс төрийн хэрүүл, Ерөнхий сайдын хэлээд байгаа энэ бүлэглэлийн эрх ашгуудын хоорондын зодооны үр дүнд бид гаднынхны өмнө нэг луйварчин хулгайч болж харагдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нэг том сургамж болоод, цаашдаа нэг ийм асуудал үүсэхгүй байх, Монголын төр нэг жанжин шугамтай, хууль нь ягштал хэрэгждэг, аливаа хууль тогтоомжийг гаргахдаа нэг алсыг харсан, ойрын нэг хэдэн жилдээ хөндөхөөргүй холч байдлаар хандмаар л байгаад байгаа юм.

Өнөөдрийн хэлэлцэх энэ 3 хэлэлцээрийн суурь үүх түүхийг нь сөхөх юм бол дандаа л ийм асуудлууд байгаад байгаа. Тэгэхээр энэ асуудлуудыг өнөөдөр хэдийгээр энэ гэрээнд дагалдаж орж ирж байгаа хэдэн нөхцөлүүд хамгийн 100 хувь бидний эрх ашигт нийцэхгүй ч гэсэн энд нөгөө нийцэж байгаа бодит боломж нь энэ байгаад байгаа юм. Хамгийн сайн үр дүн байж болох боломж нь. Тэгээд ний нуугүй хэлэхэд Ерөнхий сайд энэ дээр сайн ажиллаж, Засгийн газар. Улс төрийн зөвшилцлийг Их хурлын дарга аятайхан олчхож. Тэгэхээр иймэрхүү байдлаар бид ажиллах нэг зарчим тогтоомоор байх юм.

Нөгөө талдаа энэ нэг өнгөрсөн 10 жил өрнөсөн энэ хэрүүлийг нэг талд нь гаргамаар байгаад байгаа юм. Эсвэл хоёулаа буруутай байдаг юм бол хоёуланг нь хариуцлагыг нь тооцохгүй бол дахиад л ингээд нэг толгой илсэн байдлаар явах юм бол болохгүй шүү дээ. Хууль нь бэлэн байгаа шүү дээ. Тэгэхээр энэ асуудал дээр Ерөнхий сайд маш хатуу зоригтойгоор байр сууриа илэрхийл. Энэ ингээд нэг үүх түүх маань үүгээр дуусаад, Монголын төр нэг төр шиг байдаг, аль ч нам нь засагласан, аль ч намууд нийлээд засагласан нэг жанжин шугамаа барьж явдаг, хуулиа дээдэлдэг, гаднынхны өмнө хүлээсэн үүргээ биелүүлдэг, өөрсдөдөө ашиг хонжоотой байх энэ нөхцөлийг бүрдүүлмээр байна л даа.

Ораногийн асуудал ингээд л удахгүй орж ирнэ. Мөн л адилхан. Сүүлдээ бид чинь явж, явж тэгээд л 50 сая долларын төлбөрт унаад л дууссан. Тэгэхээр энэ дээр нэг үүгээр нэг маш том нэг дүгнэлт хиймээр байгаа юм. Энэ гэрээ соёрхон батлагдсанаараа ингээд болчихлоо гэж баярлах ерөөсөө шаардлага байхгүй. Хэнд нь буруу байгаад байсан, одоо ингээд маргаад байна л даа. Чалкогийн гэрээ л гэнэ,

нарийн, өргөн төмөр замын асуудал л гэнэ, лицензийн асуудал л гэнэ, танайх, манайх л гэнэ. Энийгээ больчихмоор байх юм. Эргээд бүх юм баримт нотолгоотойгоо байгаад байгаа шүү дээ, хангалттай байгаа. Тэгээд буруутайд нь хариуцлагыг нь онооё л доо.

Дахиад нэг ийм асуудал үүсэхгүй байх тал дээр энэ шинэ Үндсэн хуулиар бүрдсэн 126 бид ажилламаар байгаад байгаа байхгүй юу. Тэгээд л нэг чи, би, чи, би гээд нэг чичлээд байх биш. Одоо энийгээ гишүүдээ больцгоо. Адаглаад энэ асуудлыг хэлэлцэж байхад гаднынхан анхааралтай харж л байгаа. Маш анхааралтай харж байгаа. Энэ нэг чи, би гэдэг хэрүүлээ больчихмоор байна. Тэгээд энийгээ дэмжээд л явчихъя. Дараа дараагийн асуудлууд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна.

Н.Наранбаатар: Хамтарсан Засгийн газар байгуулагдаад энэ олон жил гацсан энэ том төслийг хөдөлгөх гэж байгаад талархалтай байгаа. Тэгээд бид нэг зайлшгүй анхаарахгүй их бага яригдаж байгаа зайлшгүй анхаарахгүй нэг асуудал байна. Энэ төсөл хэрэгжсэнээрээ Өмнөговь Цогтцэций сумд уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэхийг дагаад шинэ томоохон суурьшлын бүс бий болж, олон хүмүүс тийшээгээ очиж ажиллана мэдээж. 30 сая тонныг өнөө жил олборлож байна. Ингээд 27 сая гээд ингээд нэмэгдээд явахаар 60-аад сая тонн нүүрс жилдээ олборлоно. Цогтцэций сумд бүртгэлтэй 10 мянга, тэгээд бүртгэлгүй ирж, очдог 21 аймаг, 9 дүүргийн хүмүүс л байгаа. Ингээд 20-иод мянган хүн ингээд ажиллаж, амьдардаг.

Тэгээд сум их асуудалтай. Энэ даацыг үнэхээр даах багтаамж байхгүй. Сургууль, цэцэрлэг, одоо байгаа сургууль нь гэхэд л дээвэр нь нураад хүүхдийн толгой хагалчихлаа л гэж байдаг. Тэнд очсон ажилчид, уурхайчид маань орох орон байхгүй, түрээсэлье гээд ч байхгүй, мөнгө нь байгаад орон сууц байхгүй, ус нь хүрэлцээгүй, ундны ус хүрэлцээгүйн дээр одоо байгаа ундны ус нь маш чанар муутай ийм устай байдаг. Мөн технологийн уурхайн зориулалтаар нэлээд их ус хэрэгцээтэй болно. Одоо байгаа уурхай баяжуулах үйлдвэрийг хангах ус хүрэлцээ муутай байж байдаг. Ингээд маш том суурьшлын бүс бий болоод ингээд явна. Тэнд очоод ажиллах ажилчид яг өнөөдөртөө бол энэ том төсөл хэрэгжихэд тэр суурьшлын бүсийн хувьд хангалтгүй байгаа юм.

Ер нь Эрдэнэс Тавантолгой компани Цогтцэций сумын шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг хөрөнгө төсвөө гаргаад хийлгэчихсэн байгаа юм. Тэгээд энийгээ цааш нь ингээд дэд бүтцийг нь хийгээд, усыг нь, цахилгааныг нь татаад ингээд хийх ажил ингээд үлдчихсэн. Хөрөнгө төсөв нь шийдвэрлэгдээгүй ийм байдалтай байж байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ томоохон төсөл ингээд хэрэгжээд явахаар зэрэг зайлшгүй энэ нөгөө суурьшлын бүсийнх нь асуудлыг хамтад нь зэрэг эхлүүлж явахгүй бол болохгүй ийм дүр зураг харагдаж байгаа. Тэгээд энэ Их Хурлын тогтоолын төсөлдөө тусгаж оруулж өгөх юм уу аль эсвэл хөрөнгө оруулалтын гэрээндээ тусгаад оруулаад цаашдаа явах юм уу гэдэг дээр асууя гэж ингэж бодож байна. Тэгээд дараа нь тодруулъя.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Би Наранбаатар гишүүнтэй санал нэг байна. Ийм асуудал ганц Цогтцэций биш, Ханбогд, Замын-Үүд гээд олон газрууд байдаг юм. Энэ асуудал бол өнөөдрийн хэлэлцэж байгаа 2 улсын хоорондох энэ юу 3-ыг, 3 төслөө цогцоор

нь хэлэлцэх энэ асуудалд хамааралгүй манай дотоодын асуудал учраас. Бид энэ дээр мэдэж байгаа та өөрөө, бид саяхан өнгөрсөн парламентаар Хот, тосгон нутаг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн ийм хууль баталсан байгаа. Тэгээд ингэснээрээ Цогтцэций, Ханбогд, Замын-Үүд бүгд орон нутгийн хот болсон. Энэ ингээд 25 оны хагас жилээс энэ хуулиуд хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлнэ. Тэгэхээр энэ хуулийн дагуу мэдээж тухайн сум орон нутаг, аймаг орон нутаг өөрийн гэсэн төсөвтэй, хөрөнгөтэй ингээд энэ асуудлаа шийдэх ийм бүрэн боломж бололцоотой учраас бид өнөөдөр энэ асуудлыг энэ манай дотоодын асуудал учраас энийгээ тусдаа ярьж, шийднэ гэдэгт итгэл төгс байна.

Тэгээд энэ дээр бол бүгдээрээ манай энд сууж байгаа энэ асуудлууд бүгдээрээ л манай Их Хурлын гишүүдэд хамаатай. Ялангуяа өнөөдөр манай тэр тойргоос гарсан Наранбаатар гишүүн бид 2, мөн бусад гишүүд манай Мөнхбат гишүүн, мөн аймгийн Засаг даргаар ажиллаж байсан, Засаг даргаар ажиллаж байсан манай гишүүд энэ тэр бүгдээрээ байгаа болохоор энэ дээр хамтдаа энэ бүгдийг шийднэ гэдэгт итгэлтэй байна гэж хариулъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүн тодруулж асууя.

Н.Наранбаатар: Эрдэнэс Тавантолгой компанид нэг хүсэлт байгаа юм. Тойргийн гишүүний хувьд. Сая өнөө Цогтцэций сумын тэр эхлүүлээд орхисон 980 хүүхдийн сургуулийн үлдэгдэл төсөв 9,8 тэрбум төгрөгийг нь улсын төсөвт суулгах гээд өнөө зардал хас гээд тэр нь хасагдчихсан юм. Тэгэхээр ирэх жилийнхээ төсвийг ярихдаа энийг оруулах боломж байгаа юу, үгүй юу гэсэн тэгээд ийм асуулт.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 16 цаг 40 минутаас хуралдааныг даргалав.

Х.Булгантуяа: Тэгвэл Эрдэнэс Тавантолгой хариулах уу? Ажлын хэсгийн микрофон 21 дүгээр микрофон.

Х.Мөнхжаргал: Гишүүний асуултад хариулъя. Эрдэнэс Тавантолгой компани Цогтцэций сумын шинэ суурьшлын бүсийн 50 мянган хүнтэй хотын ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар нь хийлгээд, сум, аймагт батлуулаад, сум, аймагт нь хүлээлгээд өгчихсөн байгаа. Үүнтэй холбоотойгоор 2025 оны компанийн төсөвт 600 айлын орон сууц, 240 хүүхдийн цэцэрлэг, 960 хүүхдийн сургууль бол 25 оны төсөвтөө оруулсан байгаа. Яах вэ компанийн Төлөөлөн удирдах зөвлөл хэлэлцэж батлах ёстой. Саяын таны хэлсэн асуудлыг би компанийнхаа Төлөөлөн удирдах зөвлөлдөө уламжилъя. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан.

Б.Жаргалан: Монгол Улсын хувьд аливаа бодлогын цөм нь гадаад бодлого байдаг. Тэгээд жижиг, нээлттэй эдийн засгийн хувьд ч тэр манай эдийн засгийн бодлого бол гадаад бодлого. 2 том хөршийн дунд орших ардчилсан тогтолцоотой улсын хувьд ч тэр манай улс төрийн бодлого гадаад бодлого. Тэгээд өнөөдөр Их Хурал энэ манай урд, хойд хөрштэйгөө, мөн гуравдагч хөрштэйгөө ийм маш тийм гадаад бодлогын хувьд чухал ач холбогдолтой гэрээ хэлэлцээрүүдийг хэлэлцэж байна. Тэгээд Монгол Улс он удаан жил зуу зуун жилийн туршид хэдэн мянганаар тоологдох цаг хугацаанд яг энэ газар зүйн байрлал дээрээ тусгаар тогтнолоо хадгалж ингэж явж ирсэн. Үүнд манай өвөг дээдэс ч ур ухаан зарж, энэ олон хүчин

зүйлүүдийн дунд эх орондоо ашигтай тусгаар тогтнолоо бэхжүүлэх тал дээр ийм ур ухаан зарж ажиллаж ирсэн юм.

Тэгэхээр энэ гал барьдаг онцгой тэр үүрэг өнөөдөр та бидний өмнө ирчхээд байна. Тэгэхээр энийг би онцгойлон хэлэхийг хүссэн юм. Яагаад вэ гэхээр бид олон улсын нөхцөл байдлын хувьд тийм маш эгзэгтэй ийм цаг мөчид амьдарч байна. Тэгэхээр энэ бол бид нарын хувьд анхаарах нь маш чухал зүйл байгаад байгаа юм. Монгол Улс эдийн засгаа тэлэх ёстой, хил холболтуудаа хийх ёстой, гадаад худалдааны эргэлтээ улам бүр нэмэгдүүлэх ёстой. Тийм учраас энэ хил холболтын асуудлыг, боомтуудыг шинээр нээх асуудлыг дэмжиж байгаа. Ардчилсан нам энэ эдийн засгаа тэлэхийн тулд энэ хамтарсан Засгийн газарт орсон гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ зүйлүүд явах ёстой.

Нөгөө талаасаа аливаа улс оронтой хийгдэх аливаа гэрээ хэлэлцээр бол нэн түрүүнд Монгол Улсад үр өгөөжтэй, Монгол Улсад ашигтай, Монголчуудын амьдрал ахуйд тус дэмтэй ийм бодлого байх ёстой. Тооцоо, төлөвлөгөө нь ч гэсэндээ тэгж гарах ёстой. Тэгэхээр бид өнгөрсөн хугацаанд болсон үйл явдлуудыг ярихаасаа гадна ер нь энэ ирээдүйд ямар өгөөж бий болох юм бэ, ирээдүйд энэ хэдэн хүн ажлын байртай болох юм, Монгол хэдэн компани ажил, орлоготой болох юм гэдэг зүйлүүдээ тогтож яримаар байгаад байгаа юм. Тэгэхээр нөгөө ийм зовлон үзсэн гэдэг утгаараа өнгөрсөн хугацаанд ингэж алдсан юм шүү та минь ээ энэ тэр гэсэн яг л тийм яриа давамгайлаад байгаа нь төдийлөн оновчтой биш байж болох юм. Яагаад гэхээр бид ирээдүйд бий болох тэр зүйлүүдээ илүү нухацтайгаар ярих шаардлагатай гэж харж байна л даа.

Тэгэхээр энэ одоо бид нарын хэлэлцэж байгаа энэ орж ирж байгаа тогтоол 1 дүгээрт ийм төмөр замын бодлогын асуудал, нөгөө тал дээр Тавантолгойн ордтой холбоотой асуудал байгаа. Тэгээд ийм 3 зүйл яригдаад байгаа юм. 1 дүгээрт энэ төмөр замын хил холболтыг хийх асуудал, үүнтэй холбоотойгоор дараачийн хилийн боомтуудыг нээх тухай асуудал, мөн урт хугацаанд нүүрс худалдах, худалдан авах гэрээ. 16 жилийн хугацаанд бид урт хугацааны гэрээ байгуулна гэж байгаа. Үүнтэй холбоотойгоор 27 сая тонныг эхний 4 жилдээ, ирэх 4, ирэх 12 жилд нь болохоор жил бүр 20 сая тонн гээд нийтдээ 267 сая тонн нүүрсний урт хугацааны гэрээний тухай яригдаж байна. Үүнийг бол ирэх жилийн төсөвт тооцсон нүүрсний үнээр бодоод үзвэл ойролцоогоор 34 тэрбум долларын асуудал яригдаад байгаа юм.

Энэ дээр урт хугацааны гэрээ байгуулагдахад ямар хэмжээний хөнгөлөлт бий болж байгаа билээ, бид ямар тийм discount үзүүлж байгаа вэ гэдгийг манай гишүүд удаа дараалан асуух шиг боллоо. Үүн дээр яг нэг тодорхой тоо сонсогдохгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ нэг тоогоо яг тодорхой хэлээд өгөхийг хүсэж байна. 2 дугаарт уурхайн хүчин чадлыг, 3 дугаарт нь болохоор уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх буюу Тавантолгой дээр шинэ 2 ам нээх тухай асуудал яригдаж байгаа. Үүн дээр нөгөө олборлогч компанийн асуудал яригдана. Мөн олборлолтын өртгийн тухай асуудал яригдана. Үүн дээр жишээлбэл.../минут дуусав/

Х.Булгантуяа: 1 минут Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Тэгэхээр энэ Тавантолгойн уурхай дээр шинээр ам нээж байгаа дээр оператор компанийн асуудал, ажиллах хүчний асуудал яригдана. Үүн дээр ямар тооцоо судалгаа гэрээ хэлэлцээрийн түвшинд хийгдэж байгаа юм бэ гэдгийг лавлахыг хүсэж байна. Ямар ч байсан гэсэн бид энэ зүйлүүдээ хийгээд явах нь зөв

гэж харж байгаа. Тэгэхдээ нөгөө талаас энэ тооцоо судалгаанууд дээрээ яг саяын хэлдгээр энэ үндэсний эдийн засагт, үндэсний аж ахуйн нэгжүүдэд дээр, Монголчуудын амьдрал, аж ахуйд нь ямар нөлөө үзүүлэх юм бэ гэдэг дээр яг тодорхой тоонуудыг манай сайд нар хэлмээр байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Туваан сайд хариулах уу? Ямар хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж байгаа юм бэ, дотоодын бизнесүүдэд ямар өгөөжтэй байгаа вэ гэдэг талаар. Туваан сайдын микрофоныг өгье.

Ц.Туваан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Энэ дээр 3 асуудал байгаа. Таны хэлдэг үнэн. Энэ 3 асуудлын 2 дахь буюу энэ нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний асуудал байгаа. Энэ гэрээ дээр бол нэлээдгүй зүйлүүдийг ажлын хэсэг дээр ярилцаад тохирсон байгаа. Үнийн хувьд яг эцэслэж тохироогүй байгаа. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талын санал бол манай улсын төрийн өмчит болон хувийн компаниудад урт хугацаанд борлуулж байгаа үнийн аргачлалаараа бодоод өгөөч гэдэг ийм саналыг тавьсан байгаа гэдгийг хэлье. Энэ Эрдэнэс Тавантолгой компани борлуулж байгаа 4 компанийн үнэ байгаа. Тэгээд энэ үнээс дордуулахгүй нөхцөлөөр өгөөч гэдэг зүйл байгаа. Тэгэхээр үнийн хувьд бол эцэслээгүй байгаа гэж ойлгож болно.

Энэ 3 асуудлын 3 дугаарт нь бол энэ уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэдэг асуудал байгаа. Би түрүүн хэлсэн. Энэ дээр яг өнөөдрийн хүчин чадал бол Эрдэнэс Тавантолгой маань 30 сая тонныг олборлож, борлуулж байгаа. Тэгээд дахиад 20 сая тонн гээд, 30 оноос хойш 20 сая тонноор нэмэгдүүлэх юм бол бид шинэ ам нээж байж тэндээсээ олборлолт хийж байж явуулах ийм шаардлага үүсээд байгаа. Тэгэхээр энэ уурхайн хүчин чадал нэмэгдүүлэх асуудал дээр нээлттэй тендер зарлаж байж, энэ дээр оператор компани нь сонгон шалгаруулалтын зарчмаар шийдэгдэнэ гэдгийг хэлье.

Тэгээд мэдээж энэ бол зөвхөн бид Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах чиглэлийг Улсын Их Хурлаас авч байгаа ийм Их Хурлын тогтоолын төсөл. Тэгээд үүнийг баталсны дараагаар 2 улсын Засгийн газар хэлэлцээр дээрээ сууна. Тэгээд хэлэлцээрээ баталчхаад, Улсын Их Хурлаар соёрхон батлуулсны дараагаар компани хооронд, аж ахуйн нэгжүүд хоорондын гэрээнүүд явна. Тэгэхээр энэ гэрээнүүд дээр маш тодорхой нарийн заалтууд нь ороод тусаад ингээд явна гэдгийг хэлье. Тэгээд энэ дотор энэ нөгөө ажиллах хүчний асуудал, Монгол компаниудын асуудал, мөн туслан гүйцэтгэгч байх уу энэ тэр гэдэг ийм асуудлууд ороод явна гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар.

Л.Мөнхбаатар: Өнөөдөр бид Монголын эдийн засгийг жилд 1,5 тэрбум доллароор тэлэх, нийтдээ 30 гаруй тэрбум долларын төслийн хугацаанд хэрэгжих ийм томоохон асуудлыг хэлэлцэж байна. Гашуунсухайт-Ганцмодны боомтын хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтын асуудлыг Монгол Ардын намын бүлэг хэлэлцээд бүрэн дэмжсэн. Энэ хэлэлцээрийн энэ тогтоолын гол агуулга бол 2 улсын Засгийн газар хоорондын буюу олон улсын гэрээ болж байгаа. Энэ агуулгаараа нэг талдаа энэ гэрээ хэрэгжих бүрэн нөхцөл нь бүрдэж байгаа гэсэн үг хууль, эрх зүйн хувьд. Нөгөө талаасаа 2 талдаа харилцан хариуцлага хүлээж байгаа гэдгийг энд хэлэх нь зүйтэй.

Бид энэ хэлэлцээрийг явуулахад Засгийн газарт тодорхой чиглэл өгч, баримтлах чиглэл, хэлэлцээрийн хүрээ хязгаарыг тогтоосон энэ тогтоолыг бид өнөөдөр ингээд хэлэлцэж байна. Энд бол энэ хүрээ хязгаар дотроо хэлэлцээрээ хийгээд ороод ирэх юм бол энийг соёрхон батлах бүрэн боломжтой гэж үзэж байгаа гэж үзэж болно. Энд 11 зүйл байгаа. Яг хэлэлцээрийн ерөнхий нөхцөлүүдийг зааж өгсөн. Эдгээртэй бүрэн санал нэг байгаа юм.

Энэ дээр 2 зүйлийг анхаарч үзэх шаардлага байгаа юм. Энэ өөрөө их томоохон бүтээн байгуулалтын ажил. 10 гаруй жил ингээд үргэлжилнэ зөвхөн төслийн хугацаанд гэхэд. Энэ хугацаандаа томоохон бүтээн байгуулалтууд хийгдэнэ, олон тэрбумын хөрөнгө оруулалтууд хийгдэнэ. Энд мөн хэлцлийн нөгөө талын оролцогчоос гадна Монголын аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог хангах энэ асуудлыг энэ тогтоолынхоо төсөлд тусгах нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Тэгж байж хэлэлцээрийнхээ түвшинд ч тэр, энэ Улсын Их Хурлын тогтоолынхоо төсөлд энийг бол тогтоож мөн тодорхойлж өгөх нь зүйтэй. Ингэх юм бол Монголын аж ахуйн нэгж байгууллагууд, иргэд маань энэ том бүтээн байгуулалт, энэ том хөрөнгө оруулалтаас үр өгөөжөө хүртэх энэ боломжийг нь бүрдүүлэх талаар нь оруулах нь зүйтэй.

2 дугаарт ер нь энэ төмөр замын бүтээн байгуулалт хийгдсэний дараа нь жилд 30-аас 50 сая тонн бараа, бүтээгдэхүүн гарах нь байна. Энд бол монопол үүсгэхгүй байх асуудлыг нь юуны түрүүн анхаарч, хэлэлцээрийнхээ явцад авч үзэх ёстой. Үүнийг бас тусгах нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Монопол байдлаар биш, хэлэлцээр хийсэн нэг тал нь эхлээд 20 сая тонн гэдэг юм уу, тохирсон ачаа бараагаа гаргачихдаг, бусад аж ахуйн нэгж байгууллагууд нь тэр орчмын байгууллагууд бол ингээд дараалаад ороод баймааргүйгээр яг тэгш эрхийн зарчмаар энэ бараа, бүтээгдэхүүнүүд гардаг энэ нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг хэлэлцээрийнхээ ерөнхий нөхцөлд оруулж, энийгээ шийдэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Энэ 2 асуудлыг энэ удаа тогтоолдоо тусгаад явах нь зөв болов уу гэж бодож байна. Ажлын хэсэг байгуулагдах байх. Энэ дээр ажлын хэсэг дээрээ сайтар ярих нь зүйтэй байх гэж би бодож байгаа юм. Ер нь бид Улсын Их Хурал өөрөө Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг баталж өгсөн. Ингэхдээ 14 мега төсөл хэрэгжүүлэхийг даалгасан ийм чиглэл өгсөн. Үүний эхэнд нь эрэмбэлэгдсэн төсөл бол энэ төсөл. Тийм учраас энэ төслийг парламентад суудалтай намын бүлгүүд, парламентад суудалтай намууд бол бүгдээрээ бүрэн дэмжиж байгаа байх гэж бодож байгаа. Бүгдээрээ л экспортоо нэмэгдүүлье, эдийн засгаа тэлье гэсэн ийм мөрийн хөтөлбөртэй бүгдээрээ явж байгаа юм.

Нөгөөтээгүүр бид төсвөөс томоохон бүтээн байгуулалт хийх зүйл маань хумигдчихсан. Яагаад гэвэл алагдалгүй төсөв баталдаг болсон учраас ерөөсөө л олсноо зараад явж байгаа. Тийм учраас улс орныг хөгжүүлэх томоохон хэмжээний бүтээн байгуулалтуудыг энэ мэтчилний энэ төслүүдийг л явуулж байж бид улс орныхоо эдийн засгаа хөгжүүлэх, ард иргэдээ орлоготой болгох энэ боломж бүрдэнэ. Энэ агуулгаараа төслүүдээ нарийвчилж, хэлэлцээд, ойрын үед бүгдийг нь шийдээд явах юм бол Монголын эдийн засаг өсөх, ард иргэдэд хүрэх өгөөж нь нэмэгдэх боломж энд байгаа шүү гэдгийг хэлье гэж бодож байна.

Х.Булгантуяа: Мөнхбаатар гишүүн тогтоолтой холбоотой үг хэллээ. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн.

Ц.Мөнхбат: Бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ төмөр замын хил холболтыг бүгд дэмжиж байгаа гэдгээ илэрхийлж байна. Тэгэхдээ энэ гэрээ хэлэлцээр хийхэд Засгийн газарт өгч байгаа энэ чиглэлийн зарим зүйл, заалтаас ганц нэг зүйлүүдийг тодруулъя гэж ингэж бодсон юм. Гишүүд нэлээдгүй асуулаа. Зарим зүйлүүд дээр тодорхой хариулагдахгүй байна уу гэж бодоод асууж байгаа юм.

1 дүгээрт энэ 4 дүгээр зүйл дээр Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн багтаамж, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор Нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг Тавантолгой компанитай байгуулсан гэрээний нөхцөлд үнийн аргачлалыг жишиг болгож, гэрээний хугацааг 16 жил хүртэл тогтооно гээд ингээд заасан. Үнийн аргачлалыг сая хариулт дунд энэ Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас санал болгож байгаа 4 боомтын үнийг дундажласан маягтай юм уу нэг тиймэрхүү аргачлалаар бодно гээд ингэсэн байна. Тэгэхээр зэрэг энэ дээр энэ олон улсын манай нүүрс өөрөө энэ Хятадтай холбоотой нүүрсний экспорт нь. Тэгээд энэ олон улсын аргачлал гэж байдаг юм уу? Австрали улсаас нүүрс авахдаа манай айл ямар аргачлалаар явдаг юм, Оросын Холбооны Улсаас авахдаа ямар аргачлалаар явдаг юм бэ? Энэ аргачлалуудтай уялдуулах ийм боломж ер нь байдаг юм уу гэдэг нэг ийм асуулт байна.

2 дугаарт нь энэ нүүрсний хэмжээг 25-аас 29 онд 27 сая тонн, 30 оноос цаашаа 20 сая тонноос бууруулахгүйгээр экспортолно гээд нэг ийм нөхцөл ярьж байгаа юм байна. Түрүүн тэр Алдаржавхлан гишүүн асуусан байх. Энэ хэтэрвэл яах юм бэ? 27 сая тонноос хэтрээд 30 сая тонныг гаргах яах юм бэ? Илүү 3 саяыг нь авахгүй юм уу аль эсвэл өөр үнийн нөхцөлөөр нийлүүлэх юм уу гэдэг нэг ийм асуултыг асуумаар байна.

Ер нь тэгээд энэ манай Монгол Улсаас нүүрс экспортолж байгаа бусад аж ахуйн нэгжүүд бол өнөөдрийн энэ гэрээ хэлэлцээрийг маш анхааралтай ажиглаж байгаа байх гэж ингэж бодож байгаа. Зарим тохиолдолд нүүрсний үнэ буурахаар гарч байгаа, экспортын хэмжээ багасчхаж байгаа юм. Гэрээндээ хүрэхгүй, цаад тал нь авахаа больчихож байгаа гэж ингэж ойлгогдож байгаа. Тэгэхээр зэрэг бид энэ нийт Хятад улс жилдээ ер нь хэчнээн хэмжээний нүүрс хүлээн авах юм бэ гэдгийг энд оруулж болох уу? Жишээ нь түрүүн тэр Золжаргал гишүүн хэлэх шиг болсон, 120 сая тонн нүүрсийг жилдээ Хятад улсад экспортолно. Тэрний 20-оос 30 сая тонн нь энэ Чайна Энержи байх юм ч гэдэг юм уу нэг ийм нөхцөлүүдийг эндээ тусгаж болдог юм уу гэдэг нэг ийм асуулт байна. Тэгэхгүйгээр зөвхөн Чайна Энержитэй нүүрс нийлүүлээд байвал бусад аж ахуйн нэгжүүдийн авдаг нөгөө трэйдер компаниуд чинь авахаа больчих юм уу эсвэл үнээ буулгачих юм уу нэг тийм нөхцөлүүд үүсэх үү, үгүй юү гэдэг ийм зүйлийг асуух гэсэн юм.

Эцэст нь энэ 10 дээр байгаа юм. Бусад нөгөө хил холболтыг үе шаттайгаар эхлүүлнэ гээд. Энэ Гашуунсухайт-Ганцмодны боомтын төмөр замын бүтээн байгуулалтыг хийсний дараа ямар хугацааны дараа энэ бусад боомтуудыг холбох ийм төлөвлөгөө байгаа вэ гэдэг ийм 3 асуулт асуух гэсэн юм.

Х.Булгантуяа: Эхлээд Туваан сайд хариулах уу? Туваан сайд, дараа нь Дэлгэрсайхан сайд хариулъя.

Ц.Туваан: Бид энэ хэлэлцээрийн 3 цогц гэрээний 2 дугаар асуудал дээр энэ нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний асуудал байгаа. Энэ асуудал дээр бараг 2 Ажлын хэсэг ажиллаад, энэ гэрээ дээрээ бараг үндсэндээ

тохирсон. Үнэнээс бусад зүйл дээр нь бид тохирсон байгаа. Тэгээд үнэ дээрээ бид ярилцаж байгаа. Би түрүүн хэлсэн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Чайна Энержи компанийн талаас бол та нар манай улсад борлуулж байгаа 4 компанийнхаа үнийн аргачлалтай аргачлалаас дордуулахгүйгээр манайтай гэрээ хийчхээч гэдэг ийм зүйлийг тавьж байгаа. Энэ дотор энэ Чалко компанийн үнэ бас байгаа. Тэгээд эд нар бол бүгдээрээ бараг адилхан шахуу үнэ байгаа. Тэгээд Чалко компанийн үнээр жишээ авч бодоход суурь үнэ, дээрээс нь суурь үнэ дээрээсээ тэр Хятадын 5 нүүрс арилжаалж байгаа 5 цэгийн борлуулалтын үнийн индексийг тодорхой хувиар хувилж ингэж үнэ тогтоож байгаа гэдгийг хэлье.

Энэ хэмжээ бол 27 сая тонн 1 жилд гарах хэмжээ биш, энэ бол нийтдээ 25-аас 29 оны хооронд 5 жилд эхний 3 жил 5, 5 сая тонн, дараагийн 2 жилд 6, 6 сая тонн гэж тохироод нийт дүнг нь ярьж байгаа. Тэгэхээр энэ хооронд бид Эрдэнэс Тавантолгойн одоо олборлож байгаа амнаасаа 5-аас 6 сая тонныг нэмж олборлож, борлуулна гэж ингэж ойлгож болно.

Төмөр замын хил холболт холбогдсоноос хойш буюу 2030 оноос эхлээд ингээд жилдээ 20 сая тонн нүүрсийг борлуулна гэж байгаа. Энэ дээр энэ хэмжээг илүү, дутуу гэлгүйгээр ерөнхийдөө 2 талаасаа яг энэ хэмжээгээ барих хэмжээгээ л энэ дээр тавиад явж байгаа. Бүгд Найрамдах Хятад Ард Улс бол дэлхийн 2 дахь том нүүрсний хэрэглэгч ийм орон байгаа. Нэгдүгээрх нь Энэтхэг байдаг юм байна лээ, 2-т нь Хятад байгаа. Тэгээд жилдээ 3 тэрбум гаруй тонн сая тонн нүүрсний хэрэглээтэй. Бид нарын энэ харилцаж байгаа, гэрээ зурахаар яригдаж байгаа Чайна Энержи компани бол жилдээ 800 сая тонн нүүрсийг олборлож, гадна, дотнын улсуудаас худалдан авч, цааш нь цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд зарцуулдаг ийм компани байна лээ.

Тэр бусад төмөр замын асуудлыг маш чухал ярьж байгаа. Бид болдог сон бол энийг шууд ингээд зэрэгцээд явуулмаар байгаа. Гэвч Хятадын талаас нэг зарчмын асуудал ярьж байгаа нь эхлээд хэдүүлээ Ганцмод-Гашуунсухайт боомтынхоо хил холболтын асуудлыг шийдчихээд, дараа нь үе шаттай явъя гэж байгаа. Тэгэхээр бид гэрээ соёрхон.../минут дуусав/

Х.Булгантуяа: Мөнхбат гишүүн тодруулъя.

Ц.Мөнхбат: Бид хэд чинь энэ төмөр замаа барьчихвал энэ Гашуунсухайт чиглэлдээ 60, 70 сая тонн нүүрс гаргах гээд байгаа. Тэгээд энэ 20 сая тонныг нь Чайна Энержигийн гэрээтэй яриад, цаад 50-ийг нь бол одоогоор явж байгаа бусад гэрээнүүдээрээ явна гэж ойлгох юм уу, яана гэж ойлгох вэ? Энийг нэг тодруулаад асуучихъя.

Х.Булгантуяа: Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Таны хэлсэн зөв. Одоогоор Гашуунсухайт боомтоор авто тээврээр жилдээ 40 сая тонн нүүрсийг гаргаж байгаа, нэвтрүүлж байгаа. Төмөр замын тээвэр ашиглалтад энэ боомт ашиглалтад орсноор нэмж 30 сая тонн нүүрс экспортлох боломж бүрдэнэ. Тэгэхээр энэ боомтоор бол 70 сая тонн нүүрс экспортод гарна. Түүний 30 оноос хойш 20 сая тонныг нь Чайна Энержи компанид, бусдыг нь бусад компаниудын биржээр худалдан авсан болон гэрээнийхээ дагуу авч байгаа нүүрснүүд эзэлнэ гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин. Түвшин гишүүн байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням. Дамдинням гишүүн байхгүй байна. Төслийн талаар Байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Нэр өгсөн дарааллын дагуу үг хэлэх гишүүдийг. Гишүүнээс эхэлье. Таныг индэрт урьж байна. 1 номерын индэр рүү очих уу. Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

П.Сайнзориг: Баярлалаа. Тогтоолын төслийг дэмжиж байгаа юм. Мөн ч их цаг алдлаа. Энэ цагны цаана Монгол Улсын маш том боломжууд хийсэн одсон. Яах вэ боломжийг алдаж байгаа энэ цаг хугацаагаа үргэлжлүүлэх үү эсвэл энэ дээр нь цэг тавиад зарим зүйлүүд дээрээ дүгнэлт хийгээд урагшлах уу гэдэг түүхэн сонголт дээр энэ парламент ирж байна. Энэ парламентын шийдвэр гаргах энэ боломжийг хамтарсан Засгийн газар зориглон яриа хэлэлцээрийг үр дүнтэй хийгээд оруулж ирж байгаад талархаж байгаа.

1 дүгээрт энэ бүх үйл явдлуудын холбоосыг би хэлмээр байгаа юм. Магадгүй өнөөдөр Үндсэн хуулийн өөрчлөлтийг 2023 онд хийж, холимог сонгуулийн тогтолцоог оруулж ирж энэ парламентыг давжаа парламентыг ингэж өргөжүүлж чадаагүй бол нөхцөл байдал дахиад тоглолтууд явахыг үгүйсгэхгүй л байсан байх. Тэгэхээр бид хэд энэ зарим зүйлүүдийн үр дүн, эерэг үр дүнгүүд ингэж гардаг юм байна, хамтран ажиллах бололцоо байдаг юм байна гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм.

Дээрээс нь Монгол Улсын нийтлэг эрх ашгийг бид улс төрийн сэдэв болгож маш олон жил явснаас болсон. Би зүгээр нийтлэг эрх ашиг дээрээ Монголчууд нэг талдаа институт хоорондоо, парламент дахь намуудын бүлэг, намууд нэг талдаа гарч чадахаар ямар үр дүн үзүүлж байсан бэ гэдэг зүйлийг Оюу толгойн тэр сүүлийн 2, 3 жилийн кейсийг хэлмээр байна. Бид хэд жижиг юу гэдэг юм тоглолтод орж гүйгээгүй, нэг талдаа байсны хүчинд Монголын нийт ард түмэн дээр бичигдчихээд байсан 2,3 тэрбум доллар тэглэгдсэн шүү. Тэгээд бид хэд энийг урагшлуулах, хөрөнгө оруулагч тал дээрээ ойлголцохгүй байсан зүйлүүдээ шийдэхийн төлөө ингээд явж байгаа юм. Тэгэхээр би индрээс хэлж байгаа юм энэ парламентын 80 орчим залуучууд нь шинэ байгаа. Бид улс төрийн соёлыг зөв эхлүүлж, Монгол Улсын нийтлэг эрх ашиг дээр мэдээж бат зогсох ёстой. Аливаа шийдвэрийг гаргахдаа сайн, мууг нь тунгааж мэдээж хэлэлцэлгүй яах вэ. Тэгэхдээ ийм зүйлүүдийг улс төржиж гадна, дотнын гар, хөлийн эрх ашигт авталгүйгээр гаргах нь ямар чухал вэ гэдэг зүйлийг л би эцэст нь индрээс хэлмээр байгаа юм.

Тэгээд өнөөдөр энэ асуудал зөвхөн нэг нүүрс зарж, тодорхой төсвийн орлого бүрдэх асуудал биш юм. Энэ төмөр замын холболт хийгдсэнээрээ төмөр замын саад бэрхшээл арилна. Өнөөдөр бид нарын мянган төгрөгөөр авч байгаа бараа материал, үйлчилгээний 150-аас 300 төгрөг нь тээвэр логистикийн зардал байгаа. Өнөөдөр жирийн бизнес хийж байгаа залуучууд захиалсан бараагаа Монгол Улсад авч ирж чадахгүй, маш олон боомтууд дээр түгжээ үүсчихсэн. Монгол Улс шиг Замын-Үүдийн боомт дээрээ барилгын материалаа татдаг, химийн бодисоо татдаг, хүнсээ татдаг, бүх зүйлээ татдаг, зорчигч нь энүүгээрээ давхар орж ирдэг ийм улс байхгүй.

Тэгээд бид энэ бүх зүйлүүд буюу өнөөдөр энэ Ганцмод-Гашуунсухайтын хил холболтын асуудлыг шийдэхгүйгээр энэ бизнес дээр ирж байгаа дарамтуудыг буюу бизнесүүд өнөөдөр ингэж байгаа шүү дээ тээвэр логистикийн асуудал хүнд байна. Үнэхээр төмөр зам дээр экспортод гаргах гэж байгаа бараа, бүтээгдэхүүнээ ч экспортлоход олдохгүй байна. Орж ирж байгаа бараа материалууд маань ч гэсэн гацаж, гацаж байгаад л орж ирж байна. Дээрээс нь хүний нөөц, тэгээд зээл олдохгүй байна. Энэ бүх зүйлүүд дээр бол энэ хэлэлцээр амжилттай явж чадах юм бол эерэг нөлөө үзүүлнэ гэдэг дээр бат итгэлтэй байгаа юм.

Тэгээд хэлэлцээрийн энэ өгөх энэ удирдамж чиглэл дээрээ нэг тодорхой 2 зүйлийг би анхаараасай гэж хүсэж байгаа юм. 1 дүгээрт тэр өмнө нь гарсан Улсын Их Хурлын тогтоолууд дээрээ уялдаагаа хангахгүй бол энэ ижил тэнцүү Улсын Их Хурлын тогтоолуудаар өгч байсан өөр, өөр зарчим байр сууриуд байж байгаа энэ дээрээ ингээд.../минут дуусав/

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар индэр дээрээс, 2 номерын индрээс.

С.Ганбаатар: Эрхэм хүндэт гишүүд ээ,

Бүдүүн, нарийн царигийн талаар Монголчууд олон жил маргалаа. Энэ нэг цэг тавьж дахиж ярихгүй болж байх шиг байна. Хэн нь буруутай вэ гэдэг дээр би түрүүн байр сууриа илэрхийлсэн. Тэгэхээр энэ ингээд цаашид яригдахгүй байгаасай гэж бодож байна. Тэгэхдээ хамгийн гол нь цаасаа харж байж, хэн нь яг аль шийдвэрийг дэмжиж байсан бэ гэдгээ нягталж харж байж ярьж байхгүй бол энэ их аюултай зүйл.

2 дугаарт энэ өнгөрсөн хугацаанд Монголын баялгийг гадагшаа гаргана, экспортолно, уул уурхайн уурхайн баялгаа ялангуяа экспортолно. Тамсаг, Соко гэж анх байгуулагдсан. Дараа нь хөрш оронд өгсөн. Дараа нь олон ийм олон тохиолдлууд байгаа. Харин энэ дээр Монголын төр хөрш орныхоо төртэй яаж яг энэ хил холболтын асуудлаараа, нүүрснийхээ асуудлаараа тодорхой бодлогоор хамтарч ажиллах анхны, анхны юу байх вэ баримт бичиг гарч байна. Энэ дээр миний гол хэлэх гээд байгаа зүйл гэвэл одоо ингэж Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээр байгуулахад баримтлах үндсэн чиглэлээ баталж байгаа энэ үед гол анхааруулах ёстой зүйл бол өнөөдрийн энэхүү нүүрсний гэрээ гэдэг нэг амттай бялуу өнөөдрөөс эхлээд Монгол оронд зогсох ёстой шүү гэдгийг л Ерөнхий сайдад бүүр онцгойлж анхааруулж хэлмээр байна.

Ерөөсөө хаа сайгүй л улс төрийн хүрээнд хамгийн их бузартуулж байгаа юм чинь нүүрсний гэрээ авмаар байна, тонн тутамд нь 3 доллар, 5 долларын унжуургатай гэдэг нэг ийм юм сонин, радиогоор ч гэсэндээ явах юм, тэр хэвлэл мэдээллээр ч гэсэн явах юм. Ийм байдал байхгүй болох шууд энэ хатуу хэлэлцээр хийж, хатуу шууд энийг хяналттай, Монголын ард түмэнд ашигтай байлгана гэж ойлгож байна. Бид өнөөдөр их ашигтай наймаа хийхээсээ илүү шударга л байх ёстой. Дундаас нь том, том, цөм, цөм хийдэг улс төрийн бүлэглэлүүдийн хулгай зогсох л явдал. Энэ бол бидний хамгийн хүсэж байгаа гол зүйл.

Энэ хэлэлцээрийг хийхийн төлөө Засгийн газар их чармайлт гаргасан гэдэгт би итгэлтэй байна. Ингээд 2 орны энэ үйл ажиллагаа дээр Монголын аж

үйлдвэрлэгч нарыг түлхүү оруулж, Монголын аж үйлдвэрлэгч нар бүтээгдэхүүнээ гаргадаг, боловсруулсан бүтээгдэхүүнээ гаргадаг ийм байх туйлын зорилгыг байнга энэ үйл ажиллагааны гол цөм болгож яваасай гэж хүсэж байгаагаа илэрхийлье.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 17 цаг 12 минутаас хуралдааныг даргалав.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн үг хэлнэ, 2 дугаар индэрт урья.

Ж.Золжаргал: Та бүхэндээ нэмж нэг санааг хэлье. Нөгөө нүүрсний хулгай энэ тэр гээд шуугиантай байх үед Монгол Улс Биржийн тухай хууль оруулж ирээд, бирж дээр худалдаалах болсон. Үр дүнгээ өгсөн, 2 жил дараалаад сайн явсан. Түүрүүн энэ салбарын яамны удирдлагууд хэлж байсан. 24 онд жишээ нь 15 сая биржээр нийтдээ 30 сая. Мэдээж зах зээлээсээ хамаарна, татан авалт байхгүй, эрэлт байхгүй бол унана. Гэхдээ энэ байхгүй болчихно гэсэн үг биш. Тэгэхээр яагаад энийг хэлж байна вэ гэхээр энэ том чухал ач холбогдолтой хил холболтын төмөр зам, түүнийг дагасан том хэмжээний, урт хугацааны нүүрсний гэрээний ач холбогдлын талаар бид ярихдаа бирж бол ерөөсөө буруу юм байсан юм гэдгийг нэвт шувт яриад уналаа. Энэ маань үр дүнгээ өгчихсөн гэдгийг бид мэдэж байгаа шүү дээ.

Тэгэхээр цаашдаа ч энэ нь бол байг, том худалдаа нь ч байг, том худалдаа нь биржийнхээ савлагааг тогтвортой байлгадаг, биржийн шинэ тоглогч нарыг оруулж ирдэг, заримдаа үнэ өсөх, хөөсрөх үед илүүц ашиг олдог ийм нөхцөлийг бол бид харна. Ингээд жишээ болгоод би энэ хэдэн жишээ байна л даа. Австралийн New castle, Европын Energy exchange, Индонез Jakarta futures exchange, Хятадын дотоодын спот маркетын нүүрсний Zhengzhou Commodity Exchange, Ньюйорк NYMEX exchange, Dalian exchange, Көүкинг гоулд, Термик гоулд, коксжих нүүрс, эрчим хүчний нүүрс, Казахстаны түүхий эдийн олон улсын бирж гээд жишээ бол байна. Хятадад дотор нь ийм цахим худалдаа ч зөндөө явдаг. Тэгэхээр аль, аль нь ингээд хослоод явах байх гэж найдаж байна. Дээрээс нь яах вэ нэмээд хэлэхэд энэ үнийн индексийг тогтоохдоо дотоод нэгэнт ингээд бирж бий болчихсон учраас тэрийгээ Хятадын зөвхөн дотоодын индексийг ашиглахаас гадна нэмж холиод, олон улсын нэг юм эш татаад, иймэрхүү байдлаар явах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нямтайширын Номтойбаяр гишүүн үг хэлнэ. Алга байна. Гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүдийг танхимд орж ирэхийг урьж байна.

Санал хураалт. 1.“Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 70,5 хувиар санал дэмжигдлээ.

“Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаяр, Пүрэвийн Батчимэг, Буланы Бейсен, сайд Алтангэрэл, манай Батболд, Р.Батболд гишүүн, Пунсалмаа гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Батжаргал, Жигжидийн Батжаргал гишүүн, Пүрэвжавын Сайнзориг гишүүн, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн нар дэмжсэнээр протоколд тэмдэглүүллээ. Нямтайширын Номтойбаяр гишүүн, ширээнийхээ булан дээр ингээд, Ганбат гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглүүллээ. Одоо Эдийн засгийн байнгын хороо хуралдаж, анхны хэлэлцүүлэгт бэлтгэнэ. Тэр хооронд дараачийн асуудал хэлэлцэнэ.

17.15 цаг

Долоо.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд оръё. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр баталгаажуулсан суурь зарчимд нийцүүлэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Их Хурлаас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр баталсан билээ.

Уг хуулиар Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Хөгжлийн сан, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сангийн хөрөнгийн эх үүсвэр, зориулалт, хуваарилалт, хөрөнгийн удирдлагын асуудлыг хуульчлан тогтоосон. Тодруулбал Ирээдүйн өв санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад, үлдэх хэсгийн 65 хувийг хуримтлалын санд уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын бүх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 34 хүртэлх хувьд ноогдох ноогдол ашгийг төвлөрүүлэн, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх, тэдгээрийн боловсрол, эрүүл мэнд, орон сууцны хэрэгцээнд зарцуулж байхаар зохицуулсан болно.

Эдгээр сангуудын эх үүсвэрийг Ашигт малтмалын тухай хууль болон Цөмийн энергийн тухай хуульд өөрөөр тусгасан байна. Тухайлбал Ашигт малтмалын тухай хуулийн 47².1-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт

малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг улсын төсөвт төвлөрөхөөр заасан байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн хувь эзэмшилд ноогдох орлогыг иргэдийн хадгаламжийн хуримтлалын санд төвлөрүүлэхээр тусгаж, Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2-т заасан газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш шударга хүртээх агуулга, зарчимд нийцүүлсэн байдаг.

Харин Ашигт малтмалын тухай хуулийн 47².2, 47².3-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болохоор зохицуулсан боловч тусгай төлбөрийн хувь хэмжээг тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрүүлэхгүйгээр Засгийн газар тогтоож, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх зохицуулалттай байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2-т заасан зарчим, түүнд нийцүүлэн гаргасан Үндэсний баялгийн сангийн орлого бүрдүүлэх зарчимтай нийцэхгүй байгаа юм.

Ард иргэдийн хуримтлалын санд төвлөрүүлэх орлогын эх үүсвэр стратегийн ордын 34 хувийн төрийн эзэмшлийн 5 хувиас хэтрэхгүй АМНАТ-өөр орлуулж байгаа нь учир дутагдалтай байгааг нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд, олон нийт шүүмжилж байна. Иймд Цөмийн энергийн тухай хуульд 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулахдаа илүү үр ашигтай хувилбарыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болохоор заасантай ижил зарчимд нийцүүлэх шаардлагатай гэж үзсэн болно.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн зарчимд нийцүүлж, хууль хоорондын уялдааг хангаж, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөлд Ашигт малтмалын тухай хуулийн 47².1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон Цөмийн энергийн тухай хуулийн 20¹.5-д заасан цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр, Цөмийн энергийн тухай хуулийн 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь хэмжээг бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэрэг хувилбараар орлуулснаар бий болсон татварын бус орлогыг иргэдийн хадгаламж, хуримтлалын санд төвлөрүүлэхээр нэмж тусгалаа.

Тус хуулийн төслийг дагалдуулан Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд Ашигт малтмалын тухай хуулийн 47².1-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг улсын төсөвт төлөхөөр заасныг өөрчилж, иргэдийн хуримтлалын сан, хадгаламжид төвлөрүүлэх зохицуулалтыг нэмж тусгав. Түүнчлэн тус хуулийн 47².3-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь хэмжээ нь тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрэхгүй байхаар заасныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоох зарчмыг нэмж тусгалаа.

Эдгээр хуулийн өөрчлөлтөөр байгалийн баялгаас олсон орлогыг Иргэдийн хуримтлалын сангаар дамжуулан иргэдэд тэгш, шударга хүртээх Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана хэмээн үзэж байна. Үндэсний баялгийн

сангийн асуудал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.3-д заасан эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудал юм.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

О.Батнайрамдал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагчийн зүгээс Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан болох Хөгжлийн сан, Ирээдүй өв сан, Хуримтлалын сангуудын эх үүсвэрийг Ашигт малтмалын тухай болон Цөмийн энергийн тухай хуульд зөрчилтэй байдлаар тусгасан нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан баялгийн санд төвлөрүүлэх эх үүсвэрийг бууруулахаас гадна, Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т заасан газрын баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш, шударга, хүртээмжтэй, зарчимд нийцэхгүй байна гэж үзэж хууль хоорондын уялдааг хангаж, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор уг хуулийн төслүүдийг боловсруулсан. Хуулийн төслүүдийг dparliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох зүйлийг хүчингүй болгох нь хуулийн бусад зохицуулалтад хэрхэн нөлөөлөх, хууль баталснаар Орон нутгийн хөгжлийн санд үзүүлэх нөлөөлөл болон борлуулалтын үр ашгийн тооцооллын талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг цаашид бизнесийн зарчмыг анхаарч, анхаарах шаардлагатай байгаа талаар болон Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн доод хэмжээг тогтоох асуудлыг судалж үзсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар татвар, хураамж бүрдүүлэлтэд ямар ахиц дэвшилд гарч байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчим болон холбогдох хууль, тогтоолын хэрэгжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Сэддорж Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр нэмэгдсэнээр орон нутагт бий болох үр өгөөжийн талаар асуулт асууж, хариулт авсан бөгөөд мөн Монгол Улсын Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд эдийн засгийн үр өгөөжийн тооцооллын талаар санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжих асуудлаар санал хураалт явуулахад оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, Улсын Их Хурлын чуулганд нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Батсүмбэрэл, Батшугар гишүүд дуугаа намсгая. Ажлын хэсгийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Доржсүрэнхорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар тус яамны Хуулийн хэлтсийн дарга, Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монголыг ХХК-ийн гүйцэтгэх захирал, Балжиннямын Гэрлээ Эрдэнэс Монгол ХХК-ийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэгт болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Нийт 11 гишүүн байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууна. Алга байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна. Алга байна. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууна.

Г.Уянгахишиг: Ажлын хэсгийнхнээсээ хэдэн зүйл тодруулж асууя. Ер нь энэ Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж байгаа. Яагаад гэхээр зайлшгүй бид 34 хувиа бусад өөр төрлийн хувьцаагаар орлуулах болон ашигт малтмалын Амнатиин тусгай төлбөрөөр орлуулах нөхцөлд яалт ч байхгүй нөгөө Ирээдүй өв сангийн, Ирээдүй өв сан болон Хуримтлалын сан 2-т хуваарилагдах үнийн дүн маань өөр болоод байгаа учраас энэ Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зайлшгүй байгаа гэдгийг ойлгож байгаа.

Энэчээнээс яах вэ хамгийн түрүүнд юу асуумаар байна гэхээр 11.1.2-ын Г дээр татварын бус орлого гэдэг нэмэлт орсон байгаа. Тэгэхээр энэ татварын бус орлого гэдэг дотор жишээ нь ямар орлогыг хэлж байгаа вэ? Энэ дээр жишээлбэл ямар төрлийн орлого байж болох вэ гэдгийг 1 дүгээрт асуумаар байна.

Дараагийн нэг тодруулах зүйл бол дагалдаж орж ирж байгаа буюу Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байгаа. Энэ дээр яалт ч байхгүй нөгөө өмнө нь ч гэсэн яригдаад байдаг нэг асуудал бас үүдэж гарч ирээд байгаа юм. Өөрөөр хэлбэл Ашигт малтмалын тухай хууль дээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тухай зохицуулалтууд яваад байдаг. Гэтэл нөгөө талаасаа Цөмийн энергийн хууль дээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод өөрөө хамаарч байгаа учраас энэ 2 дээр нөгөө Амнатиин тусгай төлбөртэй яг ийм цөмийн энерги дээр хязгаарлалт тогтоогоогүй боловч

Ашигт малтмалын тухай хууль дээр хязгаарлалт тогтоочихсон учраас энэ хоёрын хооронд нэг зөрчилдөөн үүсэх вий гэж өмнө нь ажлын хэсэг дээр ч ярилцаж байсан. Энэ утгаараа энэ өөрчлөлтийг оруулж байгаа юм байна гэдгийг ойлгож байна.

Гэхдээ ер нь цаашдаа Ашигт малтмалын тухай хууль дээр зөвхөн амнатаар орлуулах тухай боломжийг зохицуулсан байгаа. Харин цөмийн энерги дээр жишээлбэл өөр төрлийн хувьцаагаар болон бүтээгдэхүүн хуваах ч гэдэг юм уу боломжуудыг тусгаж өгсөн байгаа. Энийгээ цаашдаа Ашигт малтмалын тухай хуульдаа адил нөхцөл байдалтайгаар оруулаад явах юм бол энэ нь өөрөө нөгөө Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн энэ оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт дээр чинь орж ирэх боломжтой ийм хувилбарууд байсан учраас яах вэ яаралтайгаар оруулж ирж байгаа болохоор энэ удаадаа ингэж оруулж ирж байгаа юм байна гэж ойлгож байна. Гэхдээ дараа дараадаа бол Ашигт малтмалын тухай хуульд энэ зөвхөн Амнатаар биш, өөр бусад хувилбаруудыг оруулах боломжтой юу гэдэг 2 дахь асуулт нь байна. Ийм үндсэн 2 асуулт асууя даа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал хариулъя.

Н.Учрал: 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол энэ газрын хэвлийн баялгийн дийлэнхийг ард түмэн эзэмшинэ гэдэг бол 50+1-ийг хангуулах гэсэн ийм хэмжүүр. Тэгэхээр 19 оны Үндсэн хуулийн амилсан энэ цаг үе бол өнгөрсөн парламентын үед энэ Үндэсний баялгийн сангийн хууль батлагдсан. Үндэсний баялгийн сангийн хууль батлагдсанаараа энэ байгалийн баялгийн дийлэнхийг ард түмэн ямар хэлбэрээр эзэмших вэ гэдэг энэ арга механизм нь тодорхой болсон. Ингээд энэ Баялгийн сангийн хууль батлагдсанаас хугацаанд яг долоо хоногийн өмнө Засгийн газраас энэ Үндэсний баялгийн сангийн хууль амилаад төрийн өмчийн уул уурхайн компаниуд энэ хуримтлал руу ноогдол ашгаа шилжүүлснээр зөвхөн 5 уул уурхайн компани хуримтлал бий болгоход л 480 гаруй тэрбум төгрөг хуримтлагдсан. Ингээд үүнийг иргэд анх удаа ИМонголынхоо аппликэйшнийг гаргаад надад ийм хэмжээний хадгаламж байна гэдгийг хардаг болсон. Тэгэхээр энэ иргэдийн хуримтлалын сан.

Тэгэхээр Үндсэн хуулийн энэ суурь концепц бол өөрөө төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын 34 хувийг иргэд Хуримтлалын сангаараа дамжуулж эзэмшинэ. Үүнийг нь эрүүл мэнддээ, боловсролдоо, орон сууцдаа зарцуул гээд. Тэгэхээр төсвөөс гадуур эдийн засгаа тэлье гэвэл бид Үндэсний баялгийн сангийн орлогыг л нэмэгдүүлэх ёстой. Энэ утгаараа энэ хөрөнгө оруулалтын гэрээнүүд, энэ мега төслүүд өөрөө Үндэсний баялгийн сангийн орлогыг төвлөрүүлэхэд л чиглэж байгаа. Тэгэхээр бид төрийн эзэмшлийн 34 хувийг тусгай амнатаар орлуулах эсвэл бүтээгдэхүүн хуваахаар орлуулах тохиолдолд эргээд эцсийн дүндээ иргэдийн хадгаламж, иргэдийн хуримтлалын сан өсөж байх ёстой.

Гэтэл өнөөдрийн Үндэсний баялгийн сангийн хуулиар тусгай бол Амнат шууд улсын төсөвт төвлөрнө гээд заачихсаныг бид Цөмийн энергийн яг хуультай адилхан хэрвээ 34 хувийг Амнатаар орлуулж байвал түүнийг нь иргэдийн хуримтлалын данс руу нь хийе. Эргээд эцэстээ иргэд хуримтлалаа л авах нь чухал болохоос биш тэр 34 хувийг ноогдол ашгаар авна уу, эсвэл Амнатаар орлуулна уу, эсвэл бүтээгдэхүүн хуваахаар орлуулна уу гэдэг бол өөрөө тухайн хөрөнгө оруулалтын гэрээний кэйс дээр л суурилах ёстой. Тийм учраас аль ашигтай хувилбарыг бид гаргаж байгаа. Энэ утгаараа тусгай амнатаар орлуулбал иргэдийн хуримтлалын данс буюу энэ

мега төслийн үр дүн хэзээ гарах вэ гэхээр жил бүрийн эцэст энэ уул уурхайн компаниуд ашиг орлогоо ингээд эргээд харахад иргэдийн хуримтлалын дансанд тусгай Амнатын хэдэн төгрөг төлөгдсөн бэ гэдэг нь энэ гар утсан дээр нь харагддаг болж байж түүнийг эрүүл мэнд, боловсрол, орон сууцад зарцуулна.

Тэгэхээр төрийн эзэмшлийн энэ хувь хэмжээг бид тусгай Амнатаас гадна бүтээгдэхүүн хуваахаар орлуулж болно. Тийм учраас үүнийг нээж байгаа. Дээрээс нь тусгай Амнатын тэр дээд босго 5 хувийг нь байхгүй болгож байгаа. Яагаад гэхээр Их Хурал өөрөө тухайн тэр хөрөнгө оруулалтын гэрээ дээрээ нэгэнт Амнатаар оруулах шийдвэр нь Их Хурлын онцгой бүрэн эрхэнд байгаа учраас хэдэн хувийн Амнатаар орлуулах юм бэ гэдгийг Их Хурал эцэслэж шийдээд явах ийм эрх зүйн орчныг боловсронгуй болгож байгаа юм.

Д.Амарбаясгалан: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн тодруулж асууя.

Г.Уянгахишиг: Би энэ дээр татварын бус орлого гэдэг дээр яг ямар төрлийн орлогууд байж болох вэ жишээлбэл гээд асуусан. Тэрнийхээ хариултыг авчихъя.

Д.Амарбаясгалан: Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн хариулъя. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн. Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Орж ирж байгаа хөрөнгө оруулалтын гэрээний төсөлтэй холбоотойгоор энэ томьёолол орж байгаа. Ямар асуудал байгаа вэ гэхээр төрийн эзэмшлийн хувийг орлуулах дээр бид 1 дүгээрт тусгай роялтийн асуудал ярьсан 5 хувийн.

2 дахь асуудал нь хөрөнгө оруулалтын гэрээний төсөл дээр бид Монголын талын бүх өгөөж нэмэгдээд 51-дээ хүрэхгүй тохиолдолд өгөөж тохируулах нэмэлт төлбөр гэдэг энэ асуудлыг бид гэрээнд оруулсан. Тэгэхээр тухайн компанийн хөрөнгө оруулалт, зардал, өр төлбөр юу байдаг юм ингээд урьдчилан тааж болзошгүй нөхцөл байдлаас шалтгаалаад, Монголын тал тухайн жилдээ өгөөж нь 51-дээ хүрэхгүй буюу Үндсэн хуулийн заалт хангагдахгүй тохиолдолд энэ нэмэлт төлбөрийг авч хангагдаж явна. Энэ төлбөр бол өөрөө татвар биш. Энэ бол ногдол ашгийн шинжтэй ийм нэмэлт төлбөр байгаа. Энэ төлбөр өөрөө 34 хувьтай холбоотой гарч ирж байгаа учраас энэ Үндэсний баялгийн сангийн тухай хууль татварын бус ийм хэлбэрийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Энэ тусгай төлбөрийн асуудал Ашигт малтмалын тухай хуулийн дагуу болоод Цөмийн энергийн тухай хуулийн дагуу Үндэсний баялгийн сангийн 3 сангийн нэг болох Хуримтлалын санд ороод, тэгээд хуримтлалын данс маань арвижих нь. Тэгэхээр ер нь бол энэ дагаж орж ирж байгаа өөрчлөлтийг дэмжиж байгаа. Тэгэхээр Хуримтлалын сан арвижсанаар газрын хэвлийн баялгийн үр өгөөж Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээд, иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууц, орон сууцны зориулалтаар дэмжлэг байдлаар иргэнд хүртээмжээ бол өгнө. Тэгэхээр яг энэ журам нь журмыг, журмын дагуу зохицуулагдах буюу журмыг нь болохоороо Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хуучнаараа хариуцаад. Сая 12 сарын 20-нд Засгийн газраар бол батлуулсан юм байна. 5 сард иргэдээс санал аваад, 12 сарын 20-нд Засгийн хурлаар батлуулсан мэдээг авлаа. Тэгэхээр иргэдэд, Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээнэ гэдэг энэ зорилгодоо хэрхэн

хүрэхээр зохицуулалт суусан байгаа юм бол? Энэ дээр яг тийм тодорхой хариултыг авъя.

Д.Амарбаясгалан: Эрдэнэс Монголын захирал Наранцогт хариулт өгье. Ажлын хэсгийн 19 дүгээр микрофон.

С.Наранцогт: Уянга гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр тэр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гарч байгаа журам бол зарцуулалттай холбоотой журам гарч байгаа. Орлогыг зохицуулахгүй, орлого бол Үндэсний баялгийн сангийн хуулиараа зохицуулагдаж байгаа. Үндэсний баялгийн сангийн хууль яг Үндсэн хуулийн зарчим дээр одоо, ирээдүй гэсэн иргэдэд тэгш шударга гээд, тэгээд бид хуулиараа одоогийн иргэддээ боловсрол, эрүүл мэндэд нь шууд бусаар зарах хуримтлалын санг бий болгосон. Энэ хуримтлалын сангийн орлого бол одоо амьд сэрүүн байгаа бүх хүнд орсон орлого нь ижил тэнцүү хэмжээгээр хуваарилагдах юм. Одоогоор бол Эрдэнэс Монголоос хуримтлалын сан 487,7 тэрбумыг энэ жилийн хувьд төвлөрүүлсэн. Энэ төлбөр бол одоо амьд сэрүүн байгаа Монгол Улсын иргэдэд хуваарилагдаад ИМонгол дээр нэг хүнд 135 мянган төгрөгийн үлдэгдэл болж ингэж гарч ирж байгаа юм. Тэгээд энэ орлого нэмэгдэх тусам иргэдэд яг адил хэмжээгээр л бүх амьд сэрүүн иргэдийн дансанд нэмэгдэж орсон тухайн үеийн орлого бол ижил тэнцүү хэмжээтэй нэмэгдэнэ гэсэн үг. Тэгэхээр таны нөгөө ярьж байгаа тэгш, шударга гэдэг зарчим тэгж хангагдах юм.

Д.Амарбаясгалан: Чинбатын Ундрам гишүүн асуулт асууна. Алга байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Төслийн Орано компанитай байгуулах энэ гэрээний төсөл дээр тэр энэ төсөлд ажиллах ажилтнуудын амьдрах байр сууцны асуудал, тэгээд энэ тал дээр хэрхэн яаж байгаа вэ? Мөн төслийн хугацаанд гадаад ажилчдаас тодорхой хэмжээний ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, 10-аас дээш гарсан тохиолдолд төлнө гэж байх шиг байна. Энэ яг төслийн гэрээгээр байж байгаа юу эсхүл ерөнхийдөө жил болгоны Засгийн газраар оруулж ирж нөгөө гадаад ажилтных нь төлбөрөөс хөнгөлөх гэдэг саналаар явах уу гэдэг санал байна. Асуулт байна.

Мөн төслийн урьдчилсан гэрээ дээр яах вэ нэлээн олон чухал заалтуудыг оруулсан байна. Гэхдээ энэ төслийн хугацаа нэлээн урт хугацаанд үргэлжлэх учраас ялангуяа тэнд байгаа ажиллах гадаад, дотоод ажилчид, мөн хүрээлэн байгаа орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал гээд нэлээн өмнөх төслүүдийн юун дээр гарч байгаа маргаан энэ тэрийг гэрээ дээр тодорхой нарийн зохицуулахгүй бол гэрээний явцад ингээд үл ойлголцох асуудлууд гарч ирээд байдаг. Тэгээд энэ чиглэлээр би ажлын хэсэгт оръё гэдэг санал хэлсэн. Энэ хүрээндээ яах вэ энийг яриад явах бололцоотой юм байна. Тэгээд саяын 2 асуулт дээр тодруулаад санал авчихъя гэж хэлмээр байна.

Маш чухал нэг асуудал маань гадаадын мэргэжилтэн Монгол ажилтнуудын цалингийн зөрөө гээд, мэдээж ур чадварын зөрөөний асуудал байдаг. Гадаад хүн учраас олон улсын жишгээрээ явна. Монгол учраас манай улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний жишигтэй ойртуулж ярих гээд байдаг. Гэхдээ би өчигдөр мэдээлэл авчихсан учраас цалин хөлсний хувьд ерөнхийдөө дундаж цалин хөлсний асуудлыг бол тодорхой хэмжээгээр боломжийн хэмжээнд ярьж тохирсон юм байна лээ гэж ойлгосон. Тийм. Ийм санал хэлье.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал хариулт өгье.

Н.Учрал: Хөрөнгө оруулалтын гэрээ дээр энэ орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр болоод энэ хүний нөөц, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр нэлээдгүй анхаарсан. Ер нь энэ Үндсэн хуулийн 6.2 бол бид нарт тодорхой хэмжүүрийг тавиад өгсөн ухаас санхүүгийн өөрсдийнхөө схемийг бид анх удаа гаргаж байж, түүн дээрээ яг өгөгдлөө цуглуулж байгаад ийм нөгөө assumption таамаглалуудыг гаргаж байгаад, анх удаа өөрсдийнхөө санхүүгийн модель дээр гэрээ хийж байгаа юм. Тэгэхээр энэ санхүүгийн модель дээр гэрээ хийж байгаагийн гол онцлог бол энэ чинь ерөөсөө бүх таамаглал дээр нөгөө шинжилгээ хийж байна гэсэн үг. Тэгэхээр ялангуяа энэ орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр нэлээдгүй анхаарах ёстой.

Энэ утгаараа Дорноговь аймаг, тэр дундаа Улаанбадрах сум өнгөрсөн 4 жилийн хугацаанд энэ нийгмийн дэд бүтцийг, энэ ажлын байр бусад нийгмийн хариуцлагатай ажлуудыг хийх хүрээнд жилд 1 тэрбум төгрөгийг ингээд олгоод явсан юм байна лээ энэ төслөөс. Тэгээд бид төсөл уурхай ашиглаж эхлэх хүртэлх хугацаанд тэрбум төгрөгөөр яваад, уурхай ашиглаж эхэлсний дараа 1 сая долларыг энэ сум, орон нутагт нийгмийн чиглэлээр зарцуулахад аймгийн дарга, сумын дарга хамтарсан зөвлөл байгуулаад, төлөвлөгөөгөө гаргаад шийднэ. Тэгээд энэ хүрээндээ ингээд төслийн 20 жилийн хугацаанд яваад, 10 жил нөхөн сэргээх ажил эхлэх үед 1,1 сая доллар олгоно гэсэн ийм тохироотой.

Дээрээс нь Орон нутгийн хөгжлийн санд тодорхой мөнгө энэ Үндэсний баялгийн сангийн хуулийнхаа дагуу шилжинэ. Үүнээс гадна түрүүн энэ Эрдэнэбат гишүүний ярьж байгаа ер нь бол бид уурхайн олборлолт хийгдэж байх үед нийт ажилчдын 90-ээс дээш хувь нь Монгол Улсын иргэн байна гээд гэж ингээд хатуу тохиролцсон 90 хувь нь. Тэр үлдсэн 10 хувь дээр л гадаад ажилтан байна гэж тохирсон. Бүтээн байгуулалтын үе шатад төсөл хэрэгжүүлэгч компанийн нийт ажилчдын хамгийн багадаа 60 хувь бол хатуу байна гэж байгаа юм. Дээрээс нь сумын оршин суугч иргэд 5 хувиас багагүй байна гэж байгаа юм. Тэгэхээр ер нь ажлын байр нэмэгдэх нь ойлгомжтой. Тэгээд бид өгөөжийг тооцохдоо шууд өгөөж, шууд бус өгөөж, дам өгөөж гэж 3 янзаар тооцож байгаа. 50 + 1-ийгээ бол шууд өгөөжөөр хангуулж байгаа. Дам өгөөж, шууд бус өгөөж бол мэдээж энэ ажлын байрыг нэмэгдүүлэх энэ тэр дээр яригдаад явна.

Гол нь хөрөнгө оруулалтын гэрээнд бид Монгол ажилчид гадаад ажилчдын цалин хөлсний ялгамжгүй ялгаатай байдлыг арилгана. Нэг ёсондоо хүний нөөцөд шударга байдлын онол гэж байгаа. Авч байгаа, цалин оруулж байгаа хувь нэмэр тэнцүү байх гэсэн энэ зарчмыг барихаар хөрөнгө оруулалтын гэрээнд хатуу тусгасан. Нийт ажилтны 10 хувиас хэрвээ хэтрээд байгаа тохиолдолд бол ажлын байрыг заавал төлнө, ажлын байрны төлбөрийг. Тэгэхээр хөрөнгө оруулалт тал бол энэ хариуцлагыг хүлээлгэж байгаа. Тэгэхээр дам нөлөө, шууд бус өгөөж гэх юм мэдээж өндөр өгөөжийг ярьж болно.

Д.Амарбаясгалан: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Үзэл баримтлал дээр нэг ийм зүйл байгаа юм. 2 дугаар зүйлд хуримтлалын сангийн бусад орлогоос ялган төвлөрүүлэх журмыг тодруулан зохицуулна гээд заачихсан байгаа. Тэгээд энэ ямар журмаар ялгах зохицуулалт нь

орж ирж байгаа юм бол? Зүгээр хуулийн төслийг аваад үзэхээр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.2-т байгаа Хуримтлалын сангийн эх үүсвэрийг 2 заалтаар нэмэгдүүлээд, 11.1.2 болон, 11.1.2-ын А болон 11.1.2-ын Б дээр 12.9-д заасан үйл ажиллагаанаас гэдэг үг л нэмж байгаа юм. Тэгээд энэ ер нь ямар үр дүн, өөрчлөлтийг авчраад байгаа юм бол? Яг энэ 11.1.2-ын А, Б гэсэн 2 заалтад өөрчлөлт оруулснаар одоо байгаа нөхцөл байдал, орлогын дүн яаж өөрчлөгдөх юм бол гэсэн нэг дэх асуулт.

2 дахь нь энэ үзэл баримтлал дээр мөн тусгасан байгаа юм. Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж оруулна гэж. 47.².1 дэх хэсгийн улсын төсөвт төлнө гэснийг тооцно гэж өөрчилсөн байгаа юм. Тэгээд уг нь бол улсын төсөвт төлнө гэдэг үгээрээ яг энэ хуулийн одоо байгаа заалт нь нөгөө аж ахуйн нэгжийн үүрэг байгаа юм л даа. Тооцно болгоод өөрчлөгдчихөөр төрийн захиргааны байгууллагын үүрэг болж, энэ үүргийг аж ахуйн нэгжид хариуцуулах гэж байгаа юм шиг ийм нэг зарчмын ойлголтын зөрөөтэй асуудал харагдаад байх юм. Тэгээд энэ дээр яг ажлын хэсэг ямар байр суурьтай хандаж байгаа юм бол гэдгийг тодруулъя.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Баялгийн сангийн хууль батлагдаад 8 сар болж байна. Үндэсний баялгийн сан дотроо 3 данстай байна гэж байгаа. 1 нь бидний мэддэг ирээдүй данс, Ирээдүйн өв сан данс. Ирээдүйн өв сан өөрөө менежмент хийж, орлогоо арвижуулах ийм боломж энэ хуулиар нээгдсэн гэж ойлгож болно.

2 дахь нь иргэдийн хуримтлал буюу хуримтлалын нэгдсэн сан. Энэ бол иргэдийн хуримтлал. Иргэдийн хуримтлал хаанаас бүрдэж байна вэ гэвэл төрийн эзэмшлийн стратегийн ордуудын 34 хувиас бүрдэнэ гээд ингээд заачихсан. Оюу толгой дээр 34 хувь байгаа. Ингээд бид ноогдол ашгаа хүлээж байгаа. Энэ гэрээний хувьд агуулгын хувьд нэг ийм өөрчлөлт орж байгаа юм. Ораногийн гэрээний хувьд. Энэ бол 10 хувь нь ямар нэгэн байдлаар санхүүгийн хариуцлага хүлээхгүйгээр 10 хувиа авна, 24 хувийг нь Амнат болон татварын орлогыг нь дүйцүүлээд 34-тэй нь хамт тооцоод, Хуримтлалын сан руу нь өгнө гээд.

Тэгэхээр энэ цаашдаа манайд хэрэгжих уул уурхайн томоохон төслүүд дээр заавал 34 хувь байх, үгүй гээд ийм олон мэтгэлцээний асуудал гардаг. Оюу толгойн төслийн ч гэсэн гол маргаан бол ер нь энэ байдаг. Тэгэхээр Ораногийн гэрээ хийгдээд, хэрвээ амжилттай болбол магадгүй Оюу толгойн төслийн 34 хувийг ч гэсэн бид Амнат тооцож сайжруулах ийм боломжийг бол гаргах боломжтой. Ирээдүйд зөвхөн Оюу толгой, Бадрах энержигийн төсөл биш, цаашдаа бид олон уул уурхайн төслүүдийг хөдөлгөж таарна. Тийм учраас энэ дээр тийм жишиг болох ийм 2 дахь загвар гарч ирж байна гэсэн үг. 34 хувьтайгаар бид нэг явсан. Одоо бол Ораногийн гэрээ бол манай улсын түүхэнд 3 дахь хөрш улстай хийж хэрэгжүүлж байгаа 2 дахь хэлэлцээр. Тэгэхээр өмнөх гэрээ дээр өнгөрсөн хугацаанд гарсан сургамж дээр үндэслээд энэ 10 хувийг 34-ийнх нь буюу 10 хувийг нь авч үлдээд, 24-ийг нь Амнат болон татварын орлогыг нь Хуримтлалын санд байна гэдэг энэ ерөнхий агуулга явж байгаа учраас өнөөдөр энэ Үндэсний баялгийн сангийн тухай хууль орж ирж байгаа.

Ирээдүйн өв сангийн хувьд бол 30 он хүртэл ингээд хуулиар түгжээтэй байгаа. Ер нь 30 оноос цаашдаа бол бид Амнатиин 65 хувь, хэдэн хувь нь орон

нутагтаа, хэдэн хувь нь Хуримтлалын санд, хэдэн хувь нь Хөгжлийн сандаа төвлөрөх вэ гэдгийг 30 оноос цааш бид төслүүдээ нэлээн олон болгочихвол яг ярилцах ийм боломж байгаа. Энэ маань өөрөө өнгөрсөн, энэ маань өнгөрсөндөө үндэслээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Асуух гэж байсан 2 асуулт маань давхцаад хариулт бараг авчихлаа. Нэг ийм зүйлийг нэмээд асуучихъя. Энэ 2015, 2016 он, 16 оны сонгуулийн өмнө иргэдийн нөгөө 1072 хувьцааны тодорхой хувиудыг ялангуяа тухайн үед сургуулиа төгсөх гэж байсан оюутны төлбөртэй байсан оюутнууд, тэтгэвэр авагчид, тэтгэврийн насныхан тэд нарын хувьцааг Засгийн газар нэрлэсэн үнээрээ худалдаж аваад, мөнгийг нь дансанд нь хийчихсэн. Тэр хувьцаагаа Засгийн газарт өгөөгүй хүмүүс нь тэр үнэ, нэрлэсэн үнээр өгсөн мөнгөнөөс илүү хувьцааны ноогдол ашгийг өнөөдөр аваад эхэлчихсэн. Тухайн үеийн нөхцөл байдлын боломжгүй нөхцөл байдлаар шалтаглаад нөгөө талаараа сонгууль болох гэж байна гэдэг утгаар санал авах зорилгоор хийгдчихсэн энэ зүйлийг буцаах боломж байгаа юу?

Үндэсний баялгийн сан иргэдэд, Монголын ард түмэнд 50-иас дээш хувийн өгөөжтэй байх тухай би ярьж байгаа. Тэгэхээр энийг Засгийн газар хийчих боломж байхгүй юу? Тэр үедээ худалдаж авсан ханшаараа буцаагаад саналаа илэрхийлсэн иргэдэд нь хувьцааг нь буцааж өгье гэдэг ийм зүйлийг хийж болохгүй юу?

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Тавантолгойн энэ 1072 хувьцаатай холбоотой ийм саналууд ялгаатай саналууд байдаг. Одоо бол Компанийн тухай хуулиар ноогдол ашиг учраас зайлшгүй л бид оны төгсгөлд ноогдол ашгаар бэлэн мөнгө иргэдэд олгохоос өөр хуулийн гарц байхгүй байгаа юм. Хуулийн гарц байхгүй. Үндэсний баялгийн сангийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр иргэд анх удаа хуримтлалтай болж байгаа юм. Хадгаламжтай болж байгаа гэсэн үг.

Цаашдаа 1072 хувьцааны ноогдол ашгийг бэлнээр авах уу, эсвэл хуримтлалын дансандаа хадгалах уу, эсвэл Хөгжлийн санд хандивлах уу гэдэг ийм 3 сонголтыг ИМонгол дээр өгдөг болно гэсэн үг. Мэдээж яг энэ зүйлийн дараа тэр асуудлыг ярьж болно. Гэхдээ одоо бол 1072 хувьцаа иргэдийн өмч. Тийм учраас аль асуудал дээр бид иргэдийн өмчид бол ямар нэгэн байдлаар Засгийн газар өмнүүр нь орж шийдвэр гаргах тийм эрх зүйн орчин бол өнөөдөр байхгүй байгаа гэдгийг хэлье.

Зүгээр цаашлаад бэлэн мөнгөөр авах уу, үгүй юү гэдэг бол ингээд сонголттой болгох ийм боломж байгаа. Урьд нь энэ Тавантолгой компани 100 орчим мянган төгрөгийн ч юм уу ийм ноогдол ашиг л тараадаг, ихэнхдээ ингээд алдагдалтай ажилладаг байсан. Энэ жил ер нь харахад бараг 400, 450 орчим мянган төгрөг, магадгүй 500 мянган төгрөгийн ноогдол ашиг тараах болчхож байгаа юм. Гашуунсухайт-Ганцмод энэ экспорт ингээд нэмэгдчихээр энэ саяас дээш гараад ер нь явчихна гэсэн үг. Тийм учраас бид ийм их хэмжээний мөнгийг шууд ингээд бэлнээр тараагаад байх уу эсвэл хадгаламжийн данс руу нь төвлөрүүлэх үү гэдэг бол бас яригдах нэг ийм асуудал бол өнөөдөр бид үндсэндээ энэ гэрээгээ соёрхон баталчихвал экспорт нэмэгдэхийн хэрээр энэ асуудал бол бас нэг яригдах асуудал

болно. Гэхдээ энэ бол баялагтаа эзэн болж байгаа, ноогдол ашгаа хүртэж байгаа хувьцаа эзэмшигчийн л эрхийн асуудал.

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууна. Алга байна. Батын Батбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Батбаатар: Асуулт маань гүйцэд ойлгогдохгүй явчих шиг боллоо. Нөгөө хүн болгон 1072 хувьцаатайгаа байж чадахгүй байгаа байхгүй юу. 16 оноос өмнө тухайн үед оюутан байсан, тэтгэврийн насны байсан хүмүүсээс Засгийн газар хувьцааг нь худалдаад авчихсан, ноогдол ашиг өгөөгүй. Хувьцааг нь аваад мөнгийг нь төлчихсөн хувьцааны үнийг нь тухайн үеийн нэрлэсэн үнээр. Тэр хувьцааг нь буцааж олгож болох уу гэж асуусан юм. Түүнээс ноогдол ашгийг тараах тухай асуугаагүй.

Д.Амарбаясгалан: Тийм, 15 онд сайн хувьцаа гээд гараад явсныг хэлээд байна тийм ээ. Одоо иргэд 1072 хувьцаатай нэг хэсэг байгаа, яг хувьцаагаа тэтгэвэртээ, нийгмийн даатгалдаа, оюутны сургалтын төлбөртөө авчихсан 300 орчим мянган иргэн давхардсан тоогоор байдаг юм байна лээ. Тэгээд тэдгээр иргэд буцаад хувьцаагаа худалдаж авах боломжийг одоо бол хараахандаа нээх нөхцөл нь бүрдээгүй байгаа. Харин энэ оны 1 дүгээр сарын 7-нд Улсын Их Хурлаар 2012 оны 4 сарын 7 хүртэл хувьцаа эзэмшигчид байсан бол 2024 оны 1 дүгээр сарын 01-ийг хүртэл төрсөн Монгол Улсын иргэд хувьцаа эзэмшигч болсон байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг ер нь цаашдаа бид нэг мөр шийдвэрлэх ёстой юм байгаа юм.

Нэгэнт Үндсэн хуулийн 6.2-оор газрын хэвлийн баялаг өөрөө нийт ард түмний мэдэлд байх ёстой, өмчлөлд байх ёстой гэж үзэж байгаа тохиолдолд цаашдаа шинээр төрсөн Монгол Улсын иргэн шууд хувьцаа эзэмшигч болдог байх тэр нөхцөл боломжийг бүрдүүлэхэд бид анхаарах ёстой юм. Батбаатар гишүүний. Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Ер нь зүгээр хэдүүлээ ингээд өнгөрснөө дүгнээд, ирээдүйгээ засах гээд, ирээдүйг хараад л яриад явж байгааг би бас өнөөдрийн гаргаж байгаа шийдвэрүүдэд талархаж байна. 1072 хувьцаа яагаад үүссэн бэ гэвэл энэ бол улс төрийн амлалтаас л болж үүссэн зүйл шүү дээ. Сонгуульд өрсөлдсөн 2 нам маань нэг нь 1,5 сая, нэг нь 1 сая төгрөг амласан. Хоёулаа нийлээд энэ чинь 2,5 сая төгрөг болсон. Үүнийг Ерөнхийлөгчийн сонгуулиар амласан. Ингээд яах вэ гэхээр бэлэн мөнгө хэрэгтэй болсон. Ингээд нийт иргэддээ хувьцааг хуваагаад тоо нь 1072 гарсан ийм асуудал үүссэн. Гэхдээ яах вэ энэ бол зөв, буруу гэж ярихаас илүүтэйгээр ер нь ийм нэг удаагийн ийм улс төрийн шийдвэр бол дараа нь урт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Дараа нь урт хугацаандаа ийм асуудал дагуулдаг юм гэдгийн нэг жишээ бол өөрөө энэ. Тэгэхээр бид цаашдаа ийм улс төрийн хэт популист ийм шийдвэрүүдийг гаргахгүй, илүү нухацтай, тооцоо судалгаатай, ил тод ингэж ярилцаж явах нь зөв гэдэг нэг сургамж бол энэ. Үүнээс үүдэж л энэ нөгөө нэг Чалкотой холбоотой эд нар асуудал гарч ирж байгаа нь тухайн үед Чайна Энержитэй ярьж байгаад гэрээгээ солиод, арай илүү мөнгө өгсөн Чалкотой гэрээ байгуулаад, тэр мөнгөө авч тараагаад, ингээд өнөөдөр бид 10-аад жилийн дараа энэ асуудал дээр ингээд ороод л. Тэгэхээр аливаа нэг асуудал бол зайлшгүй

ирээдүйд өнгөрснөө, өнгөрснөөсөө хэчнээн тойрох гэж хичээлээ, хичээлээ гэхэд заавал ингээд таардгийн л нэг том жишээ бол өнөөдрийн энэ Гашуунсухайт-Ганцмодны хэлэлцээр болж байгаа. 16 гэдэг хугацаа ч мөн тэгээд л хойшлуулж байсан хугацаагаа л бид.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Гишүүд асуултад үндсэндээ үг хэлж, байр сууриа илэрхийлсэн байна. Тэгэхээр үг хэлж дууслаа. Санал хураалт явуулах байгаа. Тэгэхдээ танхим дахь ирц санал хураалтад бүрэн хангалттай биш байгаа учраас өнөөдөр нийт 9 асуудал хэлэлцэх байгаа. 9 асуудлаа хэлэлцэж дуусаад, сүүлийн 3 асуудлын саналыг нэг дор хураана.

17.53 цаг

Найм. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд орёе. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээ орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийг бий болгох нь зөвхөн Монгол Улсын төдийгүй хүн төрөлхтний өмнө тулгарч байгаа эрхэм зорилт юм. Энэхүү зорилтын хүрээнд дэлхийн улс орнууд цөмийн эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогод нэгдэж, цөмийн эрчим хүчийг ногоон буюу тогтвортой цэвэр эх үүсвэр хэмээн зарлаж байна. Дэлхийн зах зээлд цөмийн түлш, ураны хэрэгцээ жил бүр тасралтгүй өсөж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 32 улс, 440 цөмийн реактор ашиглаж байгаа бол шинээр барьж байгаа 63, барихаар төлөвлөж байгаа 88, ирээдүйд төлөвлөгдөж буй 340 реактор байна.

Олон улсын атомын энергийн агентлагаас ураны эрэлт 2024 онд 93 мянган тонн байгаа бол 2050 он гэхэд 177 мянган тонн болж нэмэгдэх тооцооллыг гаргажээ. Өнөөгийн байдлаар Монгол Улс 192,2 мянган тонн ураны нөөц бүртгэсэн нь дэлхийн ураны нөөцийн 3 хувийг бүрдүүлж, нөөцийн хэмжээгээр дэлхийд 10-д жагсаж байна. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг Алсын хараа 2050-д нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүчний үйлдвэрлэл зэрэг стратегийн ач холбогдол бүхий эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэх зорилтуудыг тусгаж, улмаар Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Зөөвч-Овоо, Дулаан-Уулын ураны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах төслийг улсын хөгжлийн бүтээн байгуулалтын 14 мега төслийн 1 болгон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Монгол Улс цацраг идэвхт ашигт малтмалын эрэл хайгуулыг эрчимжүүлж, олборлолт, ашиглалтыг олон улсын жишиг стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх нь экспортын орлого нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээс гадна олон улсын хамтын ажиллагаа, түншлэлд чухал ач холбогдолтой юм. Цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Цөмийн энергийн тухай хууль болон дагалдах хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд тус өөрчлөлтөөр Засгийн газраас цацраг идэвхт ашигт малтмалыг хөрөнгө оруулагч талтай хамтран ашиглахдаа зөвхөн хувьцаа эзэмших замаар бус Үндсэн хуульд заасан байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, түүний үр өгөөжийн дийлэнхийг ард түмэнд ноогдуулж байх зарчмыг бусад хэлбэрээр хангуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 10 дугаар сард Бүгд Найрамдах Франц Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар болон Орано майнинг компанийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийн хэлэлцээний протоколд талууд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан. Зөөвч-Овоо төслийг хэрэгжүүлэх хугацаанд Бадрах Энержи компанийн 34 хувийн энгийн хувьцааны ноогдол ашигт 2,1 тэрбум доллар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт 717 сая доллар буюу нийт улс, орон нутгийн төсөвт 5,6 тэрбум ам.доллар төвлөрүүлэх тооцоолол гаргасан.

Харин 34 хувийн энгийн хувьцааг тус хэлэлцээний протоколын дагуу 10 хувийн давуу эрхийн хувьцаа, тусгай амнатаар орлуулж, 14 хүртэлх хувийн суурь болон өсөн нэмэгдэх Амнат тооцоход давуу эрхийн хувьцаа нь 593 сая ам.долларын ноогдол ашиг, АМНАТ-т 2 тэрбум ам.доллар, үүнээс суурь Амнатад 717 сая ам.доллар, тусгай Амнатад 717 сая ам.доллар, өсөн нэмэгдэх Амнатад 573 сая ам.доллар, нийт улс, орон нутгийн төсөвт 5,2 тэрбум ам.доллар төвлөрүүлэхээр байна. Хэдийгээр 34 хувийн энгийн хувьцааны хувилбарын тооцоолол нь илүү санхүүгийн өгөөжтэй мэт боловч Засгийн газар 34 хувийн хувьцаа эзэмших нөхцөлд төсөл хэрэгжүүлэх үед хөрөнгө оруулагчийн зүгээс зардлыг удирдах, төслийг зээлээр санхүүжүүлэх зэрэг олон хэлбэрээр төслийн төлөх татвар хураамжийг бууруулах боломжтой байдаг тул Засгийн газар анх тооцож байсан ноогдол ашгаа хүртэж чадахгүй байх, төслийн өгөөж тодорхой хугацаагүйгээр хойшлох эрсдэл үүсэж болзошгүй байна.

Дэлхийн банкны судалгаагаар Монгол Улсын Засгийн газрыг дараа дараагийн төслүүдийг хэрэгжүүлэхдээ жижиг хувьцаа эзэмшигчээр оролцохоос зайлсхийж, төсөлд бүтээгдэхүүн хуваах гэрээ эсхүл АМНАТ-өөр орлохыг зөвлөмж болгосон байгааг бид харгалзах нь зүйтэй. Түүнчлэн төсөвт төвлөрөх татвар, төлбөр хураамжийн орлого нь ноогдол ашгийн орлоготой харьцуулбал төслийн зардлын өсөлтөд сул мэдрэг буюу эрсдэлгүй орлогод тооцогддог бөгөөд хэрэв Засгийн газар 34 хувийн энгийн хувьцаа эзэмших тохиолдолд Монголын талд ноогдох нийт 5,6 тэрбум ам.долларын орлогын 82 хувь нь зардлын өсөлтөд өртөмтгий буюу эрсдэлтэй орлого, үлдсэн 18 хувь нь зардлын өсөлтөөс үл хамаарах эрсдэлгүй, найдвартай орлогод тооцогдохоор байна.

Харин Засгийн газар нь 10 хувийн давуу эрхийн хувьцаа ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулснаас эрсдэлгүй орлогын хувийг 18 хувиас 45 хувь хүртэл нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Иймд 34 хувийн энгийн

хувьцааг 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж, Монгол Улсын Засгийн газар ноогдол ашиг хуваарилах хугацааг хүлээлгүйгээр төсөл хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн төслийн үр өгөөжийг шууд хүртэх боломж бүрдүүлэх зорилгоор Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж байна, боловсрууллаа.

Засгийн газар 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцааг эзэмшсэнээр бусад энгийн хувьцаа эзэмшигчдээс тэргүүн ээлжид ноогдол ашиг хүртэх, хувьцаанд ноогдох хөрөнгө оруулалт хийх үүрэг хүлээхгүй байх, бүтээгдэхүүний 10 хүртэлх хувийг хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл, болзлын дагуу худалдан авах, түүнчлэн компанийн дүрэмд өөрчлөлт орох, тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах зэрэг компанийн тодорхой чухал шийдвэрүүдэд Засгийн газрын зүгээс хориг тавих онцгой эрхтэй байхаар талууд хэлэлцээрийн явцад тохиролцоонд хүрлээ.

Түүнчлэн ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь хэмжээг талуудын хооронд байгуулсан протоколыг үндэслэн ураны хүдрийн баяжмалын зах зээлийн үнийг харгалзан 5 хувь хүртэл байхаар тогтоолын төсөлд тусгалаа. Дээрх хувилбарыг сонгосноор төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан олон улсын фастандартын дагуу санхүүгийн тооцооллын загварыг Монголын талаас боловсруулж, хөрөнгө оруулагчтай тулган баталгаажуулалт хийсний үндсэн дээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үр өгөөжийн дийлэнх хэсэг буюу 51-ээс доошгүй хувийг Монгол Улс хуримтлагдсан дүнгээр жил бүр хүртэх нөхцөлийг баталгаажууллаа.

Хэрэв Монголын талын шууд үр өгөөж 51 хувьд хүрэхгүй тохиолдолд талууд үр өгөөжийг 51 хувьд хүргэхэд шаардлагатай үр өгөөжийн тохируулга хийх, хөрөнгө оруулагч нэмэлт төлбөрийг Засгийн газарт нөхөн төлөх үүрэгтэй байхаар гэрээнд тусгалаа. Түүнчлэн хөрөнгө оруулагч талаас нийт 27 төрлийн татварыг тогтворжуулах санал ирүүлснийг хэлэлцээрийн явцад бууруулж, зөвхөн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, гаалийн тариф, гаалийн татвар гэсэн 4 төрлийн татварыг тогтворжуулах, харин байгаль орчны салбарын албан татварыг огт тогтворжуулахгүй байхаар харилцан тохиролцлоо.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг үндсэн болон нэмэгдүүлсэн хувиар тооцох бөгөөд тусгай төлбөрийг бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс хасагдуулаг инфляцад тооцохгүйгээр бүрэн төлөхөөр тусгалаа. Хөрөнгө оруулалтын гэрээг төсөл хэрэгжүүлэгчийн эзэмшиж байгаа 3 тусгай зөвшөөрлийн хүрээнд авч үзэх, бусад ирээдүйд авч болох тусгай зөвшөөрлүүдийг хамруулахгүй байх, олборлолт үйлдвэрлэлийг газар доор уусган олборлох технологиор явуулах, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон суурь үзүүлэлтүүдийг ашиглан төслийн бүх үе шатад байгаль орчны мониторинг, гео экологийн судалгаа, цацрагийн хяналтыг хэрэгжүүлэх, төслийн үйл ажиллагаа болон технологид Олон улсын атомын энергийн агентлагийн шинжээчдээр 3 жил тутамд хөндлөнгийн аудит хийлгэх талаар хөрөнгө оруулагч талтай урьдчилан тохиролцож, хөрөнгө оруулалтын гэрээнд тусгалаа.

Мөн төсөл хэрэгжүүлэгч компани нь Дорноговь аймгийн Засаг дарга, төсөл хэрэгжүүлэх Улаанбадрах сумын Засаг даргатай 3 талт хамтын ажиллагааны гэрээ

байгуулж, орон нутгийн хөгжлийг дэмжих хүрээнд жил бүр 1 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр, төсөл хэрэгжүүлэгч компанийн нийт ажилчдын 90-ээс дээш хувь нь Монгол Улсын иргэн байх. Уурхайн ашиглалтын үе шатад нийт туслан гүйцэтгэгчдийн 60 хувиас доошгүй, жилийн нийт худалдан авалтын үнийн дүнгийн 40 хувиас доошгүй нь Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч хуулийн этгээд байхаар тус тус тохиролцон хөрөнгө оруулалтын гэрээнд тусгалаа.

Тус тогтоолын төсөл батлагдсанаар Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.11-д заасан Зөөвч-Овоо, Дулаан-Уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдаж, Монгол Францын хамтарсан ураны төсөл үр ашигтай хэрэгжиж, иргэдийн хуримтлалын сан арвижих боломж бүрдэнэ гэж үзэж байна. Уг асуудал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.3-д заасан эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чиглэх тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай горимоор Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлж, Их Хуралд танилцуулж байна. Дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Мөнхсоёл: Бүгдэд нь оройн мэнд. Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд хууль зүйн болон практик хэрэгцээ шаардлагыг үндэслэн олон улсын сайн туршлагыг харгалзан Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт байрлах Дулаан-Уул, Зөөвч-Овоо, өмнөд цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Бадрах Энержи ХХК-ийн хязгаарлагдмал хувьцаат компанийн төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж орлуулах асуудлыг тусгажээ. Тогтоолын төслийг D.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд, Сайнзориг, Мандхай, Б.Жаргалан асуулт асууж, хариулт авлаа. Байнгын хорооны хуралдаанаар дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ингээд 18 цаг болсон байна. Тэгэхээр өнөөдрийн хэлэлцэх асуудал 2 асуудал байгаа. Асуудлаа хэлэлцэж дуустал өнөөдрийн чуулганыг үргэлжлүүлэх саналтай байна. Гишүүд дэмжиж байна уу? Чуулганы хуралдааны цагийг сунгалаа.

Би ажлын хэсгийн гишүүдийг эхлээд танилцуулаадахъя. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал, Бат-Эрдэнийн Хулан ЗГХЭГ-ын даргын зөвлөх, Алтангэрэлийн Мандуул ЗГХЭГ-ын даргын зөвлөх, Пүрэвдоржийн Баттөр ЗГХЭГ-ын Үндэсний хороо, төсөл, хөтөлбөр хариуцсан хэлтсийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Лхагвагийн Баттөр ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Сэр-Одын Ган-Очир АМГТГ-ын дарга, Зэнээмядарийн Батбаяр Усны газрын дарга, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Мавагийн Чадраабал Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга, Бямбаагийн Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга, Лхамсүрэнгийн Жаргалсайхан Шинжлэх ухааны академийн Хими, хими технологийн хүрээлэнгийн захирал, Цагааны Өнөрнөсөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи, уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч, Балжиннямын Гэрлээ Эрдэнэс Монгол компанийн Хууль, эрх зүйн газрын ахлах менежер, Цэдэнбалжирын Төгсбуян Эрдэнэс Монгол компанийн Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга, Лувсаншаравын Наранчимэг Эрдэнэс Монгол компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Түмэнжаргалын Төрбадрах Эрдэнэс Монгол компанийн Хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Доржбалын Далайжаргал Мон-Атом компанийн захирал, Дашдаваагийн Сугарсүрэн Мон-Атом компанийн Захиргааны албаны дарга, Амарсанаагийн Алтанхундага Мон-Атом компанийн ахлах геологич, Дашдоржийн Баярхүү Олон улсын харилцааны судлаач, профессор, Яндагийн Ганболд Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, профессор, Норовын Тэгшбаяр физикийн ухааны доктор, Сүхдоржийн Батхүлэг дотоодын хуулийн зөвлөх, Зуунайн Шагдарсүрэн дотоодын хуулийн зөвлөх, Ганбатын Мөнхболд дотоодын хуулийн зөвлөх, Баярбатын Батмандах дотоодын хуулийн зөвлөх.

Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж горимын санал гаргана.

Б.Пүрэвдорж: Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл орж ирж байгаа. Энэ төслийг дагаад Монгол Улсын Засгийн газар болон Орано майнинг САС хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл нийтдээ 65 хуудастай ийм том төсөл орж ирж байгаа. Тэгэхээр энэ 2019 онд Үндсэн хуулийн өөрчлөлтөөр 6.2-оор Стратегийн ач холбогдол бүхий ордуудаас ашиглахдаа, ордыг ашиглахдаа үр ашгийнх нь дийлэнх нь ард түмний эзэмшилд очно гэдэг энэ л заалтын дагуу, энэ хэлэлцээрийн дагуу орж ирж байгаа.

Мөн түүнчлэн түрүүн бидний саяхан баталсан Цөмийн энергийн хууль яг энэ зарчим дээр батлагдсан байж байгаа. Тэгэхээр энэ гэрээ бол үнэхээр сайн болсон гэдгийг хэлмээр байгаа юм. Үнэхээр яг энэ 51-ээс дээш байх энэ зарчим бол үнэхээр яг энэ ард иргэдэд бүрэн хүрэх тэр Амнатиин болон хувь эзэмшил бүх зүйлээрээ бусад татваруудаар бүгдээрээ хангагдаж байгаа. Ер нь 80 доллар орчим байж байхад 51 байгаа, хэрэв цаашдаа 100 гараад явна, энэ тохиолдолд бүр 60 гараад явчих ийм боломжийг энэ гэрээний хэлэлцээрийн хүрээнд хийж байгаа юм.

Тэгэхээр энэ хэлэлцээрийн хүрээнд жишээ нь авлигын эсрэг заалтаар хэрвээ аливаа нэгэн байдлаар шан харамж, бэлэг урамшуулал өгөх, амлах, зуучлах, давуу байдал олгох юм бол шууд гэрээнээс татгалзах үндэслэл болж байгаа. Ийм, ийм олон давуу заалттай ийм гэрээ болж байгаа. Тэгэхээр энэ гэрээний асуудлыг сайн асуух тэр боломжийг өөрөөр хэлбэл гэдэс дотрыг нь сайн уудалж, энэ ард иргэдэд яг тэр бүрэн мэдээллийг өгөх зайлшгүй шаардлага байгаад байна. Ер нь энэ гэрээг бид ярилцах үед баталснаар энэ Оюу толгой, Петрочайна Дачин Тамсаг зэрэг хөрөнгө оруулалтын гэрээг хийсэн тэр компаниуд жоохон ичмээр, нэг эргэлзмээр, нэг тийм сандрахаар ийм жишиг болсон гэрээ болж байгаа шүү гэдгийг хэлэхийг хүсэж байгаа юм.

Тийм учраас энэ иргэдэд сайн мэдээллийг олгох ёстой. Энэ мэдээллийг олгохын тулд Их Хурлын гишүүд бүгдээрээ асуулт асууж, эндээс бүгдээрээ асуулт асууж, тэр гэдэс дотрыг нь сайн танилцуулах нь маш чухал байна. Тийм учраас энэ Дэгийн тухай хуулиар 120 минут ярина гэдэг арай бага байгаад байна. Тийм учраас Их Хурлын гишүүн болгон асууж, энд нь Засгийн газрын гишүүд хариулах тэр боломжийг нээж өгөөч гэж Их Хурлын даргаас хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн санал гаргалаа. Дэгийн тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын гишүүдэд гэрээний талаар асуугаад, хариулт аваад явах боломжийг олгоё гэж бодож байна. Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нийт 9 гишүүний нэр ирсэн байна. Асуулт асууж эхэлнэ. Бадрахын Найдалаа гишүүн асуулт асууя.

Б.Найдалаа: Гэрээтэй холбоотой олон асуулт байгаа. Гэхдээ өнөөдөр бол яг өргөн барьсан байгаа хуулийн төсөлтэй холбоотой ганц нэг асуулт асууя. Юу вэ гэхээр санхүүгийн загвар дээр яг энэ санхүүгийн шинжилгээ хийсэн, загвар хийсэн мэргэжилтнээс асуумаар байна. 34 хувь энгийн хувьцаатай аваад, ноогдол ашиг Монгол Улсад ирэх ноогдол ашгийн хэмжээ болон энэ хуульд өөрчлөлт орсноор 10 хувийн давуу эрхтэй хувьцаа аваад, тэгээд Амнатаар нөхөөд, энэ 2-ын хооронд харьцуулсан тооцоо нь байгаа юу? Ямархуу зөрүүтэй гарч байх юм бэ? Яг одоогийн

энэ гэрээний төсөл дээр л гэсэн үг шүү дээ. Энийг жоохон тодруулж өгөөч. Энийг бол заавал тооцоо хийж үзсэн байх. Энэ нэлээн хялбар бөгөөд тодорхой тооцоо байх ёстой.

2 дахь нь төслийн дотоод өгөөжийн хувь гэж байдаг. Тэр энэ төслийн хувьд хэд байгаа вэ? Өмнө нь хэлэхэд 20 хэдтэй юм дуугарч байх шиг байсан, одоо яг хэд байгаа вэ? Тодруулж өгөөч.

3-д нь тэр гэрээтэй холбоотой больё доо. Үүгээр ингээд дуусгая, хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Санхүүгийн тооцоолол талаас хариулт өгье. Ажлын хэсгийн дарга, ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал хариулт өгье.

Н.Учрал: Найдалаа гишүүний асуултад хариулъя. Тэгээд бид нарт мэдээж 2 хувилбар байсан. Төр эзэмшлийнхээ 34 хувийн ноогдол ашгийг авбал ямар байх вэ эсвэл орлуулбал ямар байх вэ гэж. Тэгэхээр нэг л зүйл ажиглагдаад байгаа юм. Зүгээр яах вэ яг 34 хувиараа ноогдол ашгаа авна, ямар нэгэн эрсдэлгүйгээр тэр ноогдол ашгийг авна гэвэл 5,6 тэрбум доллар гэж яригдаж яг тооцоологдсон тоо байна. Хэрвээ 34 хувиар, 34 хувиа тусгай амнатаар ингээд өсөн нэмэгдэх Амнат бусад төрлийн татвар төлбөрийг авна гэвэл 5,2 тэрбум гэж гараад байгаа юм. Харахад мэдээж ингээд тоон дээрээ 5,2 гээд бага харагдаж байгаа хэдий ч нөгөө эрсдэлгүй хуримтлал гэж ойлголт байна. Жишээ нь ноогдол ашиг татвар, хураамж аваад хамгийн эцэст нь авах ашиг шүү дээ. Гэтэл энэ маш их эрсдэлтэй. Тэгээд энэ бол бид өнгөрсөн хугацаанд хийгдэж байсан хөрөнгө оруулалтын гэрээнүүдээс харагдаж байсан.

Тийм учраас бид яг энэ санхүүгийнхээ схемийг хийхдээ энэ санхүүгийн зөвлөх үйлчилгээний энэ багийнхан өөрсдөө яг энэ IMF-ийн энэ аргачлалын дагуу Засгийн газрын хуримтлагдсан үр өгөөж, хөрөнгө оруулагчийн хуримтлагдсан үр өгөөжийг нэмээд, хөрөнгө оруулагчийн олгосон санхүүжилтийг хасахаар яг 50 + 1-ийг л хангуулж байх ёстой гэдэг энэ зарчмыг барьсан. Тэгэхээр ерөөсөө л газрын хэвлийн баялгийн 50 + 1 гэдэг бол бид нарын босго. Энд зориулсан санхүүгийн схемийг бид боловсруулсан. Ингээд энэ дээрээ тэр assumption гээд байгаа таамаглалуудаа тавьж байгаад яг үнэлгээ хийж байгаа. Ингээд үнэлгээ дээр 1 фунт ураны үнэ 50 доллар байвал ямар байх вэ, өнөөдрийн 80 доллароор тооцвол ямар байх вэ, 100 доллароор тооцвол ямар байх вэ гэдэг ийм хувилбаруудыг гаргасан. Энэ нь өөрөө тэр фаст гээд стандартыг барих ёстой байдаг юм байна.

Ингээд үзэхээр ер нь эрсдэлгүй орлогын түвшин жишээ нь 10 хувийн хувьцаа ямар ч санхүүгийн хариуцлага хүлээхгүй хувьцаа, дээр нь суурь Амнат 5, тусгай Амнат 5, ингээд өсөн нэмэгдэх 9 хүртэл Амнат, бусад татвар, хураамж гээд тооцох юм бол эрсдэлгүй орлого нь 45 хувь. Хэрвээ 34 хувь дээр аваад үзвэл эрсдэлтэй нь 18 хувь. Өнгөрсөн хугацаанд хийгдсэн гэрээ чинь бид бас сургамж байгаа. Тэнд ноогдол ашгийн хугацаа дандаа хойшлоод байдаг, санхүүгийн хариуцлага хүлээгээд байдаг. Сүүлдээ өрөнд орчихдог. Тэгэхээр энэ 10 хувийн давуу эрх дээр ямар ч санхүүгийн хариуцлага хүлээхгүй, хөрөнгө оруулалт хийх үүрэг хүлээхгүй. Ингээд шууд борлуулалтаас нь Амнатыг авч байгаа учраас уурхай ашиглаж эхлэх үеэс шууд борлуулалтаас нь амнатаа авахаар ямар нэгэн эрсдэл хүлээхгүй гэж үзэж байгаа.

Дээрээс нь Цөмийн энергийн хуулиар нөгөө ураны үнийг хувьчлаад үзэж байгаа учраас нөгөө өсөх болгонд нь тэр нөгөө өсөн нэмэгдэх Амнат чинь дагаад өсөөд явна. Ийм хувилбаруудыг бол яг энэ санхүүгийнхээ схем, модель дээр бол бид гаргаад, ажлын хэсгүүд дээр нэгдсэн байдлаар дахиад танилцуулж болно. Энэ дээр манай Ажлын хэсгийнхнээс санхүүгийнхнээс дахиад мэдээлэл өгчих үү? Хулан.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Б.Хулан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ажлын хэсгийн гишүүн, олон улсын итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч Хулан. Учрал сайдын хэлсэн дээр нэмж тодруулаад хэлэхэд саяын энэ 5,6 сая доллар, 5,2 сая доллар гээд 34 хувь дээр суурь амнатаа авах эсвэл тусгай Амнат болон өсөн нэмэгдэх Амнат 10 хувийн давуу эрхтэй хувьцааны энэ гол ялгаа нь хэдийгээр тоогоороо зөрөөтэй харагдаж байгаа ч гэсэн энэ тооцоолол дээр хөрөнгө оруулагч тал ашгаа 100 хувь ноогдол ашиг болгож тараана буюу 100 хувийн dividend pay outration гэж ярьдаг. Олсон бүх ашгаа тухай бүрд нь тараана гэдэг таамаглал дээр ийм зөрөөтэй гарч байгаа.

Тэгэхээр бодит байдал дээр төсөл хэрэгжүүлэгч компани үйл ажиллагаанаасаа ашиг олоод, түүнийгээ цооног нэмэх, нэмэх гэдэг ч юм уу, хөрөнгө оруулалтын хөрөнгө оруулалт үргэлжлүүлээд хийх боломжтой. Тэгэхээр энэ 5,6 гэдэг нь нэлээн өндрөөр тооцсон.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бадрахын Найдалаа гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тийм. Найдалаа гишүүний асуултад нэмж хариулъя. Бид Оюу толгой дээр гаргасан алдаагаа давтаж болохгүй юм байгаа юм. 34 хувийг бид эзэмшээд өнөөдрийн хугацаанд 1 центийн ч ноогдол ашиг аваагүй байгаа. Цаашаагаа хэзээ авах нь ч тодорхойгүй байгаа. Тийм учраас бид энэ эрсдэлтэй замаар явах уу, эрсдэлгүй тогтвортой 51 хувийн өгөөжөө аваад явах уу гэдэг л ийм сонголт хийсэн байгаа гэсэн үг. Ямар ч санхүүгийн хариуцлага хүлээхгүй, ямар нэг зардал энэ бүх юман дээр хариуцлага хүлээхгүйгээр 10 хувиа бид үнэ төлбөргүй авна. Тэгээд ашигтай ч бай, ашиггүй ч бай бид Амнатыг авна. Суурь Амнат, 5 тусгай Амнат, 5 өсөн нэмэгдэх нь 9 хүртэл гээд 19. Дэлхийд өөр хаана ч байхгүй хамгийн өндөр Амнатыг бид тогтоож чадсан.

Дээрээс нь 51 хувь хэрвээ хүрэхгүй тохиолдолд тэр жилд нь бид өгөөж тохируулагч нэмэлт төлбөрийг заавал авна, шууд зардлаас нь гаргаад авна. Тэгэхээр 51 хувь бол ямар нэг эрсдэлгүйгээр бид шууд авах өгөөж маань энэ. Ингээд өөрөөр хэлбэл төслийн хугацаанд 5,2 тэрбум долларыг бид ямар ч эрсдэлгүйгээр авна гэсэн үг. Тэр 5,6 тэрбум доллар бол байж болох дүн. Энэ бол зөвхөн тооцооллын хамгийн өндөр л дүн. Сая шинжээч хүүхэд хэллээ, энийг эргүүлээд бид зардалд нь ч шингээж болно, магадгүй дахиад цооног нэмээд хөрөнгө оруулалт хийх ч ийм өөрчлөлтүүд гарч ирнэ. Тийм учраас тэр маш их эрсдэлтэй бид хэзээ ч авч чадахгүй байж магадгүй тэр ноогдол ашгийг бид өнөөдөр ярихгүй. Тэгэхээр энэ эрсдэлийг бид тойрч чадсан. Тийм учраас энэ удаагийн энэ гэрээ бид өмнөх алдаануудаа засаж чадсан, тойрч чадсан, эрсдэлгүй болгож чадсан, ирээдүйдээ бүтэн өгөөжөө үлдээж чадсан ийм жишиг гэрээ болж чадсан гэж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бадрахын Найдалаа гишүүн тодруулж асууя.

Б.Найдалаа: Баярлалаа. Ойлгомжтой байна. Яг тодруулахад яг тооцоо хийгээд үзэхээр 34 хувийн энгийн хувьцаанаас авч байгаа мөнгөн дүн нь нэрлэсэн дүнгээрээ нөгөөхөөсөө илүү байгаа. Гэхдээ эрсдэлээр жигнээд үзэхээр одоогийн хуулийн заалтад байгаа зүйл дээр байна гэсэн үг мөн үү тийм ээ? Тэгвэл дахиад нэг ганцхан товчхон асуулт. 51 хувийн өгөөж чинь бол ийм бенчмарк байдаггүй байх тийм ээ? Зүгээр 50-иас дээш нэмэх нь 1 л гэж байгаа болохоос. Тэгэхээр яах вэ яваандаа зүгээр иргэдэд ч юм уу бусдад танилцуулахад 50 + 1 биш, 50 + 5 яагаад байгаагүй юм ч гэдэг юм уу асуудал үүсэж магадгүй л дээ. Тэгээд энэ дээр ажлын хэсгийнхэн нэг шийдэл, бодол байх байлгүй дээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Гуравдагч хөрш орон тоо Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн гишүүн оронтой хийж байгаа маш ингэж чухал гэрээ хэлэлцээр гэж бүгдээрээ ойлгож байгаа. Тэгэхээр энэ маань өөрөө бид анхнаасаа нухацтай нэлээн тийм тал талын харилцан ашигтай энэ нөхцөл байдлаа нэлээн нухацтай судлах ёстой байх. Оюу толгой дээр чинь бид үндсэндээ бараг эхэлснээс хойш хэдэн жил ч юм бүтэн шүүх, арбитр гээд л явчихлаа. Тэгэхээр эндээсээ нэлээн сургамж бид авсан байх ёстой байх. Сая Жавхлан сайд хэлж байна л даа. Би түүн дээр тодруулаад асууя. Оюу толгойгоос бид ингээд сургамж авсан. 34 хувиасаа өсөн нэмэгдэх Амнат нь илүү гэдэг хувилбараар одоо оруулж ирж байна. Тэгэхдээ тооцооллоор бол нөгөө тал нь гэж гарчихсан байгаа юм байна. Тэгэхдээ Оюу толгой дээр та яг нэг бодитой тоо хэлээч.

Оюу толгойг бид өсөн нэмэгдэх Амнат авсан бол 34 биш, энгийн хувьцаа биш, Оюу толгойг бид өсөн нэмэгдэхээр байсан бол ямар байх байсан юм бол? Энэ талаар манайд тооцоо байдаг юм уу? Бид ер нь энэ дээр хийсэн ийм тооцоо, Оюу толгой дээр бид ийм сургамж авчихлаа. Мөнгөн дүнгээр өнгөрсөн хугацаанд бид 2009 оноос байна уу, нааш мөнгөн дүнгээр ийм зүйл алдчихлаа, оночихлоо гэдэг энэ сургамжийг хэлж өгөөч.

2 дугаарт нь ер нь энэ Амнатын асуудал чинь явсаар байгаад үнийг хэдээр, яаж тооцох вэ гэдэг асуудал болж хувирна шүү дээ. Олон улсын зах зээлийн үнэ ямар байх вэ гэдэг асуудал болж хувирна. Тэгэхээр энэ уран чинь өөрөө уран болоод тэр шар нунтаг чинь өөрөө маш цөөн оролцогчтой, биржээр арилжаад байх боломжгүй ийм бүтээгдэхүүн гэдэг мэдээлэл бас харж байсан. Маш цөөхөн оролцогчтой, 2 бирж дээр зардаг ч гэлүү. Тэгэхдээ маш цөөхөн оролцогчтой, үнэ нь өөрөө их тийм хязгаарлагдмал хүрээнд цөөн оролцогчтой гээд. Тэгэхээр энэ дээр үнийг яг ямар үнийг суурь болгож авах гэж байгаа юм бэ? Биржийн үнэ гэнэ, манайд чинь олон улсын нүүрс дээр гэхэд биржийн үнээс гадна дахиад Тавантолгойн үнэ чинь өөр үнээр олон улсын үнээс өөр үнэтэй явдаг шүү дээ. Тэгэхээр энэ дээр юу байдаг уу?

Тэгээд төгсгөлд нь энэ гэрээний процесс маань яаж явж байгаа билээ? Бид чинь ингээд эндээс энэ 2 хуулийн төслийг, 2 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулчихаар асуудал шийдэгдчих ийм бүрэн бололцоо нь байгаа юм уу? Одоо чинь Стратегийн ордын хувь эзэмшлийг өөрчлөх, Үндэстний баялгийн сангийн хууль хоёрын тухай ярьж байгаа болохоос биш яг өнөөдөр хэлэлцэх асуудалд бараг үндсэндээ Ораногийн тухай байхгүй байгаа шүү дээ. 2 хуульд байгаа зүйл, заалтуудыг өөрчилж байгаа. Сая Чайна Энержитэй холбоотой асуудлыг дахин соёрхон батлахаар орж

ирэх юм байна. Гэтэл яг энэ Ораногийн гэрээ дээр орж ирэх билүү, орж ирэхгүй билүү? Хуулийн бололцоонууд нь байгаа юу? Ямар процессоор явах юм бэ?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга, ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал хариулт өгье.

Н.Учрал: Түрүүн Жавхлан сайд хэлсэн. Би Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ийм өгөөж тохируулах тэр adjustment хийх гээд байна. Тэр бол нөгөө энэ 50 + 1-ийг хангуулахын тулд бид нөгөө санхүүгийн схемээ хийгээд, тохиролцоонд хүрэх гэхээр зарим үед нөгөө дэлхийн зах зээлийн тэр бүтээгдэхүүний маань үнийн хэлбэлзлээс болоод зарим үед 51 хүрэхгүй байх тохиолдолд яах вэ энэ Үндсэн хуулийн зөрчил болох уу гэдэг асуудал яригдаж байгаа юм. Үндсэн хуулийнхаа хүрээнд л бид гэрээгээ байгуулна. Тэгэхээр энэ дээр өгөөж тохируулах гэсэн энэ аргачлалыг ашигласан. Жишээ нь 51 хувьдаа хүрэхгүй байгаа тохиолдолд бид шууд зардлаас нь аваад 51-ийг нь өгч байгаа. Тэгэхээр энэ өгөөж тохируулахыг хийж чадсан нь бол энэ хөрөнгө оруулалтын гэрээний хамгийн сайн дэвшил болсон гэж үзэж байгаа. Яг тэр сүүлийн ашгаас нь биш, борлуулалтаас нь амнатаа авчихна. Дээрээс нь 51 хүрэхгүй бол тэр тохируулга хийнэ. Энийг хийж чадсан.

Тэгээд жишээ нь Оюу толгой төслийн хувьд техник, эдийн засгийнх нь үндэслэлийг нь үзсэн л дээ. 2010 оны ТЭЗҮ-ийнх нь тооцооллоор Монгол Улсад ноогдох үр өгөөж 6,2 тэрбум доллар байсан юм билээ ТЭЗҮ дээр. 2023 оны байдлаар шууд ба шууд бус өгөөж нь нийлээд 2,8 тэрбум доллар л байгаа байхгүй юу. Ноогдол ашиг авах хугацаа нь хойшлоод л байгаа юм. Хэзээ авах нь тодорхойгүй. Тэгэхээр 4 тэрбум доллар бага байна гэсэн үг шүү дээ. Анхныхаа ТЭЗҮ-гээс. Тэгээд Дэлхийн банк бид нарт зөвлөмж өгөхдөө юу вэ гэхээр та бүхэн цаашдаа мега төслүүдийг хөдөлгөхдөө ер нь энэ төрийн эзэмшлийн хувиа амнат бүтээгдэхүүн хуваахаар орлуулах нь зөв. Дээрээс нь төслийн дийлэнх хувьцааг эзэмших нь буруу гэдгийг зөвлөсөн. Тийм учраас эрсдэлтэй, эрсдэлийн ангиллаар нь авч үзээд 45 хувийн эрсдэл багатай хувилбар бол энэ юм гэдгийг санхүүч нар бол хэлж байгаа юм.

Дээрээс нь хэрвээ Оюу толгой төсөл дээр бид өгөөж тохируулах яг энэ Үндсэн хуулийн 19 оны Үндсэн хуулийн өөрчлөлт хэрвээ тухайн үед хэрэгжиж байсан бол 50 + 1-гээ хангуулна гэж үзсэн бол 10-аас 23 онд Засгийн газар нэмэлтээр 352 сая ам.долларын өгөөжийн зөвхөн тохируулгын төлбөр авах байсан. Зөвхөн тохируулгын төлбөр 1 жилд 352 сая доллар авах байсан. Гэтэл бид энийг тухайн үед энэ Үндсэн хуулийн 19 оны өөрчлөлт батлагдаагүй байсан. Тэгэхээр 19 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийн дараа хийгдэж байгаа ийм жишиг гэрээ бол болно. Тэгээд хэлэлцэх явц бол юу юм бэ гэхээр энэ өөрөө нөгөө Засгийн газар хоорондын хэлэлцээр биш. Энэ бол хөрөнгө оруулалтын гэрээ. Хөрөнгө оруулалтын гэрээ бол Амнатаар орлуулах бүтээгдэхүүн хуваахад л орлуулах Их Хурлын онцгой бүрэн эрхэд байгаа энэ эрхийн хүрээнд Их Хурлын тогтоол батлаад, эрх зүйн орчин нээгдсэний дараа нөгөө компанитайгаа гэрээний эцсийн хувилбар дээр тохироод Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлээд зөвшилцөнө. Тэгээд Байнгын хорооноос.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Учрал сайд гүйцээж хариулъя.

Н.Учрал: Тэгээд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд энэ Их Хурлын тогтоол Үндэсний баялгийн сангийн хууль батлагдсаны дараа бид Франц

талтай гэрээгээ эцэслэнэ. Та бүхэнд өнөөдөр энэ тараасан байгаа гэрээ бол бидний өнөөдөр хэлэлцсэн бүх тохиролцоог агуулсан эцсийн хувилбар. Үүн дээр Их Хурлын гишүүдийн байр сууриудыг нэгтгээд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлээд, зөвшилцөөд, тэгээд шууд гэрээ батлагдах ийм эрх зүйн орчинтой. Цөмийн энергийн хуулиар хөрөнгө оруулалтын гэрээг Аюулгүй байдлын байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлдэг гэрээ батлахаасаа өмнө. Тийм учраас энэ Амнатаар орлуулж байгаа тогтоолын үеэр гэрээг бид хавсралтаар та бүхэнд танилцуулж байгаа. Тэгээд энэ тогтоол батлагдсанаар гэрээ байгуулах бүх эрх зүйн боломжууд нээгдэнэ гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Аюулгүй байдлын байнгын хорооноос эрх аваад, Засгийн газар шууд батлахаар ийм эрх бол байгаа. Гэхдээ Их Хурлын даргатай би ярьж байгаа зүйл бол Аюулгүй байдлын байнгын хороо өөрөө санал гаргавал нэгдсэн чуулганд оруулж хэлэлцүүлэх боломж байгаа тийм ээ. Тийм учраас энэ эрх зүйн боломжоо ашиглагчаасай гэж бодож байгаа. Ер нь Засгийн газрын барьж байгаа байр суурь бүх л асуудлыг Их Хурал руу нээлттэй оруулж ирнэ гэдэг ийм байр суурийг барьж байгаа. Тэгээд бүгдээрээ хэлэлцвэл буруугүй. Тэгээд бүгдээрээ ярьж байгаад, олон талаас нь судалж, шинжилж байгаад, тэгээд бүгдийг нь сайхан ярилцаж байгаад ингээд Засгийн газар, Их Хурлаар оруулж ирээд л нээлттэй ер нь цаашдаа ч гэсэн том төслүүдийг ингээд хийгээд явах нь л хамгийн зөв юм байна лээ. Нэг жижиг процедур алгасах гэж байгаад тэгээд нөгөөдөх нь нэг хэдэн жилийн дараа асуудал болоод, нөгөө дөтнийг харж дөрөв хононо гэдэг шиг юм болж байснаас бүгдээрээ тэгээд ярилцаад л явъя. Тийм учраас энэ гэрээг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дэгийн тухай хуулиараа бүрэн боломжтой. Байнгын хорооны гишүүдийн олонх нь Улсын Их Хурлын хуралдаанаар, нэгдсэн хуралдаанаар асуудлаа шийдвэрлүүлэх санал гаргаж дэмжигдсэн тохиолдолд хэлэлцээд явах бүрэн боломжтой. Ялангуяа энэ томоохон хөрөнгө оруулалтын гэрээний асуудал учраас энийг Улсын Их Хурлын чуулганаар нийт гишүүдийн оролцоотойгоор асуудлаа шийдвэрлэх нь зөв гэсэн ийм байр суурьтай байгаа. Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Тэр хэрвээ ОТ-г энэ загвараар явсан бол ямар өгөөжтэй байх байсан юм бэ гээд. Энэ тооцоолол нь их амархан л даа. Энэ төсөл маань ер нь ОТ-той харьцуулбал 5 дахин жижигхэн төсөл байхгүй юу, 5 дахин бага шүү. Хэрвээ яг энэ загвараар явсан бол ОТ жишээ нь энэ бид Орано дээр 5,2 тэрбум доллар гэж байгаа бол энийг 5 дахин л илүү хуваах байсан л гэж үзнэ. 1 дүгээрт хамгийн энгийнээр ингэж харахад ийм байгаа юм.

2 дугаарт тэр 51 хувийг би дахиад тайлбарлая. ОТ дээр жишээ нь бид өгөөж дотор ноогдол ашиг, бүх төрлийн татвар, аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар бүгдийг нь Монголын талын өгөөж гэж тооцож явдаг. Тэгвэл энд 51 хувь дотор өсөн нэмэгдэж байгаа Амнатыг тооцоогүй. Хувь хүний орлогын албан татварыг тооцоогүй, ажилчдадаа өгч байгаа, өмнөөс нь төлж байгаа нийгмийн даатгалын шимтгэлийг жишээ нь өгөөжид тооцоогүй. Тооцоогүй байхад 51 юм байгаа юм. Хэрвээ Оюу толгойд Монголын талын өгөөжид тооцож байгаа тэр жагсаалтыг бүгдийг нь энд оруулах юм бол 51-ээс бүүр илүү болно.

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье.

Б.Жавхлан: Тэгэхээр бид энэ хэлэлцээрийн шатанд тэр бусад тогтмол төлж байх ёстой аж ахуйн нэгжийн орлогын татвар, нийгмийн даатгалын шимтгэл гэх мэт орлогуудаа бид өгөөжид тооцуулаагүй нь бас их сайн талтай гэсэн үг юм байгаа юм. Та үнийн эх үүсвэр асуулаа. Яах вэ энэ дээр ер нь нэг олон улсын хэрэглэдэг энэ 3 эх үүсвэр байгаад байгаа юм. УХС, trade tech, нэгд нь Camesco гээд ийм 3 эх үүсвэр байгаад байгаа юм. Сая бид хэлэлцээрийн үед УХС-ийн зарлаж байгаа үнийг авч явж байгаад тэндхийн зарлаж байгаа өнөөдрийн үнэ гэхэд нөгөө 75 орчим доллар байх жишээтэй. Ийм байгаа тийм.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Тэр хуулийн процедурын хувьд би сая Ерөнхий сайдын хэлдэгтэй санал нэг байна. Энийг Улсын Их Хурлын чуулганаар нэгдсэн чуулганаар оруулаад соёрхон батлах нь зүйтэй байх. Дараа нь энэ чинь зүгээр хуульд нэмэлт, өөрчлөлт ороод, энэ гэрээ чинь Засгийн газрын түвшинд хийгдээд явчихдаг. Дахиад л бид гуравдагч хөршийн өмнө элдэв маргаан наана, цаана орж байхын оронд парламентаараа нэг батлаад явчих нь өөрөө ер нь аль, аль талдаа шулуун. Монгол Улсын гадаад дахь нэр хүндийн тухайд ч ийм байдалд хүрэх байх гэж бодож байна.

Ер нь саяын энэ хуультай холбоотой өсөн нэмэгдэх рояалти Амнат авъя гэдэгтэй холбоотойгоор нэг нэмээд хэлэхэд хавар 4 сарын үед би миний бланкан дээр олон гишүүн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг өргөн барьж байсан. Яг энэ заалтаар энэ боломжийг гаргая. Бид нарын энэ алдаа Оюу толгойгоос болоод авсан алдааны сургамж юм байна гэдэг заалтыг тухайн үед оруулаад, тухайн үед ер нь энийг Засгийн газрын орж ирсэн хувилбар дээр байхгүй, зарчмын зөрүүтэй байна гээд хэлэлцэгдээгүй. Тийм учраас би энийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тэгээд нэгдсэн чуулганаар энэ хөрөнгө оруулалтын гэрээ учраас Байнгын хорооны нийт гишүүдийн олонхын саналаар нэгдсэн чуулганаар хэлэлцүүлээд, Засгийн газарт гарын үсэг зурах зөвшөөрлийг өгнө гэсэн үг. Процесс нь. Тэр нөгөө Засгийн газар хоорондын хэлэлцээр биш учраас энэ гарын үсэг зурах зөвшөөрлөө Их Хурлаас авна гэсэн тийм ойлголтоор бид асуудалд хандаж болно.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Эрхэм гишүүдэд энэ цацраг идэвхт ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулаад 5.2, 5.3 дээр Монголын парламент сайн дураараа 5.2, 3-ыг та нар харвал компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг болон компанийн эзэмших компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг Монголын төр үнэ төлбөргүй шууд эзэмшинэ гэсээр байтал эндээсээ бид татгалзсан. Ингээд орж ирж байгаа анхны шийдэл энд орж ирж байна.

1 дүгээр асуулт. Энэ шар нунтаг гарч ирсэн шар нунтгаас 10 хувийг нь бид авах эрх байгаа байх. 34 хувийг нь авах эрх бий юү? 34-тэй тэнцүү тийм шар нунтгийг бид худалдаж авах, зах зээлийн үнээр нь авах эрх бий юү? Та нар 15 жилийн өмнө Оюу толгойн гэрээний 640 тэрбум долларын уул уурхайн курст суучхаад бид юу ч ойлгосонгүй. Тэмээ ярих гээд ямаа яриад байна шүү дээ. Өнөөдөр дахиад яг зэсийн тухай уурхай дээр Оюу толгойтой адилхан уурхай дээр 34 хувийг нь рояалти болгочихлоо гээд ярьж байгаа бол энэ гайхалтай. Энэ чинь

уран. Энэ чинь ямаа шал өөр зүйл. Уран бол дэлхий дээр 13-хан оронд байдаг. Монгол орон тэрний нэг нь, энэ ховор зүйл, үнэтэй зүйл биш. Тэгээд өнөөдөр энэнээс 34 хувийг нь өөрсдөө худалдаж авч хаашаа борлуулах вэ, өөрсдөө бага оврын реактороор, уранаар, хямд эрчим хүч гаргах вэ гэдэг эрхээсээ бид татгалзсан. Чин үнэндээ хэлбэл Францын ард түмний ногоон, хямд эрчим хүчээр баталгаатай хангах түүхий эдийг бид 34 жилээр хангана гэдэг ийм л асуудлыг өнөөдөр ярьж эхэлж байгаа. Дүүрсэн хэрэг.

Би 3 асуулт байна. Миний асуултууд нэлээн хурдан, хугацаа ч хурдан явах юм даа. 1 дүгээр асуул. Энэ Монгол Улсын Засгийн газар болон Францын Орано майнинг компанитай хийсэн хэлэлцээрийн протокол гэж байна. 23 оны 10 дугаар сарын 12-нд. Ерөөсөө гуравхан ашиглалтын тусгай зөвшөөрөл байгаа шүү дээ. Дулаан-Уул, Зөөвч-Овоо, Өмнөд. Тэгсэн энэ дээр Гожеговь гэдэг компанийн 19 22 21 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон ордод ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлыг тусгай хэлэлцээрээр шийдвэрлэх болно гээд ингээд ороод ирлээ бусад гэдэг дотор. Францад арай гэж Монголчуудад өгсөн авлигынхаа асуудлыг дөнгөж шийдээд, тэр прокурорынх нь бэх нь хатаагүй байхад энэ яагаад ороод ирэв? 4 дэх лиценз суганы доогуур ороод ирсэн байна. Энийг хэн хийсэн, хэн оруулсан, энийгээ тайлбарлаач.

Дараагийн 2 дахь асуулт Туваан сайдаас би мөн их асуусан даа. Оруулж ирнэ л гээд байсан. Энэ Байгаль орчны яам, энэ Уул уурхайн яам 2 бодлогынхоо эсрэг ажиллаад байна л гэж би харж байна. Миний дараагийн 2 асуулт бол нөгөө хүчлийн үйлдвэр барих яасан юм бэ? Хүхрийн хүчил өнөөдөр нийт зардлын 20 хувь. Монголд хүхрийн хүчлийн үйлдвэр барьснаараа зэс хайлуулах 5 төсөл явж байгаа шүү дээ ГОК, Оюу толгой, МАК, Ханаду нөгөөдөх нь хэн ч билээ эд нарын ганцхан проблем нь элементийн хүхрээ бид яахаа мэддэггүй л гэдэг. Тэгвэл энийг нь гаднаас авна гээд оруулаад ирсэн байна. Яагаад нэг үйлдвэртэй болж болдоггүй юм бэ? Цаадуул чинь юу ч хэлэхэд хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаа энэ үед нь одоо бол 40 хувь гэдийчихсэн. Энийг баталсны дараа бол та нартай ярих ч үгүй.

Миний 3 дугаар асуулт Байгаль орчны яам та нар энэ 750 тонн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Хөрөнгө оруулалтын гэрээг бол нээлттэй Их Хурлын гишүүдэд тарааж өгсөн. Энэ хөрөнгө оруулалтын гэрээнд бид зөвхөн 3 тусгай зөвшөөрлийн хүрээнд л ярьж байгаа юм. Зөвхөн 3 тусгай зөвшөөрлийн хүрээнд. Тэрнээс биш хөрөнгө оруулагч тал бол 4 тусгай зөвшөөрлийн асуудлыг бид нарт ярьсан. Тэгэхээр тэр таны хэлж байгаа тэр Кожеговьтой холбоотой тусгай зөвшөөрөл энд огт ороогүй. Энэнээс хязгаарлаж байгаа гэсэн үг. Яагаад гэхээр энэ өөрөө их тийм ер нь энэ Ораногийн хөрөнгө оруулалтын гэрээ бол өнгөрсөн 10 жил яг л энэ авлига, ашиг сонирхлоос болоод л таг гацчихсан юм билээ. Тийм ч учраас Францын шүүх сая торгууль ноогдуулаад тэр асуудлаасаа зогсоод хааж байх шиг байна.

Гэхдээ мэдээж энэ хууль хяналтын байгууллагуудаар энэ төрийн тодорхой албан тушаалтнуудад янз бүрийн байдлаар нөлөөлж, тусгай зөвшөөрөл өгсөн, авсан гэсэн байдал бол шалгагдаад явж байгаа юм байна лээ. Тийм учраас зүгээр ажлын хэсгийн ахлагчийн хувиар энэ тодорхой мэдээллүүдийг би бол хууль хяналтын байгууллагуудаас авсан. Тийм учраас өнгөрсөн хугацааны сургамжаа

санаад бид бол хэзээ ч энэ дээр 3 тусгай зөвшөөрлөөс нэмэлт асуудлыг ярихгүй. Энд нэмэлт нөөц тогтоогдох, нэмэлт боломжууд бий болох тохиолдолд дахиад хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулах асуудал ярихгүй өнөөдөр нөгөө Оюу толгой бүлэг ордын асуудал хамрах уу, хамаарахгүй юу гээд өнөөдрийг хүртэл энэ ярилцаад, хэлэлцээд байгаа сэдэв үргэлжилсээр байна.

Тийм учраас энэ хамаарахгүй гэдгийг хэлье. 10 хувийн эзэмшигчийн хувиар бид давуу эрхийн хувьцаа эзэмшиж байгаа юм. Тийм учраас шар нунтгаа төдий хэмжээгээр авах эрх нь бид нарт хадгалагдсан байгаа гэдгийг хэлэх ёстой. Тэр дотоодын зах зээлээсээ авна, шар нунтгийнхаа 10 хувийг нь авна. Ер нь энэ тогтоолоор бид тэр амнат орлуулах асуудлыг шийдэж байгаа болохоос 34 хувиа зүгээр ингээд үнэгүй өгчихсөн энэ тэр гэж ингэж ярих нь өрөөсгөл. Энэ Их Хуралд байгаа онцгой бүрэн эрх учраас бид 34 хувиа орлуулаад ямар ашигтай байх вэ гэдгээ тооцсон. Тийм учраас тэр нийтдээ 13 төрлийн өгөөжийг л бид Засгийн газар талын үр өгөөжид тооцож байгаа. Ялангуяа байгаль орчин дээр тэр ус бохирдуулсны төлбөр, агаар бохирдуулсны төлбөр энэ тэр гээд тэр төлбөрүүдийг бид Засгийн газрын өгөөж гэж тооцохгүй.

Жишээ нь менежментийн гэрээ, менежментийн зардал өсөөд байдаг. Эдний компани жишээ нь маркетингийн төлбөр гээд байлаа гэхэд үүнийг бид тэр нөгөө хөрөнгө оруулагч талын өгөөжид тооцож байгаа. Жишээ нь зардал дээр бүртгээгүй. Ингээд эхлэхээр түрүүн Сангийн сайдын хэлдгээр энэ нөгөө зөвхөн 50 + 1 биш хамаарагдаагүй заалтууд нэмэгдсэнээрээ өгөөж бол төдийлөн бас нэмэгдэнэ.

Д.Амарбаясгалан: Салдангийн Одонтуяа сайд нэмж хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр байгаль орчны асуудал үнэхээр хамгийн чухал асуудлын нэг байгаа энэ гэрээнд. Энэ бол аливаа нэг мөнгөөр хэмжигдэхгүй, ирээдүй хойч үед бид энэ байгаль орчноо хамгаалах, байгаль орчинд хортой нөхцөл үүсгэхгүй байх тал дээр манай яам нэлээд хичээж ажилласан байгаа. Энд бол бид нийт энэ төсөл хэрэгжүүлэгч компани нь уурхайн ашиглалтын үе шат эхлэхээс өмнө нийт 10 гаруй төрлийн энэ журам, хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулахаар оруулсан байгаа. Энэний нэгд бол Цацрагийн хамгаалалтын хөтөлбөр, Цацраг идэвхт хаягдлын маань менежментийн төлөвлөгөө, Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ, Ослоос сэргийлэх үнэлгээ, Мал, амьтны эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх гээд ийм нийт 10 хөтөлбөр байгаа. Саяын гол асуусан хог хаягдлын менежментэд нийт 3 төрлийн хог хаягдлын менежментийг заасан байгаа. Энгийн хог хаягдал, аюултай.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж минут өгье.

С.Одонтуяа: Тэгэхээр ер нь бол нийт энэ хэлэлцээр эхлэхээс өмнө 465 саналыг манай яамнаас тавьсан. Эргээд төсөл хэрэгжүүлэгч 255 саналыг хүлээж авах боломжтой гэсэн боловч бид нэлээд олон хоног хэлэлцээр хийж байгаад ер нь энэ 465 саналын 90 хувийг нь хэлэлцээрийн үед зөвшилцсөн байгаа. Тийм учраас байгаль орчны асуудлууд бараг бүгд энэ гэрээнд хангалттай зөв сайн тусаж өгсөн гэдэгт итгэлтэй байна. Яг тэр тоо 750 мянган тонн уу хэд вэ гэдгийг манай ажлын хэсгийн Уранчимэг дарга хариулчих. Ер нь бид аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг уурхайн талбайд хэрэгжүүлнэ гэж энэ дээр бол яг нарийн зааж өгсөн байгаа. Цацраг идэвхт хаягдлыг мэдээж энэ олон улсын

стандартын дагуу боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулж хэрэгжүүлнэ гэсэн энэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал нэмж хариулъя.

Н.Учрал: Энэ хөрөнгө оруулалтын гэрээн дээр үндэсний ханган нийлүүлэгчдийг дэмжих зүйл гээд 11.3-ын Б дээр заалт байгаа. Ялангуяа сая Ганбаатар гишүүний хэлж байгаа тэр хүхрийн хүчлийн үйлдвэр байгуулах асуудлуудыг тусгасан. Яагаад гэхээр 2024 оны 10 сарын 31-ний өдөр Эрдэнэт үйлдвэрийг түшиглээд зэсийн баяжмал хайлуулах үйлдвэрээс гарах хүхэрлэг хийг боловсруулан элементийн хүхэр үйлдвэрлэх туршилтыг хийсэн. Нэг ёсондоо бид дотооддоо үйлдвэрлэсэн элементийн хүхрийг ашиглаад, тэргүүн ээлжид худалдаж аваад, энэ төслийг дагалдуулж хүхрийн хүчлийн үйлдвэр барих асуудлыг шийдвэрлэнэ. Тийм учраас ТЭЗҮ-д тусгаснаар бол Зөөвч-Овоо төсөл жилдээ 206 мянган тонн хүхрийн хүчил буюу 70 мянган тонн элементийн хүхэр ашигладаг юм байна лээ. Энийг бол бид Эрдэнэтээс хангаж чадах юм. 24 оны 10 сарын 31-нд Эрдэнэт үйлдвэрийн туршилт хийсэн. Тийм учраас дам нөлөөллөөрөө өгөөж маш олон бий.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Эрдэнэтийн үйлдвэрээс тэгээд элементийн хүхэр гарна, тэгээд авах байх гээд ийм мөрөөдөл ярьж болохгүй л дээ. Энэ гэрээ дээр чинь яг өөрөө хариуцаад хүхрийн хүчдэлийн үйлдвэрээ барих боломж нь энэ Аревад байгаа яг энэ боломжийг ашиглаач гэж хэлж байгаа. Одоо бол эд нар Хятадаас авна л гэж орж ирж байна. 2 дугаарт энэ аюултай хог хаягдлын тал дээр төсөл хэрэгжүүлэгч компани нь менежментийг хэрэгжүүлэх холбогдох зардлыг бүрэн хариуцах үүрэгтэй гээд биччихсэн. Энэ дээр тэр аюултай хог хаягдлын үйлдвэрээ оруулаад өгөөч дээ? Тэгэхгүй яг одоогийн энэ дотор байгаа юм бол 34 жил контейнерт аюултай хог хаягдлаа хадгална л гэж байгаа. Тэгээд шар нунтгаа аваад гарсны дараа тэр яг зүгээр л тэр талбай дээр нь хаяна. Ийм тэнэг байдлыг зогсоогооч л гэж байгаа юм.

2 дугаарт тэр Гожеговийг ярьж байна. Найзуудаа энэ чинь бол энэ гэрээ 10 дугаар хуудас дээр байна шүү. Хөрөнгө оруулагч болон төсөл хэрэгжүүлэгч компанийн хамаарал бүхий этгээд гээд. Тэгээд Засгийн газар хоорондын яг баримт бичиг дээр өнөөдөр энэ 4 дэх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах уу? Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Энэ хөрөнгө оруулалтын гэрээний тусгай зөвшөөрөл хэсэг дээр яг 3 тусгай зөвшөөрөл байгаа шүү. Ганбаатар гишүүн та нийгэмд нөгөө 4 гэж ярьж болохгүй. 3 тусгай зөвшөөрөл гээд цагаан дээр хараар биччихсэн байгаа. Үгүй ээ үгүй наадах чинь хөрөнгө оруулалтын гэрээ шүү дээ. ТЭЗҮ, хөрөнгө оруулалтын гэрээ дээрээ яг 3 тусгай зөвшөөрөл бичсэн, 4 биш. Дээрээс нь хөрөнгө оруулалтын гэрээ дээр наад хүхрийн хүчил үйлдвэр байгуулах асуудлыг хатуу тусгаж өгсөн. Энийг хэлэлцээрийн явцад тохиролцсон. Тохиролцох тохиролцохдоо дотоодоосоо ханган нийлүүлэлтийг нь авна. Тэр дотроо Эрдэнэт 24 оны 12 сарын 31-нд туршилт хийсэн, манайд ийм боломж байгаа гээд тохироод, дотоод ханган нийлүүлэгчдээсээ авна, хүхрийн хүчлийн үйлдвэр байгуулна гээд тусгасан.

Д.Амарбаясгалан: Салдангийн Одонтуяа сайд нэмж хариулъя.

С.Одонтуяа: Энэ контейнерт хадгалж байгаад ингээд орхиод явна гээд Ганбаатар гишүүн санаа зовж байна. Тэгэхээр гэрээний 9.2-ын Б-д ингэж заасан байгаа. Аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгах гэж байгаа юм. Зүгээр хадгалаад орхичих биш, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг уурхайн талбайд хэрэгжүүлэхийг төсөл хэрэгжүүлэгч компани бүрэн хариуцна гээд ингээд бүр оруулчихсан байж байгаа.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Тэгвэл бидний энэ яриаг чинь Францууд харж байгаа байх. Аюултай хог хаягдлыг боловсруулах үйлдвэр талбай дээрээ тэр Баян сумд говьд Дорноговьд барих юм байна гэж ойлголоо шүү. Аюултай хог хаягдлын үйлдвэрийг.

2 дугаарт өнөөдөр энэ гэрээ дотор 3 орд гэж байгаа. Тэгэхдээ Кожеговь гэдэг бол манай хамаарал бүхий этгээд гэж байгаа. Протокол дээр Кожеговьд 4 дэх ордыг өгчихсөн гэж байгаа. Энэ бол зүгээр техникийн алдаа байсан юм. Зүгээр бичиг хэргийн алдаа байсан юм гэдгээ өнөөдөр та нар энэ дээр микрофондоо хэлэх ёстой шүү.

3 дугаарт өнөөдөр хүхрийн хүчлийн үйлдвэрийг Арева өөрийнхөө хөрөнгөөр барина. Тэгээд Монголын энэ зэс хайлуулах үйлдвэрүүдээс авна гэдгээ тогтож байгаа юм байна гэж ойлголоо. Энэ миний ойлгож байгаа зөв үү? Микрофонд хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Төсөл хэрэгжүүлж байгаа компани хүхрийн хүчлийн үйлдвэрийг барина. Өдрийн 700 тонны хүчин чадалтай ийм үйлдвэрийг барина. Барихдаа дотоодын ханган нийлүүлэгчээс тэр элементийн хүхрээ авна гээд хөрөнгө оруулалтын гэрээ, наад чинь энэ хөрөнгө оруулалтын гэрээ чинь бид нар нэг тийм дураараа нэг юм биччихсэн юм биш шүү. Энэ ажлын хэсэгт ажиллаж байгаа энэ экспертүүд, мэргэжилтнүүд, энэ олон зөвлөх үйлчилгээний нөхдүүд, энэ орчин цагт энэ санхүүгийн схем дээр ажилладаг болчихсон нөхдүүд өөрсдөө суугаад шөнө, оройгүй хэлэлцээд, харилцан буулт хийгээд, ингээд тусгаад ороод ирж байгаа болохоос биш нөгөө бид нар шиг энд орж ирж дураараа ярьдаг юм биш юм байна лээ л дээ хөрөнгө оруулалтын гэрээ гэдэг чинь.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 14 дүгээр микрофон хариулт өгье.

Ц.Уранчимэг: Ганбаатар гишүүнд нэмэлт хариулт өгье. Монгол Улсад тухайн аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгах, хадгалах тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд байхгүй тохиолдолд аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг өөрийн талбай дээр хэрэгжүүлнэ гэж гэрээнд тусгасан байгаа. Тэгэхээр нийт аюултай хог хаягдлын 70 гаруй хувь нь дахин боловсруулах боломжтой ийм хог хаягдал байгаа. Өмнө нь урьдчилсан тооцоогоор бол үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед жил бүр 1600 тонн хог хаягдал гээд ТЭЗҮ дээр алдаатай ийм тоо байсан. Тэгэхээр энийг манай ажлын хэсгийнхэн ТЭЗҮ-д дахин шинжилгээ хийж үзээд, яг Хог хаягдлын тухай хуулиараа одоо байгаа нь урьдчилсан тооцоогоор ТЭЗҮ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд туссан суурь үзүүлэлтүүдийг авч хэрэгжүүлж байгаль орчны менежмент төлөвлөгөөг хэрэгжүүлнэ

гэдэг заалтыг энэ гэрээнд тодорхой тусгаж өгсөн байгаа. Тэгэхээр өнөөдрийн батлагдаж байгаа ТЭЗҮ, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ нь тухайн үйлдвэрийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье.

Ц.Уранчимэг: Одоо байгаа яг энэ урьдчилсан тооцоогоор үйлдвэр барих боломжгүй. Монгол Улсад нийт 27 тусгай зөвшөөрөлтэй ийм аюултай хог хаягдлын үйл ажиллагаа эрхэлдэг компани байдаг. Тэгэхээр энэ дээр яг тэр дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж, нийлүүлэх боломжтой. Яг өөрөөсөө гарч байгаа нийт хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх бүх зардлыг энэ компани өөрөө хариуцна гэдгийг Хөрөнгө оруулалтын гэрээ дээр тусгаж өгсөн байгаа.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 18 цаг 49 минутаас хуралдааныг даргалав.

Б.Пүрэвдорж: Бүгдээрээ сайн байцгаана уу, оройн мэнд хүргэе. Би дахиад дараагийн асуулт асууж байхад Ганбаатар гишүүний асуултыг нэмээд хариулчхаарай. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууна.

О.Батнайрамдал: Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Монгол Улсын Засгийн газар болон Орано майнингийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд Улсын Их Хурлын тогтоол орж ирж байна, дэмжиж байгаа. Тэгэхээр энэ тогтоолын хүрээнд бас энэ гэрээг байгуулснаараа нэг концептын цоо шинэ өөрчлөлт оруулж ирж байгаа юм. Тэгэхээр 2019 онд бид Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дахиад яг тэр стратегийн ач холбогдол бүхий орд гэж байгаа шүү. Стратегийн ач холбогдол бүхий орд ашиглахдаа үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд дийлэнх нь ноогдохоор яаж байх вэ? Тэгэхээр бүх хуулиудаас өмнө Үндсэн хуулийн зарчим л хамгийн түрүүнд заавал биелэх ёстой. Тэгэхээр яг тэр 19 оноос хойш энэ өөрчлөлт орсны дараах яг орж ирж байгаа 2 улсын хооронд байгуулагдаж байгаа Засгийн газрын хамгийн том гэрээ л энэ байна л даа.

Тэгэхээр энэ Орано дээр байгуулж байгаа энэ гэрээний ач холбогдол нь дараа дараагийн стратегийн ач холбогдол бүхий орд дээр гэрээ байгуулагдахад яг Үндсэн хуулийн зарчим хэрхэн хэрэгжих вэ гэдэг маш том тест явж байна гэсэн үг юм. Тэгэхээр энэ дээр тэр шинэ концепт бол тэр өгөөжийн тохируулга гээд 51 хувь хэрвээ хүрэхгүй бол өгөөжийн тохируулгаар жил болгон буцаад тэр нь 50 + 1 хувиар орж ирж байгаа нь яг нөгөө Цөмийн энергийн тухай хууль бид ярилцаж байхад бол яг гол асууж байсан гол асуулт дээр хариулт болоод ороод ирж байгаад маш талархалтай хандаж байгаа юм. Тэгэхээр яг энэ өгөөжийн тохируулга, энэ шинэ концепт дараа дараагийн стратегийн ач холбогдол бүхий орд яригдахад бол бид заавал авч үзэх ёстой болж байгаа юм. Үндсэн хуулийн 6.2-ыг бид яаж бодитоор дараа дараагийн гэрээ дээр амилуулах.

Тэгэхээр сүүлийн 10 хэдэн жил Оюу толгойн гэрээнээс хойш л энгийн хувьцааны хувь эзэмшил, Монгол Улсад орж ирдэг өгөөж гэдэг санхүүгийн талаас маш энгийн боловч буруу концепт одоог хүртэл ингээд тайлбарлагдаад байна л даа. Би санаж байна. Яг 2013 оны Ерөнхийлөгчийн сонгууль санагдаж байгаа юм. Тэр үеэр залуухан байсан, ямар шторк явж байсан бэ гэхээрээ Оюу толгойн 34-ийг 51 хувь болгоно гэсэн Ерөнхийлөгчийн сонгуулийн шторк явж байсныг би одоо хүртэл

санаж байгаа байхгүй юу. Гэтэл сая Ганбаатар гишүүнээ 34 хувь тэр энгийн хувь эзэмшлээр Монголын талд ирдэг өгөөж гэдэг санхүүгийн талаасаа буруу ойлголт шүү. Маш энгийн бөгөөд алдаатай ойлголт.

Тэгэхээр энэ ойлголт чинь тэр яг 2013 онд Ерөнхийлөгчийн сонгуулийн явж байсан шторктой адилхан хуучирчихсан шүү. Одоо тийм энгийн буруу ойлголтоор ард түмэн тэгж хандахаа больсон. Энэ 126-аа дотор тийм энгийн санхүүгийн ойлголтоор хүний толгой эргүүлнэ гэж байхгүй болсон шүү. Тэгэхээр тэрийг бид маш сайн ойлгох ёстой. Энийг бүгдээрээ сонсож байгаа. Санхүүгийн талаас нь ч гэсэн авч үзсэн, би олон улсын банканд ажиллаж байсан санхүүч хүн, мэргэжлийн санхүүч хүн. Энэ тухайн хувьцаа нийлүүлэх хувь эзэмшигчид ирэх өгөөжийг маш олон талаас нь тооцоолж, маш том модель явж байж ард нь ингэж тооцоолдог юм.

Тэгэхээр тэрний хамгийн нэг эрсдэл багатай шууд орлогоос авдаг зүйл бол Амнат байж ирсэн. Энийг Амнатын бус бусад хүмүүс ойлгохгүй байна гэдэг утгаараа зүгээр энгийн хувь эзэмшлээр Монголын талд өгөөж ирж байна гэдэг улс төржилт бол тэр 13 оны Ерөнхийлөгчийн сонгуулиас л гарсан шүү дээ. Тэгэхээр одоо энэ явахгүй аргумент. Та наад аргументээ одоо сольсон нь дээр байх. Энийг нэг хүн яг тэгж шууд ойлгохоо одоо больсон. Одоо арай жоохон, илүү жоохон боловсролтой, туршлагатай хандах ёстой гэж бодож байгаа юм.

Дээр нь энэ дээр бас нэг орж ирж байгаа нэг цоо шинэ концепт. Мэдээж нөгөө Оюу толгойн гэрээтэй энийг шууд ингээд харьцуулаад тооцооллыг нь хийхэд амархан шүү дээ. Сая Жавхлан сайд хэлж байна. Ажлын хэсгээс нэмэлт тайлбар хэлчих хэрэгтэй. Бас нэг орж ирж байгаа концепт бол хориг тавих эрх. Энэ бол 1980 оноос яг Англи улсад, дарга нэмэлт 1 минутаа шууд авчихъя. Англи улсад төрийн эзэмшил бүх хувь эзэмшлээ хувьчилж байх үед гарсан цоо шинэ концепт байсан. Энэ бол алтан хувьцаа гэсэн ойлголт. Тэр алтан хувьцаа яадаг вэ гэхээрээ төр өөрийн төрийн өмчит компани хувьчлахад ямар нэгэн стратегийн ач холбогдол бүхий шийдвэр гаргахад хориг тавих эрх байдаг. Тэгэхээр энийг бид давуу эрхийн хувьцаатай ч энэ алтан хувьцааны эрхийг хориг тавих эрхийг хамгийн чухал материаллаг буюу томоохон ач холбогдол бүхий шийдвэрүүдээр хориг тавих эрхийг энэ гэрээгээрээ баталгаажуулж авч байгаа нь өнөөдөр бид анзаарахгүй байж магадгүй. Гэхдээ маш олон зүйл тохиолдоход магадгүй Монголын талыг хамгаалах ганц гарц нь энэ заалтаар хэрэгжих боломжтой болж магадгүй байхгүй юу.

Тэгэхээр энэ хориг тавих эрхийг ингээд нөгөө талтайгаа зөвшилцсөн гэж ойлгож байгаа. Оруулж ирж байгаа нь үнэхээр санхүүгийн талаасаа бүүр энэ онц шүү. Олон компаниуд энэ дээр оруулж ирж чаддаггүй. Тэгэхээр энийг ингэж гэрээ дээрээ оруулж ирснийг бол бас маш сайн жишиг гэж харж байна. Цаашдаа ч гэсэн бусад гэрээнүүд дээр магадгүй.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Батнайрамдал гишүүнээ тэгэхдээ ер нь Ганбаатар гишүүний яриад байгаа зүйл чинь 1 дүгээрт хүхрийн хүчлийн үйлдвэр байгуулснаар 1 дүгээрт тэр төслийн чинь зардлыг хянах боломж 1 дүгээрт нээгдэх байхгүй юу даа. 2 дугаарт нь бүтээгдэхүүнээ хянах ийм боломж нээгдэх юм. Тийм учраас хүхрийн хүчлийн үйлдвэр байгуулах нь маш чухал гэдгийг л хэлээд байгаа шүү дээ. Тэгэхээр бүүр яг тэр хорт хог хаягдал гэдэг талаасаа биш. Хэн хариулах билээ? 19 номер Наранцогт дарга.

С.Наранцогт: Батнайрамдал гишүүний энэ тодруулга хийсэнтэй холбогдуулаад би нэг зүйлийг гишүүддээ хэлэхийг хүсэж байна. Хөрөнгө оруулагч талдаа энэ 50 + 1 өгөөжийн тэнцвэр бодох яг энэ 50 + 1 хангуулах энд юу юуг оруулах вэ гэдэг энэ хэлэлцээр бол яг бүтэн жил гаруй маш ширүүн хэлэлцээр болсон. Хөрөнгө оруулагч маань Монголын болоод гадаадын хуулийн фирм хөлсөлсөн. Эдгээр хүмүүс танай энэ Үндсэн хуулийн ойлголт маш өргөн ойлголт. Эдийн засгийн өгөөж гэдэг маш өргөн ойлголт гээд. Тэгээд тухайн үед бид Үндсэн хуулийн цэц, Дээд шүүх, бүх газраас энэний нарийн тодорхойлолтыг гаргуулах гэж оролдсон. Тэгээд яг энэ танай хууль дээр энийгээ нарийвчлаад яг энэ энийг ойлгоно гэсэн ойлголт байхгүй. Тэгэхээр энийг бол бид ярихгүй. Яагаад гэвэл танай компаниудад чинь бид өчнөөн төлбөр хийнэ, хүмүүсийг чинь цалинжуулна, ингээд явахаар 50 хувь чинь тэртээ тэргүй хангалттай хангагдаж байгаа гэдэг юмыг хэлэлцээрийн сүүлийн мөч хүртэл хамгаалж байсан.

Тэгээд бид энэ дээр манай Хууль зүйн яам сайн ажилласан. Бид нэлээн ажилласан учраас хууль санаачлагч болоод хууль тогтоогчдын эцсийн тохиролцсон ойлголт гэдэг зүйлийг энэ Их Хурлын протокол дээр үндэслээд, зөвхөн Монгол Улсад яг ингээд төсөвт орж ирэх энэ татвар, хураамж, ноогдол ашиг гэдэг зүйлийг ойлгох нь зүйтэй юм гээд. Энэ зүйлийг бид ерөөсөө Хууль зүйн яамны гаргасан тодорхойлолтоор үзэж, хөрөнгө оруулагч дээр хатуу тулгаж, энийг хэрэв хийхгүй бол энэ гэрээг бид цааш нь хөдөлгөх ямар ч бололцоогүй гэдгээр энэ саяын ярьж байгаа 50 + 1, дээр нь нэмээд энэ өгөөж тохируулах төлбөр гэдэг зүйлийг ингэж тохиролцож чадсан онцлогтой. Энэ бол яг манай Монгол талын өгөөжид шууд татварт улсын төсөвтөө аваад, буцаагаад энэ улс орон болоод энэ төсөвтөө тусгаад явдаг энэ орлогуудыг ингэж тусгасан юм гэдэг зүйлийг тодотгож хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууна.

Д.Үүрийнтуяа: Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Энэ хөрөнгө оруулалтын гэрээний төсөлтэй ингээд танилцаад, танилцуулгуудыг хараад явж байхад энэ хэлцэл бол санхүүгийн хувьд их олон аятайхан нөхцөлүүдийг тусгасан нэлээн сайн хийгдсэн хэлцэл гэж харж дүгнэж байгаа юм миний хувьд.

Энд 2 гол асуудал тусгагджээ гэж онцолж хэлэхийг хүсэж байна. Тэр өгөөж тохируулах асуудлыг гишүүд нэлээн ярилаа. Хэрвээ бид борлуулалтын орлогоос тооцож авч байгаа Амнат ямар нэгэн эрсдэлийн улмаас бидний хүртэх ёстой тэр Үндсэн хуулийн 6.2-т заасан 51 хувьдаа хүрч байна, 50 + 1 дийлэнх гэдэгтээ хүрч чадахгүй байгаа нөхцөлд хөрөнгө оруулагч талаас зардал болгоод ч гэсэн энийг нэмж авна гэдэг бол нэг талдаа давуу тал.

2 дахь асуудал нь 10 хувийнхаа хувьцааг энгийн хувьцаагаар биш давуу эрхийн хувьцаагаар авч байгаа. Энэ бол бас нэг том давуу тал. Бид энгийн хувьцаа эзэмшигчдээс илүүтэйгээр 10 хувийнхаа энэ давуу эрхийн хувьцаанд ноогдох ноогдол ашгаа нэн тэргүүнд авах боломжтой. Шаардлагатай тохиолдолд бусад сангаас ч гэсэн ноогдол ашгийг олгох боломж бүрддэг. Энэ бол энэ гэрээний давуу тал байна гэж харж байгаа юм.

Харин бид цаашдаа нэг тодорхой асуудлууд дээр анхаарах ёстой юм шиг зүйл бидэнд ажиглагдаад байгаа юм. Энэ гэрээнүүдийг ингээд нарийн аваад үзэхээр. Ер нь цаашдаа Ашигт малтмалын тухай хуулийн шинэчлэл хийгдэж байгаа энэ цаг үед бид энэ тодорхой ойлголтуудаа нэг талд нь гаргаж авах нь зөв болов уу гэж бодож байгаа юм. Тэгээд үүнтэй холбоотой нэг тодруулах асуулт байгаа юм. Одоо бид нарт ямар 2 ойлголт яваад байна гэхээр 1 дүгээрт нь стратегийн орд газрын хувь эзэмшлийн асуудал яригдаад байгаа юм. Энэ бол Үндсэн хуулийн 6.1, Ашигт малтмалын тухай хуулийн 5.1-д зааснаараа энэ газрын хэвлийн баялаг, ашигт малтмал гэдэг бол ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна, ард түмний өмч юм, төрийн өмч юм гээд заачхаад байгаа юм.

Өөрөөр хэлбэл тэр энэ өмч өмчлөгчийн хувьдаа тодорхой хувийн хэвшилд ашиглах эрхийг нь лицензээр дамжуулж олгож байгаа юм. Нөгөө талдаа компанийн хувь, хувьцаа эзэмшигчийн асуудал яригдаж байгаа юм. Компанийн хуулиар энэ хувьцаа эзэмшигчийн 34, 50, 50 + 1 хувь бай энэ бол хөрөнгийг өмчилж, хөрөнгийн эзэн байх өмчлөгчийн асуудал яригдаад байгаа юм. Тэгээд энэ 2 асуудлаа бид нэг жоохон ялгаж, салгаж авч явахгүй бол өмчлөлийн хувьд их ялгаатай ойлголтыг хольж хутгаад яваад байна уу даа гэсэн зүйл ажиглагдаад байгаа юм. Тийм болохоор цаашдаа энэ Ашигт малтмалын тухай хууль дээр ч гэсэн, мөн энэ Үндэсний баялгийн сангийн тухай хууль, түүнийг дагаж орж ирж байгаа энэ хуулиуд дээр бид энэ ялгаатай ойлголтуудаа нэг мөр болгож, энэ тал дээр нэг ялгаа заагийг гаргаж явахгүй бол дараа нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр гэдэг бол тухайн ашигт малтмалыг ашигласныхаа төлөө л төлж байгаа төлбөр.

Ноогдол ашиг гэдэг бол Компанийнхаа хуулиар ашгаа олоод, бизнес хийгээд, тэндээс олж байгаа үйл ажиллагааны дүнгээс олж байгаа. Энэ өмчлөлийн ялгааг нэг гаргаж, ялгаж салгаж авах ёстой болов уу гэсэн ийм саналтай байгаа юм. Энэ дээр манай ажлын хэсэг бас ямар байр суурьтай байгаа юм бол?

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ? 19 номер Наранцогт дарга.

С.Наранцогт: Үүрийнтуяа гишүүний асуултын тодруулгад хариулъя. Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн хуулийн тэр төрд ноогдох компанийн 34 хувийг нь Хуримтлалын санд хүртэлх хувьцаанд ноогдох тэр ноогдол ашгийг Үндэсний баялгийн сангийн хуримтлалын санд бүрдүүлнэ гэдэг бол яг энэ компанийн тухай ойлголтынхоо хүрээнд явж байгаа ажил. Тэгэхээр төрийн өмчит компаниудын төрийн эзэмшлийн стратегийн орд дээр яригдаж байгаа.

Үндсэн хуулийн тэр агуулгаар бол ордыг өмчлүүлэх тухай ойлголт байдаггүй юм байна лээ. Зүгээр тэр ашиглалтын лиценз өгч байгаа нь нөөцөө тухайн компанид ашиглуулж байгаа, тэгээд ашигласны төлбөр гэж та бол тодруулж хэлсэн. Ашигт малтмалын нөөц ашиглалтын төлбөрийг бид авч байгаа юм. Тэгэхээр ер нь яах вэ зүгээр ойлголтын хувьд яг энэ одоо явж байгаа хуулиуд дээр нэг их тийм сүрхий хүмүүс янз бүрээр тайлбарлаж байгаа байх. Яг хууль, эрх зүйн хүрээндээ ингээд асуудал гайгүй.

Тэр төрийн эзэмшлийн хувь дээр Ашигт малтмалын хуулийн 5.5, 5.6 дээр яригдаж байгаа асуудал бол ерөөсөө нөгөө хувийн хөрөнгөөрөө яг энэ Орано шиг ордыг олсон, тэрийг улс стратегийн ач холбогдолтой орд гэж үзсэн тохиолдолд яаж түүн дээр төр өөрөө эзэмшил хувь, үр өгөөжийг хүртэх вэ гэдгийг чинь Үндсэн хууль, дээр нь нэмээд Үндэсний баялгийн сангийн хууль дээр их тодорхой зохицуулж

өгсөн. Тэгэхээр яг энэ утгаараа яг энэ Үндсэн хуулийнхаа зарчмыг бодитой амьдрал дээр бид өнөөдөр яг энэ гэрээгээр маш нарийн тодорхойлж оруулж ирж байгаа. Тэгээд манайхан ингээд сайн талаас нь нэлээн ярилаа. Үнэхээр энэ үр ашгийг бид бол сайн тооцож чадсан гэдэгтээ бол итгэлтэй байгаа.

Яах вэ нөгөө талын шүүмжлэл гарч магадгүй. Дараа дараагийн хөрөнгө оруулалт дээр бол нэлээн том босго тавигдаж байгаа гэсэн үг. Ямар ч тохиолдолд Монгол Улс яг энэ 2 талд хуваагдаж байгаа мөнгөн урсгалын яг Монгол Улсад шууд үр өгөөж өгөх тэр хэсгийг л ялгаж авч байгаа шүү дээ. Тэрнээс шууд бус маш олон хүмүүсийн цалин, энэ бэлтгэн нийлүүлэгчдэд төлж байгаа төлбөр, бараа, үйлчилгээний зардал гээд маш олон зүйл байгаа. Нөгөө талд жишээлбэл тухайлбал энэ гэрээ дээр энэ маркетингийн зардал бол бидэнд ордоггүй, зөвхөн энэ ураны нунтгийг олон улсын зах зээл дээр зарахад л хэрэглэгддэг төлбөр учраас энийг манайх авдаггүй зардал энийг ерөөсөө оруулахгүй гэж байсан. Бид энийг бид нар Их Хурлын гишүүддээ тайлбарлаж чадахгүй, энийг зайлшгүй оруулна гээд ингэж оруулсан байгаа. Тэгээд ийм, ийм зүйлүүд байгаа гэдгийг би хэлье.

Б.Пүрэвдорж: Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

Б.Батбаатар: Ораногийн гэрээ энэ цөмийн ашигт малтмалыг ашиглах тухай, олборлох тухай энэ гэрээ Засгийн газар, Бадрах Энержи, Орано гэсэн энэ хаягтай гэрээ хөрөнгө оруулалтын гэрээний төсөл 2024 оны 12 сарын 25 гээд өнөөдөр орж ирж байгаа юм. Дөнгөж сая хэллээ, одоо цагийн өмнө үү хэдэн минутын өмнө үү. Манай энэ Засгийн газрын сайдууд нэг ийм муу зальтай болчихсон. Муу зальтай яагаад ийм болчихоод байгаа юм бэ гээд харахаар аргагүй 118 батлан даагчтай, 118 Их Хурлын гишүүнтэй бүдүүн бүлэгтэй учраас ийм нөхцөл байдалд орчихсон байх шиг байгаа юм.

Энэ Ораногийн гэрээг дэмжихийн төлөө байгаад байдаг. Улс орон хөгжих ёстой, урагшлах ёстой, олон, олон том төслүүд хөдлөх ёстой гэж бодоод байдаг. Тэгэхэд зүгээр хавтастай зузаан ном оруулж ирээд, тэгээд кнопоо дар гэдэг ийм шаардлага тулгаад байна. Энэ нэг удаа биш, нэлээн хэдэн удаа ийм зүйл болчихлоо. Тэгэхээр энд ийм тохиолдолд нөгөө энийг нь уншиж судлаагүй, тогтоол дээр нь болохоор яах вэ тэр давуу эрхийн 10 хувьцаа, 10 хувийн хувьцаа эд нар гэдгийг ойлгоод байдаг. Энийг нь уншиж чадаагүй учраас эргэлзэж эхэлж байгаа юм. Тэгээд эргэлзэхээр хүнд нь хандаж асуудаг, протоколд тэмдэглүүлдэг. Ерөнхий сайд юм уу, хэн нэгэн салбарын тухайн асуудлыг хариуцсан сайдаар энд үг хэлүүлж, Их Хурлын нэгдсэн чуулганы протоколд үлдээгээд байгаа юм. Надад итгэ гэдэг. Итгэх нь муу зүйл ерөөсөө биш, сайн зүйл.

Гэхдээ энэ 3,5 сая Монголчуудын хувь заяаны асуудал. Нөлөө өгөхүйц, доргио өгөхүйц, ирээдүйд сайн сайхнаар нөлөөлөх ёстой ийм ажлыг хийх гэж л сууж байгаа. Энэ асуудал дээрээ анхаараач. Би энийг зүгээр өнөөдөр надад тусад нь ингээд хоцроогоод өгчихдөг юм байх даа гэж гайхсан чинь дотор нь он сар нь өнөөдрийн он сараар л байж байдаг. Тэгэхээр бид юунд итгэх ёстой юм. Төсөл, хөтөлбөр цаасан тооцоололд тэрийг боловсруулсан хүмүүсийн гарын үсэг, хуралдсан протокол тэмдэглэл энэ бүх зүйлд итгэх ёстой. Тэгж байж дараа нь энэ зүйлийг хэн оруулж ирж яаж хийж, тэрний үр дагавар, үр дүн юу болов гэдгийг анхаарах ёстой. Тийм болохоор Засгийн газар Учрал сайд их олон ажлын хэсэг ахалж байна. Энэ дээрээ анхаараач. Яг өнөөдөр энэ гэрээг эцэслээд, хэвлээд

гаргаж ирээгүй л байх. Ядахдаа 2 хоногийн хугацааны өмнө байсан л байлгүй. Ийм зүйлийг дахин давтахгүй байвал ажлынхаа горимд их сайн байна.

Дараа нь байгаль орчны гэрээний төсөл доторхыг уншиж амжаагүй, уншиж амжаагүй хэр нь Их Хурлын тогтоолын төсөл дээр санал өгөх гээд сууж байна. Мэдээж гэрээ биш учраас энд саналаа өгчхөж чадна. Цаашид энэ гэрээг уншаад үзэхэд, судлаад үзэхэд бид Монголын иргэдийн өмнө, иргэд сонгогчдынхоо өмнө, ирээдүй хойчийн өмнө энэ Монгол Улсаа бүрэн бүтэн байгаль орчин нь хүн, амьтан амьдрах бүрэн боломжтойгоор үлдээх үүрэгтэй. Тэр үүргээ биелүүлэхийн тулд магадгүй бусад зарим гишүүдийн үгнээс цухалзаад байна лээ. Энэ Засгийн газар анх байгуулагдаж байх үед манай Засгийн газар ногоон байна гэж хэлж байсан. Хүрээлэн буй орчны ногоон соёл иргэншил энэ асуудлыг шийдэж чадна бид.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Батбаатар гишүүнд 1 минут нэмж өгье.

Б.Батбаатар: Тэгэхээр цаашид гэрээ дотроос Монголын байгаль орчинд хохиролтой ямар нэг зүйл үлдчихсэн, хоцорчихсон байвал тэрийг оруулахыг шаардах болно. Оруулж чадаагүй тохиолдолд энэ гэрээний эсрэг зогсохоос өөр аргагүй болно. Одоо бол Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж саналаа өгнө.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн ахлагч Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Энэ Оюу толгойн гэрээнээс хойш гуравдагч хөрштэй ийм хөрөнгө оруулалтын гэрээг байгуулж байгаа. Тийм учраас ер нь хожим хойно сайн ийм үлгэр жишиг болох ийм хөрөнгө оруулалтын гэрээг оруулъя гэж ийм итгэл үнэмшилтэйгээр өнгөрсөн хугацаанд хэд хэдэн ажлын хэсэг байгуулагдаж байсан юм байна лээ. Тэгээд 3 зөвлөх үйлчилгээний компани ажилласан, дотоодын зөвлөхүүд ч ажилласан. Ингээд ер нь энд ажлын хэсэгт ажиллаж байгаа хүн бүрийн хичээл зүтгэл өнөөдрийн энэ хөрөнгө оруулалтын гэрээг цаад хөрөнгө оруулагч талтай харилцан тохиролцох түвшинд авчирсан. Тэгээд би үүнд талархаж байгаа.

Тэгээд нэг үеэ бодвол орчин цагийн боловсрол эзэмшсэн, олон улсын түвшинд нэг хэлэлцээр хийх чадвар, чадамжтай олон мэргэжилтнүүд бидэнд байгаа юм байна. Сайн эрж хайж чадвал. Ер нь Батбаатар гишүүний саналыг би ойлгож байна. Гэхдээ хөрөнгө оруулалтын гэрээг бол Их Хуралд яг ийм хавсралтаар танилцуулах эрх зүйн орчин байхгүй. Яагаад гэвэл энэ хөрөнгө оруулалтын гэрээг Их Хурлын чуулганы хуралдаанаар яг тийм батлах эрх зүйн орчин байхгүй. Ямар эрх Их Хуралд хадгалагдаж байсан юм бэ гэхээр ерөөсөө төрийн эзэмшлийн 34 хувийг Амнатаар орлуулах уу, бүтээгдэхүүн хуваахаар орлуулах уу, төр давуу эрхийн хувьцаа нь хэд байх вэ ч гэдэг юм уу энэ орлуулах хэлбэрийг Их Хурлын тогтоолоор шийддэг Ашигт малтмалын хуультай.

Энэ хуулийнхаа хүрээнд бид Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай нөгөө амнатаар орлуулж болно гэдэг зохицуулалтыг үндэслээд энэ Их Хурлын тогтоолыг оруулж ирж байгаа юм. Энэ тогтоол батлагдвал Баялгийн сангийн хуультай, Цөмийн энергийн хуулийн нэмэлт, өөрчлөлттэйгөө эрх зүйн орчин бүрдээд, Засгийн газар тэр Орано майнинг компанитай гэрээ байгуулахынхаа өмнө Аюулгүй байдлын байнгын хороонд зөвшилцөхөөр хүргүүлэхдээ энэ гэрээг яг хүргэх ёстой. Яагаад

өнөөдөр энийг хүргэчихсэн бэ гэхээр өчигдрөөс хойш бүлгүүд дээр би мэдээлэл хийхэд гэрээтэй танилцъя гээд ингээд хүсэлт тавьсан. Ингээд өчигдөр би энэ ажлын хэсгийнхнийг шөнөжин ингээд суулгаад, энэ гэрээг ингээд нээлттэй болгоё, гишүүд маань үзэж, энд хааж нуугаад байх юм байхгүй. Тийм учраас үзэж танилцаг, тэгээд Их Хурал тодорхой гишүүдийн саналыг тусгаад, хэлэлцээрээ эцэслэе гэдэг зорилгоор ингэж явсан.

Энэ удаа энэ хөрөнгө оруулалтын гэрээг хэлэлцэхэд бол эхлээд Цөмийн энергийн хууль батлагдсан. Дараа нь Баялгийн сангийн энэ хуулиараа энэ орлуулж байгаа амнатаа хуримтлалын сан руу авдаг болох хуулийг нь өнөөдөр хэлэлцүүлж байна. Ингээд орлуулах тогтоол батлагдчихвал эрх зүйн орчин бүрдчихнэ. Тэгээд түрүүн Ерөнхий сайдын хэлсэн чиглэлийн дагуу бид Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр танилцуулаад, чуулганд оруулж ирээд, дахиж эцсийн хувилбараа ингээд ёсчлох ийм нэг ийм орчин бид нарт байна. Тэгээд ингээд хувилбараар явъя. Цаашдаа Батбаатар гишүүний саналыг анхааръя.

Б.Пүрэвдорж: Жаргалсайханы Золжаргал гишүүн алга байна. Нямтайширын Номтойбаяр гишүүн алга байна. Банзрагчийн Түвшин гишүүн алга байна. Энэ гишүүдийн өмнөөс үг хэлэх нэрд оруулчхаад, өөрсдөө үг хэлэхгүй алга болчихдог нөхдүүд анхаарах ёстой шүү. Номтойбаяр гишүүн.

Н.Номтойбаяр: Цөмийн энергийн тухай хуулийн ажлын хэсэгт өөрийнхөө санаачилгаар орж ажилласан. Тэгээд мэдээж энэ чинь нэг Монгол хүн байна энэ нэг дэлхийн геополитик, энэ эдийн засгийн энэ хурдацтай интеграцид нэг зүүгдээд авъя л гэдэг ийм амбицтайгаар. Тэгэхдээ хуулийг хэлэлцэж байхад нэг анзаарах чухал зүйлүүд гарч ирсэн. Тэр нь юу вэ гэхээр зөвхөн нэг компанид зориулж энэ хуулийн төсөл маань хөтлөгдсөн. Тэгээд ураны орд газар гэхээр ганцаараа Бадрах энерги биш, уран олборлогч гэхээр энэ Орано компани нь ганцхан биш. Тэгээд ажлын хэсгийн үед Уул уурхайн яамнаас ер нь энэ ураны хэдэн лиценз байдаг юм бэ? Нийтдээ 8 байдаг юм байна. Ашиглалтын болон хайгуулын.

Гэтэл нөгөө ураны орд газар лиценз эзэмшиж байгаа компаниудад энэ эрх зүйн хууль, дээрээс нь энэ хэлэлцээрийн нэг чиглэл энэ боломжийг бас олгох уу? Яагаад би ингэж асуугаад байна гэхээр энэ чинь газар зүйн байршил, нөөц, дэд бүтэц хөгжсөн эсэх асуудал, агуулга нь, уул техникийн нөхцөл байдал гээд энэ чинь харилцан адилгүй байхгүй юу. Тэгэнгүүт нэг ийм учир дутагдалтай зүйл ингээд анзаарагдаад байна. Энгийн олон татвараас гадна бид 51 хувийн татвар авч байгаагаараа ингээд нэг эх оронч үйлдэл гаргачихсан юм шиг ингээд яриад байгаа байхгүй юу. Гэтэл бусад энэ уран олборлогч компаниуд олборлохыг горилж байгаа компаниуд энэ босгыг давж чадах уу? Ганцхан бид нэг Орано Бадрах энержигээр хязгаарлачих юм биш биз дээ? Энийгээ бид бодмоор байгаад байгаа юм.

Бусдад нь бас нэг боломжийг нь олгоё л доо. Энэ Канад гэж нэг улс байна мөн уран олборлогч технологи эзэмшигч, Австрали байна. Зөвхөн Орано Франц гэдгээр нь хязгаарлагдаж, нэг нүдээр харж болохгүй л гээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар Уул уурхайн сайд нь байгаа юм болов уу? Бусадтайгаа уулзаж үзсэн юм уу? Энэ хуулийн болон энэ хэлэлцээрийг батлах гэж байгаа чиглэлээр ярьж үзсэн үү? Бусад нь нэг ийм эрх тэгш боломж, таатай нөхцөлийг бүрдүүлэх үү? Урьдчилсан ТЭЗҮ-ээ боловсруулсан юм уу? Ер нь ТЭЗҮ байгаа юм уу, үгүй юм уу, тэрэнд нь хэр нийцэж байгаа юм бэ? Бид энийг харахгүй бол ерөөсөө яг нэг чиг баримжаатай л хараад байна л даа. Анхнаасаа энэ хуулийн төслөө тэгээд л явчихсан юм л даа.

Энийг удаа дараа л анхааруулж хэлсэн юм. Тэгээд Учрал сайд энэ дээр ч хариулахад хэцүү байх даа. Ер нь тийм мэдээлэл байгаа юм болов уу, уулзалтууд хийсэн үү?

Б.Пүрэвдорж: Цөмийн энергийн хуулийг ажлын хэсгийг ахалсны хувьд нэг зүйлийг хэлэхэд яг энэ Номтойбаяр гишүүнтэй санал нийлж байгаа юм. Өөрөөр хэлбэл яг энэ 51 хувьд хүргэх энэ зорилтын хүрээнд өнөөдөр 80 доллартой байлаа гэхэд дэлхийн зах зээлийн үнэ 80 доллартой байлаа гэхэд 51 хувьдаа хүрч байгаа юм. 100 доллар луу очиход 61 хувь руу бараг хүрнэ. Тэгэхээр энэ Цөмийн энергийн хуулиар бол ерөнхийдөө бусад улс орны компаниуд бараг орж ирэхээргүй болчихоод байгаа юм. Бараг л ганцхан Орано л энэ Монголд бизнес хийхээр ийм л нөхцөл байдалтай ийм өндөр хувь тавигдсан шүү. Амнат тавигдсан. Дээрээс нь компанийн хувь, алтан хувьцаа энэ тэр тавигдаад, олон, олон татваруудаар энэ шаардлага хангагдаж байгаа. Тэгэхээр энэ дээр нэмээд Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Тэгээд яах вэ? Цөмийн энергийн хууль их олон жил нэмэлт, өөрчлөлт ороогүй юм байна лээ. Тэгээд Цөмийн энергийн хууль дээр бид энэ тусгай Амнатын босгыг байхгүй болгосон. Тэр юу вэ гэхээр яг төрийн эзэмшлийн 34 хувийг орлуулахтай холбоотой л энэ тусгай Амнатын босгыг нь байхгүй болгоно гэхээр энэ ерөөсөө гол зорилго нь юу вэ гэхээр тус төсөл дээр өөр, өөр кэйс үйлчилнэ л гэдэг санаа. Тийм учраас энэ Ораногийн энэ хөрөнгө оруулалтын гэрээ бол бас өөр кэйс. Тэрнээс биш тэр 8 лиценз эзэмшиж байгаа компаниудтай бид хөрөнгө оруулалтын гэрээг байгуулбал бид тусгай амнатаа хэдээр тогтох вэ гэдгийг 2 тал хоорондоо харилцан тохиролцоно. Одоо бол Ашигт малтмалын хуулиар ч тэр, Цөмийн энергийн хуулиар ч тэр цаашдаа тусгай амнат дээд тал нь 5 байна гэдэг ойлголт байхгүй. Тэр 5 байна уу, 6 байна уу, 10 байна уу тэрийг Их Хурал өөрөө л шийдээд явна.

Тийм учраас бид зүгээр тухайн кэйс бүр дээрээ өөр өөрөөр шийдэх ёстой. Тэгээд сая батлагдсан Цөмийн энергийн хууль анх удаа бид өсөн нэмэгдэх Амнат гэдэг ойлголтыг бий болгосон учраас стратегийн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлээс шалтгаалаад тэр прогрессив Амнатыг хувьчилж тооцож байгаа. Тэгээд тэр бол харьцангуй шударга үнэ нь өсөж байвал багасаад явдаг. Гэхдээ бусад энэ лиценз эзэмшиж байгаа компаниуд өөр өөрсдийнхөө онцлогоос шалтгаалаад хөрөнгө оруулалтын гэрээ дээрээ 2 тал хэлэлцээр хийгээд, ингээд шаардлагатай бол орлуулна, шаардлагагүй бол 34 хувийн ноогдол ашгаа аваад явна.

Түрүүн гишүүд яриад байна. 34 хувиас татгалзаж байгаа ойлголт ерөөсөө биш шүү дээ. Төр үнэ төлбөргүйгээр 34 хүртэлх хувиа авах ёстой хуультай. Тэгэхээр энэ хуулийг хэрэгжүүлэхийн тулд Ашигт малтмалын хуулиар тэрийгээ үр өгөөжөө хүртэхдээ бид орлуулж хүртэж болно л гэдгийг ярьж байгаа болохоос төр 34 хувиа ингээд өгөх гээд байна гэж тийм юм огт байхгүй шүү дээ. Хуульдаа бид 34 хүртэлх хувийг эзэмшинэ үнэ төлбөргүй гээд заачихсаныгаа орлуулж болох учраас Их Хурлаар шийдүүлээд, орлуулаад, энэ тохиолдолд ашигтай байна гэж байгаа. Үндсэн хуулийн тэр 6.2 бол нөгөө газрын хэвлийн баялгийн дийлэнхийг ард түмэн эзэмшинэ гэдгийг ер хөрөнгө оруулагч тал маш их өргөн агуулгаар ойлгодог юм байна лээ. Бид энэ хэлэлцээр дээр юу гэсэн бэ гэхээр энэ бол шууд өгөөж байна, шууд бус өгөөж буюу тэр ажлын байр нэмэгдүүлж байгаа, тэр нийгмийн дэд бүтэц, тэр дам нөлөө гээд л байгаа худалдаа, үйлчилгээ бүх боломж нээгдэхийг тооцно гээд.

Үндсэн хуулийн чинь агуулгыг харахаар ингэж л ойлгож байна. Энийг өргөн агуулгаар бод гээд. Энэ төсөл дээр бид шууд өгөөж авна гэж л тооцсон учраас 13 янзын төлбөр, татвар. Бусад кейс дээр өөр өөрөөр ярилцаад явах бололцоотой. Өнөөдрийн энэ Баялгийн сангийн хууль зөвхөн энэ хэлэлцээртэй холбоогүй. Цаашдаа бид Ашигт малтмалын хуулиар ч гэсэн тусгай Амнатын босгыг үгүй болголоо, Үндэсний баялгийн сангийн хуулиар тусгай амнатаар орлуулсан бол Хуримтлалын сан руу авдаг боллоо. Ингээд Хуримтлалын сан арвижвал эрүүл мэнд, орон сууц, боловсролд зарцуулна гээд. Тэгээд бусад төсөл яг энэ хуулийн үйлчлэлийн хүрээнд явна гэдэг ийм л санаа хэлмээр байна.

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. С.Ганбаатар гишүүн, 2 дугаар индэр дээр.

С.Ганбаатар: Би ганцхан минутад надад хандаж асуулт асуусан Батнайрамдал гишүүндээ хариулъя. Залуу гишүүд минь анхаараарай. Хүн муучилж, хүн доромжилж, өөрийгөө ухаантай царайтай болгох гэж улс төр хийвэл энэ бол улс төрийн үхэл. Оюу толгойн 34 хувийг ярьснаараа би нэг их улс төр хийсэн биш, 20 жил Рио Тинтогоос мөнгө авсан баахан хөлсний алуурчин нийтлэлчдэд л нэг алууллаа даа. Ер нь тэгээд л хамгаалах нэр хүндгүй болтлоо зодуулна гэдэг бол улс төрчийн эрх чөлөө юм байгаа юм шүү дээ. Тэгээд яг тухайн үедээ асуудал нь 34 хувийг би эсэргүүцэж 3 захидал явуулж байсан. Роялтид хувиргаж 10-аас 15 хувь болгож, роялти болгооч гэдэг тооцооллоо хүртэл явуулж байсан. Захидал нь надад байгаа. Засгийн газрын архив дотор бас байх ёстой. Энэ бол уран өөр асуудал гэдгийг хэлээд байгаа юм шүү. Энэтэй битгий дүйцүүлээч л гэж яриад байгаа юм. Өөр асуудал. Ингээд хэлэх үг рүүгээ орёе.

Яах вэ, энэ ташрамд хэлэхэд Миеэгомбын Энхболд гуай Ерөнхий сайд байсан, яг иргэний нийгэм, ард иргэдийн төлөөллүүдийг хэлэлцээрийн ширээнд хамт суулгаж байсан шүү. Тэгээд сайн талууд тэр үед байсан. Одоо бол бид чинь хаалгаа түгжиж аваад л энэ дотроо яриад байгаа шүү дээ. Тэгээд л ганц нэг фэйсбүүкээр яривал гадаадын тагнуулч гэж хэлчих гээд л тэгээд л яваад байгаа. Энэ бол нүдний булай.

Миний хэлэх асуудал бол би 4-хөн асуудал хэлсэн. 1 дүгээрт хүхрийн хүчлийн үйлдвэр барина гэсэн. Нийт зардлын 20 хувь шүү дээ. Жилд 40-өөс 50 сая долларыг энд зарцуулна. Үүнийгээ Нарантуулын зах шиг ингээд гаднаас авна гээд ороод ирж байгаа бол бид энд суугаад байхын хэрэг байхгүй. Тэгээд 5-ын 5, манайх зэстэй орон. Зэсийн үйлдвэр яагаад баригддаггүй вэ гэвэл ганцхан хүхрээ яахаа мэддэггүй. Хүхрээ яаж, хаашаа далд оруулахаа мэддэггүй энэ проблемыг шийдэх алтан боломж шүү. Тэр зэс хайлуулах үйлдвэр боловсруулах гэж байгаа 5 үйлдвэртэй энэ талаар хэлэлцээрт орох ёстой. Тэгээд Учрал сайд бол хүхрийн хүчил барина гэж чуулганы индэр дээрээс хэлсэн. Аюултай хог хаягдлын үйлдвэр барина гэж Одонтуяа сайд хэлсэн. Тэр хариуцаж байгаа хүн нь удахгүй ярина гэж надад хэлсэн байгаа. Заавал микрофонд ярих ёстой шүү. Аюултай хог хаягдлын үйлдвэр барина. Тэгэхгүй тэгээд л зүгээр боловсруулна, булшилна, олон улсын стандартыг хангана, үгүй ээ мөн тэр цаас чинь өөрөө хөл ургаад, тэгээд тэр аюултай хог хаягдлыг мөн алга болгоно.

Орос, Хятад 2 лав тэрийг чинь авахгүй. Тэгээд Дорноговь тэрийг чинь тэр чигт нь хадгалах гэж байгаа бол бид өнөөдөр нүгэл хийж байна гэж тооцно шүү. Энийгээ бид тооцоолно. Үндсэн хуулийн 6 дугаар заалт дээр уул уурхайн баялгаас ашиг орлого олохоос илүү иргэдийн эрүүл, аюулгүй байдлыг хамгийн 1 дүгээрт эрэмбэлнэ гэж заасан байгаа шүү. Энэ эрэмбээ хаячихсан. Байгаль орчны яам нь энэ дээр ингээд таг. Эрдэс баялгийн яам нь өнөөдөр ингээд хүхрийн хүчлийн үйлдвэр гээд таг. Энийгээ сая ашгүй чуулганы индэр дээрээс хоёуланг нь барина гэж би ойлголоо. Протоколд үлдээе. Кожеговь гэдэг тэр компани хамаарал бүхий Аревагийн хамаарал бүхий компани манай протоколд шүү Засгийн газрын Ареватай хамтарсан протокол дотор 4 дэх орд нэр нь Дулаан гэж байгаа юм. Нөгөө Дулаан-Уул гэдэгтэй ойролцоо нэртэй Дулаан гэдэг орд байгаа, 4800 тонны орд. Энийг ингээд задгай мөнгө шиг панчаан шиг ингэж зүгээр бэлэглэдэг юм биш. Тэгээд энэ протоколд байгаа зүйлээ одоо албан ёсоор тайлбар өгнө шүү. Францууд чинь энийг чинь зүгээр үмхэх гээд л хэвтэж байгаа. Энэ дээрээ тайлбар өгөөрэй. Ийм 3 зүйлийг онцолж хэллээ.

Эцэст нь 4-д нь нэг зүйл хэлэхэд Монгол Улсын Засгийн газар үргэлж энэ том улс байж болно. Гаднын компаниудтай өөрийгөө эн зэрэгцүүлж хэлэлцээрийг нь баталж байдаг биш.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Батын Батбаатар гишүүн 2 дугаар индэр.

Б.Батбаатар: Өнөөдөр Монгол Улсын Засгийн газар 118 Их Хурлын гишүүний дэмжлэгтэйгээр олон, олон зүйлсийн шанг нь татаж байгаа анхны шанг. Анхны шанг нь татаж байгаа учраас зарим зүйлийг нь дэмжиж байгаа. Аз болоход энэ 118 дотор орсон нөхдүүд ямар нэг наймаа тохиролцоо хийж байж зарим зүйл дээр нэ эерэг кноп, нэмэх кноп дардаг байсан бол тэгэлгүйгээр засагт орчихсон нь энэ Засгийн хувь заяа. Монголд зөв хувь заяа байсан юм байх гэж харж байна. Иргэний Зориг ногоон нам сөрөг хүчин, цөөнхийн үүрэг гүйцэтгэж байгаа. Тэгэхдээ бид зөв зүйлийг нь дэмжинэ. Юм болгон дээр ямар нэг байдлаар шантааж хийдэг, ямар нэг байдлаар санал тавьдаг тийм зүйл Иргэний Зориг ногоон нам хэзээ ч хийхгүй. Эрх ашгийн эрэмбээ нэгд нь улс орон гэж барьдгийн хувьд бид тийм зүйл хийхгүй. Тийм болохоор энэ Орано, энэ цөмийн эрчим хүчийг ашиглах Монгол Улс энэ олон гарцуудыг нээх анхны шангуудыг нь татах энэ ажил дээр нь Засгийн газрын санаачлан оруулж ирж байгаа санаачилгуудыг дэмжиж байгаа.

Гэхдээ зарим тохиолдолд яасан ч дэмжих боломжгүй юм. Монгол Улсын байгаль орчин, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөл орчин, тэрийг дордуулахаар зүйл хийгдэж орж ирсэн тохиолдолд бид энэ танхим дотор иргэдийнхээ дуу хоолой болно. Энэ танхим дотор цөөдөх юм бол эргээд иргэд дээрээ очиж дэмжлэг хүсэж бид тэр бодлогынхоо эсрэг зогсох болно. Ингээд цааш цаашдаа Засгийн газрыг тодорхой хэмжээгээр засагт хамтраагүй улс төрийн намд, улс төрийн хүчинд мэдээллийг түрүүлж өгөх, та бүхэн тэртээ тэргүй боловсруулалтынхаа явцад хамт явж байгаа учраас эхэлсэн цэгээсээ мэдээлэлтэй байгаа. Тэр мэдээллийг өгдөг энэ ажлыг хийж өгөөч гэдэг хүсэлтийг тавимаар байгаа юм. Шаардлагыг дахин давтан хэлж байгаа.

Засгийн газар бүх ажлаа нээлттэй Их Хуралд оруулж ирж бүгдийг нь шийдүүлдэг байя гэдэг зүйлийг дөнгөж саяхан Ерөнхий сайд чуулганы танхимд хэлсэн. Бид тэр зарчмыг дэмжинэ. Гэхдээ тулгаж оруулж ирээд, гүйцэд ойлгоогүй, танин мэдэхүйн асуулт асуугаад, кноп дардаг ийм хурдтай үйл хөдлөлийг бол

дэмжээд байхад хэцүү. Хариуцлага нь Их Хурал дээр үлдэнэ. Ингээд олон, олон энэ том мега төслүүд болон улс орныг өнөөдөр байгаа хүндрэлтэй, бэрхшээлтэй олон асуудлуудаас гаргахад идэвхтэй ажиллаарай гэж 118-ын бүлэгтээ хүсье. Гэхдээ та нарын алдаж харж, онож хүрэхгүй байгаа тэр буруу замаар алхсан тохиолдолд Иргэний Зориг ногоон нам засахын төлөө зогсоно. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Нямтайширын Номтойбаяр гишүүн индрийн 2 дугаар микрофон.

Н.Номтойбаяр: Энэ чинь нөгөө дэмжих, дэмжихгүй 3, 3 гээд. Би дэмжих байр суурьтай. Тэгээд анхнаасаа энэ чинь Цөмийн энергийн тухай хууль орж ирэхэд дэмжих байр суурь илэрхийлсэн. Тэгээд энд нэг бодолцож үзэх зүйл түрүүн асуултаараа маш тодорхой хэлсэн.

2-т нь юу вэ гэхээр энэ Цөмийн энергийн тухай хуулийн ажлын хэсэгт би Ганбаатар гишүүнийг заавал байх ёстой гэж зарчмын байр суурийг Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороон дээр тавьж, тэгээд улмаар Ганбаатар гишүүн орж ирсэн. Хэдийгээр зарим зүйл, заалт дээр хатуу байр суурьтай байсан ч гэсэн зайлшгүй цаашдаа анхаарч ажил хэрэг болох ёстой хэд хэдэн ажил хэрэгч асуудлуудыг хөндөж тавьсан. Энд нь хүндэтгэлтэй хандах хэрэгтэй байх. Тэгээд ажлын хэсгийн хурал дээр хөөрхий үнэнээ хэлээд гуйж л байсан л даа. Битгий намайг ингээд та нар попын хаан, намайг юм ярихаар ингээд чихээ бөглөөд бай, үнэхээр ажил хэрэгч ийм саналууд дэвшүүлж байгаа шүү гээд. Нөгөө хуулийн төсөлдөө ноороглосон зүйлээ харуулаад, нэлээн ажил хэрэгч хандсан. Тэгээд энийг нэлээн ажил хэрэг болгомоор байна. Тэрнээс биш нэг хэлсэн үгэнд нь хэн нэгэн доромжлоод, энд нэг хэрүүл хийгээд байх нь зохисгүй. Чухал, чухал хэдэн асуудлууд байгаа. Тэгээд яагаад энийг онцолж хэлж байна гэхээр энэ санаачилгыг гаргаж, Ганбаатар гишүүнийг ажлын хэсэгт урьж оруулж ажилласныхаа хувьд энэ дээр тайлбар хийх нь зөв гэж үзэж байна. Ялангуяа тэр сүүлийн яриад байгаа өөрөө ингээд 1, 2, 3, 4 гээд байгаа. Энэ хүхрийн хүчилтэй холбоотой, энэ байгаль экологитой холбоотой чухал асуудлууд бий.

Дээрээс нь энэ хэлэлцээр дээр аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагын асуудлыг онцгойлон давхар хуульд нийцүүлж хараарай.

Эцэст нэг зүйлийг хэлмээр санагдаад байна. Урьд нь энэ хуулийн төслийг дэмжиж байхад хэлж л байсан. Бидэнд нэг сул тал байна. Нэг гаднын хүчтэй, мөнгөтэй нөлөө бүхий компаниудтай болохоор бид нэг өвдөг сулраад л, тайчих нь холгүй юм болоод л, туулай шиг царайлаад л. Дотоодынхоо аж ахуйн нэгж, хэдэн үндэсний үйлдвэрлэгчид дэндүү арслан, бар шиг 2 нүүр гаргадаг ийм царайгаа бид больчихмоор байна. Яг нэг зарчим л баримаар байна. Тэгээд саяын Чайна Энержигийн энэ холбоотой энэ асуудалд бид нэг Монголын төр нэг ийм чиг баримжаатай, нэг жанжин шугамдаа орох, голдиролдоо орж байгаа юм байна гэдэг итгэлийг төрүүлсэн байх.

Дээрээс нь энэ Оюу толгойн гэрээний дараа байгуулагдаж байгаа энэ томоохон өнөөдрийн энэ хэлэлцээрт чиглэл өгөх Их Хурлын энэ хэлэлцэж байгаа байдал, гаднын хөрөнгө оруулагчдад нэлээн дохио өгч байгаа байх. Тэгээд хэн хүнгүй л мэдэж байгаа. Монголын төр нэг аятайхан чиг баримжаа бариад явангуут бусад өөр салбаруудад гаднын хөрөнгө оруулалтын сонирхол өдөөгдөөд эхэлсэн. Энэ Цөмийн энергийн тухай хууль хэлэлцэх эсэхийг нь Их Хурлаар шийдээд

явангуут, Францын хэд хэдэн компаниуд, Хөрөнгө оруулалтын сан, банкнууд Монголын бусад салбаруудыг сонирхоод эхэлсэн. Тэгэхээр нэг далайцтай үр дүн нь энэ юм байгаад байгаа юм. Энийг л би гишүүддээ нэг онцолж хэлье. Тэгээд мэдээж энэ ажлын хэсэг гарч таараа. Эцсийн дүндээ энэ гэрээ нь Их Хурлаар соёрхон батлахаар орж ирнэ. Олон гишүүд ажил хэрэгч олон санаачилга гаргалаа. Тэгээд энийг нэг сонссон болоод өнгөрөх биш, яг ажил хэрэг болгоод, тусгалаа олоод, ард чинь бас нэг дэмжих, буруу зүйл дээр нь чичлэх ийм Их Хурал байгаа шүү. Тэгээд зоригтой хэлэлцээрийнхээ ажлыг хийгээрэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Гонгорын Дамдинням гишүүн индрийн 1 дүгээр микрофон.

Г.Дамдинням: Гишүүддээ оройн мэнд хүргэе. Тэгээд бид Дэгийн хуулиараа дэмжих, дэмжихгүй байр суурь илэрхийлэх ёстой. Би бол энэ Монгол Улсын хөгжил дэвшилд онцгой хувь нэмэртэй ийм томоохон гэрээнүүдийг бүгдийг нь дэмжих ийм байр суурьтай үг хэлэх гэж гарч ирлээ. Орано гэж яригддаг цөмийн энергийн улс болох Монгол орны эрчим хүчний эрх чөлөөгөө эдлэх боломжийг нээх, цэвэр эрчим хүчтэй болох, элдэв шахалт дарамтад орохгүй байх энэ боломжийн үүд хаалгыг нээх энэ гэрээ бидний өмнө үндсэндээ гурван аравны дараа орж ирж байна.

Үндсэн хуулийн өөрчлөлт улс орныхоо асуудлыг ширээ тойрч, парламент дээрээ ярьж чаддаг ардчилсан улс гэдгээ баталж, нэмэгдүүлж орж ирсэн анхны парламентын хамгийн том legal-ий гэж хэлье дээ. Тэгээд үлдэх өв нь энэ 2 том гэрээ болно гэж бодож байна. Ардчилсан тогтолцоонд шилжээд бид 30 гаруй жил явж байна. Үүлэн чөлөөний нар шиг л ийм тохиол бид нарт таарч байна. Ний нуугүй хэлэхэд би энэ салбарын энэ уул уурхайн салбарын судалгаа шинжилгээ хийж явсан хүн. Энэ гэрээ биднээс гэхээсээ бас бусад асуудлаас болж гацаж байсан ийм тохиолдол байсан. Маш удаан хугацаанд. Тэгэхээр энэ удаад нэг үүлэн чөлөөний онгойж байгаа дээр хэдүүлээ хийгээд авцгаах нь зөв байна. Өөр гарцгүй байна.

Монгол Улсын гадаад нэр хүнд, түүнийг өсгөх ажил маш эрчимтэйгээр Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Их Хурлын дарга, Их Хурлаараа бид бүхэн тал талдаа хичээж чармайж, нэр хүнд өндөр байгаа энэ цаг үед энэ гэрээ боломж болж бид нарт орж ирж байгаа. Чайна Энержигийн гэрээ ч гэсэн. Бид нүүрсний төмөр зам, нүүрсний гэрээ, нүүрсний компани, Ораногийн энэ гэрээ гээд энэ яриад 20, 30 жил өрөнд баригдаж, өтөнд идэгдэх хүртлээ хаадынхаа нэрээр зээл авч гурван арваныг туулцаалаа шүү дээ. Энэ хэмжээний том гэрээнүүд ер нь олон улсын судалгаагаар харж байхад тэгээд л 20 жилийн хугацаанд тэгээд нэг жигдэрч нэг байр сууриа олцгоодог юм байна лээ. Одоо яг цаг нь ирж байх шиг байна. Бидний үед таарч байх шиг байна.

Монголчуудын бидний хэлдгээр 7 хэмжиж, 1 огтолно гэж ярьдаг. Тэр хугацаа нь ч болсон байх. Одоо ус, тос нь бүгдээрээ ялгараад, шүүс нь гараад, хэн нь зөв, хэн нь буруу нь ч харагдаж байгаа байх. Төлөх ёстой төлбөрөө бүгдээрээ төлцгөөчихлөө. Улсынхаа эдийн засгаар. Хөгжих ёстой байсан боломжоороо төлцгөөчихлөө. Одоо нэг урагшаа ахицгаая, ажил хийцгээе өөр асуудал ярья. Шинэ Оюу толгой, шинэ Тавантолгой, шинэ уул уурхайн төслүүд, шинэ үйлдвэржилтийн бодлогууд бид яримаар байна. Улаанбаатарын утаа, Улаанбаатарын түгжрэл, Оюу толгой, Тавантолгойгоосоо хэдүүлээ больё л доо. Тийм учраас би энэ гэрээг дэмжиж байгаа. Энэ 2 гэрээ дээрээ хамгийн чухал анхаарах ёстой нэг л зүйлийг та бүхэн маань гэрээ хийхдээ анхаараарай, ажлын хэсэгт нь орж ажиллая гэсэн бодолтой байна.

Монголын үндэсний аж ахуйн нэгжүүд, Монгол хүмүүс ажилтай, орлоготой болох, know how буюу туршлага мэдлэгийг нь авч үлдэх энэ боломж нөхцөлийг бүрэн хэмжээгээр анхаарч гэрээнүүд дээрээ ажиллаарай гэж хүсье. Тэгээд Чайна Энержитэй хийх Монгол Улсын Засгийн газрын гэрээ, Франц Улсын бидний гуравдагч хөршийн тусгаар тогтнолтой маань холбоотой энэ том гэрээг дэмжиж байгаагаа илэрхийлж байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт, үг хэлж дууслаа. Их Хурлын дарга 7, 8, 9 дүгээр хэлэлцэх асуудлын санал хураалтыг асуудлаа хэлэлцэж дууссаны дараагаар санал хураахаар шийдвэрлэсэн байгаа.

19.36 цаг

Ес. “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Тэгээд дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 9. Монгол Улсын Улаанбаатар хотын дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2024 оны 12 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах. Тэгэхээр энэ асуудлыг хэлэлцэхэд бол энэ хэлэлцээрийн Байнгын хороогоор зөвшилцөх асуудал 8 дугаар сард Байнгын хороодоор орж, гишүүд нэлээн асуулт асууж ярьсан байгаа. Тэгэхээр одоо энэ бол соёрхон батлах тухай асуудал байгаа шүү гэдгийг хэлье. Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн танилцуулна. Индэрт урья.

Б.Чойжилсүрэн: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Дулааны гуравдугаар цахилгаан станц төрийн өмчит компанийн 48 мега ваттын хүчин чадалтай дунд даралтын хэсэг 1968-аас 1975 онд, 100мвт-ын хүчин чадалтай өндөр даралтын хэсэг 1976-аас 1981 онд ашиглалтад орж, 2014 онд 50мвт-ын хүчин чадалтай труба генератораар өргөтгөснөөр суурилагдсан хүчин чадал цахилгаанаар 198мвт, дулаанаар 585 гига ккал цаг хүрсэн бөгөөд 56 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Тус станц нь Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээний г... горимын хувьд хамгийн оновчтой байршилд байрладаг ба Улаанбаатар хотын дулаан хангамжийн хэрэглээний 32 хувийг, төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний 16 хувийг тус тус ханган ажиллаж байна.

Өвлийн улиралд дулааны цахилгаан станцууд бэлтгэл тоноглолгүй ажиллаж байгаа нь насжилт өндөртэй тус станцын хувьд техникийн гэмтэл саатлаас шалтгаалан хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хязгаарлах эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна. Энэхүү эрсдэлийг бууруулахын тулд тус станцыг ойрын хугацаанд өргөтгөн шинэчлэх нэн шаардлагатай юм. Улаанбаатар хотын одоогийн болон өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг найдвартай хангах зорилгоор Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Дулааны Гуравдугаар цахилгаан станцыг 2 үе

шаттай өргөтгөн шинэчлэхээр төлөвлөсөн бөгөөд 1 дүгээр үе шатанд цахилгаанаар 50мвт, дулаанаар 100 гига ккал цаг хүчин чадалтай, дулааны цахилгаан станц шинээр барих 2 дугаар үе шатанд ашиглалтын хугацаа дууссан 48мвт-ын станцыг буулгаж, суурин дээр нь цахилгаанаар 250мвт-ын дулаанаар 400 гига ккал цаг хүчин чадалтай дулааны цахилгаан станц шинээр барих төслийн зургийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол Оросын Засгийн газар хоорондын комиссын 2021 оны хуралдааны үеэр Оросын талаас Интер РАО экспорт компанийг Дулааны гуравдугаар цахилгаан станцыг 2 үе шаттай өргөтгөн шинэчлэх төсөлд оролцохыг дахин илэрхийлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн 2021 оны 12 дугаар сард Оросын Холбооны Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр дулааны цахилгаан станц гурав ТӨХК болон Интер РАО экспорт компани хооронд хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг эхлүүлжээ.

Интер РАО экспорт компаниас төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж, 2022 оны 9 дүгээр сард дулааны цахилгаан станц 3 ТӨХК-д хүлээлгэн өгсөн. Төслийн нийт төсөвт өртөг болон барилга угсралтын ажлын хугацааг бодитоор тодорхойлохын тулд эхний ээлжид Эрчим хүчний яамнаас Дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн зураг, төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг боловсруулж, Оросын талтай харилцан зөвшилцсөн. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 29 дүгээр тэмдэглэлийн дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороотой тус тус зөвшилцсөн бөгөөд Монгол Улсын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 48 дугаар Гарын үсэг зурах эрх олгох тухай захирамжаар Эрчим хүчний сайдад уг хэлэлцээрт гарын үсэг зурахыг, зурах эрхийг олгосон.

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Владимир Владимирович Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр тус зураг төсөв боловсруулах хэлэлцээрт 2 улсын Засгийн газрыг төлөөлөн Эрчим хүчний сайд нар 2024 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр гарын үсэг зурсан. Олон улсын гэрээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу Монгол Улсын Улаанбаатар хотын дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр Соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д заасны дагуу Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрчим хүчний сайд хамтран баталсан бөгөөд хуулийн төсөл, түүний дагалдах тооцоо судалгааг хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Улсын

Их Хуралд 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн. Энэхүү хэлэлцээр нь Монголын талын хэлэлцээр соёрхон батлах тухай хууль батлагдсанаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.

Хэлэлцээрийн хүрээнд төслийн зураг төсөл боловсруулах, инженерийн судалгаа шинжилгээ явуулах ажлын цар хүрээ, ерөнхий нөхцөлийг тодорхойлж, захиалагчаар дулааны цахилгаан станц 3 ТӨХК, гүйцэтгэгчээр Оросын Холбооны Улсын талаас санал болгосон Интер РАО экспорт компанийг томилох асуудлыг тус тус зохицуулахаар тусгалаа.

Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Олон улсын гэрээний тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Улаанбаатар хотын дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 19 цаг 41 минутаас хуралдааныг даргалав.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Тэмүүлэн гишүүнийг индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороод Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78.2 дахь хэсэгт заасныг баримтлан санал, дүгнэлтээ ирүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хэлэлцэж, санал, дүгнэлт гаргахдаа харгалзан үзсэн болно.

Байнгын хороо хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Шижир, Тэмүүжин, Жаргалан, Алтаншагай, Болормаа, Анар, Батбаатар нар хуулийн төсөлтэй холбогдуулан төслийн талаарх ойлголтыг иргэд, олон нийтэд зөв өгөхөд анхаарах, Сингапур дахь арбитр хэлэлцээрийн аль эхийг албан ёсны эх хувь гэж үзэх, төслийн өртгийн талаар, Улаанбаатар хотын эрчим хүч, дулааны өнөөгийн байдлын талаар, төслийн хэрэгжих хугацаа, үр дүнгийн тухай асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, Тэмүүжин, Болормаа, Жаргалан, Анар, Хосбаяр, Тэмүүлэн хуулийн төсөлтэй холбогдуулан цаашид эрчим хүчний салбарын үйл ажиллагааг сайжруулах, эрчим хүчний хангалтгүй байдлыг анхаарах зэрэг асуудлаар үг хэлсэн болно. Хуулийн төслийг Байнгын хороонд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг, төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 19 цаг 43 минутаас хуралдааныг даргалав.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Гансүхийн Эрхэмбаяр Эрчим хүчний яамны Гэрээ, эрх зүйн газрын дарга, Баяртогтохын Нямсүрэн Эрчим хүчний яамны Гэрээ, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн бөгөөд хуулийн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Батмөнхийн Пунцагбалжир Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн бөгөөд хуулийн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Лэгцэгийн Эрхбаатар Дулааны цахилгаан станц 3 төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал, Ганпүрэвийн Амартүвшин дулааны цахилгаан станц 3 ТӨХК-ийн Техникийн бодлогын хэлтсийн дарга гэсэн байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. 12 гишүүнээр тасаллаа. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна. Уучлаарай, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн эрэмбээрээ, ирсэн ирцээрээ.

Б.Пүрэвдорж: Шинэ жил болоод том, том ресторануудад шинэ жил тэмдэглээд явж байтал гэнэтхэн тог тасраад л тэгээд баахан лаа асаагаад л, ширээ болгон зохиолын дуу дуулаад, юун шинэ жил манатай л болж байна. Тог хаана байна вэ? Тэгэхээр ер нь бол энэ дулааны станц ихэнхийг нь Зөвлөлт холбоот улсын үед байгуулсан. Зөвлөлт холбоот улсын үед Монгол Оросын худалдаа бол дэндүү алдагдалтай байсан. Өөрөөр хэлбэл нэг хүүхдийн алаг бөмбөгийг 7 төгрөгийн алаг бөмбөгийг 1 хониор сольдог байсан байхгүй юу даа. Хэдийгээр ийм алдагдалтай байсан ч гэсэн эх оронд маань эрчим хүч хэрэгтэй байсан учраас ёстой нэг гүрийж байгаад манай ахмадууд энэ нэг хэдэн станцуудыг бүгдийг нь бариулсан.

Яагаад гэвэл бид нарт тэр технологи байхгүй, боловсон хүчин байхгүй. Тийм учраас бид тэрийгээ бариулж байсан. Тэгээд юм өгөө, аваатай байдаг. Тэгээд ардчилал гарч ирээд Оросын Холбооны Улс 11 тэрбум долларын их өрийг дарж өгсөн шүү дээ. Тэгээд өнөөдөр энэ тэр Зөвлөлт холбооны улсын үед байгуулж байсан тэр 1, 2, 3, 4 дүгээр цахилгаан станц, Дорнод, Дархан, Эрдэнэт гээд тэр хэдэн станцууд чинь нийт эрчим хүчний чинь 80 хувийг үйлдвэрлэж байгаа шүү дээ.

Тэгээд нүүрс шатаадаг дулааны эрчим хүчийг чинь дэмждэг дэлхийн улс орнууд бараг байхгүй болчихсон, бараг 2 хөрш л хоёулхнаа байж байна. Тэгээд олдож байгаа нь л энэ. Тэгээд Хятад нэг Бөөрөлжүүтийн цахилгаан станц барилаа. Тэр нь дөнгөж эхэлж ажиллаад жоохон эвдрэлтэй асуудалтай болчихоод байна. Тэр нар, салхины эрчим хүч нь үйлдвэрлэдэг, тэгэнгүүт хэзээ ч тэрийг авдаггүй, баруун аймгийнхан, зүүн аймгийнхан хэзээ ч хэрэглэдэггүй тэр нарны эрчим хүч, салхины эрчим хүчний төлбөрийг төлбөр болгон дээрээ 30, сар болгон 30 хувийн нэмэгдэл төлөөд л байж байгаа шүү дээ. Тэр эзэд нь болохоор Швейцарт дээшээ хараад хэвтэж байгаа шүү дээ. Ийм л байгаа. Тэгээд үнэтэй, үнэтэй байна гэж яриад байгаа юм. Үгүй ээ Чойжилсүрэн сайдаа та тэгэхдээ энийгээ нэг зүйлийг тодорхой хэл л дээ. Та 700 саяас 1,3 тэрбум хүртэлх хооронд зээл гэж ярьж байгаа шүү дээ. Та тэгээд зөвхөн 1,3 тэрбумыг нь ярьчихаад суугаад байна шүү дээ. Тэгэхээр хүмүүс дургүйцээд байгаа байхгүй. Энэ чинь ТЭЗҮ гарна.

ТЭЗҮ гарахаар нь манайх чинь Барилгын хөгжлийн төвтэй, Эрчим хүчний хөгжлийн төвтэй, юуны зохицуулах хороо билээ, Эрчим хүчний зохицуулах хороотой. Тэгэхээр чинь ТЭЗҮ-г нь батлаад тэр хамаг тоног төхөөрөмж нь ямар үнэтэй юм, тэр барилгын орц материал нь ямар үнэтэй юм, бүгдийг нь эрэг шургаар нь бүгдийг нь гаргаад ирнэ шүү дээ. Тэгээд таны хэлээд байгаа тэр 814 рүү аваад ирэх байхгүй юу даа. Ийм байгаа юм.

Тэгээд ер нь яах вэ жоохон үнэтэй нь үнэтэй байгаа. Тэгэхдээ энэ чинь би түрүүн хэлсэн. Бид энэний чинь хариуд тодорхой энэ 2 хөршийнхөө харилцааг сайжруулж байж бид буцаад өгөө, аваатай байдаг. Бид буцаагаад Эгийн голоо авч, барилгаа эрчим хүчнийхээ асуудлаа шийдмээр байна шүү дээ. Ийм, ийм зүйл дээр асуудлаа ойлголцоод, ярилцаад явах нь манай Их Хурлын гишүүдийн хувьд маш чухал байна. Тийм учраас гишүүд энэ 20 сая долларын зураг төслийн энэ нэг төслийг дэмжиж өгөөрэй гэж та бүхнээс хүсэж байна. Монгол Оросын парламентын бүлгийн даргын хувиар. Албан ажлынхаа хувиар.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ө.Шижир: Оройн мэнд. Бид Оросын холбооны улсаас эрчим хүч, нефть, шатахуун гээд маш чухал зарим бүтээгдэхүүнээр хамааралтай нь үнэн. Тэгээд тийм учраас энэ дулааны цахилгаан станцын өргөтгөл энэ хүрээнд орж ирж байгаа байх. Энэ хамаарлаасаа арилахын тулд орж ирж байгаа байх гэж ойлгож байгаа. Тэгэхийн тулд бид Энэтхэгийн Засгийн газартай хамтраад нефть боловсруулах үйлдвэр хийж байна. Энэ цахилгаан станцын өргөтгөл гэж орж ирж байна. Гэхдээ яах вэ ер нь сүүлийн 10 хэдэн жил Орос Монгол хоёрын хоорондоо хэрэгжүүлэх гэсэн төсөл, хөтөлбөрүүд хэр амжилттай болсон бэ гэдгийг харахаар харамсалтай нь тийм амжилттай болсон төсөл маш цөөхөн байна.

2009 онд одоо яг бид нарын яриад байгаа энэ Орано тухайн үед Арева байсан энэ асуудал хэлэлцэх үед 2009 онд Оросын Холбооны Улс танайтай хамтарна гэж хэлээд бид лицензийг нь цуцлаад, огт ашиглаагүй лицензийнхээ төлөө 70 сая долларын төлбөрт унасан саяхны тохиолдол байгаа. Энийг татвар төлөгчдийн мөнгөөр төлсөн. Энэ төсөл хэрэгжээгүй. 2008 онд Мянганы сорилтын сан Улаанбаатар төмөр замыг 188,3 сая долларын буцалтгүй тусламжаар сэргээн засварлаад өгье гээд санал тавьж байхад бас энэ төслийг хэрэгжүүлээгүй. Үгүй ээ, үгүй бид өөрсдөө хийчихнэ. Манай бид хувь нийлүүлсэн хөтөлбөрт нийгэмлэг юм чинь гээд бас энэ төслийг хэрэгжүүлээгүй. Одоо 33, 34 дэх жилдээ ярьж байгаа

Эгийн голын цахилгаан станц. Одоо болтол энэ төсөл төслийн нэгжээ байгуулаад 11 жил болчихсон. Төсөл нь яригдаад 33 жил болчихсон. Энэ хугацаанд хэвлэлд гарсан мэдээгээр бараг 60, 70 орчим тэрбум төгрөг зөвхөн төслийн нэгжийн үйл ажиллагаанд ингээд зарцуулчихсан. Одоо ч хүртэл цалин аваад сууж байдаг ийм хүмүүстэй. Тэгэхээр тэгээд Эгийн голын усан цахилгаан станцыг хэрэгжүүлэе гэхээр Байгаль нуурын экологийн тэнцвэрт байдалд нөлөөлнө гээд тайлбар тавиад байдаг. ЮНЕСКО-ын тэр тайлан дээр нь болохоор Байгаль нуурын экологийн тэнцвэрт байдалд нөлөөлөхгүй гээд тайлантай. Тэгээд бас ингээд хэрэгжүүлдэггүй. Ингээд сүүлийн 10 хэдхэн жил болж байгаа процесс л доо.

Тэгэхээр би Чойжилсүрэн сайдаас нэг асуулт асуугаад байгаа юм. Одоо энэ төсөл ингээд хэрэгжээд эхлэхэд яг бодитоор хэрэгжих магадлал, баталгаа хэдэн хувь бэ? Дахиад ингээд бид 10 хэдэн жилийн дараа дахиад нэг өөр төсөл яриад ингээд сууж байх уу? Эсвэл Эгийн гол шиг 33 жил, эсвэл Мянганы сорилтын сан шиг буцалтгүй тусламжийг нь болиулаад. Бүр больёе гэхэд уран шиг дахиад бид 70 сая долларын төлбөрт уначихсан ингээд сууж байх магадлал бий юү? Яг энэ төслийг та хэрэгжинэ гэдэгт хэдэн хувь итгэлтэй байгаа вэ? Энэ дээр нэг ам бардам хариулаач.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Баттогтохын Чойжилсүрэн гишүүн.

Б.Чойжилсүрэн: 2022 оны 9 дүгээр сард Оросын Холбооны Улсын Интер РАО экспорт компани өөрийн санхүүжилтээр техник, эдийн засгийн үндэслэлийг урьдчилсан байдлаар боловсруулаад, Монголын талд хүлээлгэж өгсөн. Тухайн үед энэ ТЭЗҮ-д заасан нөхцөлөөр бол 1 тэрбум 326 сая евротой тэнцэх хэмжээний рублиэр барина гэсэн ийм тооцооллыг өгсөн. Тухайн үед 1 евро Оросын Холбооны Улсын рубльтэй бол 60 орчим рубль байсан байна. Яг өнөөдрийн байдлаар нэг евро 100 орчим рубльтэй тэнцэж байгаа. Тэр үедээ рублиэр, рубль тэр ханшаар нь евро руу шилжүүлэхэд 1 тэрбум 326 сая болж байгаа ийм асуудал байгаа.

Монголын талаас бид сүүлийн 2 жилийн хугацаанд Оросын Холбооны Улстай нэлээд олон удаа уулзалтуудыг хийсэн. Энэ 1 тэрбум 326 саятай тэнцэх хэмжээний энэ эх үүсвэр чинь өндөр байна, зах зээлийн үнээс өндөр байна. Тийм учраас буулгаач гэдэг ийм шаардлага, хүсэлтүүдийг тавьж байгаа. Оросын Холбооны Улсын зүгээс зөрүүлээд тэгвэл зураг төсвийг, зургийг нь хийгээд магадлуулчихъя. Дараа нь магадалсан зураг дээрээ төсвийг нь хийгээд, түүний дараа эцсийн үнэ тохирьёо гэдэг ийм санал тавьж байгаа учраас энэ удаа зөвхөн Монголын тал санхүүгийн эх үүсвэрийг нь гаргаад магадгүй 20 орчим сая доллар болох байх. Энэ Улсын Их Хурлаар энэ гэрээ соёрхон батлагдсан тохиолдолд гэрээ байгуулагдаж таарна. Урьдчилсан тохиролцоо бол 20 сая доллароос хэтрэхгүй байна гэсэн ийм тооцоолол бий. Энэний дараа 2 жил орчим хийгдэх болов уу гэсэн ийм төсөөлөл баримжаа байна. Тухайн үед бид шийднэ. Зах зээлийн үнээс өндөр бол мэдээж Оросын Холбооны Улсад бид энийг хэрэгжүүлж чадахгүй гэдгийг хэлнэ. Зах зээлийн үнэтэй ойролцоо болоод эхэлсэн тохиолдолд дараагийн хэлэлцээр буюу санхүүжилтийн тухай, барилга угсралтын ажлын тухай 2 Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Улсын Их Хуралд дахиад өргөн мэдүүлж оруулж ирнэ. Ийм л асуудал байгаа.

Энэ удаа зөвхөн дахин хэлье Шижир гишүүнэ, зураг төсөв эхлээд хийгээдэхье. Энэнийхээ дараа яг тодорхой үнэтэй болсны дараа Улсын Их Хуралд бид дахиж Засгийн газар танилцуулна мэдээж. Шаардлагатай бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулна, Улсын Их Хуралд бол гарцаагүй

танилцуулна. Ийм л байна, дарааллаар явна гэсэн үг. Магадлалын тухайд хэлэхэд яг урьдчилан хэлэхэд арай эрт байна. Ямар ч байсан Оросын Холбооны Улсын тал зурагтай болчихъё, төсөвтэй болчихъё гэдэг энэ саналыг тавьсан учраас энэ саналыг хүлээж аваад, 3 хувааж байна гэсэн үг шүү дээ энэ хэлэлцээрийг. Ийм л энэ 3 багц хэлэлцээрийн эхний шат нь орж ирж байгаа. Зах зээлийн үнэтэй болохгүй бол ингээд энэ хэмжээндээ зогсох болов уу гэсэн ийм ойлголттой байгаа.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Цогтгэрэл: Өнөөдөр нэлээн онцлог өдөр байна л даа. Урд хөрштэйгөө худалдааны хамгийн том хөрштэйгөө экспортын гарцын тухай шийдэгдээгүй асуудлуудыг ярих. Гуравдагч хөрш Франц улстай шинэ техник технологийн шинэ боломжийн тухай ярилцах. Хойд хөрштэй гэрээний асуудал давхцаад орж ирж байгаа нь их тийм онцлог байна. Гурвуулаа дэлхийн томоохон улс орнууд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн гишүүн ийм 3 орон.

Тэгэхээр энэ 3 дугаар цахилгаан станцын шинэчлэлийн төсөл дээр тодорхой хэмжээний асуултууд гараад байгаа юм. Энэ мэдээж эдийн засаг талаасаа улс төрийн онцгой нөлөөллүүд янз бүрийн зүйл байгаа эсэхийг сайн мэдэхгүй юм. Тэр талаараа тодорхой хэмжээний зарим ...-аа ярьж гишүүдэд ойлголт өгвөл зүгээр байх. Технологи дээр мэргэжлийн хүмүүс ганц нэг хүмүүсээс асуухаар ер нь энэ дулааны цахилгаан станцын технологи чинь их тодорхой болчихсон, сав критикал гээд критикал супер ултра энэ тэр гээд 27-гоос аваад 60 хүртэл хувийн ашигт үйлийн коэффициенттой болчихсон. Одоо манайд ашиглаж байгаа Оросын Холбооны Улсын технологиуд чинь 20 гаруйхан хувийн ашигт үйлийн коэффициенттой. 100 тонн нүүрс түлэхэд 80-аадыг нь утаа тортог болоод агаарт дэгдээчихдэг ийм.

Тэгэхээр яг энэ зураг төслийн хувьд зураг төслийг нь ажлын зураг хийж байгаа 20 сая доллароор хийх гэж байгаагийн хувьд би урьдчилсан зураг төсөл, урьдчилсан ТЭЗҮ, концепт дизайн гэж хэлдэг төслийн менежментийн энэ үе шат бол бараг хийгдчихсэн байгаа байх гэж бодож байна. Энэ хийгдчихсэн байгаа бол саяын зүйлүүд нэлээн тодорхой болчихсон байгаа байх. Тэгэхээр энэ дээр та 1 дүгээрт мэдээлэл өгөөч.

2 дугаарт нь ер нь ингэж энийг нэг шууд энэ гэрээний асуудал болгож техник технологи наана, цаана асуудал болгож байхын оронд энийг ерөөсөө олон улсын нээлттэй тендер гэдэг зүйлийг нь зарлачхаж болоогүй юм уу? Энэ магадгүй Оросын Холбооны Улсын компани нь давуу талтай байгаад шалгарч болно шүү дээ. Тэгээд хамгийн чухал зүйл чинь нээлттэй байх, өрсөлдөөнийг бий болгох л биз дээ. Бид нарт дараа нь ямар ч асуудалгүй, албан тушаалтнууд дээр ч асуудалгүй зүйл чинь ерөөсөө л тэр нээлттэй өрсөлдөөн, шударга өрсөлдөөн тэр тусмаа нээлттэй тендер. Тэгэхээр энэ зүйл, энэ механизмыг ашиглачихсан бол бид ингэж наана, цаана хэл ам болж байхын энд хэрэгцээ шаардлагагүй байсан санагдах юм. Тэгээд энэ хууль зүйн боломжуудыг яагаад ашиглахгүй байгаа талаараа мэдээлэл өгөөч?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн.

Б.Чойжилсүрэн: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Монгол Улс өөрийнхөө хуримтлалтай, өөрийнхөө төсвийн хөрөнгө оруулалтаар хийчихдэг байсан бол энэ Оросын Холбооны Улсад ийм санал тавихгүй байх байсан байх.

Тухайн үеийн Засгийн газар энийг Оросын Холбооны Улсаас экспортын зээлээр хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлж гэдэг хүсэлтийг 2 талаасаа ойлголцоод тавьсан байна 1 дүгээрт.

Одоо манай Тендерийн хууль гэж нэрлэдэг урт нэртэй хууль байгаа шүү дээ. Тендерийн хуулиар бид аль нэг улсын тоног төхөөрөмжид, аль нэг улсын компаниудад зориулж тендер зарлах бололцоо байхгүй байгаа учраас энэ Тендерийн хуулийн энэ заалтыг тойрохын тулд санхүүжилт нь Оросын Холбооны Улсаас ирэх экспортын хөнгөлөлттэй зээл байгаа учраас бүх улсуудын экспортын зээлд тавигддаг шаардлага бол хугацаа урт байдаг, хүү бага байдаг. Гэхдээ зөрүүлээд хэд хэдэн шаардлага тавьдаг нь эдгээр санхүүжилтээр санхүүжүүлж байгаа төслүүдийг тухайн улс орны экспортын хөнгөлөлттэй зээл олгосон тухайн улс орны компаниуд аж ахуйн нэгжүүд байна гэдэг ийм шаардлага байгаа учраас бид ингэж нээлттэй олон улсын тендер зарлаж чадаагүй юм зураг төсөв дээр нь.

Энэ бол би сая танд хэллээ. Шижир гишүүний асуултад хариулахдаа. Ерөөсөө энэ асуудал зураг төсвийг нь Оросын Холбооны Улсын талтай хийгээд, үнэ бусад нөхцөл нь зах зээлийн үнэ гарч ирэх юм бол дараагийн хэлэлцээрийн үе шатад шилжинэ. Шалтгаан нь энэ, олон улсын гэрээ байгуулж байж манай Тендерийн хуульгүйгээр Оросын Холбооны Улсын Засгийн газрын санал болгосон энэ компанийг шалгаруулахад энэ олон улсын гэрээний энэ удаагийн гэрээний гол зорилго л байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Х.Булгантуяа: Цахилгаан станцын хувьд 56 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа 198 орчим мегаваттын хүчин чадалтай гээд. Одоо бидний хувьд нэг их олон сонголт байхгүй болсон л доо. Бид аягүй удаан бодсон байхгүй юу. Боломжууд нэлээдгүй байсан. 16 онд анх үүнийг ярьж эхэлж байхад бас л ингэж хэлээд л үнэтэй байна, өөр боломжийг хайя гэсэн. 16 оноос хойш миний мэдэж байгаагаар тэрнээс өмнө ч энэ асуудлыг ярьж байсан байх. Тэгэхээр 16 оноос хойш нүүрсний цахилгаан станцын санхүүжилт чангарчихсан уу гэхээс биш боломж бол нэмэгдээгүй. Одоо бол ер нь өгдөг газар Хятад ч өгөхөө байсан. Хятад Ши Жиньпин дарга НҮБ-ын хурал дээр зарласан шүү дээ. Цахилгаан станцад, нүүрсний цахилгаан станцад санхүүжилт бид олгохгүй гээд. Тэгэхээр бид ийм болчихсон байгаа цагт дахиад үргэлжлүүлээд 5-аас 10 жил бодож суух бол цаг хугацаа байхгүй байх гэж бодож байна 1 дүгээрт.

2 дугаарт 5 дугаар цахилгаан станцын санхүүжилт нь уг нь бэлэн, ТЭЗҮ нь хийгдчихсэн байсан цаг үе байсан. 12-оос 16 онд миний мэдэж байгаагаар хамгийн сүүлд 16 онд олон улсын байгууллагуудаас хэд хэдэн байгууллагуудаас бид одоо санхүүжилт нь бэлэн байна, танайх хурдан авбал одоо аваад хий, үгүй гэвэл бид дахиж бол та нарт нүүрсний цахилгаан станцын санхүүжилтийг олж өгч чадахгүй. Парисын гэрээ хэлэлцээ хүчин төгөлдөр болчихсон. Энийг бол үүнээс өмнө бид ярьж хөөцөлдөж байсан учраас одоо бол байна та бүхэн энийгээ аваад хурдан барьчхаач, дахиж олдохгүй шүү гэж зөвлөж байхад бид бас яг ийм юм ярьж байсан. Худалдаж авах үнэ тариф нь purchase power agreement нь аягүй өндөр байна, үнэ тариф нь өндөр байна.

Дээрээс нь нэмээд манайд бараг ийм хэрэглээ байхгүй дээ гэж хэлж байсан. Би маш сайн санаж байна. Тэгээд нөгөө өндөг анхдагч уу, тахиа анхдагч уу гэдэг шиг хэрэглээ байхгүй гээд аваагүй. Улс эх орон хөгжинө, бидний хэрэгцээ ихэснэ гэж ерөөсөө тооцохгүй байж байгаад өнөөдөр бид ямар байдалд ороод 2024 онд сууж байгаа билээ гэдгээ бүгдээрээ бодох хэрэгтэй. Тэгээд Чойжилсүрэн сайд энэ бол бид зургаа ч хийж, нарийн тооцооллоо ч гаргаж чадаагүй байгаа цагт түрүүлж дүгнэлт хийх бол утгагүй байх. Хэрвээ зургаа ч хийж чадахгүйгээр хэдүүлээ дүгнэлт хийдэг болох юм бол ямар ч мега төсөл явахгүй байх манай Монгол Улсад. Энэ чинь энэ байтугай мөнгөөр яг үнэнийг хэлэхэд зураг төсөв хийж байгаад, хэдүүлээ явуулах уу, явуулахгүй юу гэдэг бол тэрний дараагийн асуудал. Явуулахгүй байх бидэнд бүрэн эрх байгаа. Энэ чинь Монгол Улсын Засгийн газрын том өр болох учраас Улсын Их Хурлаар заавал оруулж ирээд яг ингэж хэлэлцэж байгаад хэдүүлээ баталж л таараа.

Тэгэхдээ бидний дараагийн том сонголт бол хэрвээ үгүй гэвэл улсын төсвөөсөө үүнийг санхүүжүүлж, том эх үүсвэрийг өөрсдөө барихаас өөр аргагүй л нөхцөл байдал болно гэсэн үг. Тэгээд олон ярьж байгаа төсөл хөтөлбөрүүд тэгнэ гэх юм бол эрчим хүчний эх үүсвэр байхгүй бол таг зогсоно л гэсэн үг. Нөгөө метроны төсөл бол жишээлбэл 1 дүгээр зөвхөн шугам нь ашиглалтад ороход 300мвт шаардлагатай гэсэн эрчим хүчний. Дахиад дээрээс нь нэмээд зарим нэг хувийн хэвшлийнхээ төсөл дээр ажиллахаар шууд л эрчим хүч байхгүй шүү, танайх төсөл хэрэгжүүлэх гэж байгаа бол өөрсдөө жижиг ч гэсэндээ цахилгаан станц бариарай гэж хэлдэг. Ингэж бид үйлдвэржсэн улс болно гэж бол байхгүй.

Саяхан хэдүүлээ сая Ораногийн гэрээг, Чайна Энержигийн энэ асуудлуудыг ярилаа. Тэгэхэд хэдүүлээ тог цахилгаангүй харанхуйд лаа барьж суучхаад мега төсөл хэрэгжүүлнэ гэж ярина гэдэг бол ичгэвтэр. Тэгэхээр эхний шатад ямар ч байсан би зураг төсвийг нь бид хийлгээд үзье. Тэгээд болохгүй бол бид нарт үгүй гэж хэлэх бүрэн боломж байгаа. Яг буланд шахчхаад өнөөдөр ав гээд байгаа юм ерөөсөө байхгүй. Хэдүүлээ өөрсдөө хамаагүй төлье гэвэл тэр гадаадын европын өндөр үнэтэй сэргээгдэх эрчим хүчнүүдийг авч болно тэр бол сонголт их байгаа. Тэгэхдээ сая нэг тог цахилгааны мөнгө нэмэгдэхэд ард түмний амьдрал дээр яаж тусаж байгаа, үүнээс хэд дахин илүү их хатуу тусна гэдгийг нөгөө талдаа бид яг бодож тооцох ёстой. Тэгээд яах вэ үүнийг бид энэ бол нэг эх үүсвэрийн олон эх үүсвэрийн нэг нь юм л гэж харж байгаа юм. Тэгээд би.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Х.Тэмүүжин: Би нэг их олон үг хэлэхгүй, 2 л үг хэлэхийг хүсэж байгаа. 1 дүгээрт нь өчигдөр хаалттай хуралдсан Байнгын хорооны хурал дээр хэлсэн үгнүүд зүгээр амнаас гарч байгаа хоосон хий биш байсан шүү гэдгийг тодотгож хэлэх гэж байгаа юм. Тэр үгнүүд протоколоороо үлдээд, дараа хожим хойно орой руу орох тийм цаг ирэхийг үгүйсгэхгүй. Үндэсний аюулгүй байдал гэдэг зүйлийг бид хэмжихдээ жоохон хэрсүү бодолтой, гал тогоон дотроо бөмбөг оруулж ирэхээсээ гадна хашааныхаа гадна тэр бөмбөгөө яаж барих вэ гэдгээ тооцоолж боддог тийм ухаантай байх ёстой шүү. Тэр бол тусдаа байх.

2 дахь нь сая эрчим хүчний үнэ нэмсэн. Иргэдийн нуруун дээр мэдээж ачаа бий болсон. Иргэд энэ ачааг ухаалаг хүлээж авч байгаа хэсэг нь бид ямар ч байсан нэг тийм үнэтэй ч гэсэн баталгаатай эрчим хүчтэй байх, үйлдвэрлэл нь хөгжих тэр

зам руу явах гэж байгаа учраас энэ удаагийн жижиг өвдөлт бол яах вэ тэснэ, гарна гэдэг итгэл үнэмшилтэйгээр алхаж байгаа. Энэ үнэ нэмж зах зээл рүү нь энэ бизнесийнх нь дүрмээр ажиллах боломж руу аваачиж өгч байгаа нь хэн нэгний халаас руу энэ улс орохгүй, хувийн хэвшил дээрээ ийм үнээр эрчим хүчний шинэ үүсвэр бариад өгөөч гэж хэлэх нүүртэй болох гэж оролдож байгаагийн нэг алхам л гэж бодож байгаа. Тэгээд энэ нүүрээ ганцхан ийм хувилбар байна гээд явцуу явган яриагаар хувийн хэвшлээ дорд үзээд, иргэдийнхээ ирэх эрсдэлийг нэмж ингэж ярих зөв биш байх.

Ер нь яагаад Багануурын цахилгаан станц зогсчихсон юм энэ 16 оноос хойших үйл явдал шүү дээ. Өнгөрсөн 8 жилийн үйл явдал. Бид популизмд, хуурмаг айдас, айж, ичээж байгаад араар нь хулгай хийдэг энэ нэг увайгүй үйлдэлд бууж өгсний л гор байхгүй юу. Жоохон зоригтой, тэвчээртэй сөрөөд зогссон бол Багануурын цахилгаан станц өдийд баригдчихсан л байгаа. Эрчим хүчээ түгээгээд бид лааны гэрэл шинэ жил тэмдэглэх тухай биш, дараагийнхаа мөрөөдлийн тухай ярих боломжтой л байсан. Тийм учраас алдаан дээр жоохон сургамж аваад, дахиад том алдахгүй байхын төлөө хэдүүлээ нэг хэрсүү байх ёстой байх. Энэ хэлдэг ч үг байна, хэлдэггүй ч үг байна. Тийм учраас олон юм ярихгүй. Торгууль ядаж эхнийхээ энэ хэсгээр дуусаасай л гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ч.Лодойсамбуу: Бүрэн эрхт, тусгаар тогтносон, ардчилсан Монгол Улсын Их Хурлын гишүүдээ бүрэн эрхтэй, тусгаар тогтносон, ардчилсан Монгол Улсын Их Хурлын гишүүд шиг байя. 8 сард энэ асуудал орж ирж байхад л бид хэлж байсан. Эдийн засгийн байнгын хороон дээр Чойжилсүрэн сайд байсан. Энэ гэрээ хэлцэл биш тулгалт байна, тулгалт. Сая Тэмүүжин гишүүн хэлж байна. Худал хуурмаг, айдас гэж. Энэ Монгол Улсын Их Хурал болохоос биш энэ Думын хурал биш. Энэ Монгол Оросын хамтарсан компанийн ТУЗ-ийн хурал биш. Энэ танхимаас гарч байгаа шийдвэр болгон Монголчуудын эрх ашигт нийцсэн байх ёстой. Хуурмаг айдсаас шалтгаалаад, популизмаас болоод өнөөдөр бид лааны гэрэлд шинэ жилээ тэмдэглэж байна гэж сая Тэмүүжин гишүүн хэлж байна. Үнэн шүү дээ.

Түрүүн Пүрэвдорж гишүүн хэлж байна. Бид нарт энэ Оросууд л энэ улсууд л цахилгаан станц барьж өгсөн, өгөө, аваатай байя. Юу ярьж байгаа юм бэ, юу өгөх гээд байгаа юм бэ, юу авчихсан юм бэ? Түүхий эдийн бааз орон чинь тэр нэг түүхий эдийг нь боловсруулаад улс руугаа зөөгөөд аваад явах, ухаж гаргаж ирэх, ингэхийн тулд хүмүүс ажиллах хэрэгтэй. Тэр хүмүүст ажил хийж байгаа юм чинь амьдрах байр хэрэгтэй, тэнд эрчим хүч хэрэгтэй. Тийм учраас л цахилгаан станцтай болж байгаа шүү дээ.

Монголчуудад хайртайдаа станц бариад өгчихсөн юм уу. Одоо ийм ярианаасаа болих хэрэгтэй. Энэ хамаа замбараагүй юм ярьж байна даа гэж байгаа би ярина. Энэ яагаад гэвэл Монгол Улсын Их Хурал. Аюул болно л гээд байгаа юм энэ асуудал унавал. Яг юу болох гээд байгаа юм бэ Чойжилсүрэн сайд тодорхой асууя би танаас? Яг энийг батлахгүй бол яана гээд байгаа юм бэ? Сая Булгантуяа гишүүн хэлж байна. Энийг явуулахгүй байх боломж нь Их Хуралд байгаа шүү дээ гэж. Тэгээд явуулахгүй юм бол бид 20 сая төгрөг, 20 сая ам.доллар зүгээр ингээд дээрэмдүүлж байгаа юм уу, ямар учиртай юм бэ? Энийгээ тодорхой хэлэх хэрэгтэй. Яг яая гээд байгаа юм бэ, бензингүй болгоё гээд байгаа юм уу, тогийг чинь тасална

гээд байгаа юм уу, яг тийм тулгалт ирдэг юм уу, энийг нуугаад байх юм байгаа юм уу? 30 жил ингэж айж ирлээ шүү дээ.

Үеийн үед том, том бид хэзээ ч жижигхэн хөрштэй байж үзээгүй. Удахгүй бид нарын эрх чөлөө, тусгаар тогтнолын өдөр болох гэж байна. Тэр үед бид жижигхэн хөрштэй байгаагүй шүү дээ. Тэр үед бас л яг намайг ийм хөнгөн юм ярьж байна гэж бодож байгаа хүмүүс бол тэр үед яг ийм хөнгөн бодолтой хүмүүсийн үндсэн дээр л эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсэн Монголчууд. Тусгаар улс байх юм уу, байхгүй юм уу, болох юм уу, болохгүй юм уу? Тэгээд энэ дээр нэг хариулт авъя. Ер нь яг ямар дарамт ирээд байдаг юм бэ? Тодорхой ярья, юуг нь тэгж нууж хаагаад байдаг юм бэ?

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Лодойсамбуу гишүүний асуултад хариулъя. Монгол Улс тусгаар тогтнол байгаа, тусгаар тогтнол. Зураг төсвөө хийчхээд, эцсийн үнээ гаргаад ирье. Таалагдвал төслийг хэрэгжүүлье. Таалагдахгүй зах зээлийн бус нөхцөл байдал үүсэх юм бол больё гэдэг л ийм шийдвэр гаргах гэж байгаа шүү дээ бид. Оndoо олон юм яримааргүй байна.

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууж, үгээ хэлье.

Ж.Баярмаа: Эхнээс нь авчихъя, уучлаарай, би сая нөгөө тодруулчих юм бодоод байсан чинь.

Д.Амарбаясгалан: Минутыг нь шинээр эхлүүлчихье.

Ж.Баярмаа: Би энд нэг нөгөө үндэсний аюулгүй байдлын манай баримт бичиг байгаа. Тэрнээс энэ нэг заалтыг уншъя гэж бодож байна л даа. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал гээд. Энэний энэ 3.2.2-т байгаа юм. Энэ дээр юу гэж заасан гэвэл ер нь нөгөө агуулга нь болохоор гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын 1/3-ээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална гээд. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална гээд.

Тэгэхээр энэ Интер РАО экспорт гэдэг энэ компани бодвол Оросын төрийн өмчит компани байх гэж бодож байна. Тэгэхээр чинь яг энэ нөгөө Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан энэ заалт маань хэр явагдах юм бол? Жишээлбэл бид 100 хувь нефтээр хараат, 100 хувь Роснефть. Тэгэхээр дахиад энэ Оросоос тогоороо хараат. Дахиад энэ өргөтгөлийг Оросоос зээл авч хийхээр дахиад хараат. Тэгэхээр нөгөө стратегийн салбар маань дахиад нэг улсаас хараат байх нь улам нэмэгдэх юм биш үү? Тэгэхээр энэ ер нь ямар хувь хэмжээ өнөөдрийг хүртэл явж ирсэн юм бэ? Тэгэхээр энэ үзэл баримтлалын заалт минь зөрчигдөх юм биш байгаа гэсэн нэг ийм асуулт байна.

Ерөнхийдөө л нэг бол Хятадаар айлгаад л, нэг бол Оросоор айлгаад л нэг иймэрхүү л юм руу орчихлоо л доо манай улс. Тэгээд үдээс өмнөх шахам яриа нь болохоор нэг Хятадын танктай холбоотой баахан нэг нэгнийгээ айлгадаг. Одоо энэ

яриа бол Оросоор айлгасан нэг иймэрхүү л юм руу орлоо. Гэтэл энэ чинь бид чинь зах зээлд шилжээд 34 жил болж байна. Монгол Улс нээлттэй улс болсон. Тэгэхээр аль ч улс бол бидний хөрш. 2 хөрш бол зэргэлдээ хөрш, бусад орон гуравдагч хөрш. Тэгэхээр өөр улс орнууд энэ төсөл дээр орох боломж байгаагүй юм уу? Жишээлбэл нүүрс бол хоцрогдсон гэж байна. Гэхдээ одоо хүртэл хэрэглэж байгаа улс орнууд зөндөө байгаа шүү дээ. Япон хүртэл зөндөө хэрэглэж байгаа нүүрсний станц, Герман байна. Тэгэхээр энэ өөр эх сурвалжууд байдаг юм уу, эх үүсвэрүүдийг судалсан юм болов уу гэдэг ийм асуулт?

Тэгээд дахиад энэ 81,2 тэрбумаар зураг төсөв хийлгэх гэж байна. Тэгээд магадгүй энэ нь үнийн хувьд үнэтэй байна гэж гарах юм энэ мөнгө яах юм бэ? Энийг улсын төсвөөс гарч байгаа гэж ойлгосон. Энэ бага мөнгө юм уу? Ингээд нэг яг ямар зорилготой нь тодорхойгүй их тийм сонин Пүрэвдорж гишүүний асуугаад байгаа асуултыг би гайхаад л байна л даа. Яагаад та тэр 2 интервалын хамгийн дээд талынхыг нь ч хэлээд байгаа юм бэ? 800-аас 1,3 гэдгийн дээд талыг нь хэлээд л байх юм. Тэгсний ар дээр нь янз бүрийн асуудлууд яригдаад л байх юм. Гэтэл чинь энэ их багагүй мөнгийг төлөөд нэг зураг төсөв хийлгэж үзэх гээд байгаа юм. Тэгээд үзээд хэрвээ энэ жоохон үнэтэй байх юм бол болих юм гээд байх юм. Тэгээд зүгээр нэг ингээд тэрбум тэрбумаар нь зураг төсөв хийж байдаг тийм баян улс юм уу Монгол гэдэг нэг ийм асуулт байна? Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Яг өнөөдөр ч гэсэн бид энэ Оросын Холбооны Улс тухайн үеийн Зөвлөлт холбоот улсын үед баригдсан хэдэн станцын хүчээр л бид цахилгаан эрчим хүчтэй байгаа. 1 улсаас хамааралтай гэж яаж ойлгох вэ гэдгээ бодох хэрэгтэй л байх. Байгаа царай нь энэ. Бид өөрсдөө эрчим хүчний тоноглол үйлдвэрлэж чадахгүй байгаа. Жижиг манайх шиг ийм цөөхөн хүн амтай улсад тэр үйлдвэрлэлийг бариад ажиллахгүй юм байна лээ. Манай зах зээл өөрөө жижиг байгаа учраас. Бид ямар ч нөхцөлд бид 2 хөрштэйгөө найрамдалт, найрсаг харилцаатай байх ийм л шаардлагатай болов уу гэж бодож байгаа юм.

Энэ Баярмаа гишүүн нэг логиктой асуулт тавьж байна. Магадгүй энэ зураг төсөв хийсний чинь дараа гэрээ байгуулагдахгүй бол энэ мөнгө яах вэ гэдэг ийм асуулт гарч байна шүү дээ. Энэний 20 орчим сая долларыг бол манай Монголын Дулааны цахилгаан станц ТӨК 3 гэдэг компанийн өмч болж үлдэнэ энэ мөнгө нь. Мөнгийг нь бид гаргаж захиалж байгаа учраас. Гэхдээ Оросын тоноглолоор биш ондоо тоноглолоор барих юм бол энэ ТЭЗҮ-ийн тодорхой хувь нь, магадгүй 50 орчим хувь нь update-лэнэ. Энэ дотор зайлшгүй хийгдэх шаардлагатай аль ч улсын тоноглолоор хийсэн шаардлагатай геологийн хайгуулын зардлууд бий, төлөвлөлтийн зардлууд нь бий, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнүүд бий гэх мэт энэ зүйл нь 50 орчим хувь нь Монголд үлдэх байх. 50 орчим хувь нь магадгүй гэрээ байгуулагдахгүй тохиолдолд эрсдэлд орно. Гэхдээ тэрбум шахам долларын төсөлд 700, 800 ийм төсөл ярьж байхад 10 сая долларын эрсдэл гаргахгүйгээр урьдчилж ийм хийхгүйгээр энэ төсөл явахгүй нь та ойлгоорой. Бидний байгаа боломж л энэ. Хэрвээ дахин давтан хэлье дотоодоосоо хуримтлалтай, эх үүсвэртэй байсан бол энэ тухай ярихгүй. Харамсалтай нь ийм боломж байхгүй учраас л бид гадаадын улс орнуудын зээл авъя гэж ярьж байгаа юм 1 дүгээрт.

2015 оны Парисын хэлэлцээр барууны улс орнууд нүүрсний төсөлд санхүүжилт олгохоо больчихсон шүү дээ. Бүх санхүүгийн байгууллагууд нь. Түүнээс гадна хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй листтэй компаниуд нь нүүрсний төслийг шинээр нийлүүлэхгүй байгаа барууны систем. Дээрээс нь 2021 оны намрын НҮБ-ын чуулган дээр Ши Жиньпин дарга Бүгд Найрамдах Хятад Ард Улс энэ мөчөөс эхлээд Хятадын газар нутгаас гадна цахилгаан станц шинээр нүүрсний цахилгаан станцыг санхүүжүүлэхгүй гэдэг ийм улс төрийн амлалт явсан. Энэ улс төрийн амлалт нь Хятадын төрийн бүх байгууллагын төрийн шийдвэр болоод гарчихсан.

Яг үнэнийг хэлэхэд 2015 оноос өмнөх санхүүжилт босгох бололцоо маань яг өнөөдөр 2024 онтой жишихэд бид 90 хувиар 15 оноосоо 24 онд буучихсан ийм төвөгтэй байгаа. Оросын Холбооны Улс бол энэ Парисын хэлэлцээрт нэгдэж ороогүй байгаа үлдсэн цөөхөн хэдэн улсын нэг учраас тухайн үеийн Засгийн газар тухайн үеийн Монгол төрийн шийдвэр гараад Оросын Холбооны Улсад экспортын зээлээр санхүүжүүлээч, танайтай хамтарч барья гэдэг ийм шийдвэр гаргаад, энэ төсөл ингээд хөгжөөд өнөөдрийг хүрч байгаа ийм байдалтай л байгаа юм.

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа: Энэ нөгөө зураг төсөв хийх гэж байгаа компани Оросын төрийн өмчит компани уу? Тэгэнгүүт түрүүний миний нөгөө асуугаад байгаа гадаад бодлогын үзэл баримтлалд тусгасан 1 улсын ТӨК-аас хамаарал багатай байх ёстой энэ заалтын хэрэгжилт ер нь ямаршуу түвшинд яваа юм гэдгийг тодруулж асууя.

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулт өгөх үү.

Б.Чойжилсүрэн: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Энэ Интер РАО экспорт гэдэг компани бол Интер РАО гээд үндсэн том компани байгаа юм байна лээ. Энэ компани бол Москвагийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, хувьцааны нэг тодорхой хэсэг нь төрийн өмчийнх, тодорхой хэсэг нь хувь иргэдийн оролцоотой ийм компани байгаа. Яг өнөөдрийн байдлаар би танд төрийн өмчийн хувьцаа хэдэн хувь байгаа гэдгийг сүүлийн мэдээллүүдийг аваагүй байна. Гэхдээ энд төслийг бидэнд ТЭЗҮ өгч байсан 2022 оны 9, 10, 11 дүгээр сарын мэдээллээр хувийн, төрийн өмч хосолсон ийм компани юм байна лээ.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд энэ чинь хөрөнгө оруулалт юм уу, зээл ярьж байгаа юм уу гэж асууж байна шүү дээ. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хөрөнгө оруулалтын асуудлыг сая Баярмаа гишүүн хөндөж асуугаад байна. Тэгэхээр хөрөнгө оруулалт авах гээд байгаа юм уу, зээл авах гэж байгаа юм уу гэдгийгээ тодруулж хэлэх нь зүйтэй.

Б.Чойжилсүрэн: Энэ бол экспортын зээл авна гэдэг ийм ойлголтоор явж байгаа. Бид үнээ тохирч чадвал дараагийн санхүүжилтийн тухай яригдана. Тэр нь экспортын зээл байна гэсэн үг. Оросын Холбооны Улсын ... эконом банкнаас өгнө гэж ярьж байсан. Энэ бол 2022 оны яриа. Одоо хоригт орсон учраас хоригт ороогүй нэг банкаар дамжуулж өгөх хэрвээ төсөл явахаар бол ийм байдалтай болно. Нэг талаасаа хөрөнгө оруулалт гэж үзэх үү, зээл гэж үзэх үү энэ бол Монгол Улсын Засгийн газар баталгаа гаргана, зээл авна, түүнийгээ дулааны цахилгаан станц 3 ТӨХК-д дамжуулан зээлдүүлдэг ийм л бусад улс орнуудтай хийж байгаа бизнесийн нэг загвар л явж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Цэнгүүн: Миний гарт энэ дулааны 3 дугаар цахилгаан станцтай холбоотой эхлэхээс нь хойш бүх 2 улсын хооронд явуулж байсан сайд нарын албан бичиг гээд бүх харилцаанууд нь байна л даа. Тэгээд энийг уншаад сууж байхад маш өрөвдөлтэй л санагдаж байна. Манай сайд нар хөөрхий амьтад бүгдээрээ л нэг тойруулж, яаж энэ цаг хугацааг нь уртасгах вэ, энэ зүйлээс яаж холдох вэ гэсэн байдлаар л хандаж явж ирж л дээ. Тэгээд Чойжилсүрэн сайдыг бол буруутгаад байх арга байхгүй манай байдал ийм байгаа юм.

Гэхдээ зүгээр ингээд өнөөдөр ч гэсэн бид харж байна. Хэдхэн сарын өмнө тангараг өргөөд орж ирсэн Улсын Их Хурлын гишүүд шүү дээ бид. Тухайн үед бид бүгдээрээ Монгол Улсын төлөө, Монгол Улсын эрх ашгийн төлөө ажиллана гэж тангараг өргөсөн хүмүүс. Тэгэхээр өнөөдөр тэр цаг үеийн шалгуур нь болсон хэдхэн минутын дараа санал хураалт болоход шалгуур гарч ирэх байх гэж харж байна л даа. Тэгээд нэг зүйлийг ингээд харахаар ер нь эрх чөлөөний төлөө бид тэмцэх ёстой. Яагаад вэ гэхээр бид ийм байсаар байх юм бол айдсаар удирдуулаад ингэчих юм бол ингэнэ, ийм зүйл хийх юм бол болохоо больчихно гэдэг энэ байдлыг бодсоор нь байгаад л өнөөдрийн байдалд ирсэн шүү дээ. Энэ байдал хэзээ ч дуусахгүй. Хэдүүлээ хэзээ ч үнэнээс зугтаагаад амжилтад хүрэхгүй.

Өнөөдөр Оюун-Эрдэнэ сайд энэ танхимд цуг байж байна. Та зоригтой байх тухай яриад байгаа. 14 мега төслийг хүчтэй хөдөлгөнө гэж хэлж байгаа юм. Тэгэхээр энэ дотор чинь бид Монгол Улс эрсдэл гаргаад ч хамаагүй эрх чөлөөгөө олж авах ёстой байгаад байна. Тэгэхээр энэ дээр та ажиллаж чадах уу гэж асууя.

Дээрээс нь нэг зүйлийг хэлэхийг хүсэж байна. Өнөө орой гэртээ очоод бүх Улсын Их Хурлын гишүүд унтахдаа өөрөөрөө бахархаад унтаасай гэж хүсэж байна. Та бүхэн зөв шийдвэр гаргаасай гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Ер нь үндсэндээ Цэнгүүн гишүүн үг хэлчихлээ тийм ээ? Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Дараа нь нэг мөсөн хариулчихъя.

З.Мэндсайхан: Хэдүүлээ нэг юман дээр бодит үнэнтэйгээ нийлсэн нь дээр байх. Монгол Улсад юу байна эрчим хүчний нүүрс байгаа. Энэ эрчим хүчний нүүрс дээр станц дээр дэлхий бас зээл өгөхгүй болчихсон нь үнэн. Өнөөдөр бид чадлаа гүйцэхгүй, хэрэглээгээ гүйцэхгүй чадалтай байгаа нь үнэн эрчим хүчний салбар маань. Энийг та нар бүгдээрээ мэдэж байгаа. Тарифаа нэмчхээд бид хязгаарлалтад ороод байж байгаа.

Өнөөдөр Оросын Холбооны Улс л ганцхан зээл өгье гэж байгаа юм. Тэгээд би энэ асуудал дээр би энэ салбарт байсан хүний хувьд нэг хэлэхэд энэ Интер РАО гэдэг компани 2017 онд ТЭЦ 3-ыг 570 сая еврогоор шинэчилж өгье гэдэг санал өгч байсан юм. Тэр үед, үе үеийн Засгийн газар энэ эрчим хүчний салбарыг анхаарч ирсэн. Тэр үед Хятад улс хөнгөлөлттэй зээл өгдөг байсан учраас өнөөдөр бид Эрдэнэбүрээнийг 8 жил хөөцөлдөж байгаад сая үзэглэлээ. Дорнодыг өргөтгөж авлаа, Эрдэнэтийг өргөтгөж авлаа. Энэ өргөтгөсөн чадлын хүрээнд өнөөдөр бид нэг арай нэг лаатай хоночихгүй явж байгаа. Тэгээд ингээд бид байгаа ганц бодит үнэн бол Оросын Холбооны Улс зээл өгье гэж байгаа шүү дээ. Түүн дээрээ хэдүүлээ судлаад үзье. Болохгүй бол энэ ТЭЗҮ чинь өөрөө манай ТЭЦ 3-ын өмч болоод үлдэнэ.

Цаашаа бид өөрчлөөд, олон улс дээрээс мөнгө санхүү босгоод явах тэр боломж нь байгаа. Нэг аравны, тэр үед 570 сая гэж байсан өнөөдөр 1,4 гэж 2022 онд хийсэн үнэлгээгээр бий болсон байна. Яагаад ийм үнэлгээ бий болчхов гэвэл өнөөдөр энэ нүүрсний салбарт ялангуяа цахилгаан станцуудад зээл өгөхгүй болчихсонтой л холбоотой ийм асуудал үүсчхээд байгаа шүү дээ.

Тэгэхээр бид байгаа боломжоо ашиглах гээд оролдоод үзье л гэж байгаа юм байна гэж би Чойжилсүрэн сайдыг ойлгоод байгаа юм. Тэгээд боломжгүй бол хэдүүлээ ТЭЗҮ-г нь ахиад л өөрчлөөд л явъя. Энэ бодитой юмнуудаа ингээд попроод баймааргүй байна. Энэ бүхний цаана юу явж байна вэ гэхээр ерөөсөө тэр та бүгдийн түрүүний хэлээд байгаа эрчим хүчний тусгаар тогтнолын чинь төлөө л бид яваад байгаа байхгүй юу. Үгүй бол тэгээд л уяатай хойноосоо байж байя л даа. Энэ бол зээл аваад, эргүүлээд төлж болдог юм. Бид эрчим хүчний хувьд дандаа хараат байна гэсэн ойлголт байж болохгүй.

Ер нь ингээд би нэг юмыг дахин, дахин хэлээд л байгаа. Эрчим хүчний үндэсний хороо гэж байгуулаад, даргаар нь томилогдоод, Олон улсын байгууллагад их олон жил ажилласан нөхөр гоё сайхан нэр томьёо яриад л яваад байгаа. Үгүй ээ тэгээд ийм үед дуугараач. Яагаад мөнгө босож ирэхгүй байгаа юм бэ? Яагаад энэ боломжийг ашиглахад иргэдэд буруу ойлголт яваад байгаа юм бэ? 2, 3 өдөр л Чойжилсүрэн сайдыг эх орноо худалдах гэж байгаа юм шиг энэ хэвлэлээр зарлалаа шүү дээ. Нөхцөл байдлаа үнэнээр нь тайлбарлаад явах ёстой. Бид эрчим хүч экспортолно гэж тэр 20, 30 жилийн дараах яах вэ. Эрчим хүчний хязгаарлалтад ороод, лааны гэрэлд суухгүй шиг байхын төлөө хэдүүлээ хичээх хэрэгтэй.

Энэ Хятадын зээл олгохоо зогсоохоос өмнөхөөр нь, өмнөх тэр боломжийг нь Монгол Улс боломжийн ашиглачихсан. Энэ Бөөрөлжүүт юу гэдэг юм энэ Баян гээд нийтдээ 1250мвт-ын чадал бид нарт хүлээгдэж байна. Дээрээс нь ТЭЦ 3-нхаа энэ дэд бүтцийг ашиглаад шинэчлэл хийгээд үзье гэж байгаа шүү дээ. Тэгэхдээ энэ бол шинэчилчихье гэж байгаа асуудал биш. Энэ байгаа дэд бүтцээ ашиглаад Оросын зээлийг оновчтой байх нь уу, үгүй юу гэдэг дээр нь судлаад үзье л гэсэн ийм асуудал шүү дээ. Тэгээд энэ бүхний цаана эрчим хүчний чинь тусгаар тогтнол гэдэг асуудал явж байгаа. Би өнөө орой гэртээ их тайван хонох байх гэж бодож байлаа.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд Цэнгүүн гишүүний асуултад хариулах уу? Түрүүн өнгөрөөд явчихлаа. Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Цэнгүүн гишүүнээ манай тусгаар тогтнолд яг өнөөдрийн байдлаар та яаж үнэлж байгаа юм. Миний хувьд ямар нэгэн тийм айхтар тийм сөрөг нөлөөлөл байхгүй байна, эрх чөлөөгөө алдчихсан юм байхгүй байна гэж би бодож байгаа юм. Энэ Оросын Холбооны Улсын экспортын зээлийг аваад, энэ төсөл маань бүрэн дүнгээрээ Монголын талд ашигтай зах зээлийн нөхцөл бий болох юм бол энэ төсөл явна. Тэгэхгүй бол зогсооё л гэж байгаа шүү дээ. Бүрэн эрх нь бидэнд байгаа шүү дээ. Тусгаар улс байгаа шүү. Больё гэж байгаа. Оросын Холбооны Улс заавал энэ зээлийг авахгүй бол ингэнэ, тэгнэ гээд нэг тийм тулгаад шаардаад байгаа ч юм байхгүй. Ийм учраас энийг зүгээр ингээд бид эхлээд өөрсдийгөө л бодъё.

Бид энэ сүүлийн 34 жил, сүүлийн 100-гаад жилийн дотор энэ хэрэглээ маань ингэж жилд 7 хувиар энергиэр чадлын өвлийн оргил ачаалал дээр 10 хувиар өснө гэдгийг урьдчилан тооцоолж чадаагүй, энд бэлэн биш байгаа учраас энэ хязгаарлалт дотор чинь яваад байгаа шүү дээ. Бурууг бусдаас хайхаасаа түрүүлээд

бид эхлээд өөрсдөөсөө хайвал яасан юм. Бид энэ эх үүсвэрээ дотоодоосоо бусдаас хараат бус, одоо Оросын Холбооны Улсаас бид тогтворжуулалтын 220 киловольтын хос шугамаар 345мвт-ыг тултал нь аваад явж байгаа шүү дээ. 6,5 центээр л авч байгаа. Нэг шахаад айлгаад, боогоод байсан ч юм алга. Оросын Холбооны Улс өөрөө дайны байдалд байна. Маньтайгаа манатай байгаа. Зүгээр л хөрш. Сэтгэл хөдлөлдөө автахгүйгээр цэвэр тооцоолол хийгээд л, эрх чөлөөгөө эдлээд л, гаргах шийдвэрээ гаргаад л явцгаая гэсэн ийм байр суурьтай.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Батбаатар: Эрчим хүч, олон, олон асуудал, утаа, түгжрэл яриад байвал олон, олон асуудал Монголын асуудал болчихсон бид бүгдээрээ мэдэж байгаа. Намагт гүн шигдчихсэн байгаа зүйлээ яаж гаргаж ирэх вэ гэдэг тухай ярьж байгаа. Аргагүй өнөөдрийн нөхцөл байдал дотор, өнгөрсөн цаг хугацаа дотор эрх баригчдын эрх барьсан бүх хүмүүсийн, танай, манай, өөрийн гэж ялгахгүй бүх хүмүүсийн л алдаа дутагдал байгаа. Тэгэхдээ бид тэрийг шүүж хэлэлцэхээсээ илүү өнөөдөр тэндээс яаж гарах юм бэ гэдэг тухайгаа бодох ёстой. Гарахдаа ямар байдлаар гарах юм бэ дахиад нөгөө намагтаа улам гүн бат баригдах юм уу, илүү жоохон чөлөөтэй хөдлөх боломжтой болж гарах юм уу гэдэг тийм бодлого бодох ёстой. Тулчихсан асуудлаас бид тойрч гүйгээд юм уу, холдож гүйгээд асуудлаас ангижирна гэж байхгүй. Нүүр тулах хэрэгтэй, гар барих ёстой, энэ арга байхгүй. Өнөөдөр хэн нэгнийг буруутгах гэхээс гадна бид дахиж одоо энэ цагаас цаашаагаа хүн буруутгаад тэрнээс болоод тэглээ гэдэг байдал дээр л суумааргүй байгаа юм.

Эрчим хүчнийхээ энэ 3 дугаар цахилгаан станцынхаа тэр зураг, төсвийг нь хийлгэх нь 20 сая доллар гарах нь. Тэр зураг, төсөв чинь өөрөө мөнгөөр л хийлгэдэг зүйл шүү дээ. Өөр зүйл, нэг сургууль, цэцэрлэгийн барилга хийлгэсэн ч хийлгэдэг зүйл шүү дээ. Тэр нь бол болж байна гэж үзэж байгаа юм. Түүнээс биш Чойжилсүрэн сайдын хэлээд байгаа 1,3 тэрбум еврогийн тэр хэмжээний үнэ өртөг бүхий цахилгаан станцын асуудлыг оруулж ирэхгүй гэж би итгэж байгаа. Оруулж ирэхдээ тулбал Эрчим хүчний сайдын ажлаа түрүүлээд өгчих юм байна, өөрөө оруулж ирэхгүй юм байна гэж ойлгоод байгаа юм. Миний ойлгож байгаа ойлголтоор энэ хүнийг бага сага мэддэгийн хувьд. Тэгэхдээ магадгүй буруу ойлгохыг, өнөөдөр өөр болчихсон байхыг үгүйсгэхгүй.

Тийм учраас энэ зүйл дээр бид Их Хурлын гишүүд илүү олон, илүү дутуу зүйл бие биедээ хэлэхээсээ илүү өөр өөрсдийнхөө итгэл үнэмшлээр саналаа өгөхөд л болно. Би бол энэ дээр татгалзах санал өгнө. Энэ миний итгэл үнэмшил. Магадгүй зураг, төсөв нь бэлэн болчихсон, дараагийн асуудлууд нь байж байхыг үгүйсгэхгүй. Хардах сэтгэл байна. Хардахгүй байхын арга алга, хаа сайгүй цахилгаан хязгаарлагдаж байна. Ямар муухай хартай юм бэ гэж хэлэх байх. Гадаад харилцааны сайдаас уг нь асуумаар байгаа юм. Эрчим хүчний сайд ганцхан асуудлыг яриад байдаг. Эрчим хүчний асуудлыг ярих юм бол бид энийг авах ёстой гэдэг шийдэл рүүгээ дөхөөд байна. Эдийн засгийн асуудал яривал энийг авах ёсгүй л гээд яваад эхэлнэ. Магадгүй зураг, төсөв нь гараад, тэр Чойжилсүрэн сайдын хэлээд байгаагаар 814 сая долларын өртгөөр энэ цахилгаан станц босно гэх юм бол болно гэж үзээд байгаа шүү дээ. Ингэж ойлгож байгаа.

Тийм болохоор бусад эх үүсвэр бусад зүйлүүд гээд их олон зүйлүүд яриад нааш нь, цааш нь болгоод баймааргүй байгаа юм. Яг үнэндээ өнөөдөр энэ өндөр өртөг төсөвтэй тодорхой төсөл орж ирж байна. Тэр нь бид нарын хувьд эмзэглэл

төрүүлж байна гэдэг бол бид өнгөрсөн цаг хугацаанд энэ улсын төрийн толгойд байсан хүмүүсийн өр төлбөрийг татвар төлөгчдийн мөнгөөр, ирээдүйн үр хүүхдийнхээ талхны мөнгөөр сольж төлж байгаатай л адилхан зүйл шүү дээ. Тэрийгээ ойлгодог болж.

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Батбаатар гишүүн нөхцөл байдлыг зөв ойлгож байгаа. Үнэнтэйгээ нүүр тулъя гэдэгт үнэхээр баяртай байна. Тантай санал нэг байна. Нэг зүйл Монгол Улсын Ерөнхий сайд Монгол Ардын намын дарга Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд зааланд байна. Би Эрчим хүчний сайдын хувьд Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэндээ хандаад нэг зүйлийг хариуцлагатайгаар амлана. Зах зээлийн бус нөхцөлтэй ийм хэрвээ яриад байгаа, хүмүүсийн хардаад байгаа шиг Монгол Улсад ашиггүй, алдагдалтай ийм төсөл байх юм бол энэ төслийг оруулж ирэхгүй, хариуцлагатайгаар та бүхэн зөв ойлгоорой.

Магадгүй Оросууд энэ нөхцөл байдлыг ойлгоод зураг, төсөв хийхэд 2 жилийн хугацаанд нөхцөл байдлыг ойлгоод буугаад зах зээлийн юу хүлээж авах бололцоотой хүлцэх түвшинд ийм саналууд ирэх юм бол дахин Засгийн газарт танилцуулна, тэгээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод болон шаардлагатай бол Улсын Их Хурлын чуулган дээр танилцуулга хийхэд бэлэн байгаа. Нэг зүйлд итгэлтэй байгаач. Монгол Улсад хохиролтой, тулгуулсан ямар нэгэн зүйл байхгүй.

Д.Амарбаясгалан: Хариулт болсон уу, тодруулах уу? Батын Батбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Батбаатар: Яах вэ учиргүй тулгаж тодруулъя гэж бодсонгүй. Тэгэхдээ Чойжилсүрэн сайд сая 1 үг хэлчихлээ шүү дээ. Зах зээлийн, гэхдээ хүлцэж болох хэмжээнд үнийн өртөгтэй орж ирэхгүй бол оруулахгүй гээд хэлчихлээ. Хэрвээ өнөөдрийн энэ яригдаад хүмүүсийн уур бухимдал төрүүлээд байгаа, эмзэглээд байгаа, өөр аюулгүй байдал, хөрш орон өөр бусад зүйлийг татан оролцуулаад байгаа тэр үнийн дүнгийн хэмжээнд орж ирэхээр бол ажлаа өгнө гээд хэлчих шиг боллоо. Зөв ойлгочхов уу, буруу ойлгочхов уу? Та өөрийнхөө амаар хэлчих.

Д.Амарбаясгалан: Одоо 1 гишүүн асуулт асууж, үг хэлээд санал хураалт явагдана. Гишүүдийг чуулганы танхимд хүрэлцэн ирэхийг урья. Эдийн засгийн байнгын хороо хуралдаж байгаа. Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд санал хураах цаг болж байгаа учраас мэдээлэл хүргэхийг хүсэж байна. Сандагийн Бямбацогт гишүүн сайд асуулт асууж, Сандагийн Бямбацогт сайд асуулт асууж, үг хэлье.

С.Бямбацогт: Би ч асуулт асуух гэж байсан асуултыг сая Батбаатар гишүүн асуугаад, Чойжилсүрэн сайд ерөнхийдөө хариулчихлаа. Зах зээлийн бус, дэлхийн жишгээс гадуур хэт өндөр үнэтэй ийм цахилгаан станц барих асуудал би хэзээ ч зөвшөөрөхгүй. Хэрвээ ийм асуудал оруулж ирэх юм бол бүхий л хариуцлагаа хүлээнэ гэж байна. Энийг л асуух гээд байсан юм.

Тийм болохоор манай гишүүд зөв ойлгомоор байгаа юм. Нөгөө нэг танкны үлгэр яриад том төслүүдээ гацаадагтай адилхан өнөөдөр тийм үү бид зураг, төсөв ярьж байгаа энд. Эрчим хүчний эх үүсвэрээ яаж нэмэгдүүлэх вэ зураг, төсөв. Зураг,

төсөв хийгдсэний дараа хэт өндөр өртөгтэй бол хийгдэхгүй, зах зээлийн жишигт нийцсэн, дэлхийн жишигт нийцсэн байх юм бол хийгдэнэ, энэ төсөл хэрэгжинэ. Ийм л асуудал ярьж байна шүү дээ. Тэгж байхад өнөөдөр ерөөсөө шууд л энийг дэмжээд кнопдчих юм бол ерөөсөө эх орноо худалдсан, Оросоос айдаг, буу тулгуулсан ийм хүмүүс болох юм шиг битгий ингэж яриач, битгий тэгж яриач. Өнөөдөр зураг, төсөв боловсруулах хэлэлцээрийг бид батлах гэж байна.

Зураг, төслөө хийж байх явцад өндөр үнэтэй байвал хийхгүй байна гэж хэлж байна. Сайд өөрийнхөө амаар хэллээ шүү дээ. Энэ чуулганы танхимд сайдын өөрийнх нь хэлсэн үгэнд итгэхгүй, хэний үгэнд итгэх вэ бид нар. Тийм болохоор бид энийг бодох хэрэгтэй байх. Хүний амьдралын анхдагч хэрэгцээ байдаг идэх, өмсөх, унтах. Түүнтэй адилхан эрчим хүч чинь анхдагч хэрэгцээ болчихсон байна. Хэт өндөр үнэтэй эрчим хүчтэй боллоо гээд бухимдсан. Өнөөдөр эрчим хүч хязгаарлалтад ороод, тоггүй болсон чинь яаж байна тогтой байя үнэ хамаагүй гэж асуудал ярьж байна шүү дээ. Тэгвэл өнөөдөр Засгийн газар, Чойжилсүрэн сайд эрчим хүчний эх үүсвэрүүдээ яаж нэмэгдүүлэх вэ гэдэг асуудал ярьж байна. Хувийн хэвшлийнхэн Бөөрөлжүүтийн станц оруулж байна, дэмжиж байна.

Хятадын хөрөнгө оруулалттай 660мвт-ын цахилгаан станц баригдах гээд бид дэмжиж байна. Үүнтэй адилхан хуучин Оросын технологиор байсан Орос суурьтай станцууд дээрээ өргөтгөл, шинэчлэл хийе. Гэхдээ зураг, төсөв хийгээд, судалгаа хийгээдэхье гэж байгаа юм. Ийм л асуудал ярьж байхад юу гэдэг юм Оросынх болохгүй, Хятадынх болно, эсхүл Оросынх болохгүй, Германых болно, Японых болно гэдэг байдлаар бид хандмааргүй байна. Тэгээд өнөөдөр Франц улстай бид хөрөнгө оруулалтын гэрээ хийж, ураны асуудал ярьж байна. Хятад улстай олон жил гацсан төслөө хэрэгжүүлэх Гашуунсухайт-Ганцмодны төмөр зам, түүнийг дагаад олон төмөр замууд баригдаж, Монгол Улсын экспорт нэмэгдэнэ. Монгол Улсын эдийн засаг томорно.

Эдийн засаг өсөхөд, экспорт нэмэгдэхэд эрчим хүч анхдагч хэрэгцээ нь. Хүний амьдралын анхдагч хэрэгцээ болсонтой адилхан эрчим хүч байхгүйгээр бид үйлдвэрлэл ярихгүй, эрчим хүч байх, байхгүйгээр бид тийм үү байгалийн баялгаа олборлох, борлуулах асуудал байхгүй. Ажилтай, орлоготой байх асуудал байхгүй. Тийм болохоор эрчим хүчний эх үүсвэр дээр аль болох олон талаас нэмэгдүүлье. Эрчим хүчний үйлдвэрлэлийг аль болох олон үйлдвэртэй болж, цахилгаан станцтай болж, энэ хэмжээгээрээ нийлүүлэлт нэмэгдэж, энэ хэмжээгээр өрсөлдөөн бий болж байж эрчим хүчний үнэ тариф хямдарна. Тийм болохоор өрсөлдөөнийг дэмжье, эрчим хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлье. Түүнийх нь нэг эх үүсвэр нь Оросоос байж болох юм гэдэг л асуудал ярьж байна шүү дээ. Олон эх үүсвэртэй Оросоос, Хятадаас, тэр гаднаас Германаас, Японоос нарны, салхины, усны, нүүрсний гээд.

Нүүрс дэлхий дээр өнөөдөр үндсэндээ хог болчихоод байгаа шүү дээ. Удахгүй хог болох гэж байгаа. Герман улс музейдээ тавьчихсан, цахилгаан станцаа бүгдийг нь хаачихсан. Ганцхан нүүрсний цахилгаан станц барья гэж зөвшөөрч байгаа улс нь Оросын Холбооны Улс байна шүү дээ. Тийм болохоор эрчим хүчнийхээ эх үүсвэрийг нэмэгдүүлье, энэ цахилгаан станцуудаа олон болгоё гэж байгаа бодлогоо нэг бүгдээрээ бодоцгоогооч. Энэ өрсөлдөөн нэмэгдэж байж үнэ хямдарна. Ингэж байж эрчим хүч цахилгааны үнэ хямдарна шүү дээ. Хямд үнэтэй тог эрчим хүч хэрэглэмээр байна шүү дээ бид. Тэгэхийн тулд бид яах ёстой вэ аль болох энэ станцаа л нэмэх ёстой шүү дээ. Тэгэхгүй ганцхан монопол байдалтай хэд гэсэн

үнээр, хэд ч байсан үнээр хамаагүй авахаас өөр аргагүй байдалд орчихсон. Тогтой л байж байя, үнэ хамаагүй гэдэг болж байна шүү дээ сүүлийн үед.

Тэгвэл аль болох олон станцтай болж, өрсөлдөөнийг нэмэгдүүлж, нийлүүлэлтийг нэмэгдүүлж, хямд үнэтэй тог хэрэглэмээр байна. Үүнийг Монголын ард түмэн хүсэж байгаа шүү дээ. Үүний төлөө нэг боломжийг нээсэн энэ төслөө бүгдээрээ дэмжицгээе. Станц барих гээгүй шүү гэдгээ бүгдээрээ сайн ойлгомоор байна. Өнөөдөр станц барих зураг, төсөл хийнэ. Зах зээлийн үнээс хэт өндөр үнэтэй байх юм бол энэ төсөл хэрэгжихгүй, би хариуцлагаа хүлээнэ гэж Чойжилсүрэн сайд өөрөө энэ танхимд хэлж байна. Тийм болохоор энэ бүгдийг бодолцоосой гэж гишүүддээ хэлье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Би өмнө нь гишүүдэд сануулж хэлж байсан. Танхимд бусад гишүүдийн санал өгөх нөхцөлд ямар нэгэн байдлаар популизм хийж халдаж болохгүй гэдэг зүйлийг бүгдээрээ анхааралтай бодож, үгээ хэлж байх ёстой. Улсын Их Хурлын гишүүн бол бүрэн эрхийнхээ хүрээнд ямар нэгэн нөлөөгүйгээр санал өгөх эрхтэй. Тэр санал өгч байгаа эрхэд өөрийн үзэл бодлыг тулгаж, асуудалд хандах бол энэ улс орны эрх ашиг, тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө хийж байгаа үйлдэл огтоос биш. Инээж байгаа болгон нөхөр биш, уурласан болгон дайсан биш. Дэмжиж байгаа санал улс эх орны эсрэг гэдэг ойлголт өгч, ярьдаг энэ байдал байж болохгүй.

Монгол Улсад өнөөдөр эдийн засгийнхаа эрх чөлөөг, эрчим хүчнийхээ тусгаар тогтнолыг олон талаас нь бүрэн хангаж авах тэр боломж бололцоо энэ 126 гишүүнтэй парламент бүрдсэнээр бий болж байна гэж бид өнөөдөр ярьж байна. Өнөөдөр түүхэн өдөр. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн 3 оронтой эдийн засгийн том, жижиг хэлэлцээрийг Засгийн газраас өргөн барьж, өнөөдөр парламент хэлэлцэж байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улстай 16 жилийн нийт дүнгээрээ 30 орчим тэрбум долларын өртөг бүхий гэрээ хэлцлийг бид өнөөдөр хэлэлцлээ. Францын төрийн өмчит Орано групптэй 9 орчим тэрбум долларын хөрөнгө оруулалтын гэрээний төслийг бид ярьж хэлэлцэж байна. Мөн Оросын Холбооны Улсын экспортын зээлээр 3 дугаар цахилгаан станцын өргөтгөлийг барих эсэх талаар тооцоо судалгаа хийх зорилготойгоор зураг, төслийг нь боловсруулах Засгийн газар хоорондын хэлэлцээрийг бид хэлэлцэж байна.

Тэгэхээр эдгээр асуудал бүгд улс эх орны эрх ашигт нийцүүлж, аюулгүй байдлыг хангах зорилгоор орж ирж, хэлэлцэгдэж байгаа. Ямар нэгэн байдлаар хийсвэр ойлголтоор, өөрийн эсэргүүцдэг үзэл санаагаар асуудалд хандаж бол мэдээж болно. Гэхдээ бусдад тулгаж болохгүй гэдгийг гишүүд маш хариуцлагатайгаар ойлгож байх ёстой. Өнөөдөржингөө бид энэ түүхэн өдрийг ярилаа. 10-аас 30 хүртэл жилийн хугацаанд гацсан төслүүдийг бид өнөөдөр урагшлуулж байна. Харин энэ удаагийн парламентын 126 болсны том үр дүн гарч эхэлж байна гэдэг талаас нь бид харах ёстой юм гэдгийг та бүхэндээ хэлье.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан байгаа. Сүүлийн 3 асуудлаар санал хураалтыг хойшлуулсан байгаа. Санал хураалтыг явуулж эхэлнэ. 3 санал хураалт байгаа, нийт 5 санал хураалт байгаа, 3 асуудлын. Түүний өмнө ирц бүртгэлийн 1 санал хураалтыг явуулаадахъя. Ирц бүртгэлийн санал хураалт. Танхимд 79 гишүүн байна, санал хураалтад өнөөдөр бүртгэлтэй 105 гишүүн байгаа. Санал хураалт эхлүүлье.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг, төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Дэгийн тухай хуулиараа, Дэгийн тухай хуулийн 78.3-д нэгдсэн хуралдаанд хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, Байнгын хорооноос оруулсан саналын томьёоллоор ил санал хураалт явуулж, Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол Соёрхон батлах тухай хууль эцэслэн батлагдсанд тооцно гэж байгаа юм. Тэгэхээр 64 гишүүнээр санал дэмжигдэнэ гэж ойлгож болно. Ингээд соёрхон баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 69 гишүүн дэмжсэн байна. Энхбатын Болормаа дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье. Болдын Жавхлан, Жигжидийн Батжаргал гэсэн гишүүд дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье. Нийтдээ 72 гишүүн дэмжсэн байна.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул Улаанбаатар хотын дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг, төсөл боловсруулах тухай хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцлоо.

20.44 цаг

Дараачийн санал хураалт 7 дугаар асуудал. Байнгын хорооны саналаар Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт 1, 2 санал хураалт байгаа. 1 дүгээрт нь Байнгын хорооны саналаар Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 84 гишүүн буюу 80 хувиар санал дэмжигдлээ. Сангийн сайд Болдын Жавхлан дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье. Жигжидийн Батжаргал гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

Хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 83 гишүүн буюу 79 хувиар санал дэмжигдсэн байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

20.47 цаг

Дараагийн санал хураалт. Байнгын хорооны саналаар “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт. 1. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын

хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 82 гишүүн буюу 78,1 хувиар санал дэмжигдлээ. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

20.48 цаг

Улсын Их Хурлын өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөлөө. Маргааш өглөө 10 цагаас чуулганы нэгдсэн хуралдаантай. Одоо Эдийн засгийн байнгын хороо үргэлжлүүлэн хуралдана.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА